

Улсын бүртгэлийн  
дугаар...

Төсөл хэрэгжүүлсэн  
гэрээний дугаар: ШуСс-2018/64

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ  
НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ  
ТҮҮХИЙН ТЭНХИМ**

**МОНГОЛЫН ТҮҮХЭН ГАЗРЫН ЗУРГИЙН БҮРТГЭЛ,  
СУДАЛГАА**

**Суурь судалгааны сэдэвт ажлын тайлан**

**(2018-2021)**

Сэдэвт ажлын удирдагч: Ж.Гэрэлбадрах-доктор (Ph. D), профессор  
МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгууллага: БСШУСЯ

Тайлан өмчлөгч: МУБИС СБД, VIII хороо, Бага тойруу-  
14, Улаанбаатар-48, Монгол Улс-210648

Улаанбаатар  
2021

### Сэдэвт ажлын гүйцэтгэгч:

Н.Баярцэцэг	МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн багш. Түүхч, доктор (Ph.D)
А.Ган-Эрдэнэ	АШУҮИС-ийн НЭМС-ийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн багш. Түүхч, докторант
Ш.Мөнхбаатар	Чингис хааны өв, соёл судлалын хүрээлэнгийн Сурвалж судлал хариуцсан ЭША. Докторант
Ц.Цэрэндорж	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн секторын дарга. Түүхч, Доктор (Ph.D), дэд проф.
Л.Эрдэнэболд	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн багш. Түүхч, Доктор (Ph.D) дэд проф.

## ГАРЧИГ

### УДИРТГАЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ НУТГИЙН ЗУРГИЙН СУДАЛГАА.....9

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АРХИВТ ХАДГАЛАГДАХ НУТГИЙН ЗУРАГ

2.1. Данс-I хадгалагдаж буй Монгол нутгийн зураг.....45

2.2. Данс-II хадгалагдаж буй Монгол нутгийн зураг.....96

2.3. Данс-III хадгалагдаж буй Монгол нутгийн зураг.....105

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНД ХАДГАЛАГДАХ НУТГИЙН ЗУРАГ

3.1. Халхын Түшээт хан аймгийн нутгийн зураг, цэс.....116

3.2. Халхын Сэцэн хан аймгийн нутгийн зураг, цэс .....201

3.3. Халхын Засагт хан аймгийн нутгийн зураг, цэс.....340

3.4. Халхын Сайн ноён аймгийн нутгийн зураг, цэс.....380

3.5. Дөрвөд хоёр аймгийн нутгийн зураг, цэс.....450

3.6. Өртөө, харуулын нутгийн зураг, цэс.....457

3.7. Өвөр Монголын хошуу, чуулганы нутгийн зураг.....510

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР ХАДГАЛАГДАХ НУТГИЙН ЗУРАГ.

4.1. Халхын Сэцэн хан аймгийн нутгийн зураг.....514

4.2. Халхын Түшээт хан аймгийн нутгийн зураг.....555

4.3. Халхын Сайн ноён аймгийн нутгийн зураг .....585

4.4. Ховдын хязгаарын нутгийн зураг.....606

4.5. Халх-Баргын харуулын нутгийн зураг.....613

4.6. Бусад нутгийн зураг.....615

ДҮГНЭЛТ.....615

НОМ ЗҮЙ.....619

### ХАВСРАЛТ

## УДИРТГАЛ

### **Төслийн шаардлага:**

Монголын түүхэн сурвалж бичгийн нэг үндсэн төрөл нь нутгийн зураг юм. Мөн нутгийн зураг нь Монголын түүхэн газарзүйн нэгэн чухал судлагдахуун билээ. Монголчууд эртний Хүннү гүрний үеэс нутаг дэвсгэрийнхээ зургийг зурж байсан тухай бичгийн мэдээ бий. Зүүнгарын улсын нутгийн зураг, Шведэд хадгалагдан үлдсэн байдаг. XVIII зуунаас монголчууд нутгийн зураг, нутгийн цэс үйлдэх нь ихэд олширсон билээ. Эдүгээ Монгол улс, ХБНГУ, Япон, Польш, БНХАУ-д Монголын түүхэн нутгийн зураг хадгалагдан үлдсэн байна. Тэдгээрийн зарим нь хэвлэгдсэн, зарим нь цахим хэлбэрээр байршсан байна. Энэ бүхнийг нэгтгэн нэгдсэн бүртгэл хийх, хийхийн зэрэгцээ нутгийн зургийн зурагдсан байдал, түүнд буй өгүүлэмж, түүхэн мэдээллийг нь судлан шинжлэх ухааны хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол улсад Үндэсний Төв Архив, Үндэсний Номын сан, Газар зохион байгуулалт, Геодези, зураг зүйн газар, Аймгийн орон нутаг судлах музей гэсэн газруудад, мөн хувь хүмүүс цуглуулагчидын гарт түүхэн газрын зургууд хадгалагдаж байна.

Үүнээс Газар зохион байгуулалт, Геодези, зураг зүйн газар болон хувь хүмүүст хадгалагдаж буй нутгийн зургуудын талаар нарийн тодорхой бүртгэл, судалгаа дутмаг хэвээр байна. Эхний ээлжинд тэдгээр бүх нутгийн зургийг он цаг, зурагдсан газар, харьяалалаар нь бүртгэх, Монгол улсын хэмжээнд нэгтгэн хэвлэх шаардлага байсан билээ. Мөн түүхэн нутгийн зургуудын үйлдсэн эд, хэрэглэсэн хэмжээс, өгүүлэх түүхэн мэдээлэл зэргийг нарийн нягтлан судалж, Монголын түүхэн газрын зургийн талаар цогц дэлгэрэнгүй судалгаа хийх хэрэгцээ байна.

Монголын түүхэн газрын зургийн талаар хоёр удаа хурал хийж, илтгэл өгүүлүүд хэвлэгдсэн хэдий ч нэгдсэн бүртгэл байхгүй бөгөөд сайтар нягталсан цогц судалгаа өнөө хэр гараагүй байна. Монголын түүхэн нутгийн зургийн талаар иж бүрэн судалгаа үгүйлэгдсээр байна.

Учир иймийн тул, дээр дурдагдсан шалтгаан, нөхцөлүүдийн үндсэн дээр энэхүү суурь судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

### **Судлагдсан байдал:**

XVIII-XX зууны эхэн үеийн Монголын түүхэн нутгийн зургийн судалгаа зохих хэмжээгээр хийгдсээр ирсэн билээ.

Монгол Улсын Үндэсний төв архив (), Үндэсний номын санд (), Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн газар (182) нутгийн зургийн тусгай хөмрөг байгаа бөгөөд түүнд дурдан буй үед холбогох шинжлэх ухаан ... түүхэн нутгийн зургийн архив зүй ба номын сангийн боловсруулалтын ажил хийж данс, дугаар үүсгэн хадгалж байна. Тэдгээр түүхэн нутгийг зургуудыг цахим хэлбэрт оруулж, зөвхөн захирлын зөвшөөрлөөр судлаачдад үзүүлж байна. Энэ хөмрөг нь уг суурь судалгааны ажлын үндсэн нэг тулгуур сурвалж болж байна.

Монгол улсын аймгуудын Орон нутаг судлах музей болон түүхийн дурсгалт зүйл цуглуулагч хувь хүмүүст хадгалагдаж буй түүхэн нутгийн зургууд бас анхан шатны судалгаа хийсэн хэмээн үзэж байна. Харин нэгдсэн бүртгэл хийгдээгүй хэвээр байна.

Европ дахинд Монгол нутгийн зургийн талаарх анхны мэдээг Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов 1911 онд хүргэжээ. Залуу судлаач байсан тэрбээр Баруун Монголоор судалгаа хийж очоод “Эзэн хааны Оросын Газарзүйн нийгэмлэгийн мэдээ”-д

монголчуудын үйлдсэн Баруун хойд Монголын нутгийн зургийн талаар товч танилцуулга бичжээ. Тэрхүү нутгийн зургийн уг эхийг худалдаачин А.В.Бурдуков Петербург руу илгээсэн байна. Зургийн нэр, он цагийн талаар дурдаагүй. Түүний бичсэнээр, эл нутгийн зургийг нимгэн хятад цаасан дээр өнгө ялган зурахдаа уулыг цэнхэр, улаанаар, нуур, голыг цэнхэр өнгөөр ялгаж, хилийг босоо III зураасаар, замыг ..... цэгээр, овоог □□ , харуулыг X эсвэл □ босоо дөрвөлжингөөр тэмдэглэжээ. Мөн зарим газар улаан цаасан дээр тодруулга бичиж наасан байна. Тэрбээр нутгийн зурагт буй 68 бичвэрийг дугаарлан бичээд төгсгөлд нь өмнө зүгийг баруун, хойд зүгийг зүүн гэж бичсэнийг анхаарах хэрэгтэй гэжээ.<sup>1</sup> Энэ бол Ар Монголын Ховдын хязгаарын Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг байв.

Түүний дараа 1938 онд Японы эрдэмтэн Аояма Садао “Дорно дахины судлалын сэтгүүл”-д Японд хадгалагдаж байсан Монголын Юань гүрний үеийн “Хол ойрын зай ба түүхэн нийслэлүүдийн нэгдсэн газрын зураг” гэх нутгийн 2 зургийн талаар том хэмжээний (56 х.) өгүүлэл нийтлүүлжээ.<sup>2</sup>

БНМАУ-д Монголын уламжлалт нутгийн зургийн судалгааг УБДС-ийн Зураг, шугам зургийн тэнхимийн ахлах багш Б.Гончигдорж авгай 1970 онд эхлүүлсэн<sup>3</sup> нь одоо ч үнэ цэнэтэй хэвээр байна. Тэрбээр монголчуудын нутгийн зураг дахь дүрслэлийн арга барил, өнгө, хүрдний хэрэглээ, 24 зүг чигийн утга учир (1 зүгт 15° багтах), зурах арга барил зэргийг нарийн тайлбарлажээ. Мөн нутгийн зураг хэрхэн үйлдэж байсныг тодорхой жишээн дээр зурж үзүүлсэн юм. Тэрбээр монголчууд нутгийн овоодын байршлыг олж тэмдэглэхдээ туйлын солбицлын аргыг хэрэглэж байсныг нотолжээ. Б.Гончигдорж авгайн 1-т, Хүннү нараас ч өмнө газрын зураг хийж байсан байж болох, 2-т, нутгийн зурагт татдаг хэмжээс бүхий торыг бурхан зурахад хэрэглэдэг тигээс үүсэлтэй байж болох гэсэн саналууд багагүй сонирхол татдаг билээ.

Түүний араас Лха.Дарьсүрэн, Ц.Шагдарсүрэн, О.Пүрэв нар нутгийн зургийн судалгааг улам гүнзгийрүүлсэн юм. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолын дагуу зохиолч, түүхч Лха.Дарьсүрэн авгайн удирдлагаар БНМАУ-ын архив, номын сангуудад хадгалагдаж буй аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийг судалж, аймаг тус бүрээр 5 дэвтэр цомог хэвлэн гаргасан<sup>4</sup> нь эдүгээ сурвалжийн эмхэтгэлийн хэмжээнд үнэлэгдэж олдохуйяа бэрх болжээ. Уг цуврал цомгуудад бичвэрийг худам монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлэхэд гарсан алдаа, нутгийн зураг дээр тоо тавихдаа зарим дүрслэлийг дарсан, бүдгэрүүлсэн зэрэг дутагдал гарсан байдаг. Хэдий тийм боловч, эдгээр цомгийг XIX–XX зууны эхэн үеийн Ар Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зураг судлалын анхны бүтээл болсон гэж өндрөөр үнэлэх ёстой.

Ц.Шагдарсүрэн авгай нутгийн зургийг хамрах хүрээгээр нь ангилж, нутгийн дэс, өнгө, тэмдэг тэмдэглээ, зургийн дүрэм зэргийг нарийвчлан тайлбарласан билээ.<sup>5</sup> Тэрбээр монгол газрын зургийг хамрах хүрээгээр нь улсын хэмжээний, аймгийн, хошууны, хотын, хүрээ хийдийн, өртөө замын, харуулын хэмээн ангилжээ. Тэрбээр өөрийн судалгааны талаар франц хэлээр өгүүлэл бичиж барууны судлаачдад хүргэсэн юм.<sup>6</sup> Түүхэн газарзүйч

<sup>1</sup> Б.Я.Владимирцов. Объяснения к карте С.-З. Монголии, составленной монголами. ИИРГО. 1911. том. XLVII. с. 491-495

<sup>2</sup> Аояма Садао. Юань улсын үеийн нутгийн зургийн тухай (япон хэлээр). The Toho gakuho. VIII. Journal of Oriental studies. 1938. Токуо. т. 103-152

<sup>3</sup> Б.Гончигдорж. Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудал. ШУАМэдээ. № 1. 1970. УБ., т. 54-66

<sup>4</sup> Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986, Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1986; Халхын Засагт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Түшээт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Сайн ноён хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987

<sup>5</sup> Ц.Шагдарсүрэн. Монголчуудын уламжлалт газрын зураг. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991. т. 64-78

<sup>6</sup> Shagdarsürüng. Ts. la connaissance géographique et la carte des Mongols. SM. Tom. III. (11). Fasc. 20. №.1. UB. 1975. pp. 345-370

О.Пүрэв авгай БНМАУ-ын бүх аймаг, сумаар явж, урьд үеийн хошуу бүрийн нутаг дэвсгэрийг нарийвчлан тодорхойлсон нягт нямбай судалгаа хийжээ. Тэрбээр өөрийн цуглуулсан асар их баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан Ар Монголын дэлгэрэнгүй нутгийн зураг зохиосон юм.<sup>7</sup> О.Пүрэв авгайн үйлдсэн нутгийн зургийн үнэ цэнэ нь Монгол нутгийн зурагт огт тэмдэглэгдээгүй, албан баримт бичигт тэр бүр тусдаггүй хошууны засаг захиргааны бага нэгжүүд болох сум, баг, хорин, арван, отог, хамжлагын нэр, нутгийг сурвалжлан олж зурж тэмдэглэсэнд оршино.

Монгол нутгийн зургийн судалгаанд Герман, Япон улсын эрдэмтэд хүндтэй байр суурь эзэлдэг. ХБНГУ-д Монгол нутгийн зургийн баялаг өв хадгалагдаж байгаа нь монгол судлаач Х.Констений хийсэн цуглуулга юм.<sup>8</sup> М.Балкийн тэмдэглэснээр, Х.Констен бээр Бээжин хотод хорь гаруй жил амьдрах хугацаандаа Монгол нутгийн 180 гаруй зураг цуглуулж 1950 онд Германд аваачсныг түүнийг нас барсны дараа Берлин хотын Улсын номын санд шилжүүлжээ. Тэдгээр зургийн цөөнгүй хэсгийг Шинэ засгийн бодлогын үед үйлдсэн бөгөөд Манжийн хаанд танилцуулахаар зургийн бичвэр дээр хятадаар орчуулж бичсэн олон цаас наасан зураг 90 орчим бий. Берлин хотын улсын номын санд хадгалагдаж буй Монгол нутгийн зургийн талаар судалгааны хэд хэдэн бүтээл гарчээ. 1961 онд монголч эрдэмтэн В.Хайссиг, К.Загастер нарын “Монголын гар бичмэл, модон бар, нутгийн зураг” номд дээрх нутгийн зургийн бүртгэлийг оржээ.<sup>9</sup> Судлаач Магадбүрэн Халтод тэр 182 зурагт буй газрын нэрийг тусгайлан судлан “Монголын газар нутгийн нэр” гэсэн ном гаргахдаа 26 нутгийн зургийг оруулжээ.<sup>10</sup> В.Хайссиг авгай нутгийн бүх зургийн нэрийг судалсан бүтээлдээ 118 нутгийн зургийг хэвлүүлсэн байна.<sup>11</sup> 1981 онд Рашдондог нарын судлаач өмнө гарсан 2 номд буй нутгийн зургийн нэрийн хэлхээсийг хэвлэжээ. Бүр сүүлд Г.Клүсер “XIX зууны сүүл, XX зууны эхэн үеийн монголчуудын суурьшиж байсан газар орны нутгийн гар зургийн түүхэн газарзүйн судалгааны ач тус”<sup>12</sup> гэсэн ном бичжээ.

Япон улсын судлаачид Их Юань улсад үйлдсэн дэлхийн нутгийн зургаас Манжийн эрхшээлийн үеийн хүртэлх Монгол нутгийн зургийн бүх үеэр даацтай судалгаа хийсээр ирэв. Үүнд тухайлан А.Садао, М.Сугияма, О.Иноүе<sup>13</sup>, Х.Фүтаки<sup>14</sup>, А.Камимүра<sup>15</sup> нарыг дурдаж болно. Хамгийн сүүлийн том бүтээл нь 2004 онд Х.Фүтаки, А.Камимүра нарын Токиогийн Гадаад судлалын ИС-д хадгалж буй 16 нутгийн зургаар гаргасан CD бүхий ном юм.<sup>16</sup> БНХАУ-д судлаач Б.Оюунбилиг, Б.Насандалай нарын Японы Тэнри ИС-д

<sup>7</sup> О.Пүрэв. XX зууны эхэн үеийн Ар Монгол (1900-1930 он). УБ., 2004

<sup>8</sup> Ж.Урангуа. Монгол судлаач Херманн Констен (1878-1957 он). Түүхийн судлал. Tomus. XLVIII. УБ., 2019. т. 273-290

<sup>9</sup> Heissig, Walther: Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten (Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland, Band 1, Franz Steiner Verlag Wiesbaden, 1961

<sup>10</sup> Magaddürin Haltod. Mongolische Ortsnamen. Teil I. (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) –VOHD, Supplementband 5, I, Wiesbaden, 1966

<sup>11</sup> Walther Heissig. Mongolische Ortsnamen. Teil II. (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) –VOHD, Supplementband 5, 2, Wiesbaden, 1978

<sup>12</sup> Günter Klüser. Zum Quellenwert von handgezeichneten Altkarten mongolischer Siedlungsgebiete des späten 19. und frühen 20. Jahrhunderts- insbesondere im Hinblick auf deren historisch-geographische bearbeitung. Verlag Dr.Kovač. 1999. Hamburg

<sup>13</sup> Inoue Osamu. Old maps showing Erdene zuu monastery from the private archive of prof. W.Kotwicz. In the heart of Mongolia. 100<sup>th</sup> anniversary of W.Kotwicz's expedition to Mongolia in 1912. Cracow. 2012. p. 207-244; Inoue Osamu. L.Altanzaya. A consideration on Shindai kenryuu-ki kobudo kyouiki-zu (The frontier-area map of Hobd in Qianlong era of Qing dynasty). Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т. 80-99

<sup>14</sup> Х.Фүтаки. Японы судлаач, цэргийн хүний үлдээсэн XX зууны эхний Ар Монголын зүүн хэсгийн газарзүйн тухай мэдээлэл. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. 97-106

<sup>15</sup> А.Камимүра. Монголын хошуу нутгийн зургийн зураг зүйн хувьсал ба Чин улсын Монгол захиргаа. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. т. 1-16; А.Камимүра. Алтайн Урианхайн долоон хошууны газрын зургийн тухай. Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т. 100-120

<sup>16</sup> Landscapes reflected in old Mongolian maps. Edited by F.Hiroshi and K.Akira. Tokyo. 2005

хадгалагдаж буй Монголын хошуу нутгийн 45 зургийг уг эхээр татаж, галигласан ном хэвлэгджээ.<sup>17</sup>

Монгол улсад Ц.Шагдарсүрэн<sup>18</sup>, Э.Равдан<sup>19</sup>, Л.Алтанзаяа<sup>20</sup>, Ж.Гэрэлбадрах<sup>21</sup>, Ш.Мөнхбаатар<sup>22</sup> нарын олон судлаач нутгийн зургийн талаар өгүүлэл бичиж хэвлүүлжээ. Судлаач Э.Жигмиддорж, Г.Намнансүрэн нар хамтран гаргасан Сайн ноён аймгийн гэр харуулын архивын баримтын эмхэтгэлд харуулын хоёр зураг хэвлүүлсэн байдаг.<sup>23</sup>

Дээрх хэд хэдэн газар хадгалагдаж буй нутгийн зураг, нутгийн зургийг багтаасан ном хэвлэл, цахим хаяг нь Монголын түүх, соёлын асар үнэт өв юм.

### **Судалгааны зорилго:**

Сэдэвт ажлын үндсэн зорилго нь:

1. XVIII-XX зууны эхэн үеийн Монголын түүхэн газрын зургийн анхны нэгдсэн бүртгэлтэй болох,
2. Монголын түүхэн газрын зургийн иж бүрэн судалгааг хийснээр Монголын түүхийн судалгаа, тэр дотроо газрын зургийн судалгааг төдийгүй түүнийг дагалдан сурвалж судлал, түүхэн газарзүйн судалгааг улам бүр гүнзгийрүүлэх,
3. Монголчуудын газрын зураг, нутгийн цэс үйлдэх өвөрмөц байдал, онцлогийг судалгааны үр дүнгээр дамжуулан шинжлэх ухааны хүрээнд болон олон нийтэд мэдээлж таниулах
4. Сэдэвт ажлын үр дүнд бий болох газрын зургийн нэгдсэн бүртгэл нь Монголын түүхийн сурвалж, түүхэн газарзүйн судалгааны хэрэглэгдэхүүнийг баяжуулах зэрэг болно.

---

<sup>17</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014

<sup>18</sup> Ц.Шагдарсүрэн. Монголчуудын газрын зургийн уламжлал, түүнийг судалсан тойм, үр дүн. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. т. 27-48

<sup>19</sup> Э.Равдан. Эртний болон дундад эртний Монгол гүрний нутаг дэвсгэр, газарзүйн биетүүдийн нэр дэлхийн болон бүс нутгийн газрын зурагт туссан тоймоос. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. т. 49-62

<sup>20</sup> Л.Алтанзаяа. Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн асуудалд. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. т. 63-74

<sup>21</sup> Ж.Гэрэлбадрах. Илдэн засгийн хошууны газар нутаг, хил хязгаарын тухай. ШУАМ. № 2. УБ., 1996.т.71-75; Ж.Гэрэлбадрах. Некоторые особенности землевладения в Монгольских хошунах (XVII–начало XIX вв). Altaica. t.VIII. М., 2002.стр.61-67; Ж.Гэрэлбадрах. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нэгэн зургийн судалгаа. УБ., 2015. Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т. 55-65; Ж.Гэрэлбадрах. Дарьгангын гурван газрын зургийг нягтлах нь. Акта Хисторика. t.XVII. УБ., 2016. т. 154-168; Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгаар зургаар нягтлах нь. Акта Хисторика. t.XIX. УБ., 2018. т. 144-156; Ж.Гэрэлбадрах. Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн хэдэн зураг. Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. УБ., 2018. т. 79-93; Ж.Гэрэлбадрах. Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга. Культурное наследие монголов: Коллекции рукописей и архивных документов. III. УБ., 2019; Ж.Гэрэлбадрах. Даавуун дээр зурсан Монгол нутгийн зургууд (XVIII-XX зууны эхэн). Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал. ЭШ-онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2019. т.18-22; Ж.Гэрэлбадрах. Дундговь аймгийн музейд буй хошууны нутгийн хоёр зураг. Дундговь судлал-II. УБ., 2019

<sup>22</sup> Ш.Мөнхбаатар. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутгийн гурван зураг. УБ., 2018. Евразийн нүүдэлчдийн түүхэн замнал: Төр, нийгэм, соёл” УБ., 2018. т. 34; Ш.Мөнхбаатар. Жалханз хутагтын шавийн нутгийн хоёр зураг. УБ., 2018. Acta Historica.t.XIX.УБ., 2018. т.156-166: N.Atsumi, Sh.Munkhbaatar. Preliminary Analysis of the Southbound Ikh Khuree Route with Fourteen Relay Stations. Tokyo. 2019. Inner Asian Studies, No.34 Tokyo. 2019. pp.95-118

<sup>23</sup> Гэр харуулын түүхэнд холбогдох архивын баримтууд. I. Халхын Сайн ноён аймгийн гэр харуул. Эмхэтгэсэн Э.Жигмиддорж, Г.Намнансүрэн. УБ., 2019. 52-56

## **Эдийн засаг, нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдол:**

Эл төслийн нийгмийн болон шинжлэх ухааны ач холбогдлыг нарийвчлан тодорхойлбол,

1. XVIII-XX зууны эхэн үеийн Монгол нутгийн зургийн анхны нэгдсэн бүртгэлтэй боллоо.
2. Монголын түүхийн судалгаа судалгаа, тэр дотроо нутгийн зургийн судалгаа төдийгүй түүнийг дагалдан түүхэн газарзүйн судалгаа, сурвалж судлал, орон нутаг судлал, зурагзүйн шинжлэх ухаан, газар усны нэр судлалын судалгааг улам бүр гүнзгийрүүлэх боломж бүрдлээ.
3. Монголчуудын нутгийн зургийн тухай, арга, арга зүй, дүр дүрслэл, огноо, баталгаажуулалт, овоо, цэс үйлдэх өвөрмөц байдал, онцлогийг судалгааны үр дүнгээр дамжуулан олон нийтэд мэдээлж таниулж байна.
4. Уг төслийн үр дүнд бэлэн болсон нутгийн зургийн нэгдсэн бүртгэл нь Монголын түүхийн сурвалж, түүхэн газарзүйн судалгааны хэрэглэгдэхүүнийг баяжуулж байна. Судалгааны өгүүлэл, нэгэн сэдэвт зохиолууд хэвлэгдэн гарч судалгааг улам бүр гүнзгийрүүлж байгаа билээ.

## **Судалгааны арга зүй:**

Уг судалгааг хийхдээ түүхийн шинжлэх ухааны уламжлалт арга зүй, залдан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших, интерпретацийн арга, хээрийн судалгаа, анализ, синтез зэрэг аргыг ашиглав.

Тус судалгааны ажилд шаардагдах мэдээллийг Улаанбаатар хот, Баянхонгор, Хэнтий, Хөвсгөл, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймаг, Хөвсгөл аймгийн Галт, Цагаан-Уул, Бүрэнтогтох сум, Өмнөговь аймгийн Манлай сум зэрэг Орон нутаг судлалын музейд хадгалагдах нутгийн зургийг бүртгэн авч хээрийн судалгааг хийж гүйцэтгэв.

## **Судалгааны үр дүн:**

### **Нэг.**

#### **Судалгааны ном бүтээл**

1. Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. Монгол нутгийн зураг. (Халхын Сэцэн хан аймаг) I боть. УБ., 2020 (95 х.х) ISBN 978-9919-23-345-7
2. Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. Монгол нутгийн зураг. (Халхын Түшээт хан аймаг) II боть. УБ., 2020 (95 х.х) ISBN 978-9919-23-346-4
3. Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. Монгол нутгийн зураг. (Халхын Сайн ноён аймаг, бусад) III боть. УБ., 2020 (95 х.х) ISBN 978-9919-23-374-1
4. Монгол нутгийн зургийн судалгааны зарим асуудал. УБ., 2020. (17,4 хх) ISBN 978-9919-9634-2-2
5. Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. Монгол нутгийн зургийн бүртгэл (ГЗБГЗЗГ-ын архив) УБ., 2021. (17,2хх) ISBN 978-9919-24-040-0
6. Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. Монгол нутгийн зургийн бүртгэл. УБ., 2021.

### **Хоёр.**

#### **Эрдэм шинжилгээний өгүүлэл (Зохиогч тус бүрээр):**



## **Ж.Гэрэлбадрах**

1. Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгийн зургаар нягтлах нь. Акта Хисторика. t.XIX. УБ., 2018. т. 144-156
2. Ж.Гэрэлбадрах. Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн хэдэн зураг. Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. УБ., 2018. т. 79-93
3. Ж.Гэрэлбадрах. Монгол улсын Газар зохион байгуулалт, Геодези зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга. Культурное наследие монголов: Коллекции рукописей и архивных документов. III. УБ., 2019.
4. Ж.Гэрэлбадрах. Даавуун дээр зурсан монгол нутгийн зургууд (XVIII-XX зууны эхэн). Даавуун артай соёлын баримтад өвийн өнөөгийн байдал. ЭШ онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 18-22
5. Ж.Гэрэлбадрах. Дундговь аймгийн музейд буй хошууны нутгийн хоёр зураг. Дундговь судлал-II. УБ., 2019.
6. Ж.Гэрэлбадрах. Монгол нутгийн зургийн судалгаа. Их семинар. УБ., 2020. т. 6-74

## **Ш.Мөнхбаатар**

1. Ш.Мөнхбаатар. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутгийн гурван зураг. Евразийн нүүдэлчдийн түүхэн замнал: Төр, нийгэм, соёл” УБ., 2018. т. 34
2. Ш.Мөнхбаатар. Жалханз хутагтын шавийн нутгийн хоёр зураг. Acta Historica.t.XIX.УБ., 2018. т. 156-166
3. Nakumara Atsushi, Sh.Munkhbaatar. Preliminary Analysis of the Southbound Ikh Khuree Route with Fourteen Relay Stations. Tokyo. 2019. Inner Asian Studies, No.34 Tokyo. 2019. pp.95-118
4. Sh.Munkhbaatar. qalq-a-yin jasaγtu qan ayimaγ-un jalkangja qutuγtu-yin šabi-yin nutuγ-un qoyar jiruγ. Budapest., 2019. pp.24
5. Ш.Мөнхбаатар, Г.Алтансүх. Монголын нууц товчоон дахь bürgi-ergi-ийн байршлын тухай. УБ., 2020. Монголын нууц товчоон: Түүхэн газар нутгийн судалгаа. УБ., 2020. т.73-78
6. Ш.Мөнхбаатар. Халхын дөрвөн аймгийн өртөөний байршлыг нутгийн зургаар тодруулах нь. УБ., 2020. Монгол нутгийн зургийн судалгааны зарим асуудал. 2020. т.75-136

## **Тайлангийн боловсруулалт, бүтэц хэмжээ:**

Төслийн ажлын тайлан нь удиртгал, 4 бүлэг, 16 зүйл, дүгнэлт, ном зүй гэсэн 620 хуудас, хавсралт 92 хуудас материалуудаас бүрдэнэ. Нийт 712 хуудастай.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.  
МОНГОЛ НУТГИЙН ЗУРГИЙН СУДАЛГАА**

Монголчууд эрт цагаас оршин амьдарч ирсэн газар нутгаа тодорхой сайн танин мэдэж, янз бүрийн арга хэлбэрээр тэмдэглэж, өмчлөн эзэмшиж хамгаалсаар ирсэн түүхтэй. Монгол нутагт амьдарч байсан эртний хүмүүс Хуучин чулуун зэвсгийн дээд (40.000-12.000 жилийн өмнө) үеэс нутгийнхаа хад чулуунд сүг зураг сийлж тэмдэглэж эхэлжээ. Дунд чулуун зэвсгийн (12.000-8.000 жилийн өмнө) үеэс хаданд тамга сийлж, нутаг орноо баталгаажуулдаг болсны нэг гэрч нь Рашаан хадны дурсгал юм. Хүрэл зэвсгийн (4500 жилийн өмнө) үеэс хадны сүг зураг үйлдэх нь улам бүр ихэссэн байдаг. Малчин монголчууд өөрсдийн малын бэлчээр нутгийн зах хязгаарт мод тулан босгож, чулуугаар овоо босгон тэмдэглэх болсон юм. Төр улс бий болж, улсын нутгийн хил хязгаар, засаг захиргааны нэгжийн нутгийн зааг тодорхой болохын хамт нутаг дэвсгэрээ зурах, бас бичиж баримтжуулан баталгаажуулах болжээ. Монголчууд нутаг дэвсгэрээ зурж, мөн бичиж тэмдэглэсээр ирсэн нь нутгийн зураг, нутгийн цэс, газар нутгийн тэмдэглэл-ойллого зэрэг хэлбэрээр бидний үед уламжлан иржээ.

### **Монголчуудын нутгийн зургийн түүхэн уламжлал**

Монгол бол нутгийн зургийн эртний уламжлалтай үндэстэн билээ. Монголчуудын эртний өвөг Хүннү гүрэн “нутаг дэвсгэр бол төрийн үндэс” гэсэн үзэл баримтлалтай, хил хязгаар хариуцсан тусгай оута вантай байв. Хүннү нар өөрсдийн нутгийн зурагтай байсан тухай мэдээг Хятадын хожуу Хан улсын түүхэнд тэмдэглэн үлдээжээ. Тэр талаар “Со своей стороны, император отправил [к шаньюю] начальник охранной стражи телохранителей Ли Мао, в это время как Би тайно послал ханьца Го Хэна поднести императору карту сюннских земель”<sup>24</sup> (Эзэн хаан өөрийн зүгээс шаньюй руу хамгаалалтын харуул бие хамгаалагчдын дарга Ли Мао-г илгээв, тэр цагт Би нууцаар хааны хатан Го Хэнд элч илгээн эзэн хаанд Сюннү-гийн нутгийн зураг өгчээ) хэмээн өгүүлдэг. Уг мэдээ Нийтийн тооллын 46 онд холбогдоно.

Хүннүгийн дараах Монголын эртний улсуудад нутгийн зургаа үйлдэх ажил уламжлагджээ. Монгол угсааны Хятан гүрний үед Х зуунд “Хятаны нутгийн зураг, тайлбарыг” зохиосон тухай мэдээг нанхиадч Б.Багана авгай олж зохиолдоо тэмдэглэжээ.<sup>25</sup> Харамсалтай нь түүний 130 хуудас гар бичмэл зохиол эдүгээ олдохоо больжээ. Х.Пэрлээ авгай түүний судалгааг гүнзгийрүүлэн 1179 онд зохиосон “Ци-дань-го-цзи” хэмээх түүхийн зохиолд байсан Хятан улсын нутгийн зургийг номдоо хэвлэсэн байна.<sup>26</sup> Тэр зурагт Цагаан хэрмээр заагласан Хятаны умард, өмнөд ордын нутаг дэвсгэр тод тусгагдсан агаад уул нуруу, гол мөрөн, далайг зурж тэмдэглэсэн нь хожмын Монгол нутгийн зургийн дүрслэлтэй зарим талаар төстэй харагдана.

*Нутгийн зураг № 1. Хятан улсын нутгийн зураг*



<sup>24</sup> Фан Е. История поздней династии Хань, глава 79. Повествование о южных Сюнну. Материалы по истории Сюнну (по китайским источникам) вып. II. Предисловие, перевод и примечания В.С.Таскина. М., 1973. с. 70

<sup>25</sup> Б.Багана. Хятан нарын асуудал. ШУА. Түүхийн хүрээлэн. ГБС. т. 123

<sup>26</sup> Х.Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959. т. 31

Монголын Их Юань улсын үед холбогдох нутгийн хоёр зураг хадгалагдан үлджээ. Эхнийх нь “Нийт нутаг дэвсгэр дээрх газар орон ба орчны онцлог байдлын зураг” (圣朝混一方同胜览) хэмээх 3 бүлэгтэй 6 дэвтэр нутгийн зураг бүхий нутгийн тэмдэглэлийн бар хэвлэл юм. Он цагийн хувьд Дадэ-гийн үе буюу 1297-1307 оны үед хамаарна. Тайвань улсын нийслэл Тайпей хотын Үндэсний ордон музейд хадгалагдаж байна. Уг барламал зурагт анхны эхийг шинэчлэн бичээд чухам юуг өөрчилснөө тэмдэглэжээ. Бүтцийн хувьд Хятадын Сүн улсын үеийн Жу му гэгчийн зохиосон “Газар орон ба орчны онцлог байдал” (方同胜览) гэдэг бүтээлийг дууриажээ. Түүнд 14 нутгийн зураг хэвлэсний 1 нь нийт газар нутгийн, бусад нь гадаад мужуудыг дүрсэлсэн байна. Эл бүтээлд одоогийн Бээжин хот, түүний ойр орчмын нутгийг засаг захиргааны нэгжид тулгуурлан зураглажээ. Бичвэрийн хэсэгт муж, зам, гацаа, тосгоны нэр, нутаг орны зан заншил, цаг уурын байдал, газар орчны онцлог, үзэж харууштай зүйл зэргийг тэмдэглэсэн байна. Мөн орон нутгийн засаг захиргааны төв, алдар хүндтэй эрхмүүдийн орших газрыг ч оруулжээ. Хэдийгээр уг бүтээл “Нэгтгэсэн их Юань гүрний газарзүйн нэвтэрхий толь бичиг”-ийн адилаар хөндсөн сэдвээ эцэслэн бүрэн хамарч чадаагүй ч чухал хэрэглэгдэхүүн болж чадах ажээ.<sup>27</sup>

*Нутгийн зураг № 2. “Нийт нутаг дэвсгэр дээрх газар орон ба орчны онцлог байдлын зураг”*




Хоёрдахь нутгийн зураг бол “Хол ойрын зай ба түүхэн нийслэлүүдийн нэгдсэн нутгийн зураг” (混一疆理历代国都之图) юм. Уг зураг Япон улсын Нагасаки мужийн Шимабара дахь Хонко-жи Токива түүхийн музейд хадгалагдаж байна. 1368 онд Солонгосын элч Жинь Шихэн гэгч “Газар орны нэрийн дуудлагыг үзүүлсэн газрын том зураг” (1330), “Хятадын түүхэн нийслэлүүдийн нэрийг багтаасан хол ойрын зайн нэгдсэн нутгийн зураг” (1328-1392) гэсэн хоёр зургийг нутагтаа авчирсныг баруун, зүүн гарын сайд Ким Тохийон, Их Хозэг-ийн И Мү нарын тушаалаар 1402 оны үед нийлүүлэн нэг зураг болгожээ. Харин тэр зураг ямар замаар Японд ирсэн нь тодорхойгүй. Эл зураг хоёр хувь байгаагийн нэг эх Японы Киото хотын Ниши Хонган-жи сүмд байснаа Рюкоку ИС-д шилжжээ. Нөгөө эх нь Японы Шимабара-гийн хойгийн Хонко-жи сүмээс олдсоныг арай хожим 1470 оны үед үйлдсэн хэмээн үздэг. Нутгийн зургийг өндөр 220 см х өргөн 298 см

<sup>27</sup> Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. Мюнхен. Хирмер хэвлэлийн газар. 2005. т. 312-313

хэмжээтэй цаасан дээр бэх, өнгийн будаг хольж зурсан ажээ. Зургийн доод талд Солонгосын Чосон улсын хааны сайд алдарт уран бичээч Квон Күний бичээс бий.

Уг нутгийн зургийн талаар В.Фучс<sup>28</sup>, А.Садао<sup>29</sup>, М.Сугияма<sup>30</sup> нар тусгайлан судалжээ. В.Фучсын үзсэнээр зургийн бичвэрийг монгол хэлээр хятад үсгээр бичсэн ажээ. Тэр зураг Монголын эзэнт гүрний өргөн уудам нутаг дэвсгэр, хил хязгаарыг хамраад зогсохгүй түүний гаднах эдийн засгийн нөлөөллийн бүс нутаг, Еврази бүхлээр, Африк тивийн хойд хэсгийг багтаасан байна. Нутгийн зурагт Монголын Юань улсын төв нутгийг нарийвчлан дүрсэлжээ. Мөн хараат улс Солонгос болон Японыг дутуугүй нарийн үзүүлсэн нь Солонгосын өндөр албаны түшмэд захиалан үйлдүүлсэнтэй холбоотой бололтой. Баруун зүгт Дундад Ази, Ираныг харьцангуй жижиг боловч зөв харуулсан ажээ. Ямар боловч энэ зурагт Лалын ертөнцийн газарзүйн мэдлэг ухааны нөлөө туссан гэдэг. Газар дундын тэнгисийг өнгө ялган зураагүй тул Европ тивийг танихад бэрхтэй ч хамгийн захад Марсель, Севилья хотууд харагддаг. Африк тивийн өмнөд эргийн Сайн итгэлтийн хошууг анх дүрсэлсэн нь 1488 онд тэнд хүрсэн Б.Диасын аяллаас бүр өмнөх хэрэг болж байна. Зөвхөн энэ баримт дэлхий ертөнцийг европчууд нээн судалсан гэх Европ төвт үзэл харьцангуй болохыг харуулдаг. Монголчуудын ноёрхол хүн төрөлхтөний түүхэнд анх удаа олон улс түмнийг хамарсан нийгэм, хил хязгааргүй соёл бий болгосныг энэ нутгийн зураг илтгэдэг.<sup>31</sup>

Нутгийн зураг № 3. “Хол ойрын зай ба түүхэн нийслэлүүдийн нэгдсэн нутгийн зураг”



Монголын эзэнт гүрний нэг бүрэлдэхүүн Ил хаант улсын Газан хаан (1284-1291)-ыг 1290 оны 5-р сарын эхээр улсынхаа нутгаар аялж явахад Кутбуд-дин Шираз гэгч ноён бараалхаж, нутгийн зураг өргөн барьсан мэдээ бий. Энэ тухай “At that station Mawlana Qutbud-din Shirazi came to court and presented a map of the western sea and its gulfs and shores, which included many territories of the west and north. The emperor was highly pleased by his conversation since he explained the territories of Anatolia”<sup>32</sup> (Тэр өртөөн дээр Мавлана Хутбуд-дин Шираз очиж, түүний өргөөнд бараалхан баруун тэнгис, булан ба эрэг, мөн өрнө ба дорнын их хэмжээний нутаг дэвсгэрийг багтаасан газрын зургийг өргөн барив.

<sup>28</sup> Walter Fuchs. The 'Mongol atlas' of China. Monumenta serica. Monograph VIII. Peiping. 1946. p. 42

<sup>29</sup> Аояма Садао. Юань улсын үеийн нутгийн зургийн тухай (япон хэлээр). The Toho gakuho. VIII. Journal of Oriental studies. 1938. Tokyo. т. 103-152

<sup>30</sup> Masaaki Sugiyama. World maps originating in Asia. Changes in History: Real, representative and imaginary. Collection of papers and abstracts on history I. Beijing forum. 2005. pp. 15-29

<sup>31</sup> Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. Мюнхен. Хирмер хэвлэлийн газар. 2005. т. 336-337

<sup>32</sup> Rashiduddin Fazlullah's Jami'u't-tawarikh: (Compendium of Chronicles. A history of the Mongols. Part three. Section fifteen. English translation and annotation by W.M.Thackston. Cambridge. 1999. p. 574

Эзэн хаанд түүний Анатолийн нутаг дэвсгэрийг тайлбарласан яриа ихэд таалагджээ) хэмээн өгүүлсэн байдаг. Уг мэдээнээс үзэхүл, Монголын эзэнт улсуудад нутгийн зураг үйлддэг, хэрэглэдэг байсан гэдэг нь илэрхий байна.

Хожим XIV–XVII зууны “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улсын үед ч нутгийн зураг үйлдэх, хэрэглэх уламжлал үргэлжилсэн юм. Ойрад монголчуудын байгуулсан Зүүнгарын улсын нутгийн зураг эдүгээ Шведийн Упсала хотын Их сургуулийн номын санд хадгалагдан үлджээ. 1709 онд Хаант Орос улстай хийсэн байлдаанд олзлогдон Сибирьт цөлөгдсөн Шведийн армийн их бууч юнкер И.Г.Ренат гэгч 1716 онд Зүүнгарын цэрэгт давхар олзлогдож, 1733 он хүртэл монголчуудад хүчин зүтгэжээ. Галданцэрэн хаан түүнийг эх орондоо буцахад Зүүнгарын улсын нутгийн 2 зураг бэлэглэжээ. Хожим “Ренатын зураг” хэмээн алдаршсан тэр хоёр зургийг “А зураг”, “Б зураг” гэж ялган нэрлэдэг. “А зураг”-т их төлөв Зүүнгарын улсын төв, баруун нутгийг зурсан ба нийт 236 газар усыг тод үсгээр тэмдэглэн бичжээ. “Б зураг”-т Зүүнгарын улсын зүүн хэсгийг голлон зурахдаа 536 газрыг бичиж тэмдэглэжээ. Ингэхдээ Монгол уламжлалын дагуу уулыг хүрэн өнгөөр, гол нуурыг хөх цэнхэр өнгөөр зурсан байдаг. Энэ хоёр зургийг нийлүүлэн тухайн үеийн Зүүнгарын улсын нутаг дэвсгэрийг бүрнээр төсөөлөн ойлгож болно. Уг хоёр зургийн хуулбар хувь Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна.<sup>33</sup> Судлаач Г.Бадамсамбуугийн нягталснаар, Ренатын хоёрдугаар зурагт Халх Монголын баруун талын багагүй нутгийг оруулан зурсан бөгөөд үйлдсэн арга барилын хувьд 1780 онд хийсэн Халхын Түшээт хан аймгийн нутгийн зурагтай нилээд төстэй ажээ.<sup>34</sup>

*Нутгийн зураг № 4. “Ренатын зураг -А”*



1733 онд И.Г.Ренатад Зүүнгарын улсын нутгийн зураг бэлэглэж явуулснаас 2 жилийн дараа олон жил үргэлжилсэн Халх–Ойрадын хил хязгаарыг тогтоох яриа хэлэлцээр дуусч, 1735 онд улсын хилийг тогтоосон билээ.<sup>35</sup> Харин уг зурагтай бараг нэг цаг үед Халх монголчууд нутаг дэвсгэрээ зурж байсны гэрч болох 1730-1743 оны үеийн Түшээт хан аймгийн нутгийн бүдүүвч зураг хадгалагдан үлджээ.

*Нутгийн зураг № 5. “Ренатын зураг -Б”*

<sup>33</sup> Уг хоёр зургийн хуулбарыг 2006 онд Монгол Улсын Үндэсний Номын санд бэлэглэсэн билээ.

<sup>34</sup> Г.Бадамсамбуу. Жанжин Сэцэн ханы бүтээлгэсэн нэгэн онцлог зураг. “Монгол нутгийн зургийн судалгааны зарим асуудал” Их семинарын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2020

<sup>35</sup> Ж.Гэрэлбадрах. Ойрад-Халхын хилийн асуудалд (XVI–XVIII зуун). *Studia Historica*. t. XXX. УБ., 1997. т. 38-47



Монголчууд Манж Чин улсын эрхшээлд орсны дараагаас буюу XVIII зуунаас хошуудын нутгийн зураг үйлдэх явдал өргөн дэлгэр болжээ. Энэ нь Монголд тогтоосон Манжийн төрийн дэглэм, засаг захиргааны хуваарьтай шууд холбоотой. Манжууд өөрсөддөө үнэнч зүтгэсэн, дагаар орсон язгууртнуудыг засаг ноён болгож байснаас хошуу нэн хурдацтай олшров. Мөн нөгөө талаар, Монголын тэргүүлэх ноёд язгууртнууд өсч олширсон тул тэдний заримд ч болов харьяатаа захирах эрх, хошуу байгуулж өгөх нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсон ажээ. Хошуу олширсныг монголчуудыг олон хэсэгт хуваан захирах Манжийн төрийн бодлоготой холбон тайлбарлаж бас болно. Тийнхүү хошуу олширсон учир ноёд харьяат нутаг бэлчээрээ бусдаас ялган зааглах шаардлагатай болжээ. Урьд өмнө Монголын цөөн хэдэн хошууд нутаг дэвсгэрээ том уул нуруу, гол мөрөн, говь тал газраар ерөнхийлөн зааглаж байсан бол хошууд эрс олширсноор хил заагийг илүү нарийн тодорхой тогтоох хэрэгтэй болов. Тэгээд ч ноёд өөрсдийн харьяат хүн ам, мал сүрэг, түүний бэлчээр нутгийг бусад хошуунаас нарийн тодорхойлж зааглахгүйгээр эзэн, харьяатын харилцаа бүрэн хэрэгжих боломжгүй билээ.

Нутгийн зураг засаг захиргааны үндсэн нэгжид тулгуурлан хийгдэж байв. Энэ бол Манжийн төрөөс эрх олгосон тамга барьсан засаг ноёнттой, захиргааны алба, албан хаагчидтай, хүн ам, мал сүрэг, өөрийн гэсэн нутаг бэлчээртэй хошуу юм. Хошууны засаг ноёны бүрэн эрхийг баталгаажуулах, хэрэгжүүлэх нэг чухал хэрэгсэл нь хошууны нутгийн зураг юм. Засаг ноёны өргөмжлөл, хошуу захирах тамга, нутгийн зураг, цэс нь тухайн хошууг захирах засаг ноёны албан ёсны эрхийг баталгаажуулах, улмаар хэрэгжүүлэх үндсэн албан баримт юм. Аймгийн чуулганы газарт ирүүлсэн хошуудын зургуудыг ашиглан аймаг, чуулганы нутгийн зургийг үйлдэнэ. Аймаг, чуулган бол харьцангуй том засаг захиргааны нэгж билээ. Монгол хошууд нутгийн зургаа Манжийн Тэнгэрийн тэтгэсэн (1736-1795) хааны зарлиг ёсоор үйлдэж эхэлсэн байдаг. Эл зарлигт “эл хошууны уул усны нэрээр хүснэгтлэн зурж, нүүдэллэн бэлчээрлэх газарт уул голгүй болбоос овоо босгоно. Хошуу нутгийн хязгаарын газар уул, голгүй тэгш тал, говь байвал чулуу овоолон овоо босгоод бэлчээрийн хязгаарыг тогтоож, өөрийн харьяат газраа тодорхойлон нутаг алгасахгүй нүүдэллэн амьдрах хэрэгтэй” хэмээн заажээ.

Гэр харуул, өртөө нь засаг захиргааны үндсэн нэгж биш боловч улсын хилийн хамгаалалт болон шуудан холбооны онцгой үүрэг гүйцэтгэх улсын тусгай бүс нутаг тул

тэдний нутгийн зураг, цэсийг үйлдэх болсон байна. Чингэж хошууны нутгийн, арай хожим харуул, өртөөний нутгийн зургийг хийдэг болжээ. Нутгийн цэсийг хэзээ бичиж эхэлсэн тухайд бол энэ нь нутгийн зургаас арай хожуу цаг үед холбогдоно.

### **Монгол нутгийн зураг ба Манжийн төр**

Манжийн төрөөс Монголын аймаг, хошуудын төдийгүй нийт Чин гүрний эзэмшил муж, хязгаар нутгуудын зургийг цуглуулан эмхэтгэдэг байв. Түүний гол зорилго нь эзэнт гүрний бүх нутаг дэвсгэрийг бичиж тодорхойлох, нутгийн зургийг нэгтгэн зурж албан ёсоор баталгаажуулах, төрийн албан хэрэгт ашиглахад чиглэнэ. Монгол хошууд нутгийн зургаа хэдэн хувь үйлдээд нэгийг тамгын газартаа хадгална. Бусад хувийг аймгийн чуулганы газарт хүргүүлнэ. Арай хожмын цагт нутгийн цэс дагалдуулах болжээ. Хошуудаас дээд газарт 4 хүртэл хувь нутгийн зураг явуулж байсан мэдээ байдаг. Аймгийн чуулганы даргын газраас харьяалан захирах Манж сайдын болон жанжны газруудад өргөнө. Тэндээс Бээжин дэх Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд явуулна. Тус яамнаас Монголын бүх хошуудын нутгийн зургийг нэгтгэн хаанд танилцуулахад бэлтгэнэ. Чингэхдээ зургийн бүх бичвэр дээр хятад хэлнээ орчуулж бичсэн цаас давхарлан наадаг байв.

Хаанд танилцуулсны дараа Монголын аймаг, хошуудын нутгийн зургийг Манж чин гүрний бусад мужийн зураг, тэмдэглэлтэй нийлүүлэн “Дайчин улсын бүгд хууль бичиг” буюу “Да Чин И Хуй дянь” (大清一会典) гэдэг нэрээр тусгай эмхэтгэл болгон барлаж байв. Энэ ажлыг хааны зарлигаар байгуулсан “Бүгд хууль бичгийн хороо” (会典馆) эрхлэн зохиож, барладаг байжээ. Эмхэтгэлийг Манжийн төрийн яамдын хүрээнд хадгалахаас бус, “Хууль зүйлийн бичиг”, “Цаг тооны бичиг”-ийн адилаар орон даяар тараадаггүй ажээ. “Дайчин улсын бүгд хууль бичиг”-ийг нийтдээ 5 удаа эмхэтгэн барлажээ. Тэдгээр нь Энх-Амгалан хааны 1690 оны, Найралт төв хааны 1732 оны, Тэнгэрийн тэтгэсэн хааны 1764 оны, Сайшаалтай ерөөлт хааны 1818 оны, Бадаргуулт төр хааны 1899 оны хэвлэл юм. Эхний хоёр хэвлэл нутгийн зураггүй, товч тэмдэглэлтэй. Сүүлийн 3 хэвлэл нь товч тэмдэглэл болон нутгийн зурагтай. Хамгийн бүрэн бүтэн хийгдсэн нь Бадаргуулт төрийн үеийнх гэдэг. Уг хуулинд Монголын аймаг, хошуудын зургийг Манж чин гүрний бусад бүх муж, хязгаарын адил нэгтгэн зурсан учир хэмжээний хувьд багасч, мэдээлэл ихэд товч болжээ. Б.Оюунбилигийн нягталснаар 1818 оны хэвлэлээс эхлэн Монгол хошуудын нутгийн зургийн ашиглан дөрвөн зүг, найман зовхисыг тэмдэглэх болсон байна.<sup>36</sup>

“Дайчин улсын бүгд хууль бичиг”-ийн зэрэгцээ “Дайчин улсын хамтатган тэмдэглэсэн бичиг” буюу “Да Чин И Тунжы” (大清一统志) гэх зохиолд Монгол хошуудын нутаг дэвсгэрийн тэмдэглэл, нутгийн зургийг бусад муж, хязгаарын хамт 3 удаа бараар хэвлэжээ. Уг ажлыг “Хамтатган тэмдэглэсэн бичгийн хороо” (统志馆)-ноос эрхлэн хийдэг байв. Эхний 2 нь нутгийн тодорхойлолт, зурагтай, сүүлийн хэвлэл нь нутгийн зураггүй, товч тодорхойлолттой юм. “Дайчин улсын хамтатган тэмдэглэсэн бичиг”-т байгаа мэдээлэл, барласан он цаг хоёр хоорондоо зөрүүтэй байдаг. Уг бичгийг анх Энх-Амгалан хааны үед 1684 оноос эхлэн найруулж, Тэнгэрийн тэтгэсэн хааны үед 1743 онд бараар хэвлэсэн ч доторх мэдээлэл нь Энх Амгалан хааны үеийнх юм. 1764 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар уг бичгийг дахин найруулан хэвлэжээ. Гуравдахь удаад Сайшаалтай ерөөлт хааны цагт дахин шинэчлэн найруулах ажил эхэлж, Төр гэрэлт хааны үед буюу 1842 онд барласны агуулга нь өмнөх хааны үед холбогддог.

“Дайчин улсын бүгд хууль бичиг”-т буй мэдээлэл Монгол нутгийн зурагт үндэслэсэн бол “Дайчин улсын хамтатган тэмдэглэсэн бичиг” нь Тэнгэрийн тэтгэсэн хааны үед зохиосон “Дотоод яамны хураангуй зураг”-ийг ашигласан байдаг ажээ.<sup>37</sup> Дээрх хууль

<sup>36</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 003

<sup>37</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 003

бичгүүдэд хошуудын нутгийн дөрвөн зүг, найман зовхис (дөрвөн зүг, дөрвөн зовхис)-ыг бичиж, багасган зурдаг байсан тул хэмжээний хувьд бага, агуулах мэдээлэл хомс болдог. Чухамдаа тэдгээр тэмдэглэлийг гол хэрэглэгдэхүүн болгон ашиглаж Хятадын судлаач Жан му, Хэ цю тао нар “Монголын бэлчээр нутгийн тэмдэглэл” гэдэг түүхэн газарзүйн бүтээлийг 1867 онд бичсэн билээ.<sup>38</sup>

Манжийн төрөөс даалгасны дагуу аймаг, хошуу, харуул, өртөө бүр өөрсдийн нутаг дэвсгэрийн зах хязгаарыг нарийн тодорхойлох болсон ажээ. Аймаг, хошууд нутгийнхаа захын уул, толгой, хяр зэрэг өндөрлөг газарт мод, чулуугаар овоо босгон нутгийн заагийг тогтоож байв. Говь, хээрийн хошуудад тал газар чулуу овоолон овоо үйлдэх нь нийтлэг юм.

### **Монголчуудын хил заагийн талаарх ойлголт**

Монголын аймаг, хошуудын нутаг дэвсгэрийн хил заагтай холбогдох нутгийн зах, захын овоо, овооны тэмдэг, хилийн овоо, хайч овоо, хязгаар овоо, нутгийн дээс зэрэг хэдэн үндсэн ойлголт бий.

Нутгийн зах. Анх Монголын овог, аймаг, улсууд нутаг дэвсгэрийнхээ зах хязгаарыг тодорхой уул, овоо, гол мөрнөөр багцаалан үздэг байсныг нутгийн зах хэмээнэ. Түүний дараагаар нутгийн захыг илүү тодорхой болгохын тулд овоо босгон тэмдэглэх болжээ.

Нутгийн захын овоо. Нутгийнхаа зах газруудад овоо босгон тэмдэглэх болсон нь эрт үеэс улбаатай. Монгол нутаг дахь эртний хүмүүс амьдарч байсан нутгийнхаа хад чулуунд сүг зураг, дараа нь тамга сийлж тэмдэглэдэг байв. Хожмын малчин монголчууд нутгийнхаа захын уул толгод дээр чулуу овоолж, эсхүл мод бургас тулж овоо босгодог болжээ. Үүнийг нутгийн захын овоо хэмээнэ. Бүр сүүлд захын овоодыг нэмж олноор босгоод тэдний хоорондын зайг хэмжиж, зах хязгаарыг нарийвчлан тогтоох болжээ. Хошуудын нутгийн зургаас захын өндөрлөг газарт овоо босгоод тэдгээрийг хооронд нь шулуун холбох байдлаар зах хязгаараа дүрсэлснийг харж болно. Нутгийн захын овоог байц овоо гэж нэрийдсэн нь бас тааралдана. Чингэж нэрийдэх болсон нь тэдгээр овоог байнга байцаан үзэж шалгадаг байснаас үүдэлтэй бололтой.

Овоог ихэвчлэн чулуу овоолж босгодог. Ой мод ихтэй газарт мод, бургасаар босгох нь элбэг байдаг. Тэгш тал газарт чулуугаар овоо үйлдэнэ. Мөн зассан өндөр шон модонд бичиг бичиж, чулуун овооны голд газар ухаг суулгадаг. Түүнд аль аймаг хошууны, ямар нэртэй, хэддүгээр овоо болохыг бичдэг. Үүнийг овооны тэмдэг хэмээнэ. Тэмдэгийг бас овооны голд чулууны дунд хатгадаг. Аймаг, чуулган зэрэг том эзэмшлийн хооронд хоёр талаас харалдаа давхар овоотой байх нь бий. Тэдгээр хоёр овооны хооронд багахан хэмжээний дундын газар бас байжээ.

Хилийн овоо. Улсын хилийн овоодыг хайч овоо, хязгаар овоо гэж ялгана. Хилийн овоог нураах, буулгах, өөр газар зөөж шилжүүлэхээс сэргийлэн тухайн өндөрлөг газрын хоёр талын бэл хормойд модонд бичиг бичээд нууцаар булаах явдал байв. Хоёр талын нутгийн захад байгуулсан овоог харуулын овоо, хайч овоо гэх зэргээр хэлдэг. Харуулчид хилийн шугамыг шалгахдаа зэргэлдээх харуултай хайчлан уулзаж зөрдөг овоо тул хайч овоо хэмээнэ. Хоёр улсын хайч овооны дундын газар буюу хилийн шугам дээр босгосон овоог хязгаар овоо хэмээнэ. Монгол, Оросын хил хайч овоо, 2 талын хязгаар овоо гэсэн цувраа 3 овооноос бүрдэх тул хилийн шугам хоёр давхар байжээ. Овоод хоорондох хилийн торгон шугамыг тодотгохдоо яртай модыг морин цуваагаар чирэн зурдаг байв.<sup>39</sup> XVIII зуунаас маргалдаж эхэлсэн Халх-Баргын нутгийн хил бас хайч овоо, дундаа хязгаар овоотой байжээ.

Нутгийн дээс. Нутгийн захыг газар дээр нь нарийвчлан тогтоосон илүү нарийн шугам, тодотгол юм. Хошуудын нутгийн захын овоод хоорондын зайг тодорхой хэмжээгээр

<sup>38</sup> Мэнь-гу-ю-му-цзи. Записки о Монгольскихъ кочевьяхъ. Переводъ съ китайскаго П.С.Попова. С-Петербургъ. 1895; Монголын хошуу нутгийн тэмдэглэл. Намжун, Банзрагч монголчлов. Дээд дэвтэр. 1988, дунд дэвтэр 1990, доод дэвтэр. 1992. Бээжин

<sup>39</sup> Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2002. т. 188



зангидсан дээсээр хэмжиж гаргадаг байснаас нутгийн дээс гэсэн ойлголт үүссэн гэж үзвэл зохистой. Энэ нь тухайн нутгийн хилийн заагийг илэрхийлнэ. “Нутгийн дээс давлаа” гэх хэллэг нутгийнхаа хилээс гарлаа гэсэн утгатай. Тэр дээс ямар хэмжээтэй вэ? гэхүл нэг алд (1.6 м)-ын дайтай байх магадлал өндөр юм. Алд бол нутаг дэвсгэрийг хэмжих уртын хэмжүүрийн үндсэн 4 нэгж (газар, хувь, алд, тохой)-ийн нэг агаад морин дээр авч явахад, бас хэмжихэд илүү тохиромжтой юм. Харин Ц.Шагдарсүрэн авгай нутгийн дээсийг арай өөрөөр тайлбарладаг. Түүнийхээр бол захын уул овоонд овоо босгодог, хад чулуун дээр тэр газрын нэрийг сийлж тэмдэглэдгийг нутгийн дээс гэж нэрлэдэг байсан ажээ.<sup>40</sup>

### **Нутгийн зураг үйлдэхэд хэрэглэх зүйлс**

Монголчуудын нутгийн зураг үйлдэхэд хэрэглэх гол эд зүйлсийн тоонд цаас, даавуу, бэх, хулсан үзэг, зүг чигийн хүрд ордог. Мөн 1868 онд Түшээт хан аймгийн Үйзэн засаг Чимэддоржийн хошууны нутгийн цэс үйлдэхэд “зүг үзэх толь”<sup>41</sup> хэрэглэн зүг чигийг тогтоосон тухай дурдсан нь луужинг хэлсэн байж магадгүй юм. Нутгийн зургийг гол төлөв цаас, даавуун дээр зурна. Зургийн үндсэн дүрслэл болон бичвэрийг хар өнгийн, хэмжээсийн дөрвөлжин тор, нутгийн зах, хилийн шугамыг улаан, зургийн бусад тэмдэглэгээг шар, ногоон, цэнхэр, ягаан өнгийн бэхээр зурна. Бичвэрийг бага зайд жижиг хэмжээгээр шахаж бичих тул голдуу нарийвтар хулсан үзгийг хэрэглэдэг.

Зүг чигийн хүрд. Уг хүрд 24 зүг чигийн нарийвчлалтай. Үүнийг хуваарь гэнэ. Хүрдийн 24 зүг чиг Монголын 12 жилийн амьтан, 8 өнгө, зурхайн 4 хүлэлээс бүрдэнэ. Үүнийг бас тухайн цагийн албан бичигт “цаг улирлын тооны хорин дөрвөн зүг” гэж бичсэн байдаг. Дээрх 24 зүгийг гурван зүйлээр дэлгэрүүлэн тоочсу. Үүнд,

12 жилийн амьтан: хулгана (хойд зүг), үхэр, бар, туулай (зүүн зүг), луу, могой, морь (урд зүг), хонь, бич, тахиа (баруун зүг), нохой, гахай,

8 өнгө: хар (эр өнгө), харагчин (эм өнгө), хөх, хөхөгчин, улаан, улаагчин, цагаан, цагаагчин,

4 хүлэл: зогсолт (зүүн хойд зовхис), орлого буюу оролт (зүүн өмнөд зовхис), эевэрхүү (баруун өмнөд зовхис), мөнх (баруун хойд зовхис)

Энэхүү 4 хүлэл нь Дорно дахины зурхайн ухаанд хэрэглэдэг 8 хүлэлээс зээлдэн авч хэрэглэсэн зүйл юм. Тэрхүү 8 хүлэл нь

зогсолт ☰, шавардал ☷, мөнх ☶, хөдлөл ☵,



оролт-орлого ☱, гэрлүл ☲, эевэрхүү ☴, баясал ☳ ажээ. Монголчууд хүлэлийг хэзээ, хэрхэн авч хэрэглэж эхэлснийг тусгайлан судлах хэрэгтэй юм.

Анх судлаач Б.Гончигдорж авгай Монгол нутгийн зургийн 1 зүгт 15° багтаж байсан хэмээн тэмдэглэжээ. Түүнийг бичснийг үндэслэвэл, 24 зүг чиг нь ертөнцийн 360 хэмийн (1 хэм x 15° = 360°) хураангуйлсан хэлбэр болох ажээ. Эндээс тухайн цагийн монголчуудын газарзүйн мэдлэг орчин цагийн шинжлэх ухааны төвшнөөс ор хоцроогүй байсныг харна. Үндсэн дөрвөн зүгийг дурдвал, хойд хулгана зүг -0°, зүүн туулай зүг -90°, урд морин зүг -180°, баруун тахиа зүг -270° болох юм. Дөрвөн зовхис нь, зогсолт зүүн хойд -45°, мөнх баруун хойд -315°, орлого зүүн өмнө -135°, эевэрхүү баруун өмнө -225° ажээ. Бүр хожим 2012 онд Японы судлаач О.Иноүе нутгийн зургийн 24 зүгийг хятад нэршил болон газарзүйн хэмээр харьцуулсан хүснэгт хийсэн байдаг.

### *Зураг № 1. Зүг чигийн хүрд*

<sup>40</sup> Ц.Шагдарсүрэн. Монголчуудын уламжлалт газрын зураг. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991. т. 68

<sup>41</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-9, д-3, хн-5289, б-17. Өргөх цэс




Монголчууд зүг чигийг 24 хуваасан хүрд ашиглан нутгийн зураг үйлдэж байсан нь тухайн цаг үеийнхээ шаардлагад нийцэж байв. Тэр цагийн нутгийн гар зургууд орчин цагийн солбицлыг цаг, минут, секундээр нягталдаг зураг зүйн салбар шинжлэх (картография) ухааны шалгуурт бүрэн нийцэж чадахгүй гэдэг нь тун илэрхий зүйл билээ. Б.Насандалайн судалж нягталснаар Монгол нутгийн зургийн зүг чигийн хэмжээ дэлхийн уртраг, өргөргөөр 45°-ээр зөрсөн байдаг.<sup>42</sup>

Гэхдээ монголчууд нутгийн зураг үйлдэхдээ 24 зүг чиг заадаг хүрдийг шууд хэрэглэж эхлээгүй билээ. Эхэн үедээ аймаг, хошууны нутгийн зурагт ертөнцийн зүг чигийг тэмдэглэдэг байв. Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас ч нутгийн зурагт 4 зүг, 8 зовхис бичихийг даалгаж байв. Тэр талаар Халхын Түшээт хан аймгийн нутгийн 1730-1740 оны бүдүүвч зурагт “энэ нь журганд бичиг барихад гэж барьсан дүрэм буй. Тэнгэвч журганд 4 зүг, 4 зовхисын газрын нэрийг тавьж барисан” хэмээн өгүүлсэн байдаг. Чингэж шаардаж байсан нь Манжийн Чин улсын бүх нутаг дэвсгэрийг хамарсан нутгийн зураг, товч тэмдэглэлийн эмхэтгэл хэвлэхэд ашиглах зорилготой байсан билээ.

*Нутгийн зураг № 6. Түшээт хан аймгийн Дайчин засаг Төрболдын хошууны нутгийн зураг (1891)*

<sup>42</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 003



Харин амьдрал дээр бодит байдал тэс өөр, уг шаардлагыг тэр бүр ягштал дагаж мөрддөггүй байсан нь хошуудын нутгийн зургаас харагдана. Олон хошуудын эхэн үеийн нутгийн зурагт ертөнцийн зүг чигийг бараг тавиагүй байдаг. Дараагаар нь нутгийн зурагт үндсэн 4 зүг болох өмнөд этгээд (өмнөд зүг), хойд этгээд (хойд зүг), зүүн этгээд (зүүн зүг), баруун этгээд (баруун зүг)-ийг бичих явдал тогтмолжсон ажээ. Бүр сүүлд XIX зууны эхэн үеэс хошууны нутгийн зурагт 4 зүг дээр нэмж 4 зовхис (зүүн хойд, зүүн өмнөд, баруун хойд баруун өмнөд)-ыг тэмдэглэх нь нэг мөр жигдрэх хандлагатай болсон байна. Энэ талаарх албан бичгийн мэдээг дурдвал, 1805 онд Ар Монголыг ерөнхийлөн захирах Улиастайн жанжны бичигт “байцааваас Халхын дөрвөн аймгийн наян дөрвөн хошууны нутаглах газарт угтаа цөм овоо байгуулж, хязгаар хэлхээг тэмдэглэсэн бөгөөд зурсан газар орны зургийг харьяат жанжин амбасын газарт хадгалсан” ба олон хошуудын нутгийн “дөрвөн этгээд найман зүгт хүрэх газрыг тодорхойлон” байцаасан зураг нэг хувийг үйлдэж ирүүлэхийг тушаасан тухай өгүүлдэг.<sup>43</sup> Тэдгээр нутгийн зургийг Сайшаалтай ерөөлт хааны (1796-1820) зарлиг ёсоор “Олон мужийн хэргийг шийтгэх хураангуй хууль бичиг зохиож үйлдэх газар”-т нийлүүлэн нэгдсэн зураг үйлдэж хаанд толилуулахаар бэлдэх зорилготой байжээ.

Дээрх шийдвэрийн дагуу мөн онд Халхын дөрвөн аймгийн чуулган даргын газруудаас харьяа хошуудад “урьд олон хошууны нутаглах газрыг хуваасан цагт байгуулсан овооны нэр” болон “басхүү өөр өөрийн нутгийн дөрвөн этгээд, найман зүг”-т зах нийлсэн газрыг тодорхойлон зураг зурж ирүүлэхийг тушаажээ.<sup>44</sup> Манж Чин улсын бүх нутгийн зураг, товч тэмдэглэлийн эмхэтгэлийн 1818 оны хэвлэлээс Монгол хошуудын нутгийн дөрвөн зүг, найман зовхисыг тэмдэглэж эхэлсэн нь хошууд нутгийн зурагтаа ертөнцийн зүг чигийг бичдэг болсонтой холбоотой юм.

Чухам хэдий үеэс нутгийн зурагт 24 зүг чигийг албан ёсоор хэрэглэж эхэлснийг яг таг хэлэхэд түвэгтэй. Одоогоор мэдэгдэж байгаагаар зүг чигийн хүрд ашиглан үйлдсэн анхны нутгийн зураг 1891 онд холбогдож байна. Тухайлан хэлбэл, Түшээт хан аймгийн Цогтой засаг, Дайчин засгийн хошууны 1891 оны нутгийн зурагт 24 зүг чигийг тодорхой гаргаж, тойруулан бичжээ. Түүнээс нэлээн хожуу 1907 оны албан бичгүүдэд 24 зүг зүгийг хэрэглэн нутгийн зураг зурсан тухай бичиж, бас нутгийн зургуудад ч түүнийг ашигласнаа илтэд тэмдэглэсэн байдаг.

### **Нутгийн цэс**

<sup>43</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-172, б-5. Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин хэбэй амбаст өргөсөн бичиг

<sup>44</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-172, б-39. Хар дэл засаг Гомбожавын тамгын туслагч, түшмэдийн бичиг

Нутгийн цэс (nutuγ-un čēsě) бол монголчуудын нутгийн тэмдэглэл-ойллогын нэг төрөл юм. Хошуу, харуул, өртөөний нутаг дэвсгэрийн хэмжээ, уулын өндөр, нам, модтой, нүцгэн, захын овоодын хоорондох зай, зүг чиг, дугаар, аль талаар ямар нутагтай зах нийлэх зэргийг тодорхойлон бичсэнийг нутгийн цэс хэмээнэ. Харин Ц.Шагдарсүрэн авгай үүнийг “нутгийн өгүүлэл цэс” гэж нэрийдсэн байдаг. Дийлэнх цэсийг “нутгийн цэс” хэмээн бичдэг бөгөөд “нутгийн өгүүлэл”, “нутгийн өргөх цэс”, “нутгийн цэс дэвтэр”, “нутгийн өгүүлэл цэс”, “өргөх цэс” гэж нэрлэсэн нь харин цөөхөн юм.

Он цагийн хувьд цэс нь нутгийн зургийн дараа бий болжээ. Нутгийн зургийг илүү нарийн зөв үйлдэхийн тулд тухайн газрыг дэлгэрэнгүй тодорхойлж, хэмжиж бичих хэрэгтэй болсон байна. Тийнхүү хошууны нутгийн зураг үйлдэхийн өмнө түүний үндэс суурь болох цэсийг эхэлж бичдэг болов. Хошууны түшмэд нутгаараа явж уул нуруу, гол мөрөн, булаг шанд, зам, захын овоод зэргийг хэмжиж, зүг чигийн хүрд ашиглан тодорхойлж “... харагчинаас туулайн зүг зургаан газар найман хувь хорин дөрвөн алд” гэх зэргээр бичнэ.

Нутгийн цэсийг ихэвчлэн нугалбар бичгийн байдалтай бичдэг. Заримдаа нутгийн цэсийн араас нутгийн зураг наасан нь тааралдана. Тэр нь том цаасан дээр үйлдсэн нутгийн зураг, нугалбар цаасан дээр зурсан тухайлсан багавтар нутгийн, хэдэн овооны нутгийн зураг зэрэг юм. Тухайлан дурдвал, 1907 онд Халхын Сэцэн ханы хошууны нутгийн цэсийн араас нутгийн зургийг залган наасан байдаг.

Монголын хошуу, тамгатай хутагтын шавь бүр нутгийн цэстэй байв. Нутгийн цэсийг хэдэн хувь үйлдэж, нутгийн зургийн хамт хошууны тамгын газарт хадгалдаг ажээ. Мөн нутгийн цэсийг нутгийн зурагт дагалдуулан аймгийн чуулганы даргын газарт өргөдөг байв. Хошуудын нутгийг цэсийг нэгтгэн аймгийн нутгийн цэсийг бичдэг ажээ. Халхын Сэцэн хан, Түшээт хан аймгийн хэд хэдэн нутгийн цэс уламжлан ирсэн байдаг. Хошуудын зэрэгцээ гэр харуул, өртөөд нутгийн цэсээ үйлддэг байв. Гэр харуул тус бүрийн нутгийн цэс цөөвтөр, харин харьяалан захирах аймгийн олон харуулын нутгийг нэгтгэн бичсэн цэс нэлээд хэд үлджээ. Тухайлан Сэцэн хан аймгийн Хорин нарс харуулын цэс (1907), Сэцэн хан аймгийн 14 гэр харуулын нутгийн цэс (1865), Сайн ноён аймгийн 12 гэр харуулын нутгийн (1903, 1907) цэсийг дурдаж болно. Өртөөний нутгийн цэс тун цөөхөн агаад өртөө тус бүрээр биш, тухайн өртөөний чиглэлээр нэгтгэн хийдэг байжээ.

Нутгийн цэсийг нарийн тодорхой үйлддэг байсан хэдий ч түүний бүх мэдээлэл нутгийн зураг бүрт бүрэн тусч чаддаггүй байв. Учир иймийн тул хэт бага хэмжээтэй, мэдээлэл багатай нутгийн зургийн дутуу сул талыг нутгийн цэсээр нөхвөрлөн тодотгож ойлгох хэрэг гарна. Нутгийн цэсийг тусгайлан судалбал түүнд агуулж буй мэдээллийн үнэ цэнийг улам илүү агаад үнэн зөвөөр ойлгоно. Тэр цагийн сайн хийсэн нутгийн цэсэнд тулгуурлан өнөө цагт хошууны нутгийн зургийг сэргээн зурах боломжтой. Монголчууд нутгийнхаа уул овоо, худаг ус нэрийг цэсэнд бичиж, зурагт тэмдэглэхээс гадна хад чулуун дээр сийлж үлдээх явдал бас байв. Ийм нэгэн эдийн баримтыг Ц.Шагдарсүрэн авгай сурвалжлан олж тэмдэглэсэн нь, Түшээт хан аймгийн Зоригт засгийн хошууны нутгийн (Төв аймгийн Эрдэнэсант сум) нэг хаданд “Гүнцэлийн Цүүгэл булаг энэ”<sup>45</sup> гэж сийлсэн бичээс ажээ.

#### **Нутгийн зургийн хувьсал өөрчлөлт**

Монгол хошуудын эхэн үеийн нутгийн зурагт зонхилох уул нуруу, гол нуурыг зурж нэрийг бичсэн, гаднах зах хязгаарыг нарийн сайн гаргаагүй, зүг чиг заасан бичвэр алдаг оног байдаг. Ийм нутгийн зургийг судлаач А.Камимүра хэлбэргүй гэж нэрлэсэн байдаг. Дараагийн үеийн нутгийн зурагт хошууны нутаг дэвсгэрийн дөрвөн зүг, дөрвөн зовхисыг тэмдэглэж, зах хязгаарыг шугаман зураасаар тодорхой гаргах болов. Үүнийг хэлбэртэй зураг хэмээсэн нь бас л оновчтой нэрийдэл биш юм. Бүх нутгийн зураг өөрийн гэсэн

<sup>45</sup> Ц.Шагдарсүрэн. Монголчуудын уламжлалт газрын зураг. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991. т. 69

хэлбэр дүрстэй тул хэлбэргүй зураг гэж огт байдаггүй. Харин нутгийн зургийг зах хязгаарыг тодорхой гаргаагүй болон тодруулж дүрсэлсэн гэж ялгаж болох юм. Нутгийн зураг үйлдэх хувьсал хөгжлийн үе шатын дагуу эхлээд зах хязгаарыг тэр бүр нарийн зурдаггүй байснаа дараа нь үргэлжилсэн зураас болон цэгэн зураасаар тэмдэглэдэг болсон гэж үзэх нь зүйтэй.

Ер нь Монголын хошуудыг шууд л бүрэн гүйцэд нутгийн зураг хийгээд эхэлсэн гэж ойлгож болохгүй. Хошуудын эхэн үеийн нутгийн зураг гарчиг, он цаггүй, ертөнцийн зүг зүгийг тавиагүй, цөөн хэдэн уул, нуурыг зурж бичиж, ерөнхий баримжааг гаргасан байдалтай байдаг. Харин дараа дараагийн нутгийн зургуудад уул, нуруу, толгой, гол, булаг, худаг зэрэг байгаль-газарзүйн биетийн дүрслэл нэмэгдэж, хэний хошууны зураг болох тухай гарчиг, төгсгөлийн бичвэр-үйлдсэн огноо (он, сар, өдөр), зүг чиг бичиж, зах хязгаарын шугамыг бүрэн гүйцэд дүрсэлдэг болжээ. Яг ийм хувьсал өөрчлөлтийн үйл явц Халхын Сайн ноён хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зургийн зургуудад тодхон тусч үлдсэн байдаг.

Мөн аймгийн нутгийн зургийг үйлдэхийн өмнө эхлээд бүдүүвч байдлаар дүрсэлдэг байв. Түшээт хан аймгийн 1730-1742 оны хооронд үйлдсэн нутгийн зурагт том дөрвөлжин хүснэгтийн дотор Түшээт хан аймгийн 13 хошууны нутгийн багцаа байдлаар засаг ноёны нэрийг тавьж, гадуур нь Орос зүгийн гэр харуул, эргэн тойрны чухал гол, газруудын нэрийг бичжээ. Ийм дэвсгэр зураг хийсний дараа хошуудын нутгийн зургийг ашиглан аймгийн нутгийн зураг үйлдэж байв.

Нутгийн зураг бүрийг урд зүгээс эхлүүлэн зурдаг гэж үзэх нь учир дутагдалтай болохгүй. Нэлээд олон хошуу нутгийнхаа хойд зүгээс харж зургаа зураад бичвэр, гарчиг, үйлдсэн огноог бичсэн байдаг. Нутгийн зургийг хоёр талаас нь буюу урд, хойд зүгээс харж зурах явдал зэрэгцэн оршиж байгаад хожим хүрд ашиглан 24 зүг чигийн хуваарийг нарны цацраг мэт татаж суурь дэвсгэр болгоод урд-морин зүгээс эхлэн нар зөв эргүүлэн зурах болжээ. Нутгийн зурагт гол мөрөн, уул нуруу, овоо, сүм хийд, ноёны орд өргөө, зам, өртөө, худаг булаг шанд ус, захын овоодыг зурж зах нийлж байгаа хошуудыг тэмдэглэнэ. Зарим нутгийн зурагт голын урсгалын чиг, нуурын цэнгэг, давстай эсэх, уулын модтой, модгүйг нарийвчлан дүрсэлсэн байдаг.

Нутгийн зурагт тухайн хошууны захын овоодыг ялгаатай тэмдэглэдэг. Зарим нутгийн зурагт хошууны захын овоог дугаарлалгүйгээр нэрийг нь бичдэг бол нөгөө хэсэг зурагт нутгийн захын овоодыг дугаарлаж нэрийг бичсэн байдаг. Харин нутгийн зурагт сум, баг, хорин, арван, отог, хамжлага зэрэг хошуудын дотоод засаг захиргааны нэгжийг зурж тэмдэглэдэггүй байв.

Б.Гончигдорж авгайн судалснаар аймаг, хошуудын нутгийн зураг дахь уул, овоо, гол, мөрөн, ноёдын өргөө, сүм хийд, ой мод, булаг шанд, хилийн овоодын дүрслэлүүд “Монгол үндэсний уран зургийн арга барилаар” хийгдсэн ажээ. Тэдгээрийг “хэвтээ тусгал (проект) буюу дээрээс харсан байдал, нүүрийн тусгал буюу өмнө талаас харсан байдал хоёрыг нэг дүрслэл дээр хамтатган”<sup>46</sup> хэрэглэсэн байна. Үнэхээр Монгол нутгийн зурагт ийм хоёр дүрслэлийн аль аль нь байдаг. Нэлээд хожим “аливаа зүйлийг өмнөөс хойд зүг хандуулан” дүрслэхийг журамлан заах болсон байдаг.

XVI зуунаас Монголд бурхны шашин өргөн дэлгэрсэнтэй холбоотойгоор Энэтхэг, Түвд, Хятадын газар шинжих ухаан нэвтэрч, улмаар хөгжжээ. Монгол лам нар газрын шинжийн судар зохиох болж, энэ талаар Авга дэг, Боржигин дэг, Далай вангийн дэг сургууль хүртэл бий болов.<sup>47</sup> Газрын шинжийн сударт их төлөв уулсын дүрсийг газарзүйн төлөв байдлаар нь нарийн шинжиж олон төрөл болгон ялгасан байдаг. Монголчуудын газар шинжих ухаан нутгийн зураг дахь уул усын дүрслэлд ямар нэгэн хэмжээгээр туссан байх учиртай. Энэ талаар тусгайлан судалбал сонирхолтой судалгаа болох нь дамжиггүй.

<sup>46</sup> Б.Гончигдорж. Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудал. ШУАМэдээ. № 1. 1970. УБ., т. 55

<sup>47</sup> Газрын шинжийн Монгол судар. монгол, англи хэлнээр орчуулсан Б.Няммягмар. УБ., 2012. т. 3-9

Дийлэнх нутгийн зурагт үйлдсэн цаас, даавууны зүүн талд аль аймаг, ямар хошууны, ямар хэргэм, зэрэг, цолтой, хэн гэдэг ноёны нутгийн зураг болохыг, баруун захад нь ямар төрийн, хэдэн оны, хэдэн сарын хэдний өдөр үйлдсэн болохыг бичдэг. Нутгийн зургийн гарчигт хошууны ноёны нэрийг орхиж, түүний хэргэм, цол хэдэн зэрэг нэмсэн, тэмдэглэснийг бичих нь нийтлэг байв. Энэ нь ноёныхоо нэр усыг бүтнээр, ил хэлэхийг цээрлэдэг ёстой холбоотой байж магадгүй. Басхүү зургийн гарчиг, огноо хоёрыг, эсхүл аль нэгийг нь бичээгүй нутгийн зураг цөөнгүй байдаг.

### **Нутгийн зургийн баталгаажуулалт**

Аймаг, хошууны нутгийн зураг төрийн албан баримт тул гарчиг, төгсгөлийн бичвэр хоёр дээр болон үйлдсэн цаасны залгаас, зарим их хэмжээний бичвэр зэрэг дээр тамга дарж баталгаажуулна. Цөөнгүй нутгийн зурагт тамгыг төгсгөлийн бичвэр буюу зураг үйлдсэн огноо дээр дарсан байдаг. Тамга ор дараагүй нутгийн зураг ч нэлээд бий.

Монголын хошуудын нутгийн зургийг баталгаажуулсан байдлаар нь албан ёсны нутгийн зураг, нутгийн албан бус зураг, ноорог болон бусад зураг хэмээн гурав ангилж болохоор байна. Албан ёсны нутгийн зураг гэдэгт аль аймаг, хошуу, шавь, өртөө, харуулын зураг болох тухай гарчигтай, үйлдсэн огноо буюу төгсгөлийн бичвэртэй, тэдгээрт тамга дарж баталгаажуулсан зургийг багтаана. Албан бус зураг нь гарчиг болон төгсгөлийн бичвэртэй, бичвэргүйн алин боловч тамга дарж баталгаажуулаагүй нутгийн зургууд юм. Тамга дараагүй нутгийн зургийг албан ёсны бус, баталгаажуулаагүй нутгийн зураг хэмээн үзэж болох талтай ч түүнд буй мэдээлэл үнэ цэнэтэй хэвээр байна. Ноорог болон бусад гэдэгт нутаг дэвсгэрээ дутуу зурсан, доторх дүрслэл, бичвэр нь хэт бага, харьяалал ба он цагийг тэмдэглээгүй, тамга дарж баталгаажуулаагүй зургууд орно.

Аливаа хошууны нутгийн зургийг үйлдсний дараа тамга дарж баталгаажуулна. Учир нь хошууны нутгийн зурагт буй бүх дүрслэл, бичвэрийн үнэн магадыг албаны тамгаар баталгаажуулдаг ёстой. Тэгээд ч тамга дарж баталгаажуулаагүй нутгийн зургийг аймгийн чуулган даргын газар, Манж сайдын болон жанжны газар, улмаар Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд өргөн мэдүүлдэггүй байв. Нутгийн зурагт засаг ноён, хутагт ламын хувийн тамга дарсан тохиолдол одоогоор гараагүй байна. Үйлдсэн огноог бичээгүй зургийг ихэвчлэн тамга дарж баталгаажуулаагүй тал харагддаг. Монголын хошууд тамга дарж баталгаажуулсан нутгийн зургийн нэг хувийг авч үлдээд бусад албан бус зургийн хамт хошууны тамгын газарт хадгалж байсан нь тамгагүй нутгийн зураг цөөнгүй үлдэж хоцорсноос мэдэгдэнэ.

1727 оны Буурын гэрээгээр тогтоосон улсын хойд хилийг хамгаалах (59) гэр харуулд хуяг цэргүүд өрх гэр, хөрөнгө малын хамт нүүн очиж алба хаах тул хилийн шугам, оршин амьдрах, мал сүргээ адгуулах зураг, цэс бүхий тусгай нутагтай байв. Гэр харуулын нутгийг хошуудынхаас дутахгүй нарийн зурсан байдаг нь хилийн бүс нутгийг сэргийлэн сахих бодлоготой холбоотой. Гэр харуулын нутгийг харьяалах аймгаар (Түшээт хан аймгийн 14 гэр харуулын нутгийн зураг) нэгтгэж, эсхүл бас тухайн нэг харуулыг (Сэцэн хан аймгийн Хурц гэр харуулын нутгийн зураг) зурсан байдаг.

1864 оны Тарвагатайн гэрээгээр тогтоосон Монголын баруун хойд хилийн дагуух “Алтай зүгийн суман харуул”-ын (24) тухайлсан нутгийн зураг үлдэж хоцорсонгүй. Суман харуулыг аймаг, хошуудын нутгийн зурагт маш товчоор, зөвхөн нэрийг бичиж тэмдэглэжээ. Суман харуул нь цэргийн алба хаах журмаар ганц биеэр гурван жилийн хугацаагаар хаадаг алба учир бага хэдий ч харуулчдын адуу малыг адгуулах нутагтай, хилийн бүсийн зах заагтай байсан билээ. Алтайн нурууны өмнө талаар байсан Алтны харуулыг Засагт хан, Сайн ноён аймгийн өмнөд хошуудын нутгийн зурагт тэмдэглэсэн байдаг. Халх-Баргын нутгийн харуулын зураг олон байдаг нь нутаг дэвсгэрийн маргаан их гарч байснаас улбаатай.

1723 оноос Ар Монголд байгуулагдаж эхэлсэн өртөөд хэмжээний хувьд бага хэдий ч өөрийн нутагтай байсан нь тэдний зургаас тодорхой харагдана. Тэр нь элч, улаачийн явах зам, өртөөний алба хаагчдын алба, амины мал сүргийг маллах бэлчээр нутаг юм.

Харин дийлэнх өртөөний зургийг тусад нь бус, дайран гарах хошуудын нутаг зураг дээр ялгаж зурсан байдаг нь анх өртөөг байгуулахдаа тэдгээр хошуудын нутаг дэвсгэрээс газар таслан олгосонтой холбоотой билээ. Бас зарим чиглэлийн өртөөний тусгайлан үйлдсэн цөөн зураг хадгалагдан үлджээ. Өртөөдийг хэвтээ тусгал буюу дээрээс харсан байдлаар том онги хэлбэртэй дугуй зураад хооронд нь холбосон онцлог зургууд хэд хэд бий. Тэдгээр зургийг “туузан зураг” хэмээн нэрлэсэн нь тааралдана. Зургийн нэрийг арай өөрөөр “гинжин хэлхээст зураг” гэж хэлж болох юм. Мөн Сайр ус–Хүрээний өртөөдийн нутгийг тэгш дөрвөлжин хэлбэртэй зураад хооронд нь нийлүүлсэн зураг бас байдаг.

*Нутгийн зураг № 7. Хүрээ–Хиагтын 11 өртөөний нутгийн зураг (1907)*



Монголын хошууд нутгийн зургийг олон удаа зурдаг байсан нь тодорхой учир шалтгаантай. Нэгд, Манжийн засаг захиргаанаас хошуудын нутгийн зургийг үе үе шинэчлэн үйлдүүлж авдаг байсантай холбоотой. Дийлэнх хошуу нутгийн зургаа шинээр үйлддэг бол зарим нь өмнөх зургийг шинэчлэн хуулбарлаад оныг сольж бичдэг байв. Сэцэн хан аймгийн Саруул засаг Дамдинжавын хошууны тамгын газрынхан 1900 онд үйлдсэн нутгийн зургийг 1907 онд яг тэр хэвээр нь өнгө, үг үсгийн зөрүүгүй хуулбарлан зурж бичээд оныг шинэчлэн бичсэн удаатай. Хоёрт, Нутаг дэвсгэрийн маргаанаас үүдэн нутгийн зургийг олонтоо зурдаг байв. Энэ нь Халх–Баргын нутаг залгах Сэцэн хан аймгийн зүүн захын Илдэн засаг, Ачит засгийн хошуудад илүү тод харагдана. Тэдгээр хошууд өөрийн нутгийн зургаас гадна тухайлан Баргатай зах нийлэх газраар суулгасан харуул, хязгаар болон хайч овоодыг тусад нь зурж байв. Ер нь цөөнгүй нутгийн зурагт бусадтай маргаантай буй, өөр хошуу, тамгатай хутагтын шавьд өгсөн газруудыг тэмдэглэж, бас зурж үлдээсэн байдаг.

#### **Нутгийн зураг дахь тэмдэглэгээ**

Монгол хошуудын нутгийн зурагт буй тэмдэг тэмдэглэгээ өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Анхлан Ц.Шагдарсүрэн авгай нутгийн зургуудыг шүүрдэн үзэж, хил хязгаарын шугамаас авахуулаад зам, худаг хүртэлх тэмдэглэгээг нэгтгэсэн нь нийтдээ 28 болжээ. Тэрбээр эдгээрийг “зургийн дүрэм буюу зургийн илэдхэл” гэж нэрлэсэн юм.<sup>48</sup> Түүний надад хэлж тайлбарласнаар бол яг ийм нэртэй тусгай дүрэм, илтгэл байгаагүй, харин нутгийн зурагт бичигдсэн нэрээр ингэж нэрийдсэн ажээ. Угтаа энэ бол дүрэм, илтгэлийн алин ч бус, харин нутгийн зурагт буй тэмдэг тэмдэглэгээ юм. Тэрхүү нэгтгэсэн тэмдэглэгээг дүрслэн харуулбал доорх байдалтай болно. Үүнд,

*Хүснэгт № 1. Зургийн дүрэм буюу зургийн илэдхэл (Ц.Шагдарсүрэн)*

<sup>48</sup> Ц.Шагдарсүрэн. Монголчуудын уламжлалт газрын зураг. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991. т. 64-78

1.		Хил хязгаарын шугам, хилийн овоо	15.		Суурин гацаа, айл гэр, хүй гацаа
2.		Шинээр хошуу нутаг салгах зэрэгт татсан шинэ хязгаар	16.		Худаг ус
3.		Уул нуруу	17.		Сүм хийд
4.		Модтой уул	18.		Суварга
5.		Овоо	19.		Гүүр
6.		Ой мод, модтой газар	20.		Албаны гэр буюу засаг захиргаа түүний гэр нь
7.		Дэрстэй газар	21.		Засаг ноёны өргөө гэр
8.		Элс манх	22.		Харуул
9.		Гуу суваг	23.		Өртөө, өртөө зам
10.		Гол ус, түүний урсгалын чиг	24.		Тариалан
11.		Булаг шанд, цөөрөм	25.		Төмөр зам
12.		Нуур тэнгис	26.		Төмөр утасны шугам буюу утсан холбоо
13.		Давстай нуур	27.		Усан онгоц явж болохуйц гол мөрөн
14.		Ухаа толгод	28.		Зам

Ц.Шагдарсүрэн авгайн цуглуулсан мэдээлэл бүрэн бус тул нэмэлт болгон зарим тэмдэг тэмдэглэгээг нөхөн өгүүлсү. Нутгийн зургуудад тариалангийн газрыг арай өөрөөр тэгш өнцөгт хэлбэртэй хараар, бас ногоон өнгөөр будсан, хоосон дөрвөлжин гэсэн 3 хэлбэрээр тэмдэглэж, мөн талбай дээрх тарианы байшинг зурдаг байв. Өвсний газрыг мөн ногоон дөрвөлжингөөр тэмдэглэнэ. Мөн нутгийн захын овоодыг хэдэн янзаар тэмдэглэдгээс дунд нь модон тэмдэг босгосон, өндөр гурвалжин овоо зурдаг, босоо хос дөрвөлжин, том хар цэгэн • овоо, олон жижиг чулуу овоолдог, гурван дугуй чулуу овоолж тавьдаг, овооны голд мод бургас хатгадаг, онги О тамга, бүдүүн улаан цэг, гурвалжин тэмдэг гэсэн 10 тэмдэглэгээ лав бий. Өөр дутуу үлдээсэн тэмдэглэгээ бол намагтай газар юм. Үүнийг Түшээт хан аймгийн Ахай засаг Лувсанхайдавын хошуу зэрэг цөөн зурагт газрын нэрийг бичээд зурсныг олж үзээгүй бололтой. Мөн худгийг онги тамга, давхар онгин тамганы адил хэлбэртэй тэмдэглэдэг байжээ. Хэрэв өнгөт нутгийн зураг бол зах заагийг бүдүүн улаан цэгэн зураас, улаан, ягаан, улбар ягаан өнгийн шугаман зураасаар, хар цагаан нутгийн зурагт хар өнгийн шугаман зураасаар зурдаг. Тарианы талбайг услахаар голоос татдаг шуудууг голын урсгал шиг зурж усан цэнхэр өнгөөр буддаг байв. Замыг их төлөв хар өнгийн цэгэн зураасаар, цөөнхидөө хар шулуун шугамаар, заримдаа шар өнгөөр буддаг байв.















Малчин айлын өвөлжөөг хоёр янзаар зурдаг. Эхнийх нь бодит байдалд ойртуулан зурах, удаах нь тоймлон зурах юм. Мөн малчин айлын бууцыг тусгайлан зурж бичсэн байдаг. Бурхны шашны сүмийг олон янз байдлаар дүрсэлсэн байдаг нь ганц дуган зурах, хашаанд дотор 1 дуган зурах, давхар сүм зурах, хийдийг бүхлээр нь зурах зэрэг юм. Үнэн










алдартны сүмийг яг байгаагаар зурсан ганц нэг тохиолдол бий. Өртөөг бас ромбо ◇ хэлбэртэй, 3 болон 4 онги нийлүүлж, харуулыг бас X , □ дүрсээр тэмдэглэдэг байв.

Хот суурин газрыг зурахдаа гудамжийг тодорхой гаргадаг нь Хиагт хотын зурагт тусч үлджээ. Хошууны засаг ноёдын өргөө, гэр хүрээг их төлөв улаан халзтай гэрээр, заримд нь үүдэвч майхан залгаж барьсан халзтай гэрээр, энгийн дөрвөлжин дүрсээр зурж байв. Тамгын газар болон жасааг халзтай эсвэл халзгүй ганц гэрээр илэрхийлнэ. Язгууртны оршуулга, хошууны ноёдын дээд өвгөдийн бумба хүүрийг олон улаан цэгээр дөрвөлжилж, бас тахилын сүм, улаан тэмдэг, ширээ тамга хэлбэртэй дүрсэлж байв. Нас барсан хүн тавьдаг газрыг араг ясаар төлөөлүүлэн зурсан тохиолдол бий. Байгалийн тогтоцоос уул, нурууны зэрэгцээ хад, эргийг зурсан нь тааралдана. Эдгээр нэмж өгүүлсэн тэмдэг тэмдэглэгээг хүснэгтлэн харуулбал доорхи байдалтай харагдана.

Хүснэгт № 2. Нутгийн зургийн нэмэлт тэмдэг тэмдэглэгээ (Ж.Гэрэлбадрах)

1.	Засаг ноёны гэр хүрээ, тамгын газар, жасаа		12.	Өртөө	
2.	Овоо		13.	Харуул	
3.	Зам		14.	Малчны өвөлжөө	
4.	Худаг		15.	Бурханы шашны сүм	
5.	Усны шуудуу		16.	Үнэн алдартны сүм	
6.	Чингисийн хар туг		17.	Суварга	
7.	Эрэг, хад		18.	Тариалангийн газар, өвсний газар	

8.	Дэрс		19.	Хот суурин газар	
9.	Мод		20.	Язгууртны оршуулга, бумба хороо	
10.	Намагтай газар		21.	Хүн тавьдаг газар	
11.	Нутгийн зах		22.	Бууц	

Ер нь нутгийн зурагт тэмдэг тэмдэглэгээг зүгээр зураад зогсохгүй, уул, гол, дэрс, элс, булаг, хийд, харуул, өртөө гэх зэргээр нэрийг бичдэг. Модыг зурахын хамтад тэр ойг шинэ хуучнаар ялгаж “шинэ мод”, ямар төрлийн мод буйг “хус мод”, өтгөн сэлүүхнийг “шингэн мод”, “өтгөн мод”, “шингэн бут” гэх зэргээр тодруулан бичсэн нь тааралдана. Бас зарим нутгийн зурагт гол булгийг зурж нэрийг бичээд хажууд нь “энэ усгүй” гэж, нуурыг “энэ тогтмол” гэж тус тус тодотгосон, мөн тэдний урт өргөнийг бичсэн байдаг.

Хошууны нутгаар урсах голын нэрийг бичээд “Хэрлэн гол зүүн зүг урсмуй” хэмээн урсгалын чигийг, “урт нь жаран дөрвөн газар нэг хувь” гэж урсацын уртыг зааж өгдөг. Дайран өнгөрдөг замыг зураад доор нь “энэ зам Жибзундамба хутагтын хүрээ хүрмүй”, “энэ зам Хөх хот хүрмүй”, “энэ зам Долоон нуур хүрмүй” зэргээр хүрэх газрыг бичдэг байв. Бас тэдгээр зам тухайн хошууны нутагт хэдий хэр үргэлжилдэгийг “Нийслэл хүрээний зам нэг зуун дөчин хоёр газар” хэмээж, замын өргөнийг “өргөн нь хоёр алд хоёр чи” гэх зэргээр бичнэ.

Монгол уран зургийн хэдэн дүрслэл нутгийн зурагт тусгалаа олсон байдаг. Зарим нутгийн зургуудад буй хурц шовх хэлбэртэй уулын дүрслэл, нуурын долгио, голын урсгалыг янз бүрээр хээлэн харуулсан нь уран зураг зураг гэлтэй харагдана. Нутгийн зурагт булаг, дэрс, мод, элс, зам, сүм хийд, монгол гэр, уул нуруу зэргийг хэрхэн зурж дүрсэлснийг урлагийн талаас тусгайлан авч судалбал сонирхолтой үр дүн гарах нь эргэлзээгүй. Энд тухайлан Засагт хан аймгийн Далай засгийн хошууны нутгийн зурагт Сангийн далай, Зүүн нуурыг олон жижиг хээгээр долгиолуулан зурж давалгааг харуулаад нуур бүрт хос ангир, 2-3 хун шувууг өнгө ялган зурсан, Хан Тайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошууны нутгийн зурагт Тэлмэн нуурын дотор томоо гэгчийн загас зурсан байдгийг онцлон дурдах байна.

### Нутгийн зургийн өнгө


















Монгол нутгийн зургийг өнгөөр нь хар цагаан, өнгө ялгасан, өнгөт хэмээн ялгаж болно. Хар цагаан нутгийн зураг бол цаас, даавуун дээр дан хар өнгийн бэхээр үйлдсэн зураг юм. Өнгө ялгасан нутгийн зураг нь хошууны нутгийн захын болон хэмжээсийн торын зураас, уул овоо, гол нуур зэрэг ямар нэг дүрсийг будсан зураг юм. Өнгөт нутгийн зураг гэдэг нь тухайн зурагт туссан нутаг дэвсгэрийг бүхэлд нь ногоон, хөх өнгөөр будсан зураг ажээ. Эхэн үедээ хар цагаан нутгийн зураг зонхилж байсан ахул дараа нь өнгө ялгасан, өнгөт нутгийн зураг давамгайлсан болсон ажээ.

Хар бол нутгийн зургийн суурь дэвсгэр өнгө юм. Нутгийн зургийн бүх дүрслэлийн үндсэн зураас, бичвэрийг хараар үйлдэнэ. Бас зам, нутгийн зах хязгаарын шугамыг хүртэл хараар зурах нь түгээмэл тааралдана. Хар өнгө дээр улаан, шар, хөх өнгө нэмэгдэж, монголчуудын үндсэн 4 өнгө болно. Мөн ягаан өнгийг бас хэрэглэдэг. Хараар зурж

дүрсэлсэн суурь дэвсгэр дээр улаан, улбар шар, улаан хүрэн өнгөөр хошуу, өртөө, харуулын нутгийн зааг, хэмжээсийн дөрвөлжин тор, засаг ноёдын гэрийн халз зэргийг, хөх цэнхэр өнгөөр мөрөн, гол, нуур, тойром бүрдийг, ногооноор, ой мод, бут дэрс, тариалангийн талбай, өвсний газрыг, шар өнгөөр замыг, ягаанаар элсийг будаж тэмдэглэдэг байв.


Цөөнгүй нутгийн зурагт уул ус, захын овоодыг зурангаа нэрийг бичилгүй зураг дууссаны дараа улаан цаасан (ягаан, цагаан ганц нэг таарахыг эс тооцвол) дээр бичиж наасан байдгийг өнгө ялгасан зураг гэж хэлэхэд бэрхтэй. Ер нь тийм бичвэрийн наалт урагдах, тасарч алга болох, үндсэн дүрслэлийг дарах зэрэг муу талтай байдаг.

### **Нутгийн зураг үйлдэх дүрэм, хууль**

Манжийн төрийн Монголыг баримтлан захирах гол хуульд нутгийн зураг үйлдэх талаар ямар нэгэн зүйл заалт байдаггүй. Харин нутгийн зураг хэрхэн үйлдэхийг хааны зарлигаар зохицуулж иржээ. Эхлээд 1864 онд, нэлээд хожуу 1890 онд Манжийн захиргаанаас нутгийн зургийн товчхон дүрэм гаргажээ. Уг дүрмийг “Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм” хэмээнэ. Тэрхүү дүрэмд “Өнцөг тутам шулуун тийш нэг зуун газар болмуй. Олон мужийн урт өргөн тийш хэмээх нь адилгүй. Өнцгийн үлэмж цөөнийг бодохгүй, зургийн дүрмийн их боловч бага боловч зүй нь энэ хэмжээг мөрдвөөс зохимуй. Аливаа зурах хууль, мужийн хотыг  ийм зурмуй. Фү-гийн хотыг  ийм зурмуй. Жили тэнхимийн хотыг  ийм зурмуй. Сул тэнхимийн хотыг  ийм зурмуй. Жили жөү-гийн хотыг  ийм зурмуй. Сул жөү-г  ийм зурмуй. Шяний хотыг  ийм зурмуй. Тус газрын жөү-г  ийм зурмуй. Тус газрын шянийг  ийм зурмуй. Жанжин, хошууг захирах сайд, хуувийн сайд, ангийн сайдуудын суугаа хотыг  ийм зурмуй. Өртөөг  ийм зурмуй. Хотны даргаас доргогш суугаа сахигч хамгааллыг  ийм зурмуй. Харуулыг  ийм зурмуй. Овоо хороо тосгоныг  ийм зурмуй. Уулыг  ийм зурмуй. Усыг  ийм зурмуй. Хилийг  ийм зурмуй. Замыг — — — — ийм зурмуй”<sup>49</sup> хэмээн бичжээ. Уг дүрэм ёсоор нэг дөрвөлжинд 100 газар багтааж багасган зурах ёстой байв. Мөн 18 тусгайлсан тэмдэглэгээ зааж өгчээ.

*Баримт бичиг № 1. “Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм” (1890)*

<sup>49</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, данс 2, хн-3864, б-22. Хошуудын нутгийн хил хязгаар орон нутгийн зураг зурж ирүүлэх талаар харилцсан нугалбар бичиг



Нэг дөрвөлжинд 100 газрын хэмжээс (масштаб) баримтлан үйлдсэн зургийн хэмжээ бага, харин гадагш зах нийлэх газар, овоодын тайлбар харьцангуй их болдог. Ийм нутгийн зургийн сул тал нь тухайн хошууны нутаг дэвсгэрийн дүрслэл бага, уул усны нэр цөөн байдагт оршино. Гэхдээ монголчууд хошууны нутгийн зураг үйлдэхдээ “Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм”-д тогтоосон хэмжээсийг тэр бүр баримталдаггүй байв. Бага хэмжээсээр үйлдсэн зурагт хошууны нутаг дэвсгэр өргөн талбиун, доторх дүрслэл болон түүний тайлбар бичвэр ихтэй байдаг давуу талтай.

Манжийн Чин улсын төрөөс гаргаж байсан нутгийн зураг үйлдэх талаарх зарлиг, дүрэм, шийдвэр хоорондоо багагүй зөрүүтэй, нэгдмэл утгатай байж чадаагүйг зориуд цохон тэмдэглэх байна. 1890 оны “нутгийн зургийн дүрэм”-ийн дөрвөлжин хэмжээст 100 газар багтаах шийдвэрийг Сэцэн хан аймгийнхан тэр даруйд (1891) нь “өөр өөрийн нутаг газар орны нутаг хэмжээ байдал уудам их, гол уул даваа буй газар бөгөөд уг зарлаж гаргасан дүрмийн зовхис хуваах бага хэмжээнд хараахан багтаан чадахгүй хэмээн хоёр хосыг нэг зуун газар болгон зурж мэдүүлсэн” хэмээн эсэргүүцэж, дөрвөлжинд 50 газар багтаан зурж байв. Гэтэл ингэж зурахыг 20 гаруй жилийн өмнө 1864 онд Манжийн Бүрэнт засагч (1862-1874) хааны зарлигт заасан байв. Уг зарлигийг Монголд хүргээгүй байх учиргүй байлтай, үүний дагуу нутгийн зургаа зурж ирүүлэхийг Халхын гурван аймагт тушаасан албан баримт хадгалагдан үлдсэн байдаг.

1864 онд Манжийн Бүрэнт засагч хаанд Олон улсын хэргийг ерөнхийлөн шийтгэх яамнаас Чин гүрний далай, хаалганы захаарх нутгийн зургийг шинээр зуруулах санал айлтгасныг зөвшөөрч, зарлиг буулгажээ. Тэр зарлигийн ёсоор 2-р сард Монголын аймгийн чуулганы дарга нарт “хоёр ямхын дөрвөлжин хэмжээ зурж тавин газар бодож нэгэн хэмжээнд хэлэлцэх хуудас наалдуулж нарийн зураг” зурж 3-р сарын дотор багтаан ирүүлэхийг даалгажээ.<sup>50</sup> Зураг үйлдэхдээ урьд өмнөх хуучин зургийг мөрдөн ташаарахгүй байх, нам гүм шийтгэж “орос нарт задруулбаас болохгүй хэмээн” тушаасан байна. Манжийн хааны уг зарлиг Манж Чин улс–Хаант Орос улсын хооронд байгуулсан 1860 оны Бээжингийн гэрээ, 1864 оны Тарвагатайн хэлэлцээрийн дараахнаас Монгол дахь


<sup>50</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-9, д-3, хн-4883, б-2. Хамаарсан да хэбэй түшээ гүнгийн бичиг

засаглалаа бэхжүүлэх, Хаант Оросын нөлөөг сөрөн зогсох улс төрийн зорилготой байв. Чингэж лавтайяа 1864 оноос нутгийн зургийг шинэ байдлаар буюу дөрвөлжин хэмжээсийг 2 ямх болгож, дотор нь 50 газар багтаан зурахыг зөвшөөрчээ. Гэтэл Манжийн төрийн хууль тогтоомж Монголд жигд хэрэгждэггүйн улмаас дөрвөлжинд 100 газар багтаан зурах явдал нийтлэг хэвээр байв.

1911 онд монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээсний дараа нутгийн зураг зурах дүрмийг шинэчилжээ. 1913 онд Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас бүх хошуу, харуул, өртөөдөд нутгийн зураг зурж ирүүлэхийг даалгаж илгээсэн бичигт эл өөрчлөлт тод туссан байдаг. Үүнийг толилуулбал,

“Жагсаан бичсэн, өгүүлэл нь, дөрвөлжин нэг ямхын дотор хорин газар. Уул хадыг уул өнгийг аядуулах буюу хуучин удаагаар зурмуй. Хүрээ сүмийг мөн хэвээр зурмуй. Хотыг □ энэ мэт зурмуй. Яам тамгын газрыг хелтрөгтэй монгол гэр мэт зурмуй. Олон засаг ба захиргааны суусан газрыг монгол гэр бөгөөд үүдэвч майхантай мэт зурмуй. Байшин орон болбоос мөн тэр ёсоор зурмуй. Тариаланг ▨ энэ мэт зурмуй. Уурхайг ⊙ энэ мэт зурмуй. Овоог Δ энэ мэт зурмуй. Хуурай замыг шар өнгөөр зурмуй. Төмөр замыг ▨ энэ мэт зурмуй. Төмөр утсыг ⊙ энэ мэт зурмуй. Цөм нэр бичмүй. Гадуур өмнөд хойд дөрвөн зүгийг захад дотогш хандуулан заан бичмүй. Худаг О энэ мэт зурмуй. Аль газраас аль хүртэл хэдэн газар болох ба мөн тойрон тоо хэмжээг тодорхой бичмүй. Хошуу ба харуул өртөөний тойронг цөм улаанаар зурмуй. Хаана хязгаар нийлснийг бичмүй. Давсан нуурыг ⊙ энэ мэт зурмуй. Мөрөн голыг аль зүг урссан тэр зүг хөх өнгөөр зурмуй. Онгоцыг ☞ энэ мэт зурмуй. Модыг мод, дэрсийг дэрс мэт зурмуй. Нуур ба гол, булаг, усыг цөм хөх өнгөөр зурмуй. Бэлчээр газрыг ногоон, элс ба говь шил газрыг бүдэг ягаан өнгөөр зурмуй”<sup>51</sup> гэжээ. Уг дүрмээр нутгийн газар орныг хэрхэн тэмдэглэхийг заагаад зогсохгүй, ямар өнгө хэрэглэхийг тусгаснаараа давуу талтай.




























*Баримт бичиг № 2. Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамны бичиг (1913)*



Манжийн эрхшээлийн үеийн дүрэм, Монгол улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараах шинээр журамласан тэмдэг тэмдэглэгээг хүснэгтээр харьцуулбал доорх байдалтай байна.

*Хүснэгт № 3. Манж Чин улс ба Монгол улсын тэмдэглэгээг харьцуулсан нь*

<sup>51</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-А-47, д-1, хн-139. Хан тайшир уулын чуулган даргын жасаа. хуулга данс

Манжийн “Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм”		Тэмдэглэгээ	Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамны бичиг		Тэмдэглэгээ
1.	Мужийн хот		1.	Хот	
2.	Фү-гийн хот		2.	Тариалан	
3.	Жили тэнхимийн хот		3.	Уурхай	
4.	Сул тэнхимийн хот		4.	Овоо	
5.	Жили жөү-гийн хот		5.	Төмөр зам	
6.	Сул жөү		6.	Төмөр утас	
7.	Шяний хот		7.	Худаг	
8.	Жөү		8.	Давсан нуур	
9.	Шянь		9.	Онгоц	
10.	Сайд суугаа хот				
11.	Өртөө				
12.	Сахигч хамгаалал суугаа				
13.	Харуул				
14.	Овоо Хороо тосгон				
15.	Уул				
16.	Ус				
17.	Хил				
18.	Зам				

Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамны өөрчлөлтөөр нутгийн зурагт татдаг хэмжээсийн дөрвөлжин торын хэмжээг нэг ямх (3.2 см) хэмээн нарийвчлан зааж өгсөн нь нутгийн бүх зургийг нэгэн жигд хэмжээтэй болгоход чиглэсэн бололтой. Мөн нэг дөрвөлжинд багтах хэмжээсийг 20 газар болгосон нь их чухал сайн өөрчлөлт байв. Чингэж хэмжээс өөрчлөгдсөнөөр хошуудын нутаг дэвсгэр урьд өмнөхөөс илүү том хэмжээтэй зурагдах, түүнийг дагаад дэлгэрэнгүй тэмдэглэл, бичвэртэй болох юм.

Нутгийн зургийг 12 жилийн амьтан, 8 өнгө, зурхайн 4 хүлэл, нийт 24 зүг чигт багтааж зурах ёс урьдын адил хэвээр байв. Өмнө хэрэглэж байсан нийтлэг тэмдэглэгээ дээр тариалан, уурхай, төмөр зам, төмөр утас (холбооны) зэргийг хэрхэн тэмдэглэхийг нэмж өгчээ.

Гэтэл 1913 оны 8 дугаар сард Бүгд ерөнхийлөн захирах яамнаас даалгасны дагуу Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас 3 сарын дотор нутгийн зураг, цэсийг 3 хувь зурж ирүүлэхийг тушаан илгээсэн бичигт, нэг дөрвөлжин торонд 20, эсвэл 25 газрыг багтаана гэж салаа утгатай бичсэн байдаг. Түүнд “өөр өөрийн захирсан нутгийн зурагт гурван зуун жаран алдыг нэгэн газар болгож нэгэн ямхын дөрвөлжин хэмжээнд хорин газар буюу эсбээс хорин таван газрыг багтаан зурж, аливаа уул, ус, нуурын байдал төлөв мөн уул, ус, нуурын өргөн, уртын газрын хэмжээг тус тус ялган салгаж бас давс гарах нуур буй үгүйг тодорхойлон бүх тойрон нутгийн овоог эрс чигээр зүг үзэх тольд сайтар нийлүүлэн хулгана, морины зэрэг арван хоёр эрхтэн эш махбодийн найман өнгө, найман хүлэлийн эевэрэхү, мөнх, зогсолт, оролтыг зааж, хоорондох газар чухам хэд хэд болохыг тодорхойлон нэгдүгээр овооноос үүсгэн эргэн тойронд бүгд хэддүгээр овоо болохыг

дараалан зах нийлсэн аймаг хошууг бичиж, бүх захирсан нутгийг хураангуйлан нарийвчлан тодорхой зураг цэс тус бүр гурваад хувийг үйлдэж мэдүүлэн ирүүлэх явдлыг зохих олон газарт хуваан явуулан тушаажээ”<sup>52</sup> гэжээ.

Эндээс үзэхүл, зургийн хэмжээсийн торонд багтаах газрыг 20, 25 гэсэн хоёр янзаар авч болох ажээ. Мөн “зүг үзэх толь” хэмээн луужин хэрэглэхийг заасан бололтой. Хэмжээсийн дөрвөлжин торонд багтаах газрын хэмжээг хожим хуулиар нэг мөр цэгцэлж 25 газар болгосон юм. 1919 онд Улсын Дээд, Доод хурлаар баталсан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн “Нутгийн хэргийн хууль” хэмээх дэвтэрт “Нутгийн зураг үйлтгүүлэх нь” гэсэн зүйл бий. Тэр зүйлд ийнхүү заасан байна. Үүнд,

“Нэгэн зүйл. Олон засаг хошууны нутаг газар орны хэмжээ байдлыг нарийн тодорхой зураг зурж тойрон овоо тэмдэг байгуул. Цөм цаг улирлын тооны бичгийн найман хүлэл, арван хоёр жилийн хүрдний доторх найман зүг, арван хоёр салаа, хорин дөрвөн зүгийн морин үсгийг өмнөх болгож, уул овооны толгойг хойш хандуулан зурагтун. Гурван зуун жаран алд газрыг нэгэн газар, гучин зургаан алдыг нэгэн хувь, хувьд үл хүрэхийг алдын тоогоор хэмжиж, хорин таван газрыг нэгэн ямхын хэмжээнд багтааж, дөрвөлжин хүснэгт татаж, зүүн этгээд хөх барс, хөхөгчин туулай, өмнө этгээд улаагчин могой, улаан морь, баруун этгээд цагаан бэчин, цагаагчин тахиа, хойд этгээд харагчин гахай, хар хулгана, зүүн өмнө орлого, шар луу, баруун өмнө зөвэрхүү, шарагчин хонь, баруун хойд этгээд зогсолт, шарагчин үхрийн зүг чигийг үзэж зах нийлэх засаг хошуу лугаа хязгаар уулзах газарт байгуулсан овооны нэр, хоорондын хэмжээ, мөнхүү зүг лугаа тохиолдуулан хэмжиж тодорхой цэс бичиж, Дотоод яамнаа мэдүүлэн ирж хянан байцаалгагтун”<sup>53</sup> гэжээ.

Хуулийн дээрх заалтаас хэдэн зүйлийг мэдэж болно. Юуны өмнө, Монгол улсын хошууд нутгийн зураг, цэсээ үйлдэж Дотоод яаманд ирүүлэн хянуулахаар болов. Мөн 24 зүг чигийг баримтлан зурах, чингэхдээ уул овоодын толгойг хойш харуулах, морин зүгийг өмнө зүг болгохыг тогтоожээ. Бас хэмжээсийн дөрвөлжин торыг 1 ямхаар хийж, түүнд 25 газар багтаахыг хуульчлав. Газар хэмжих уртын хэмжүүрийн нэгж болон 4 зүг, 4 зовхисыг зааж өгсөн байна.

#### **Нутгийн зурагт хэмжээс хэрэглэх ёс**

Монголчууд нутгийн зураг үйлдэхдээ тодорхой хэмжээтэй тэгш дөрвөлжин тор татаж, хэмжээс (масштаб) болгон ашиглаж байв. Гэхдээ бүх нутгийн зурагт тор тавьж зурсан гэж ойлгож болохгүй. Эхэн үеийн нутгийн зурагт тор таталгүй нүдэн баримжаагаар зурж байв. Одоогоор мэдэгдэж байгаагаар 1863 оны нутгийн зурагт хэмжээсийн дөрвөлжин тор анхлан татаж эхэлсэн нь 2 х 2 ямх (6.5 см х 6.5 см) хэмжээтэй байв. Албан баримт бичигт өгүүлснээр бол 1864 оны үеэс “хоёр ямхын дөрвөлжин хэмжээ зурж тавин газар бодож” багтаахыг тушаасан байдаг. Хоёр ямх нь 6.4 см болох агаад нутгийн зурагт буй торыг хэмжиж үзэхэд 6.5 см х 6.5 см байгаа нь хэмжээний хувьд багцаагаар таарна.

Ихэнх нутгийн зурагт торыг 2 х 2 ямхаар зурсан байдаг ч бүгд яг тийм хэмжээтэй биш юм. Нутгийн зургуудад

1.5 см х 1.5 см, 1.6 см х 1.6 см, 2.2 см х 2.2 см, 2.3 см х 2.3 см, 2.5 см х 2.5 см, 2.7 см х 2.7 см, 2.8 см х 2.8 см, 3 см х 3 см, 3.2 см х 3.2 см, 3.3 см х 3.3 см, 3.7 см х 3.7 см, 4 см х 4 см, 4.5 см х 4.5 см, 5 см х 5 см, 5.5 см х 5.5 см, 6 см х 6 см, 6.2 см х 6.2 см, 6.3 см х 6.3 см, 6.4 см х 6.4 см, 6.6 х 6.6 см, 7 см х 7 см, 7.2 см х 7.2 см


хэмжээтэй дөрвөлжин тор тааралдана. Тэр бүү хэл 6 см х 6.3 см, 6 х 8 см, 8 см х 5 см, 9.3 см х 10 см хэмжээтэй тэгш өнцөгт тортой нутгийн зураг хүртэл байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол хошуудын нутгийн зургийн хэмжээсийн дөрвөлжин тор бүгд адил байсангүй. Хожим 1913 онд Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас уг торыг 1 ямх (3.2 см) хэмжээтэй зурахыг журамласан нь 1919 онд хуулинд дахин туссан билээ.

<sup>52</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-А-56, д-1, хн-114, б-1. Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас харуул нутгийн зураг өгүүллийг нарийн тодорхой зурж ирүүлэхийг мэдэгдэн тушаасан хэрэг.

<sup>53</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Дэвтэр. 45

Хэмжээс (масштаб)-ийн тэгш дөрвөлжин тор дотор 50 газар (1 газар-576 метр орчим) багтааж зурахыг 1864 онд тушаасан атал 1890 оны “Зарлигаар тогтоосон мужийн зураг, хэмжээний дүрэм”-д 100 газар багтааж зурахаар заасан нь хоорондоо зөрчилддөг. Манжийн төрөөс тогтоосон хоёр янзын багтаамжийг Монголын аймаг, хошууд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тохируулан хэрэглэж байсан ажээ. Аймгийн хэмжээний том зураг үйлдэхдээ их төлөв 1 дөрвөлжинд 100 газар багтааж байв. Үүний жишээ болгон 1891 онд үйлдсэн Халхын Засагт хан аймгийн 19 хошуу, 3 тамгатай хутагтын, мөн онд Сайн ноён аймгийн 24 хошуу, 6 тамгатай хутагтын шавийн том зурагт нэг дөрвөлжинд 100 газар тус тус багтаан зурсныг дурдаж болох юм. Зарим хошуудын нутгийн зурагт хэмжээсийн дөрвөлжинд торонд 50 газар багтаан зурсан нь цөөнгүй тааралдана. Нутгийн зурагт ямар хэмжээсийг хэрэглэсэн байдлаас шалтгаалан доторх мэдээлэл нь их, бага байдаг. Нутгийн зурагт татсан хэмжээсийн дөрвөлжин торонд 100 газар багтаасан зураг товч, бага мэдээлэлтэй, 50 газар багтаасан нутгийн зураг их мэдээтэйд тооцогдоно.

*Нутгийн зураг № 8. Сайн ноён хан аймгийн Хамба хутагтын шавийн нутгийн зураг (1921)*



1913 онд Монгол улсын Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас нутгийн зургийн дөрвөлжин торонд багтаах газрын хэмжээг 20, 25 газрын аль нэгээр, сүүлд 1919 онд “Монгол улсын хууль зүйлийн бичиг”-т 25 газар гэж тогтоож өгсөн билээ. Гэтэл үүнийг тэр бүр баримталдаггүй байсан нь Сайн хан ноён аймгийн Хамба хутагтын шавийн 1921 оны нутгийн зурагт 1 ямх дөрвөлжинд 20 газар багтааснаас харагдана. Тийнхүү түүхэн цаг үедэд хэмжээсийн дөрвөлжинд багтаах газрын тоо өөрчлөгдөж ирсэн байна. Эхэн үед 100 газар багтааж байснаа дараа нь 50, улмаар 25, 20 газар болгож багасгажээ. Ингэж өөрчлөх болсон нь хэмжээс (масштаб) багасах тусам нутгийн зураг илүү том, дэлгэрэнгүй мэдээлэл сайтай болдогтой холбоотой юм.

Гэхдээ гараар үйлддэг Монгол нутгийн зургийн хэмжээс (масштаб) өнөө цагийн зургийн нарийвчлалд хүрдэггүйг хэлэх хэрэгтэй. Нэгэн жишээ дурдахад, 1900-1904 онд үйлдсэн нэг дөрвөлжинд 50 газар багтаасан Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн зургийг өнөөгийн зурагттай харьцуулахад уртрагийн дагуу 26 (26.540 метр) километр дутуу, харин өргөргийн дагуу 39 (39030 метр) километрээр илүү зурсан зөрөө гарч байв.<sup>54</sup>

### **Нутгийн зурагт хэрэглэх уртын хэмжүүр**


<sup>54</sup> Ж.Гэрэлбадрах. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн нэгэн зургийн судалгаа. Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т. 55-64



Монгол нутгийн зурагт өргөн хэрэглэдэг уртын уламжлалт хэмжүүрийн нэгжүүд бол газар, хувь, алд, нум, тохой, ямх зэрэг юм. Ямх (цун) гэж хүний эрхий хурууны үзүүрээс 1-р үе хүртэлхийг хэлэх агаад 3.2 см ажээ. Тохой бол хүний тохойны үзүүрээс хурууны өндөг хүртэлх хэмжээ юм. Г.Гонгоржав авгайн судалснаар хуруугаа тэнийлгэвэл үзүүр тохой (40 см), гараа атгавал мухар тохой (32 см) болдог. Нум нь алдтай адил хэмжээтэй уртын хэмжүүрийн нэгж юм. Нум газар таван тохой газартай тэнцдэг нь 160 см орчим болдог.

Алд хэмээн хүний хоёр гараа алдлан дэлгэсэн байрлалыг хэлэх бөгөөд мөн үзүүр алд, мухар алд гэж ялгана. Нэг алдыг дундажлан мухар алдаар буюу 160 см-аар авдаг.<sup>55</sup> Хувь газар 57.6 метр хийгээд 36 алдтай тэнцдэг. 10 хувь нь 1 газар болно. Газар бол Монголын уртын уламжлалт үндсэн хэмжүүр билээ. Нэг газар 360 алд газар буюу 576 метр орчим байдаг. Тодруулж хэлбэл, нэг алдыг 160 см гэвэл 360 алд газар нь 576 метр болно гэсэн үг юм. Тэгээд ч нутгийн зургийн дүрэмд “360 алдыг 1 газар, 36 алдыг 1 хувь газар” гэж заасан байдаг. Ганц нэг зурагт хятадын чи (33.33 см) гэх хэмжүүрийг хэрэглэсэн нь харагдана.

Бүдүүвч № 1. Монгол нутгийн зураг дахь уртын хэмжүүр



Газар, хувь, алд, нум, тохойг уул овоодын өндөр болон өргөн, голын урсац ба замын урт, нутаг нийлэх хошууд, захын овоод хоорондын зайг хэмжихэд хэрэглэж байв. Уулын өндрийг “Суварга уул, өндөр нэг газар нэг хувь” гэх зэргээр, голын урсацын уртыг “Хадтайн гол, далан газар гурван хувь дөрвөн алд” хэмээж, замыг уртыг “нэвтрэн өнгөрөх энэ зам нэг зуун ерэн газар” гэж, овоод хоорондын зайг “арван есдүгээр Үнэгэдийн арын овоо хүртэл гурван газар нэг хувь гучин гурван алд” гэх зэргээр бичиж байв. Нутаг хэмжээд явж байхад 1 газар хүрэхгүй газар үлдвэл хувиар хэмжинэ, хувь хүрэхгүй газар үлдсэн тохиолдолд алдаар, алд хүрэхгүй газар үлдсэн бол тохойгоор хэмжинэ гэсэн үг юм. Тохойн хэмжүүрийг нутгийн зурагт тун цөөн тохиолдолд, гол төлөв нутгийн цэсэнд хэрэглэсэн байдаг. Нумыг хааяа нэг нуур, гол, булгийн өргөн, уртыг хэмжихэд “энэ Сангийн далай хэмээх нуур өргөн нь тавин нум, урт нь зуун нумны газар болмуй” гэх мэтээр хэрэглэжээ. Харин ямхыг нэлээд хожим нутгийн зураг дахь тэгш дөрвөлжин торын хэмжээст ашиглах болжээ. Чи-г их төлөв замын өргөнийг хэмжих хэрэглэж, “зүүнээс баруун зүг өнгөрөх зам өргөн нь хоёр алд нэг чи” гэж бичсэн байдаг.

<sup>55</sup> Г.Гонгоржав. Монголчуудын эрдэм ухааны уламжлал (эртний үеэс 1920-иод он). УБ., 2008. т. 119

Тийнхүү XX зууны эхэн үед Монгол нутгийн зураг “аливаа зүйлийг өмнөөс хойд зүг хандуулан” дүрслэх, “хоёр ямхад тавин газар багтаан” зурах, “цаг улирлын тооны хорин дөрвөн зүг тохируулан”<sup>56</sup> үйлдэх болсон байна.

Дээр товчхон өгүүлсэн монголчуудын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зураг үйлдэх уламжлалт арга барил үндсэндээ 1926 онд Монгол улсын Ардыг гэгээрүүлэх яамны сайд Эрдэнэбатханы захиалгаар Германы Лейпциг хотын Вагнер, Девес нарын хэвлэлийн газарт орчин цагийн аргаар “Монгол Ард улсын газрын зураг” (1:200000 масштабтай) хэвлэх хүртэл үргэлжилсэн байна. Ганц нэг хошуунд хуучин гар аргаар нутгийн зураг үйлдэх явдал 1929 он хүртэл мэр сэр байв

### **Ар, Өвөр Монголын нутгийн зургийн онцлог ялгаа**





XVII зуунаас монголчууд Манж Чин улсын эрхшээлд Ар Монгол, Өвөр Монгол, Хөх нуур, Шинэ хязгаар (Шинжаан) зэрэг хэдэн том эзэмшилд хуваагдан орших болсон нь цаг хугацааны эрхээр ахуй, соёл, ёс заншил, хэлний аялгуу, шашин шүтлэгийн багахан боловч ялгаа онцлогийг аандаа бий болгосон юм. Эл ялгаа нутгийн зурагт бас зохих хэмжээгээр тусч үлджээ.

Үндсэн хэдэн ялгаа байсныг дурдвал, 1) Өнгөний зарим нэг ялгаа бий. Өвөр Монголын хошуудын нутгийн зурагт голын урсгал, хэмжээсийн дөрвөлжин торыг хараар зурсан нь цөөнгүй. Халхын хошуудын нутгийн зурагт голын хөхөөр, торыг улаанаар зурдаг. 2) Нутгийн зурагт буй зарим тэмдэглэгээ онцлог ялгаатай. Халхын дийлэнх хошуудын нутгийн зурагт сүм хийд, ноёдын гэрийг улаан халзтай хэдий ч жижгэвтэр даруухан дүрсэлдэг бол Өвөр Монголын хошуудын олонх зурагт тэдгээрийг арай том, илүү нарийн тодорхой зурдаг байв. 3) Халхын хошуудын 1900-аад оноос хойших бараг бүх нутгийн зураг хэмжээсийн тортой бол Өвөр Монголын хошуудын нутгийн зурагт хэмжээсийн торыг тун цөөн хэрэглэсэн байдаг. 4) Хэмжээсийн тор Халхын хошуудын зурагт янз бүрийн хэмжээтэй байдаг ахул Өвөр Монголын нутгийн зурагт нэгэн жигд бага хэмжээтэй олон жижиг тор шигүү татдаг онцлогтой. 5) Өвөр Монголын цөөнгүй хошууны нутгийн зургийг босоо тэгш өнцөг загварт оруулж үйлддэг байсан бол Халхын хошууд нутаг дэвсгэрээ уг байгаа хэлбэрт аль болохоор ойртуулан зурж байв. 6) Өвөр Монголын хошуудын нутгийн зургийн гарчиг ихэд товч, заримд нь байдаггүй ахул Халхын хошуудын нутгийн зургийн гарчиг дэлгэрэнгүй, ямар аймгийн, ямар цол, хэргэм, зэрэгтэй, хэн гэдэг ноёны хошууны нутгийн зураг болохыг бичсэн байдгаараа ялгаатай.

### *Хүснэгт № 4. Өвөр Монголын хошуудын нутгийн зургийн зарим онцлог тэмдэглэгээ*

1.	Засаг ноёны гэр		7.	Овоо	
2.	Борчуудын гэр		8.	Хэрэм	
3.	Суурин гацаа		9.	Сүм	

<sup>56</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-5233, б-19. Харьяат аймгийн бүх нутгийн зураг цэс үйлдэж олон хошууны зургуудын хамтаар хүргүүлсэн учрыг сайдтанаа мэдүүлэх бичгийн эх

4.	Байшин		10.	Суварга	
5.	Мод		11.	Бумба хүүр	
6.	Рашаан		12.	Яам, тамгын газар	

### Нутгийн зургийн ангилал

XVIII–XX зууны эхэн үеийн Монгол нутгийн зургийг хэрхэн үйлдснээр олон ангилан ялгаж, цааш дэлгэрүүлэн хөөж болно. Тэдгээр нь, цаас ба даавууны алин дээр зурснаар, 4 зүг 8 зовхис ба 24 зүг чигийн хүрд ашигласнаар, ямар хэлээр бичсэнээр, хэмжээсийн дөрвөлжин тортой ба торгүйгээр, хар цагаан ба өнгө ялгаснаар, уул усыг зурангаа нэрсийг бичсэн ба зурсны дараа нэрийг бичсэн цаас нааснаар, тамга дарж баталгаажуулсан ба баталгаажуулаагүйгээр нь ялгаж ангилах гэх зэрэг юм.

Ерөнхий байдлаар, Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийг нэгтгэн зурсан болон тус бүрчлэн зурсан зураг хэмээн үндсэн хоёр хэсэгт хуваан үзэж болно. Нэгтгэсэн зурагт Халхын Сэцэн хан аймаг, Түшээт хан аймаг, Засагт хан аймаг, Сайн ноён аймгийн нутгийн зураг, мөн Түшээт хан аймгийн 14 гэр харуулын, Сэцэн хан аймгийн харуулын, Халх-Баргын нутгийн харуулын, Хүрээ-Хиагтын өртөөний зураг зэрэг орно. Тэдгээр зураг тооны хувьд цөөн, хэмжээний хувьд том хэмжээтэй авч доторх мэдээлэл нь арай товч байдаг. Учир нь нэг зурагт их хэмжээний нутаг дэвсгэрийг багтаах тул бүгдийг бус, чухал газруудыг тэмдэглэдэгтэй холбоотой. Хошуу, харуул тус бүрийн нутгийн зураг илүү дэлгэрэнгүй зурагдах учир харьцангуй мэдээлэл сайтай.

Эхний судалгаагаар Монгол нутгийн зургийг үйлдсэн байдлаар нь хоёр хувааж үзэж болохоор байна. Тэр нь

1. XVIII–XIX зууны дунд үеийн нутгийн зураг
2. XIX–XX зууны эхэн үеийн нутгийн зураг юм.

Эхнийх XVIII–XIX зууны дунд үеийн нутгийн зурагт хэдэн онцлог байна. Тэр нь хэмжээний хувьд харьцангуй том, хэмжээсийн дөрвөлжин тор тавиагүй, өнгөөр ялгаагүй, захын овоодыг дугаарлаагүй, ертөнцийн зүг чигээр баруун хойд захын овоо, зүүн захын овоо гэх зэргээр зурж бичсэн, үйлдсэн оныг тэр бүр бичдэггүй, ямар хошууны нутгийн зураг болохыг товч дурддаг, тамга дарж баталгаажуулаагүй зэрэг юм. Түшээт хан аймгийн Эетэй засаг Азарын (1789-1812) хошууны нутгийн зурагт дээрх бүх шинж бүрэн байна. Мөн Сэцэн хан аймгийн Эрдэнэ засаг Жамсранжавын хошууны 1805 оны нутгийн зурагт хэний хошууны зураг болох, хэдэн онд үйлдсэнийг зургийн голд товч төдий бичээд тамга дарсантай адил зураг цөөнгүй байдаг. Бодохул, энэ бүхэн тэр үед нутгийн цэсийг хийдэггүй байсантай холбоотой бололтой. Хэрэв нутгийн цэсийг нарийн тодорхой бичсэн бол нутгийн зураг бас л тийм болох ёстой билээ. Тэдгээр зургийн давуу тал нь хошууны нутгийн доторх газар усны талаарх мэдээлэл бусдаас арай илүү байдагт оршино.

Удаах XIX–XX зууны эхэн үеийн хошууны нутгийн зураг нь эхлэл зүүн талд ямар аймаг хошууны, ямар цол хэргэмтэй ноёны хошууны нутгийн зураг болох тухай гарчигтай, хэмжээсийн дөрвөлжин тор татсан, зүг чигийн хүрд ашигласнаа тодорхой гаргасан, нутгийн захын овоодыг дугаарлаж бичсэн, уул овоодын өндрийн хэмжээг тавьсан, баруун талд үйлдсэн он сар өдрийг заасан төгсгөлийн бичвэртэй, тамга дарж баталгаажуулсан

зэргээр бүрэн гүйцэд хийдэг болсон байна. Ийм нутгийн зургуудын үндсэн дүрслэл багавтар, харин хошууны нутгийн захын овоодын бичвэр дийлэнх зайг эзэлдэг онцлогтой.


### **Монголын нутгийн зургийн тархац**

Монгол нутгийн зураг дэлхийн хэд хэдэн улсад хадгалагдаж байна. Монгол улс болон хилийн чанадад хадгалагдаж буй Монгол аймаг, чуулган, хошуу, харуул, өртөөний нутгийн зураг урьдчилсан тооцоогоор 1240 орчим байна. Хошуудын нутгийн зургийг хэдэн хувь үйлддэг байсан тул цөөнгүй зураг давхардана.

Монгол улсын номын сан, архив, музейд одоогийн байдлаар 766 орчим нутгийн зураг хадгалагдаж байна. Үүнээс Үндэсний номын сангийн хөмрөгт 433 зураг<sup>57</sup>(-16), Үндэсний төв архивын хадгаламжид 145 зураг<sup>58</sup>, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын архивт 182, Дундговь аймгийн музейд 2, Баянхонгор аймгийн музейд 1, Хэнтий аймгийн музейд 1, Өмнөговь аймгийн Манлай сумын музейд 1, Хөвсгөл аймгийн Галт сумын Соёлын төвд 1 нутгийн зураг бий. Дээрх тоо Үндэсний номын сангийн нутгийн зургийг нарийн бүртгэсний дараа өөрчлөгдөнө.

Нутгийн зургийг хэдэн хувь үйлддэг байсан тул дээрх байгууллагад хадгалагдаж буй цөөнгүй зураг давхардана. Мөн Үндэсний төв архивын Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архивт гэрэл зургийн шилэн негатив хэлбэрээр 65 нутгийн зураг байгаа нь цаашид нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нь 1980-ад оны үед архив, номын санд хадгалагдаж байсан нутгийн зургуудын гэрэл зургийн хувь учир бусадтайгаа бараг бүгд давхцана. Монголын түүх соёлын биет өв цуглуулагч хүмүүст цөөнгүй нутгийн зураг хадгалагдаж байна. Тэдгээр хүмүүст буй Монгол нутгийн зургийн бүртгэлийг хийхээр төлөвлөж буйг дашрамд тэмдэглэе.

### *Бүдүүвч № 2. Монгол улсад хадгалагдаж буй нутгийн зураг*



ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Санкт Петербургийн салбарын номын санд Халхын Сэцэн хан аймаг (1907), Түшээт хан аймаг (1868)-ийн хоёр зураг байгаа нь санаснаас арай бага юм. Олон зууны туршид Монголыг судалж, түүх-соёлын арвин өв цуглуулсан ОХУ-д Монгол нутгийн зураг тун цөөн байгаа нь хачирхалтай.

<sup>57</sup> Ч.Нарантуяа. Монгол дахь Монгол гар бичмэл судрын гарчиг. УБ., 2008; Catalogue of the Mongolian manuscripts in the National library of Mongolia. compiled by Ch.Narantuya and D.Enkhtungalag. Edited by Tachibana Makoto. Bulletin of Waseda institute for Mongolian studies. A separate volume Waseda University. 2011

<sup>58</sup> Монгол улс. Үндэсний Төв Архив. "Газрын зургийн цуглуулга" хөмрөгийн Манж Чин улсын үеийн байнга хадгалах баримтын данс. (1791-1909). хөмрөг-460, данс-1; "Газрын зургийн цуглуулга" хөмрөгийн Богд хаант Монгол улсын үеийн байнга хадгалах баримтын данс (1913-1921). хөмрөг-460, данс-2


Нэрт монголч Н.Поппе-гийн бичсэнээр 1939 онд Халх голын дайны өмнө БНМАУ–Манж Го улсын хоорондох хилийн зурвасыг тогтоох комиссын дарга генерал Богданов тус хүрээлэнд очиж Дорнод Монголын хэдэн монгол нутгийн зураг үзээд түр авч явахдаа “Япон болон Манж Го-гийнхны зарга ямар ч үндэсгүй юм байна. Би зургуудыг чинь аль болох хурдан буцаана аа”<sup>59</sup> гэжээ. Гэвч зургийг эргүүлж өгөөгүй нь эдүгээ 2-хон нутгийн зураг байгаагаас мэдэгдэнэ.

Япон улсад Монголын аймаг, хошуудын 61 нутгийн зураг бий. Үүний 45 нь Тэнри Их сургуулийн номын санд, 16 зураг Токиогийн Гадаад судлалын ИС-ийн номын санд хадгалагдаж байна. Х.Фүтаки авгай Тэнри номын санд буй нутгийн зургийг судлан тусгай өгүүлэл бичсэн<sup>60</sup> агаад Японы улс төрийн зорилгоор тэдгээр зургийг цуглуулсан гэж үзжээ. Үүнийг Б.Оюунбилиг лавшруулан Манж Го улс (1932-1945)-ын эхэн үед Японд аваачсан, тэр нь Хятадыг эзлэх, ЗХУ-ыг халдан довтолоход бэлтгэж байсантай холбоотойгоор цуглуулж байсан зургууд гэжээ. Токиогийн Гадаад судлалын ИС-ийн номын санд буй 16 нутгийн зураг хадгалагдаж байгаа нь Монгол улсаас очсон ажээ.

Польш улсын Краков хотын ШУ-ны архивт буй монголч эрдэмтэн В.Котвич авгайн хувийн цуглуулгад Халх Монголын Түшээт хан, Сэцэн хан аймаг, Жибзундамба хутагтын Их шавийн Хар Дархадын гурван отгийн гэсэн 5 нутгийн зураг байдаг.<sup>61</sup> В.Котвич авгай тэдгээр нутгийн зургийг Монгол нутгаар судалгаа хийж явахдаа цуглуулсан ажээ. БНТайвань улсын Үндэсний Ордон музейд Монголын 22 нутгийн зураг хадгалагдаж байна гэж судлаач А.Камимүра үзсэн байдаг. Судлаач Б.Насандалайн тооцоолсноор БНХАУ-д XVIII–XX зууны эхэн үеийн Монголын аймаг, хошуудын 200 орчим нутгийн зураг байгаа ажээ.

ХБНГУ-ын Берлин хотын Улсын номын санд Монгол нутгийн 182 зураг хадгалагдаж байгаа нь XX зууны эхэн, дунд үед судлаач Х.Констений ноёд тайж, лам нараас авсан, Бээжингийн захаас худалдан аваачсан (Б.Оюунбилигийн бичсэнээр монголч эрдэмтэн В.Хайссиг бас Хятадаас нэмж цуглуулсан) нутгийн зургууд юм. Швед улсын Упсала хотын Их сургуулийн номын санд хадгалагдаж буй ойрад монголчуудын Зүүнгарын улсын нутгийн 2 зураг он цагийн хувьд өмнөх үед хамаарах тул уг тоонд оруулсангүй.

Бүдүүвч № 3. Монгол нутгийн зургийн тархац



<sup>59</sup> Николас Поппе. Дуртгал. Англи хэлнээс орчуулсан М.Саруул-Эрдэнэ. УБ., 2009. т. 132

<sup>60</sup> Х.Фүтаки. Тэнри номын санд хадгалагдаж буй Монгол нутгийн зургийн эмхэтгэл.

<sup>61</sup> In the heart of Mongolia. 100<sup>th</sup> anniversary of W.Kotwicz's expedition to Mongolia in 1912. Cracow. 2012. p. 207-208

Монгол улсад Халхын Засагт хан аймаг, Ховдын хязгаарын хошуудын нутгийн зураг харьцангуй цөөн хадгалагдан үлджээ. 1911 онд монголчууд тусгаар тогтнолоо сэргээн Улиастайн Манж жанжны газрыг 1912 оны 1-р сард буулган авсан, Ховдын сайдын газрыг 1912 оны 8-р сард довтлон эзлэх байлдааны үед Ховдын хязгаар, Засагт хан аймгийн хошуудын нутгийн зургийн олонх үрэгдсэн байж болох юм. Гэхдээ аймгийн чуулган даргын газар, хошуудын тамгын газарт нутгийн зургийн нэг хувийг хадгалах тул тэдгээр зураг үлдсэн байх учиртай. Мөн 1922 оноос эхлэн Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгээс явуулсан хуучны ном судар, түүхийн дурсгал цуглуулах ажил замын холоос шалтгаалан баруун хязгаарт сайн хийгдэж чадаагүйг тэдний зураг цөөн байгаа явдал харуулна. Гэтэл 1923 онд Судар бичгийн хүрээлэнд Хан тайшир уулын аймгийн 22 хошуу, 3 хутагтын шавь, Цэцэрлэг мандалын аймгийн 24 хошуу, 8 хутагтын шавийн нутгийн зураг, цэс мөн харуулын тус бүр 2 зураг, 2 цэсийг зарлага Гэрэл хүргэж өгөхөөр явснаас<sup>62</sup> үзэхэд баруун аймгуудын нутгийн зураг, цэс бүрэн ирсэн бололтой байна.

### **Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн архивт буй нутгийн зургийн хөмрөг**

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын архивт буй Монгол нутгийн зургийн сан хөмрөг өөрийн гэсэн түүхтэй. 1980 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс Монголын эртний аймаг, хошуудын нутгийн зургийг төвлөрүүлэн хадгалах тухай нууцын зэрэглэлтэй тогтоол гаргажээ. СнЗ-ийн 1980 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 149-р тогтоолын 7 дугаар зүйлд “БНМАУ-ын нутаг дэвсгэр, эртний аймаг, хошуудын нутгийн хуваарийг тогтоосон түүхийн холбогдолтой газрын зургуудыг нэгтгэн төвлөрүүлж, эмхэтгэн хадгалуулах зорилгоор Барилга-Архитектурын комиссын Улсын геодези, зураг зүйн газарт шилжүүлэхийг” НАХЯ болон ШУА-д даалгасан байдаг. Нууцын зэрэглэлтэй дээрх тогтоолын дагуу НАХЯ-ны харьяа Улсын Түүхийн Төв Архив, ШУА-ийн харьяа Улсын Төв Номын Сангийн сан хөмрөгт тус тус хадгалагдаж байсан Монголын аймаг, хошуудын нутгийн зургийг Улсын геодези, зураг зүйн газарт татан төвлөрүүлэн ажил эхэлжээ. Чингэж 1980-ад оны эхэн үед БНМАУ-ын Улсын геодези, зураг зүйн газарт Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн нэгдсэн сан хөмрөг бий болсон байна.

Төдий удалгүй Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн цомог хийх ажил эхэлжээ. Уг ажилд зохиолч, түүхч Лха.Дарьсүрэн аругайн тэргүүлэн Улсын геодези, зураг зүйн газрын ажилтан А.Суусар, Б.Рагчаа нарын 10 гаруй хүн оролцсон байна. Цомог хийх ажил 1984 оноос эхлэн явагдаж, нийт 5 дэвтэр цомог хэвлэн гаргажээ.

Эхний хоёр дэвтэр “Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом” (26 зурагтай), “Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом” (26 зурагтай) гэсэн нэрээр 1986 онд хэвлэгдэн гарав.<sup>63</sup> Удаах гурван дэвтэр 1987 онд гарсан нь Засагт хан аймаг (21 зурагтай), Түшээт хан аймаг (22 зурагтай), Сайн ноён хан аймгийн (32 зурагтай) хошууны нутгийн зургийн альбом юм.<sup>64</sup> Дээрх 5 цомогт,

- нутгийн зургийг 70 x 50 см хүрээнд багтаан хэвлэсэн,
- зарим хар цагаан нутгийн зургийг өнгөт болгосон,
- нутгийн зурагт буй уул, овоо, гол, нуур булаг, сүм хийд, гэр өргөөг араб тоогоор дугаарласан,

-тэрхүү дугаарын дагуу хуудам монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлэн тусад нь жагсаан бичсэн зэрэг ажилбарууд хийгдсэн юм.


<sup>62</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. х-23. д-1. хн-17. х-57. Ардын засгийн Дотоод явдлын яамнаас Судар бичгийн хүрээлэнд илгээсэн бичиг

<sup>63</sup> Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986, Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1986

<sup>64</sup> Халхын Засагт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Түшээт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Сайн ноён хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987

Нутгийн зургийн цомгийг өргөн олон нийтэд бус, албан хэрэгцээнд зориулан хэвлэснийг “нууц” гэсэн улаан өнгийн тэмдэг дарснаас харж болно. Эдгээр цомгийг Улсын геодези, зураг зүйн газарт цөөн тоогоор хэвлэсэн тул эдүгээ нүдний гэм болжээ.


*Гэрэл зураг № 1. Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн цомог (1986-1987)*



Монголын аймаг, хошуудын нутгийн зургийн цомгийг хэвлэсний дараагаас Улсын Түүхийн төв архив, Улсын Төв номын санд цөөнгүй нутгийн зургийг эргүүлэн өгсөн ажээ. Уг хөмрөгт Халхын Засагт хан аймгийн хошууны нэг ч зураг байхгүй нь тэр бүгдийг эргүүлэн өгсөн гэдгийг нотолно. Мөн анхнаасаа архив, номын сан хоёр нутгийн бүх зургаа шилжүүлэн өгөөгүй нь цомогт орсон нутгийн зургаас ямар нэгэн байдлаар мэдэгддэг. Харин авсан нутгийн зургуудыг буцаан өгч болох талаар Засгийн газрын ямар нэгэн тогтоол шийдвэр байдаггүй тул тухайн үеийн дарга, захирал нарын хоорондын тохироо, гэрээгээр хийгдсэн бололтой. Мөн нутгийн зураг олноор цугларч, нэгдсэн данс бүртгэл хийгдээгүй байсан тухайн цаг үеийн сул задгай байдлын улмаас цөөнгүй нутгийн зураг хувь хүмүүсийн гарт орсон байдаг.


Хэдий тийм алдаа завхрал гарсан хэдий ч БНМАУ-ын Улсын геодези, зураг зүйн газарт биеэ даасан нутгийн зургийн сан хөмрөг үлдэж хоцорчээ. Эдүгээ Улсын газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын харьяа Геодези, зураг зүйн баримтын төвд XVIII–XX зууны эхэн үеийн Монголын аймаг, хошуу, шавь, харуул, өртөөний нутгийн 182 зураг хадгалагдаж байна. Тэдгээр нь Халхын Сэцэн хан аймаг, Түшээт хан аймаг, Жибзундамба хутагтын Их шавь, Сайн ноён хан аймаг, Ховдын хязгаар, Халх-Баргын харуул, Барга хошуу, харуул, өртөөний нутгийн зураг зэрэг юм. Хамгийн том нутгийн зурагт Сэцэн хан аймгийн 23 хошууны газар орны 123 см х 255 см хэмжээтэй даавуун зураг, удаад нь Түшээт хан аймгийн 21 хошууны 100 см х 171 см даавуун дээр зурсан зураг орно. Хамгийн олон тоотой нь Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зураг ажээ.

*Бүдүүвч № 4. ГЗБГЗГазрын архивт буй нутгийн зураг*



Сэцэн хан аймгийг бүхэлд нь зурсан нэг зураг бий. Сэцэн хан аймгийн 26 хошуунаас 18 хошууны 67 зураг, 3 гэр харуулын тус бүр 1 нутгийн зураг байна. Зарим хошууны нутгийн зураг 9 хувь байдаг. Харин тамгатай хутагтын шавийн нутгийн зураг байхгүй.


*Бүдүүвч № 5. Сэцэн хан аймгийн нутгийн зураг*





Түшээт хан аймгийг бүхэлд нь зурсан нутгийн зураг 4 байна. Түшээт хан аймгийн 21 хошуунаас 17 хошууны 44 зураг бий. Зарим хошуу 1-9 хүртэл нутгийн зурагтай нь он цагийн хувьд өөр өөр үед хамаарна. Харуул өртөөний бүдүүвч зураг нь гадуураа харуулын, дундаа өртөөдийн чиглэлийг зурж, нэрсийг бичсэн нийтэд тархсан зургийн нэг хувилбар юм.


*Бүдүүвч № 6. Түшээт хан аймгийн нутгийн зураг*



Халхын шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтын Их шавийн нутгийн зураг 2 байгаагийн нэг нь түүний 202 отгоос өөрийн гэсэн нутагтай Хар Дархад 3 отог шавийн нутгийн зураг, нөгөө нь Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны нутаг дэвсгэр дээр орших Их шавийн отгуудаас тус хошуутай бэлчээр нутаг булаалдсан зураг юм.

Сайн ноён хан аймгийн 24 хошуунаас 11 хошуу, 8 тамгатай хутагтын шавиас 4 шавийн нутгийн зураг байна. Хошуудын нутгийн зураг 1-12 хүртэл бий. Хамгийн олон 12 нутгийн зурагтай нь Сайн ноён хан аймгийн Бишрэлт засгийн хошуу юм.


*Бүдүүвч № 7. Сайн ноён хан аймгийн нутгийн зураг*



Ар Монголын Ховдын хязгаарын нутгийн зураг 2 бий. Эхнийх нь Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг юм. Удаах 1912 оны нутгийн зурагт Дөрвөд аймгуудаас гадна Ховдын хязгаарын бусад 17 хошуунаас Алтайн Урианхайн Зүтгэлт засгийн, Өөлдийн Үйзэн засгийн, Дамбийжаажанцан хутагтын шавь хошуу, Мянгадын Дайчин засгийн, Ховдын тариачин хошууны, хамгийн урд талын Захчин бэйлийн, Захчин гүний гэсэн 7 хошууны нутаг туссан байдаг. Халх-Баргын нутгийн хилийн харуул, Халхын хошуудаас Баргатай нийлэх зах нийлэх нутгийн 11 зураг буй нь 1841-1866 онд хамаарна. Хөлөн Буйрын Барга монголчуудын нутгийн зураг 2 байгааг манж хэлээр бичжээ. Бусад гэсэн ангилалд орж болохуйц 2 зураг байгаа нь язгууртны оршуулга, хулгайч этгээдийн оргосон зураг юм.

Нутгийн зургийн он цаг. Уг сан хөмрөгт буй 180 зургийн 123-т үйлдсэн огноо (он, сар, өдөр)-г тэмдэглэжээ. Хамгийн эхний зураг 1730-1742 оны хооронд үйлдсэн Халхын Түшээт хан аймгийн нутгийн бүдүүвч зураг бол, сүүлийнх нь 1927 онд хийсэн Монгол улсын Богд хан уулын аймгийн Их дулаан уулын хошууны нутгийн зураг юм. Тэдгээрээс 1907 онд хамгийн олон буюу 44 нутгийн зураг хийгджээ. Энэ нь Манжийн Шинэ засгийн бодлогыг явуулахад хэрэглэх зорилгоор нутгийн зургийг дахин зуруулах Манжийн хааны зарлиг 1907 онд гарсантай холбоотой. Түүний дараа 1805, 1913 он 9 зураг, 1849, 1900 онууд 7 нутгийн зургаар удаална. Нутгийн зургийг бичсэн оны дагуу жагсаавал бүдүүвч доорх байдалтай харагдана.

*Бүдүүвч № 8. Нутгийн зургийн он*



Үйлдсэн он цагийг тэмдэглээгүй нутгийн зураг 57 байна. Үүнээс нэлээд зургийн оныг хошууны засаг ноёны цаг хугацааг баримтлан ойролцоогоор тодорхойлов.

Нутгийн зургийг үйлдсэн эд. Монголчууд нутгийн зургийг их төлөв цаас, даавуун дээр зурдаг. Тус сан хөмрөгт буй нутгийн зургийн 152-ыг цаас, 28-ыг даавуун дээр зуржээ. Он цагийн эрхээр цаасан дээр зурсан цөөнгүй зургийн хадгалалтын байдал тааруу болж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй.

Нутгийн зургийн өнгө. Тэдгээр Монгол нутгийн зургийн 161-т ямар нэгэн байдлаар өнгө ялгасан, өнгөт зураас орсон байдаг бол 19 нь дан хар цагаанаар зурагдсан байна. Нутгийн зургийн бичвэрийн тухайд 172 зураг монгол бичгээр, 8 зургийг манж бичгээр үйлдсэн ажээ.

Нутгийн зургийн хэмжээсийн тор. Монголын аймаг, хошуудын нутгийн зурагт хэмжээс (масштаб)-ийн дөрвөлжин тор татдаг байсан нь арай хожуу үед билээ. Тус сан хөмрөгт хадгалагдаж буй 94 нутгийн зурагт хэмжээсийн дөрвөлжин тор татсан бол 86 нутгийн зураг дөрвөлжин торгүй байна. Дийлэнх нутгийн зурагт нэг дөрвөлжинд хэдэн (100, 50, 25, 20) газар багтаасныг бичээгүй тул тухайн хошууны нутаг дэвсгэрээр баримжаалан хэдэн газар (1 газар-576 метр) тооцож хийснийг тодруулах хэрэгтэй болж байна. Мөн хэмжээсийн торын хэмжээ харилцан адилгүй өөр өөр юм.

Нутгийн зургийн тамга. Уг сан хөмрөгт буй нутгийн зургийн 102-ыг тамга дарж баталгаажуулжээ. Зарим нутгийн зурагт тамгыг 1-8 удаа хүртэл дарсан байна. Харин 78 нутгийн зурагт тамга дарж баталгаажуулаагүй тул албан ёсны баримт хэмээн үзэхэд учир дутагдалтай. Гэхдээ тэдгээрт агуулагдаж буй мэдээлэл судалгааны чухал ач тустай.

Тус газрын Архив, мэдээллийн төвд хадгалагдаж буй зарим нутгийн зурагт захын овоодын дугаар, нэрийг бичилгүй тусад нь улаан өнгийн цаасан дээр бичиж наажээ. Энэ нь зургийн үндсэн бичвэрт буй бусад газрын дүрслэл, нэрийг дарах, эсхүл тэрхүү наалт цаас үрэгдэж алга болсноор мэдээлэлгүй хоцрох зэрэг сөрөг талтай. Мөн хөх ногоон өнгөөр бүх нутгийг нийтэд нь будсан зарим нэг нутгийн зураг тэрхүү гүн өнгөн дээр хараар бичсэн уул, усны зарим нэр гаргагдахгүй дутагдал дагуулна. Нэг хэсэг нутгийн зурагт

захын овоодыг нэгдмэл байдлаар дугаарласан бол нөгөө нутгийн зургуудад дугаарлахгүйгээр нэрийг бичсэн, эсхүл зэргэлдээх хошуу тус бүртэй зах нийлэх овоодыг тусгайлан дугаарласан байдаг.

Нутгийн зургийг ихэвчлэн хавар, зун, намрын урин дулаан цагт үйлддэг байсан нь төгсгөлийн бичвэр—огноогоос харагдана. Учир нь түшмэд урин дулаан цагт хошууныхаа нутаг дэвсгэрээр явж цэс болон зургаа үйлддэг, мөн өмнө хийсэн зургаа нягтлан шалгаж шинэчилдэг байжээ. Өвөл нутгийн зураг үйлдсэн цөөн хэдэн тохиолдол бас цөөнгүй тааралддаг.

Нутгийн зургийн бичвэрт худам монголоор бичих дүрэм нэг мөр тогтоогүй, сургалтын нэгдсэн тогтолцоо байхгүй байсны улмаас, мөн бичээчийн чадвараас шалтгаалан үгийг алдаатай бичих, үгийн нөхцлийг буруу залгах зэрэг зөв бичих дүрмийн алдаа элбэг тааралдана. Үүнийг хэл шинжээчид тусгайлан судлах буй за.

Хэвлэлд бэлтгэсэн нь. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын архивт хадгалагдаж буй Монгол нутгийн зургийг 3 боть болгон хэвлэж байна. Аймаг, хошуудын нутгийн зургийн дэс дарааллыг наран мандах дорно зүгийг баримтлан эрэмблэв. Тэргүүн ботид Халхын Сэцэн хан аймаг, дэд ботид Халхын Түшээт хан аймаг, Жибзундамба хутагтын Их шавь, гутгаар ботид Сайн ноён хан аймаг, Ховдын хязгаар, Халх-Баргын нутгийн харуул, Хөлөн Буйрын Барга, бусад нутгийн зургийг оруулав.

Уншигчийг үзэж ойлгоход хялбар болгох үүднээс нутгийн зураг бүрт шинээр нэр оноон өгч, зургийн уг гарчиг (нэр)-ийг доор нь зүүж тавив. Чингэхдээ гарчиг, огноог дурдаагүй нутгийн зурагт зэргэлдээх хошуудын ноёдын цол, нэрийг бичсэн бол түүгээр мөшгин уг хошууны ноёны цол, нэр, оныг бичив. Гарчиггүй зарим нутгийн зургийг түүнд гарах уул усны нэрээр хөөн нягталж, ямар хошууны зураг болохыг тодруулав.

Боть тус бүр үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэгт нутгийн зураг бүрийг уг эхээр нь тавив. Чингэхдээ зургийн уг нэр, товч тодорхойлолтыг бичиж, хэмжээний харьцуулалт, одоогийн зурагт хэрхэн харагдаж буй дүрслэлийг хийв. Удаах хэсэгт нутгийн зургийг галиглаж, хөрвүүлэв. Ингэхдээ нутгийн зурагт 2.5 см х 2.5 см хэмжээтэй тор татаж, босоогоор дээрээс доош латин үсгээр (үсгэн багана), хөндлөнгөөр зүүнээс баруун тийш араб тоогоор (тоон эгнээ) дугаарлав. Тэр дарааллын дагуу дөрвөлжин тор бүрт буй бичвэрийг дугаарлан эрдэм шинжилгээний галиг хийж, бас хаалтанд хөрвүүлэн бичив. Нутгийн зургийн бичвэрийг кирилл монгол үсэгт хөрвүүлсэн нь уг сурвалжийг өргөн олон нийт үзэж ашиглахад зориулсан хэрэг юм. Гаргагдахгүй, бүдэг бичсэн, бас урагдаж алга болсон бичвэрт ... (...) гэж тэмдэглэв.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВТ ХАДГАЛАГДАХ НУТГИЙН ЗУРГИЙН БҮРТГЭЛ**

**Данс-I хадгалагдаж буй Монгол нутгийн зураг**

**1. Нутгийн зургийн нэр:** 56 дугаар он ... газраас харьяат хошууны нутаг ... өргөсөн зураг энэ (56 дугаар он ... qajar-ača qariyatu qosiqun-u nutuу ... ergügsen jiruу ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад дахь умард хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Жонон засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Биндэрьяа хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-1

**Он:** 1791 (Тэнгэрийн тэтгэсний 56 он)

**Хэмжээ:** 78.5 см х 69.4 см

**Бичвэрийн хэл:** монгол хэл

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Өмнөдэлгэр, Баян-Адарга, Батширээт, Биндэр сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 8 зовхисыг бичжээ. Хошууны нутгийн захыг зурж тэмдэглээгүй. Хилийн овоодыг зурж бичээгүй. “56 дугаар он” гэж бичсэн нь Тэнгэрийн тэтгэсэн хааны үе болов уу? Уул болон хадыг өвөрмөцөөр зурсан. Захын овоодыг гурвалжин Δ болон онги О дүрсээр тэмдэглэжээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Хэсэг газраа урагдаж алга болсныг сэргээн засварлаж суурь цаасан дээр наасан.

**2. Нутгийн зургийн нэр:** ... засаг Цэдэндорж ... дугаар он (... jasaу ёdedendorji ... duqar он)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад дахь өмнөд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ачит засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Баянтүмэн хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-2

**Он:** 1805 (Сайшаалтай ерөөлтийн 16 оны 2 сарын 12)

**Хэмжээ:** 63 см х 63.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан (улаан зураас орсон)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Булган, Хэрлэн, Баянтүмэн, Сэргэлэн, Чойбалсан, Гурванзагал Цагаан-Овоо, Баян уул, Баяндун сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 8 зовхисыг бичжээ. Нутгийн төвд ноёны гэрийг “.. Цэдэндорж ... гэр суумуй” гэж бичжээ. Хэрлэн голын урсгалыг өвөрмөц гоё хээгээр зурсан байна. Хошууны нутгийн хойд талаарх Бэрхээс Хөвөлзөх хүртэл 13 гэр харуулын нэрийг бичжээ. Хошууны нутгийн захыг үргэлжилсэн улаан зураасаар, захын овоодыг гурвалжин Δ болон онги О дүрсээр тэмдэглэжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал тааруу. Дундуураа урагдаж тасарсныг сэлбэн засаж цаасан дээр наасан.

**3. Нутгийн зургийн нэр:** Төр гэрэлтийн арван долдугаар он суман бичгийн өртөөдийг шинэчлэн тогтоосон зураг цэс хамт (törü gereltü-yin arban doluduqar он суман бичгийн өртөөдийн зураг)

**Өртөөний албан ёсны нэр:** Халхын нутаг дахь суман бичгийн өртөөдийн зураг

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-3

**Он:** 1837 (Төр гэрэлтийн 17 он)

**Хэмжээ:** 57 см х 28 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. ...., ...., .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чиг бичээгүй. Өртөөний замыг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зурсан байна. Баруун талын өртөөдийг хоёр гэр дээр, доор давхарлан зураад доод талд нь нэрсийг бичжээ. Бусад өртөөдийг хоёр овгор дүрс дээр доор давхарлан зурж дүрсэлжээ. Өртөөний зам дагуух 20 хошуудын засаг ноёны өргөөг улаан халзтай монгол гэрээр зурж, ноёны цолыг Түшээ гүн, Мэргэн ван гэх зэргээр бичсэн байна. Улиастайн цэргийн хүрээг том хаалгатай дөрвөлжин хэрэм дотор сүмээр дүрслэн зуржээ. Их Хүрээг бас дөрвөлжин хүрээн дотор хаалга 1 сүмтэй зурсан байна. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг.

#### 4. Нутгийн зургийн нэр: Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад дахь адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Галшар уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-4

**Он:** 1843 (Төр гэрэлтийн 23 оны 7 сарын 15)

**Хэмжээ:** 104.5 см х 123 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (нутгийн голд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Галшар сум, Сүхбаатар аймаг. Түвшинширээ сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Худгийг давхар онги хэлбэртэй зураад цэнхэрээр будаж, нэрсийг бичсэн байна. Хошууны нутгийн захыг улбар шар өнгийн үргэлж зураасаар зуржээ. Хилийн овоодыг өндөр гурвалжин болон онги дүрсийг зэрэгцүүлэн ΔОД гэж тэмдэглээд өнгө ялгаж, нэрийг бичсэн байна. Эргэн тойрон зах нийлж буй хошуудын ноёдын нэрийг тодорхой бичсэн байна. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Сэргээн засварлаж тусгай хатуу цаасан дээр нааж бэхжүүлсэн.

#### 5. Нутгийн зургийн нэр: Засаг Дугамцэмбэлийн хошууны нутгийн зураг (jasaγ duγarċembül-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-5

**Он:** 1843 (Төр гэрэлтийн 23 оны 5 сарын 14)

**Хэмжээ:** 75 см х 84.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Жаргалтхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Хилийн овоодыг ногоон өнгийн овгор тэмдэгээр зурж нэрийг бичсэн байна. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн.

**6. Нутгийн зургийн нэр:** Засаг Дугамцэмбэлийн хошууны нутгийн зураг (jasaγ duγarġembül-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-6

**Он:** 1843 (Төр гэрэлтийн 23 оны 12 сарын 10)

**Хэмжээ:** 79 см х 82 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (баруун доод хэсэг, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Жаргалтхаан, Баянмөнх сумын хагас нутаг

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Уулыг цэнхэр, шар, улаан өнгөөр, модтой уулыг ногооноор зурж ой зурсан байна. Гол, худаг, бүрдийг цэнхэрээр зуржээ. Хошууны нутгийн захыг улбар шар өнгийн үргэлжилсэн зураасаар зурсан. Хилийн овоодыг ногоон өнгийн овгороор зурж нэрийг бичсэн ажээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн.

**7. Нутгийн зургийн нэр:** Засгийн тэргүүн зэрэг тайж Цэрэндондовын хошууны нутгийн байдал төлөвийн зураг (jasaγ-un teregün jerge tayiji ġerindondub-yin qosiqun-u nutuγ-un bayidal tölüb-yin jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын зүүн этгээдийн хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Сэргэлэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Идэрмэг баян хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-7

**Он:** 1843 (Төр гэрэлтийн 23 оны 9 сарын 15)

**Хэмжээ:** 101 см х 99 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (нутгийн голд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг зүгийг бичээгүй. Уулыг цэнхэр, шар, улаан өнгөөр, модтой уулыг ногооноор зурж ой зурсан байна. Гол худаг, бүрдийг цэнхэрээр буджээ. Хошууны нутгийн захыг хар өнгийн цэгэн зураасаар тэмдэглэжээ. Хилийн овоон дээр 2-3 хос ОО онги зурж тэмдэглээд улаан, шар, хөх өнгөөр будаж нэрийг бичсэн байна. Уг зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн.

**8. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Оцол сансар уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-8

**Он:** 1843 (Төр гэрэлтийн 23 оны 6 сарын 28)

**Хэмжээ:** 82 см х 99 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга 6 удаа дарсан (огноо, нутгийн зах зааг дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Говьсүмбэр аймаг. Сүмбэр, Шивээ говь, Баянтал сум, Дорноговь аймаг. Айраг, Даланжаргалан, Алтанширээ сум, Дундговь аймаг. Цагаандэлгэр, Говь угтаал, Баянжаргалан сум, Төв аймаг. Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс өмнө зүгийг бичжээ. Худаг, усыг О онги тэмдэгээр тэмдэглэж, нэрийг бичжээ. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг хос ▲▲ дүрсээр тэмдэглээд нэрийг бичжээ. Уг зургийг 4 талаас нь харж зуржээ. Хадгалалтын байдал сайн.

**9. Нутгийн зургийн нэр:** Чуулганы дарга нартны газраас тушаасныг дагаж, засаг Дуламжав миний нэгэн хошууны нутгийн зах нийлэх да чин ван, хэбэй Сэцэн хан, засаг Равдандорж, Цэрэндондов, Дашдондов эдгээр таван хошууд лугаа харилцан батлалцаж, зах нийлэх газруудад цөм нэгэн адил овоо тэмдэг байгуулан басхүү харьяат нутгийн дотор бүхий уул усны нэр байдал төлөвийг тодорхойлон зурж, нэгэн хувь зураг үйлдэж тамга дарж чуулганы дарга нартанаа өргөжээ. (ᠴᠢᠶᠤᠯᠠᠭᠠᠨᠤ daruᠭᠠᠨᠠ nar tan-ᠤ ᠶᠠᠵᠠᠷᠠᠴᠠ tusiyaysan-i daᠷᠠᠵᠠ jasaᠭ dulamjab minu nigen qosiyun-ᠤ nutuᠭᠤ-un jiq-a neyilekü da čin wang, kebei sečen qan, jasaᠭ rabdandorji, čerindondub, dašidondub edeger tabun qosiyud-luᠭᠠ qarilčan batulalčaju, jiq-a neyilekü ᠶᠠᠵᠠᠷ-ud-dur čöm nigen adili obuᠭᠠᠨ temdeg bayiyulun basakü qariyatu nutuᠭᠤ-un dotur-a бүкүй аyula usun-ᠤ ner-e bayidal tölüb-yi todurqayilan jiruju nigen qubi jiruᠭ üiledčü, tamaᠭᠠᠨ daruju čiyulᠠᠭᠠᠨᠤ daruᠭᠠᠨᠠ nar tan-ᠠ ergjüüküi)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын зүүн гарын баруун этгээдийн хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Сүжигт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Мөнх жавхлант уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-9

**Он:** 1844 (Төр гэрэлтийн 24 он зуны сүүл сарын 28)

**Хэмжээ:** 75 см х 118.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт



**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 4 удаа дарсан (хойд тал, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Баян овоо сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн өмнө, хойд захыг бичжээ. Нутгийн зурагт “засаг Дуламжав миний гэр үүнд нутаглан суумуй” гэж бичихдээ гэр зураагүй. Хошууны нутгийн захыг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Уулыг ногоон, гол, худгийг хөх өнгө ялгаж зуржээ. Зургаан газар ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**10. Нутгийн зургийн нэр:** Засгийн улсад туслагч гүн Цэвээндоржийн хошууны нутгийн зураг энэ (jasaγ-un ulus-tur tusalayıci güng čewengdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Дархан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-10

**Он:** 1845 (Төр гэрэлтийн 25 оны өвлийн дунд сарын 29)

**Хэмжээ:** 63 см х 81 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Бор өндөр хот, Дорноговь аймаг. Их хэт сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 8 зовхисыг бичжээ. Худаг усыг О онги тэмдэгээр зуржээ. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар тэмдэглэжээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**11. Нутгийн зургийн нэр:** Засаг Гомбожавын хошууны нутгийн зураг (jasaγ qombujab-un qosiqun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Баян хан уулын хошуу (1923-1926), Дашбалбар уулын хошуу (1926-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-11

**Он:** 1845 (Төр гэрэлтийн 25 оны 6 сарын 28)

**Хэмжээ:** 40 см х 52.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (баруун доод тал, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг зүгийг бичээгүй. Давхар дөрвөлжин зураад “хэрэм” гэж бичжээ. Уулыг монгол зургийн аргаар хээлэн зуржээ. Уулыг улаан, шар, хөх өнгөөр будсан. Худгийг онги О тэмдэгээр тэмдэглэж,

хөхөөр буджээ. Хошууны нутгийн захын шугамыг зураагүй. Хилийн овоодыг хос хоёр босоо гурвалжингаар зурж хараар буджээ. Овоо бүр дээр зах нийлэх хошуудыг тодорхой бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Уг эх нь үрэгдсэн бололтой. Ашиглалтын хувь. Хувилсан эхийн хадгалалтын байдал сайн.

**12. Нутгийн зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж

Цэрэндаш миний харьяат хошууны нутгийг зураг зурж өргөх нь (qalq-a-yin sečen qan ayimaγ-un jasaγ-un teregün jerge tayiji čerindasi minu qariyatu qosiqun-u nutuγ-i jiruγ jiruju ergükü anu)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Өндөр цагаан уулын хошуу (1923-1926), Биндэрьяа хан уулын хошуу (1926-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-12

**Он:** 1845 (Төр гэрэлтийн 25 оны зуны сүүл сарын 20)

**Хэмжээ:** 125 см х 79.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 3 удаа дарсан (баруун, хойд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн дөрвөн этгээдийг бичжээ. Худгийг онги О тэмдэгээр тэмдэглэж, хөхөөр буджээ. Хошууны нутгийн захыг ягаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Хилийн овоодыг хос ΔΔ гурвалжин дүрсээ тэмдэглэж улаанаар буджээ. Гурван газар ямар хошуудтай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**13. Нутгийн зургийн нэр:** Жонон гүн (jinong güng)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад дахь умард хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Жонон засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Биндэрьяа хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-13

**Он:** 1845 (Төр гэрэлтийн 25 оны 10 сарын 13)

**Хэмжээ:** 127.5 см х 117 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 4 удаа дарсан (зүүн тал, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Өмнөдэлгэр, Баян-Адарга, Батширээт, Биндэр сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Сайхан өндөр уулын өвөрт “гүн Гомбожав миний гэр” гэж бичсэн ч гэр зураагүй байна. Бэлгэ элзийт сүмийг зуржээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Хилийн овоодыг үзүүр нь хойш урагшаа харсан Δ гурвалжин дүрсээр тэмдэглэж улаанаар буджээ. Захын овоо бүрийн нэрийг бичихдээ ямар хошуутай зах нийлэхийг дор бүрт нь бичжээ. Нутгийн хойд талаар буй Хүйгээс Гилбэр хүртлэх 7 гэр харуулын нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**14. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын зүүн гарын дундад хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Дархан засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Түмэнцогт уулын хошуу (1923-1926), Мөнх хаан уулын хошуу (1926-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-14

**Он:** 1845 (Төр гэрэлтийн 25 оны өвлийн сүүл сарын 3)

**Хэмжээ:** 73 см х 115 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан (нутгийн захыг зурсан)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (нутгийн дунд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Түмэнцогт сум, Хэнтий аймаг, Баян овоо, Норовлин сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зурагт “засаг Базарсадын хошууны нутгийн төв” гэж бичжээ. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Хошууны нутгийн захыг ягаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг жижиг хос ΔΔ гурвалжингаар тэмдэглэжээ. Захын овоодыг ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**15. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад баруун этгээдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Далай дархан засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Хан Хэнтий уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-15

**Он:** 1846 (Төр гэрэлтийн 26 оны цагаан сарын 21)

**Хэмжээ:** 182 см х 128.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 9 удаа дарсан (огноо, нутгийн дунд, зах)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Цэнхэрмандал, Батширээт сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зурагт “үүнд засаг Буяндэлгэр нутаглан суумуй” гэж бичжээ. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Уулыг ногоон, шар өнгөөр, голын цэнхэрээр будсан байна. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг гурвалжин 2-4 гурвалжин ▲ тэмдэгтээр зурсан. Захын овоодыг нэрийг бичихдээ ямар хошуутай зах нийлэхийг дор нь дурджээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьгүй.

**16. Нутгийн зургийн нэр:** Засгийн улсад туслагч гүн Цэвээндоржийн хошууны нутгийн зураг энэ (jasaγ-un ulus-tur tusalaγci güng čewengdorji-yin qosiyun-u nutuγ-un jiguγ ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Дархан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-16

**Он:** 1847 (Төр гэрэлтийн 27 оны хаврын тэргүүн сарын 25)

**Хэмжээ:** 69 см х 92 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Бор өндөр, Дорноговь аймаг. Их хэт сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Дөрвөн зүг, найман зовхисыг бичжээ. Нутгийн төв хэсэгт “Үүнд гүн Цэвээндорж нутаглан суумуй” гэж бичжээ. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Худаг усыг О онги зурж тэмдэглэжээ. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Гурван ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

#### 17. Нутгийн зургийн нэр: Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын зүүн гарын умар адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Үйзэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Матад хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-17

**Он:** 1847 (Төр гэрэлтийн 27 оны хаврын дунд сар)

**Хэмжээ:** 95.5 см х 57 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 3 удаа дарсан (нутгийн урд, хойд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Матад сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Матад уул, Матахан уулын орой дээр олон чулуу овоолж голд нь өндөр хөлтэй ганжир босгожээ. Нутгийн төв хэсэгт “үүнд гүн Махсүх би нутаглан суумуй” гэж бичжээ. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Булаг, шанд, худгийг хөх өнгийн О онги зурж тэмдэглэжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг бөөрөөрөө нийлсэн онгин чандмань хэлбэртэй дүрсэлжээ. Захын овоо бүрийн зах нийлэх хошуудыг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлжээ. Ашиглалтын хувийг хар цагаанаар хийсэн байна.

#### 18. Нутгийн зургийн нэр: Засгийн хошууны бэйс Пунцагдорж манай хошууны нутгийн

байдал төлөвийг шинэчлэн үйлдэж өргөх зураг (jasaγ-un qosiqun-u beyise fungᠰuγdorji man-u qosiqun-u nutuγ-un bayidal tölüb-yi sinečilen üiledčü ergükü jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад дахь зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Далай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Мөнх хаан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-18

**Он:** 1847 (Төр гэрэлтийн 27 он 3 сарын 14)

**Хэмжээ:** 297 см х 57 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 5 удаа дарсан (хойд, төв, урд, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Мөнххаан, Түмэнцогт сум, Хэнтий аймаг. Баян-Овоо, Норовлин сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зурагт ямар нэгэн гэр, сүм зураагүй. Худгийг хоосон онги О зурж тэмдэглэжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг хос гурвалжин ▲▲ дүрсээр тэмдэглэж хар өнгөөр буджээ. Уулыг ногоон өнгөөр зурсан байна. Онон, Улз, Хэрлэн голын урсгалыг угалзан хээгээр дүрсэлж хөхөөр буджээ. Захын овоодыг ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувь хийгээгүй.

#### **19. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад адгийн баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Эрх засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Өлзийт уулын хошуу (1923-1926), Галшар уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-19

**Он:** 1847 (Төр гэрэлтийн 27 он цагаан сарын 24)

**Хэмжээ:** 102 см х 106 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Түвшинширээ сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн ор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 8 зовхисыг бичсэн байна. Нутгийн төвд “Хар дэлийн засаг Равдандоржийн нутаглан суугаа газар” гэж бичсэн байна. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг 2-3 гурвалжин Δ дүрсээр тэмдэглэж хөх өнгөөр буджээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу дайран гарах 2 зам тус бүрийг 3 давхар үргэлж улаан зураасаар зураад “зам” гэж бичжээ. Захын 13 овоог ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлжээ. Ашиглалтын хувийг өнгө ялгаснаар бус, хар цагаанаар бүдэг үйлдсэн байна.

#### **20. Нутгийн зургийн нэр:** Засгийн улсад туслагч гүн Гомбожавын хошууны нутгийн энэ (jasaγ-un ulus-tur tusalaγči güng γombujab-yin qosiqun-u nutuγ-un jiruγ ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Дархан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-20

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он өвлийн дунд сарын 20)

**Хэмжээ:** 62.5 см х 79.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (хойд хэсэг, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Бор өндөр хот, Дорноговь аймаг. Их хэт сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн дөрвөн зүг, найман зовхисыг бичжээ. Нутгийн төвд “Үүнд гүн Гомбожав нутаглан суумуй” гэж бичжээ. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Нутгийн голд “төв дунд” гэж бичсэн ажээ. Худгийг давхар онги зурж тэмдэглэжээ. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Захын овоодыг гүйцэд бичээгүй. Гурван газар ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**21. Нутгийн зургийн нэр:** Засаг Жигмэддоржийн хошуу, зүүн Хуучид ван Чойжинжавын хошуун лугаа зах нийлүүлж шийтгэсэн нутгийн зураг (jasaγ jigmeddorji-yin qosiyu, jegün qayučid wang čoyijungjab-yin qosiyun-luγ-a jiq-a neyilegüljü sidkegsen nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын умард хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Хурц засгийн хошуу

**Зургийн агуулга:** Сэцэн хан аймгийн Хурц засгийн хошууны Шилийн голын чуулгантай зах нийлэх нутгийн зураг

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Зотол хан уулын хошуу (1923-1927), Эрдэнэ цагаан уулын хошуу (1927-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-21

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он 8 сарын 18)

**Хэмжээ:** 51 см х 47 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Эрдэнэ цагаан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Тус хошууны нутгийн урд талын зах болох Өвөр Монголын Шилийн голын чуулганы Үзэмчин, Зүүн Хуучид, Баруун Хуучид гурван хошуутай нийлэх 10 нутгийн уул овоодыг зуржээ. Овоодын нэр, ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Нутгийн урд захын шугамыг зураагүй. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**22. Нутгийн зургийн нэр:** Түгээмэл элбэгтийн тэргүүн он, Түшээт хан, Түшээ гүн хоёр хошууны тэмцсэн Эргэнэг зэрэг газрыг байцаан үзээд хоёр этгээдэд тушааж зуруулсан зураг (tügemel elbegtū-yin terigün on, tüsiyetü qan, tüsiy-e güng qoyar qosiqun-u temečegsen ergeneg jerge γajar-yi bayičayan ügejed, qoyar eteged-tü tusiyaju jiruquluγsan jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын Очирай бат Түшээт сайн ханы хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Түшээт ханы хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хан уулын аймгийн Хангай хайрхан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-22

**Он:** 1851 (Түгээмэл элбэгтийн тэргүүн он)

**Хэмжээ:** 72.5 см х 53.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Хархорин, Хужирт, Бүрд, Есөнзүйл сум, Булган аймаг. Гурванбулаг сум, Архангай аймаг. Хашаат, Өгий нуур сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Хоёр газар “суман өртөөний нутаг” гэж бичээд зуйвандуу нутгийг нь тойруулан үргэлжилсэн хар зураасаар зураад голд хас тэмдэг зурсан байна. Мөн “дам Хашаат өртөөний ба хавсаргын нутаг хэмээмүй” гэж бичээд нутгийг тойруулан зуржээ. Бас нэг газар “хавсаргын нутаг” гэж бичээд нутгийг нь тойруулан зурсан байна. Тодруулж хэлбэл, гурван өртөөний нутгийн тойруулан зурсан ажээ. Маргалдаж буй Эргэнэг уул болон бусад газрыг тойруулан хар өнгийн үргэлжилсэн зураас татжээ. Захыг овоодыг онги О дүрсээр тэмдэглэж, нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**23. Нутгийн зургийн нэр:** Засгийн улсад туслагч гүн Гомбожавын хошууны нутгийн зураг энэ (jasaγ-un ulus-tur tusalaγci güng qombujab-yin qosiyun-u nutuγ-un jiruγ ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын ..... хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн ..... уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-23

**Он:** 1851 (Түгээмэл элбэгтийн тэргүүн он өвлийн тэргүүн сарын 20)

**Хэмжээ:** 62.5 см х 79 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн дөрвөн зүг, найман зовхисыг бичсэн байна. Нутгийн төвд “үүнд гүн Гомбожав нутаглан суумуй” гэж бичсэн байна. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Гурван газар ямар газраар зах нийлэхийг бичжээ. Нутгийн захын худаг усыг О дүрсээр тэмдэглэжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувь үйлдсэн байна.

**24. Нутгийн зургийн нэр:** Засгийн улсад туслагч гүн Гомбожавын хошууны нутгийн зураг энэ (jasaγ-un ulus-tur tusalaγci güng γombujab-yin qosiyun-u nutuγ-un jiruγ ene)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын ..... хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн ..... уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-24

**Он:** 1852 (Түгээмэл элбэгтийн 2 он өвлийн дундад сарын 20)

**Хэмжээ:** 64 см х 80 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 4 зовхисыг бичсэн байна. Нутгийн төвд “үүнд гүн Гомбожав нутаглан суумуй” гэж бичсэн байна. Ямар нэгэн гэр, сүм зураагүй. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Гурван газар ямар газраар зах нийлэхийг бичжээ. Нутгийн захын худаг усыг О дүрсээр тэмдэглэжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**25. Нутгийн зургийн нэр:** Түгээмэл элбэгтийн аравдугаар он илүү гурван сард да ван, дэд да гүн нарын хоёр хошууны тэмцэлдсэн нутгийн хэрэг шүүлгэхээр гаргасан гүн Занашир, туслагч Үржинбадам нар овоо байгуулсан газар байдал дүрс зурж өргөсөн зураг нь (tügemel elbegtū-yin arbaduγar on ilegüü γurban saradu da wang, ded da güng nar-un qoyar qosiyun-u temečeldügsen nutuγ-un kereg sigülger-e qarγaysan güng janasiri, tusalaγči ürjingbadm-a nar obuγ-a bayiyuluγsan γajar bayidal dürsü jiruju ergügsen jiruγ anu)

**Зургийн агуулга:** Илдэн засаг, Эрхэмсэг засгийн хошуудын тэмцэлдсэн нутгийн зураг

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Илдэн засгийн хошуу, Эрхэмсэг засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-25

**Он:** 1860 (Түгээмэл элбэгтийн 10 он илүү 3 сар)

**Хэмжээ:** 72 см х 31.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан (овоог улаанаар)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Халх гол сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зурагт “гүнгийн сүмийн ор, суварга” гэж бичээд 1 сүм, нэг суварга зуржээ. Хоёр хошууны нутгийн зах нийлэх 9 овоог хос жижиг улаан ΔΔ гурвалжингаар тэмдэглэжээ. Бусдыг хар цагаанаар зурсан байна. Хоёр хошууны нутгийн захыг зааглан зураагүй ажээ. Уг нутгийн зургийг хойд зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**26. Нутгийн зургийн нэр:** Чуулганы даргатны газраас гаргасан гүн Занашир, туслагч Үржинбадам нар да ван манай хошууны туслагч Жигмэддаш, дэд да гүнгийн хошууны туслагч Лутжаргал нарыг авч хоёр хошууны тэмцсэн нутгийн газар орныг байцаан үзээд тогтоон шийтгэж овоо байгуулсан зах нийлсэн газар орны зураг. Түгээмэл элбэгтийн аравдугаар он зуны дундад сарын шинийн нэгнээ (čiquγan-u daruγ-a tan-u γajarača qarγaysan güng janasiri, tusalaγči ürjingbadm-a nar da wang man-u qosiyun-u tusalaγči jigmeddasi, ded da güng-ün qosiyun-u tusalaγči lutajirγal nar-i abču qoyar qosiyun-u temečegsen nutuγ-un γajar orun-i bayičayan üjegeged toγtuγan sidkejü obuγ-a bayiyuluγsan jiq-a neyilegsen γajar orun-u jiruγ. түгемел элбегтү-йин arbaduγar on jun-u dumdadu sarayin sineyin nigen-e)



**Зургийн агуулга:** Илдэн засаг, Эрхэмсэг засгийн хошуудын тэмцэлдсэн нутгийн зураг

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Илдэн засгийн хошуу, Эрхэмсэг засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-26

**Он:** 1860 (Түгээмэл элбэгтийн 10 он зуны дунд сарын шинийн 1)

**Хэмжээ:** 92.5 см х 23.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (бичвэр дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зурагт “гүнгийн сүмийн ор, суварга” гэж бичээд 1 сүм, нэг суварга зуржээ. Хоёр хошууны нутгийн зах нийлэх 9 овоог хос жижиг гурвалжин  $\Delta\Delta$  улаан дүрсээр тэмдэглэжээ. Хоёр хошууны нутгийн захыг үргэлжилсэн зураасаар зааглан зураагүй ажээ. Халхын голын дагуух бургасыг зураад ногооноор будсан байна. Уг нутгийн зургийг хойд зүгээс харж үйлдсэн байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**27. Нутгийн зургийн нэр:** Түшээ гүн Цэрэндорж нарын зурсан зураг (tüsü-e güng  
čerindorji narun jirүsan jirү)

**Зургийн агуулга:** Нэр үл мэдэгдэх хоёр хошууны нутгийн заагт босгосон 4 овооны зураг (Баян-Өндөр, бүрдний баруун өмнө, бүрдний хойдох, Өндөр толгой)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-27

**Он:** 1861 (Түгээмэл элбэгтийн 11 он 3 сарын 12)

**Хэмжээ:** 26.5 см х 26 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс хойд, зүүн хойд, баруун хойд, баруун, баруун өмнөд, өмнө зүгийг бичжээ. Захын нийлэх хошуудыг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж зуржээ. Уул голыг их том хэмжээтэй дүрсэлж бичсэн, хошууны нутгийн захыг зураагүй, захын овоод бичиж тэмдэглээгүйгээс харахад нилээн дээр үеийн зураг гэлтэй харагдана. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай.

### **94. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Аймгийн албан ёсны нэр:** Халхын Сэцэн хан аймаг

**Зургийн агуулга:** Халхын Сэцэн хан аймгийн тойм зураг

**Аймгийн хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймаг (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-94

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 104 см х 53.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймаг, Дундговь аймаг

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Сэцэн аймгийн нутгийн хойд талаарх 14 гэр харуулын нэрийг бичжээ. Нутгийн зүүн, урд, баруун талаар зах нийлэх Түшээт хан аймгийн хошуудаас Солон дагуур, Барга хүртэл 13 хошууны нэрийг бичжээ. Сэцэн аймгийн нутгийн 25 засаг ноёны нэрийг улаанаар бичээд хошуудыг хэдэн сумтай байсныг дурджээ. Сэцэн хан аймгийн нутгийн захыг бүдүүн хар үргэлжилсэн зураасаар зуржээ. Уг нутгийн зургийг хойд зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай.

**95. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын зүүн гарын өмнөд хошуу

**Хошууны нийтлэг нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Эрхэмсэг засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Хан чандмань уулын хошуу (1923-1926)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-95

**Он:** он бичээгүй (1786-1821)

**Хэмжээ:** 72.5 см х 64 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Халх гол сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн хойд, зүүн, өмнө зүгийг бичжээ. Нутгийн төв хэсэгт “Дэлгэр гол, үүнд түшээ гүн Дашгэлэг би нутаглан суумуй” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг зураагүй. Захын нийлэх Халх, Солон Барга, Шилийн голын чуулганы хошуудыг бичжээ. Худгийг том онги О тэмдэгээр дүрсэлжээ. Уг нутгийн зургийг зүүн зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай.

**96. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын зүүн гарын дундад хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Эрх засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Баян-Агт уулын хошуу (1923-1925), Намнан уулын хошуу (1925-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-96

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 25.2 см х 25 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Баян-Агт сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүгийг бичээгүй. Таван газар жижиг дуган зураад тус бүрт нь “хурал” гэж бичжээ. Хануйн голыг цэнхэр өнгөөр буджээ. Хошууны нутгийн захыг зураагүй. Захын овоод, зах нийлэх хошуудыг тэмдэглэж бичээгүй. Уг нутгийн зургийг хаанаас харж зурсан нь мэдэгдэхгүй.

Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай.

**97. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Албан ёсны нэр:** Орос зүг тавьсан гэр харуул

**Зургийн агуулга:** Орос зүг тавьсан Хүмүүл, Хярхан, Гилбэр, Агц, Баян-Адарга гэр харуулын нутгийн зураг

**Аймгийн хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймаг (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-97

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 67.5 см х 22 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн өмнөд, хойд зүгийг бичжээ. Хүмүүл, Хярхан, Гилбэр, Агац, Баян-Адарга гэсэн 5 гэр харуулуудын нутгийн өмнөд захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар, хойд захыг шар өнгийн үргэлжилсэн зураасаар тус тус зуржээ. Гэр харуулууд хоорондын нутгийн захыг улаан өнгийн шулуун үргэлжилсэн зураасаар зуржээ. Гэр харуулуудын нутгийн өмнө захын овоодын нэрийг бичиж, ямар хошуудтай зах нийлэхийг дурджээ. Уг нутгийн зургийг бүх талаас нь харж зурсан гэлтэй байна. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай

**98. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Баян барайшир уулын хошуу (1923-1927), Батцэнгэл уулын хошуу (1927-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-98

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 52.5 см х 47.7 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өлзийт, Өгийнуур сум

**Товч тодорхойлолт:**

Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Энэ нь бүрэн гүйцэд нутгийн зураг биш, Өгий нуураас баруун тийшхи хэсэг нутгийн зураг ажээ. Нутгийн зүүн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Түүний зүүн талаар улаан өнгийн тасархай улаан зураасаар уртрагийн дагуу багахан нутгийн тэмдэглэсэн нь бусадтай зарга тэмцэлтэй газар байсан байж магадгүй. Захын овоодын нэрийг бичээгүй, ямар хошуудтай зах нийлэхийг дурдаагүй. Уг нутгийн зургийг бүх талаас нь харж үйлдсэн гэлтэй байна. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**99. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй.

**Зургийн агуулга:** Манж Чин улсын өртөө, гэр, суман харуулын бүдүүвч зураг

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-99

**Он:** он бичээгүй  
**Хэмжээ:** 100 см х 67.7 см  
**Бичвэрийн хэл:** монгол  
**Өнгө:** хар цагаан  
**Зурсан эд:** цаас  
**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нийслэл хот, Жанчхүү, Сайр усын заргач, Улиастай, Хүрээ, Ховд, Хиагтыг тус бүрт нь давхар дөрвөлжин дотор өөр өөр хээ тавьж дүрсэлжээ. Бээжин-Жанчхүү-Сайр ус-Улиастай-Ховдын, Улиастай-Жинжлэг харуулын болон Сайр ус-Хүрээ-Хиагтын өртөөний чиглэлийг зурж, өртөөдийн нэр, ямар аймаг хариуцах, хэн захирахыг бичжээ. Зүүн хойд зүг Баргын Зүртэйгээс баруун хойд зүг Баянбулаг хүртлэх гэр харуул, Жинжлэгээс Хонь майлах хүртэлх суман харуулын чиглэл, нэр, ямар аймгаас хэдэн цэрэг суудагийг бичжээ. Мөн өртөө болон харуулыг хэрхэн хааж байсан талаар тус бүртээ он бүхий их хэмжээний тайлбар бичвэртэй. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьгүй.

**100. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Халхын Түшээт хан аймгийн Ганга, Моност, Урт навчин өртөө

**Аймгийн нэр:** Халхын Түшээт хан аймаг

**Аймгийн хожмын нэр:** Богд хан уулын аймаг (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-100

**Он:** он бичээгүй  
**Хэмжээ:** 51.5 см х 21.7 см  
**Бичвэрийн хэл:** монгол  
**Өнгө:** хар цагаан  
**Зурсан эд:** цаас  
**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Булган, Сэлэнгэ аймаг

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүг, 8 зовхисыг бичжээ. Өртөө тус бүрийн нутгийг том дөрвөлжин дотор дүрсэлж, Сэлэнгэ голыг зураад, өвөлжөө, зусланг бичжээ. Өртөөдийн тэгш дөрвөлжин нутгийн 4 зүг, 8 зовхис тус бүрийг бичжээ. Уг нутгийн зургийг хойд зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**101. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Хөтөл цайдам, Хараат, Дэлгэр булаг овоо хавийн нутгийн зураг

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-101

**Он:** он бичээгүй  
**Хэмжээ:** 40.8 см х 23.5 см  
**Бичвэрийн хэл:** монгол  
**Өнгө:** өнгөт  
**Зурсан эд:** цаас  
**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс өмнө зүгийг бичжээ. Зургийн дээд талд 3 дугаар Дэлгэр булаг, 4 дүгээр Хараат, 5 дугаар Хөтөл цайдам гэж бичжээ. Өвөлжөөг бүдүүн хар ● цэгээр, худгийг цэнхэр өнгийн дөрвөлжин □ дүрсээр тэмдэглэжээ. Улаан шугамтай нугалбар цаасан дээр зурсан тул нутгийн цэсийн ард үргэлжлэл болгон үйлдсэн зураг юм. Нутгийн цэсээс салган авсан тул ямар аймаг, хошууны нутгийн зургийн хэсэг болохыг шууд мэдэх боломжгүй. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**102.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Сайр ус-Хүрээ чиглэлийн Тал долоон, Сүүж, Солгой, Билгэх, Баянхошуу, Бор даага өртөөний нутаг

**Аймгийн нэр:** Халхын Түшээт хан аймаг

**Аймгийн хожмын нэр:** Богд хан уулын аймаг (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-102

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 134 см х 24.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дундговь аймаг

**овч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс өмнө зүгийг бичжээ. Анхандаа бүх өртөөний нутгийг багтаасан урт том зураг байснаа хожим тасарсан гэлтэй байна. Учир нь Бор даага өртөөний нутгийн тал нь орсон байна. Өртөө бүрийн нутгийг том дөрвөлжин дотор багтаажээ. Овоодыг тэгш оройтой улбар шар гурвалжин тэмдэгээр, усыг дотроо цэнхэр усан хээтэй онги О дүрсээр тэмдэглэжээ. Тал долооноос бусад өртөөний нэрийг бичээгүй. Өртөөдийн захын овоодыг зурж, бичээгүй. Өртөөдийн нутгийг давхар зураастай шулуун үргэлжилсэн зураас зааглаж ягаан өнгөөр буджээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Сэлбэн засаж тусгай цаасан дээр нааж бэхжүүлсэн байна. Ашиглалтын хувьтай.

**103.Нутгийн зургийн нэр:** Амбан Түшээт ханы хошууны зураг (amban tüsiyetü qan-u qosiyun-u jirüγ)

**Зургийн агуулга:** Монголын өртөө, гэр, суман харуулын бүдүүвч

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-103

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 50.5 см х 44.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан (өртөөний замыг)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүгээс ганц өмнө зүгийг бичжээ. Нутгийн зургийн нэр агуулгатайгаа зөрсөн байна. Залаат (ТХА.Эетэй засаг?)-Модон-Хүрээ, Залаат-Улиастай-Ховд, Хүрээ-Улиастайн өртөөний чигийг улбар шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Бүх өртөөдийн нэрийг бичээгүй. Улиастай, Хүрээ, Хиагт, Ховд хотыг дөрвөлжин □ тэмдгээр дүрсэлжээ. Гэр харуулаас Уялга, Цагаан булан, суман харуулаас Үүрэг нуур харуулын нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьгүй.

**104.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Хүрээ-Улиастай, Хүрээнээс гарсан бусад өртөөний ноорог зураг

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-1, хн-104

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 52.5 х 26.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Энэ нь ертөөний чиглэлийн ноорог зураг бололтой. Зарим газар онги О тэмдэг, бүдүүн хар цэг • тавиад нэрийг бичээгүй орхижээ. Онги голыг баруун хойно байгаагаар бичжээ. Хүрээнээс Улиастайн зүг явах 24 өртөөг онги тэмдэгээр тэмдэглэж, доор нь нэрсийг бичжээ. Онги гол хүртэл, бас Шилүүтэй хүртэл өртөөдийг тэмдэглэж нэрийг бичжээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

### **Данс-II хадгалагдаж буй Монгол нутгийн зураг**

**105. Нутгийн зургийн нэр:** Түшээт хан аймгийн Ачит гүн Бадрахын хошуу нутгийн зураг (tüsiyetü qan ayimaγ-un ачиту гүнг badaraqu-yin qosiyu nutuγ-un jiryγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Түшээт хан аймгийн Ачит засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хан уулын аймгийн Ашиг хорго уулын хошуу (1923-1924), Хоёр Өлзийт уулын хошуу (1924-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-1

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он илүү 12 сарын)

**Хэмжээ:** 60.5 см x 70 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг. Мандах сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 2.8 см x 2.8 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн баруун хэсэгт улаан халзтай гэр зураад доор нь “засгийн тамгын газар” гэж бичжээ. Түүнээс урагшаа чулуун сүмийн барилга зураад доор нь “дочит ламын сүм” гэж бичжээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу 2 зам дайран гардагийг үргэлжилсэн шар зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар, захын овоодыг жижиг гурвалжин Δ дүрсээр тэмдэглэжээ. Захын овоодыг дугаарлан нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийн өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**106. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Халхын Түшээт хан аймгийн Түшээт засаг, Түшээт хан, Далай засгийн хошуудаас Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошуунд өгсөн нутгийн зураг

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-2

**Он:** он бичээгүй (1915-1923)

**Хэмжээ:** 49.3 см x 49.3 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. .... аймаг. .... сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Түшээт чин ван Лхамсүрэнгийн хошуунаас Итгэлт гүн Равдангийн хошуунд нутаг өгсөн тухай бичвэртэй. Итгэлт гүн Равданд өгсөн нутгийн захыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Үүн дотор “Түшээт вангийн хошуунаас урьд аймгийн түшмэлийн хэмжээлэн өгсөн нутаг”, “Түшээт ханаас өгсөн нутаг”, “Далай гүнээс өгсөн нутаг” гэж бичжээ. Нутгийн зургийн өмнө, зүүн хэсэгт хар цэгэн зураасаар тэмдэглэсэн хоёр газар



тус бүрт нь “Түшээт вангийн хошуунаас сайдын тушаалаар нэмсэн нутаг”, “Түшээт вангийннаас сайдын тушаалаар нэмсэн нутаг” гэж бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**107.Нутгийн зургийн нэр:** Сэцэн хан аймгийн Хурц засаг бэйс Түдэнгийн хошууны нутгийн зураг өгүүлэл (sečen qan ayimaγ-un qurča jasaγ beyise tüdden-yin qosiyun-u nutuγ-un jiruγ ögüel)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын умард хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Хурц засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Зотол хан уулын хошуу (1923-1927), Эрдэнэцагаан уулын хошуу (1927-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-3

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 9 сарын 18)

**Хэмжээ:** 69.5 см х 44.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Эрдэнэцагаан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 2.7 см х 2.5 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Нутгийн төв хэсэгт үүдэвч майхантай улаан халзтай гэр зураад хажууд нь “Хурц бэйс Түдэнгийн суусан газар”, улаан халзтай гэрийн доор “Хурц засаг бэйс Түдэнгийн тамгын газар” гэж бичжээ. Түүний баруунтаа сүмийн барилга зураад доор нь “Өнө өглөгт сүм” гэж бичжээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу 3 зам дайран гардагийг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам тус бүрийн нэрийг “энэ Долоон нуурын зам нэг зуун тавин таван газар” “энэ өртөө зам нэг зуун тавин газар”, “Нийслэл Хүрээний зам нэг зуун дөчин хоёр газар” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлж зураасаар, захын овоодыг гурвалжин Δ дүрсээр зураад овоодын нэрсийг, ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг хойд талаас харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**108.Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Зоригт гүн Гончигчойнзунгийн хошууны нутгийн зураг (sayin noyan qan ayimaγ-un joriγtu güng qongcūγcoyingjun-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун гарын дунд баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрдэг мандал уулын аймгийн Цагаан сүм уулын хошуу (1923-1925), Цэцэрлэг голын хошуу (1925-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-4

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 12 сарын 29)

**Хэмжээ:** 42.3 см х 41.2 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Цэнхэр сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн төв хэсэгт улаан халзтай 2 гэр зураад доор нь “засгийн өргөө”, “тамгын өргөө” гэж бичжээ. Түүний баруунтаа дөрвөлжин хүрээн дотор сүм зураад доор нь

“хийд” гэж бичжээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу 3 зам дайран гардагийг шар өнгийн үргэлж зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлж зураасаар зуржээ. Захын овоодыг тэмдэглээгүй, нэрийг бичээгүй. Нутгийн зургийн 4 талд ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**109.Нутгийн зургийн нэр:** Нийслэл Хүрээний баруун замын арван нэгдүгээр босуул ертөөний нутгийн зураг (neyislel küriyen-ü baraγun jam-un arban nignedüger bosuγul örtegen-ü nutuγ-un jiruγ)

**Аймгийн нэр:** Түшээт хан аймаг

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-5

**Он:** 1914 (Олноо өргөгдсөний 4 он 8 сарын 13)

**Хэмжээ:** 33.5 см х 35 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:**

Хэмжээсийн 3.1 см х 3.3 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Нутгийн зургийг тойруулан ертөнцийн 24 зүг чигийг дарааллын дагуу бичжээ. Өртөөний нутгийн төвд жижиг хар гэр зураад “албаны гэр” гэж бичжээ. Өртөөний нутгийн захыг улбар шар өнгийн үргэлж зураасаар зуржээ. Нутгийн захын 4 зүг, 8 зовхист босгосон овоодыг гурвалжин Δ дүрсээр тэмдэглэж, нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**110.Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Үйзэн ван Бат-Очирын хошуунд зарлигаар шинэ олгосон нутгийг хуучин нутаг лугаа нийлүүлэн нэг дөрвөлжин ямхыг хорин газрын хэмжээ болгож үйлдсэн зураг амуй (sayin noyan qan ayimaγ-un üjeng wang batuwaᠰar-yin qosiqun-dur jarliγ-iyar sin-e olquγsan nutuγ-i qaqučün nutuγ-luγ-a neyilegүlүн nigen dörbeljin imaqu-yi qorin-u qajar-un kemjiy-e bolγaju üiledдүgsen jiruγ amui)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун гарын дундад этгээдийн зүүн гарын хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Арвайхээр уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-6

**Он:** 1919 (Олноо өргөгдсөний 9 он 6 сарын 29)

**Хэмжээ:** 81 см х 69.3 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (гарчиг, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Арвайхээр, Тарагт, Төгрөг, Зүүнбаян улаан, Баянгол, Гучин ус сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 2.7 см х 2.7 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Хошууны нутгийн хойд хэсэгт үүдэвч майхантай улаан халзтай гэр зураад доор нь “засаг суух гэр”, “ халзтай гэрийн доор “тамгын жасаа” гэж бичжээ. Долоон газар сүм зурж, нэрсийг бичжээ. Нутгийн дундуур өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам

хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар, захын овоодыг онги О дүрсээр тэмдэглэсэн ч нэрсийг бичээгүй. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Цаас нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**111.Нутгийн зургийн нэр:** Хан Хэнтий уулны чуулганы дарга Эрдэнэ далай вангийн хошууны нутгийн зураг (qan kentei ayulan-u c̄iyulγan-u daγuγ-a erdeni dalai wang-un qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны өмнөх нэр:** Халхын дорно замын дундад дахь зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Далай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Мөнх хаан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-7

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он 5 сарын шинийн 3)

**Хэмжээ:** 61.8 см х 97 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (бичвэр, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сүхбаатар аймаг. Мөнххаан, Түмэнцогт сум, Хэнтий аймаг. Баян-Овоо, Норовлин сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн урд хэсэн улаан халзтай хоёр ба гурван гэр нийлүүлэн зураад “яам тамгын”, “харьяат засгийн” гэж бичжээ. Гурван газар олон гэр тойруулсан хашаатай хүрээ хийд зурж, нэрсийг бичжээ. Дөрвөн газар улаан онги О зураад тус бүрийн дотор нь “мөн өртөөний нутаг” гэж бичжээ. Нутгийн дундуур өргөргийн дагуу 4 зам дайран гардагийн 3 замыг давхар зураасаар зураад шараар будсан байна. Хамгийн урд талын 1 замыг шар үргэлжилсэн зураасаар зуржээ. Гурван зам тус бүрд “энэ зам Хүрээ ормуй” гэж, нэг зам дээр “энэ зам Хүрээ хүрмуй” гэж бичжээ. Бас нэг замыг шар зураасаар зураад “энэ өртөө зам” гэж бичжээ. Хэрлэн, Улз голыг зүүн зүг урсахыг бичжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар, захын овоодыг бүдүүн улаан цэгээр тэмдэглэжээ. Захын овоодыг дугаарлан нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Сэлбэн засварлаж цаас нааж бэхжүүлсэн. Ашиглалтын хувьтай.

**112.Нутгийн зургийн нэр:** Сэцэн хан аймгийн үе улиран бэйлийн зэрэг Дайчин засаг тэргүүн зэрэг тайж Дашцэрэнгийн хошууны нутгийн зураг (sečen qan ayimaγ-un üy-e ularan beyile-yin jerge dayičin jasaγ teregün jerge dasičerin-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Дайчин засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын аймгийн Батноров уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-8

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он 5 сарын 16)

**Хэмжээ:** 75 см х 79 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Батноров сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн төв хэсэгт улаан халзтай олон гэр нийлүүлэн зураад хажууд нь “засаг бэйлийн суух газар” гэж бичжээ. Түүнээс баруун зүгт гэр, хашаа зурж, доор нь “тамгын газар” гэж бичжээ. Гурван газар гэр, хашаа зураад “гол хийдийн газар”, “Харзны хурлын газар”, “Дара эхийн хурлын газар” гэж бичжээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу 4 зам дайран гардагийн шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар, захын овоодыг М хэлбэртэй тэмдэглэжээ. Захын овоодыг дугаарлан нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**113.Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймаг Хамба хутагт номун ханы шавь нарын нутгийн зураг (sayin noyan qan ayimaᠭ gambu qutuᠭtu nomun qan-u šabinar-un nutuᠭ-un jiruᠭ)

**Шавийн албан ёсны нэр:** Сайн ноёны аймгийн Хамба хутагт номун ханы шавь

**Шавийн нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Хамба хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Шажинбат сэвжидгацал уулын хошуу (1925-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-9

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он 9 сарын шинийн 9)

**Хэмжээ:** 40.5 см х 28 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 2 удаа дарсан (гарчиг, огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тэлмэн, Тосонцэнгэл сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 3.3 см х 3.3 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 этгээдийн бичжээ. Шавийн нутгийн төв хэсэгт үүдэвч майхантай улаан халзтай гэр зураад доор нь “шанзудба-гийн суудаг газар” гэж бичжээ. Түүний баруунтаа улаан халзтай гэр зурж, доор нь “тамгын жасаа” гэж, хойд талд сүм зураад “Буянбаясгалант сүм” гэж бичжээ. Нутгийн дундуур уртрагийн дагуу 1 зам дайран гардагийг бүдэг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Шавийн нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Захын овоодыг гүйцэд тэмдэглээгүй, захын цөөн овооны нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**114.Нутгийн зургийн нэр:** Халхын Сайн ноён аймгийн засаг Бу-гийн хошууны нутгийн зураг (qalq-a-yin sayin noyan ayimaᠭ-un jasaᠭ bu-yin qosiyun-u nutuᠭ-un jiruᠭ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Шажинбат сэвжидгацал уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-10

**Он:** он бичээгүй (1840-1865)

**Хэмжээ:** 126 см х 49.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тосонцэнгэл сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин торыг нэлээд ташуу татсан нь 8 см х 5 см хэмжээтэй болжээ. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Нутгийн зурагт 5 газар “энэ уулын

өвөр, араар өвөлжиж хаваржмуй”, “Идэр голоор зусч намаржмуй” гэж бичиж наажээ. Бүрэнт засагчийн 5-р (1866) онд Ялгуусан хутагтад баруун талаас нутаг тасдаж өгсөн тухайгаа бичжээ. Нутгийн дундуур өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг бүдэг улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг бүрэн гүйцэд зураагүй. Зарим газар хар өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Захын овоодыг гүйцэд тэмдэглээгүй, захын цөөн овооны нэр, ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

**115.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён аймгийн Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Шажинбат сэвжидгацал уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-11

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 44.5 см х 34.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тосонцэнгэл сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Нутгийн зургийн бүх бичвэрийг бор цаасан дээр хараар бичиж наажээ. Идэр голын урд биед 2, хойд талд байх 7 сүмийг маш гоёмсогоор зурсны олонхийн нэрийг бичээгүй. Нутгийн дундуур өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг тод улаан өнгийн үргэлжилсэн зураасаар зураад “их зам” гэж бичжээ. Замын дагуу 6 газар онгин чандманийг доош харуулан дүрсэлсэн нь бууж үдэлдэг газар байж магадгүй. Хошууны нутгийн захыг хар өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Захын овоодыг гүйцэд тэмдэглээгүй. Хойд талын Булнайну нуруугаарх захын цөөн овооны нэрийг бичжээ. Хойд, урд талаар ямар хошуутай зах нийлэхийг бор цагаан цаасан дээр бичиж наажээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

**116.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын дундад зүүн гарын адгийн хошуу

**Зургийн агуулга:** Ивэн голын адаг урсгалын тарианы нутаг

**Хошууны нэр:** Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-12

**Он:** он бичээгүй (1884-1923)

**Хэмжээ:** 48 см х 51 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан (замыг)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Сант сум (Ивэн голын нутаг)

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс зүүн хойд, баруун хойд зовхисыг бичжээ. Орхон голын хойд талаас хоёр салаалан цутгах

Ивэн гол голын хоёр хөвөөгөөрх тарианы газрыг хар өнгийн шулуун зураасаар зуржээ. Ивэн голын урсгалын дагуу тариа талбай руу ус татах сувгийн олон боолтын нэрийг бичжээ. Ивэн голын зүүн этгээд Түшээт хан аймгийн Эрдэнэ засаг Намсрайн хошууны, баруун этгээд засаг Ахай засаг Лувсанхайдавын хошууны нутаг болохыг бичжээ. “Шажныг бадруулагч сүмийн тарианы газар” 1, “Амарбаясгалант сүмийн тарианы газар” 4 байна. Сангийн тарианы байшин 2, дуган 1-ийг зурж, бичжээ. Ивэн голын хоёр талаар уртрагийн дагуу тус бүр 1 зам дайран гардагийг улаан хүрэн өнгийн үргэлжид зураасаар зурж, тус бүрт нь “энэ зам” гэж бичжээ. Уг нутгийн зургийг хэдэн талаас харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

**117.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын дундад дахь баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Түшээт хан аймгийн Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хан уулын аймгийн Хүнцэлцавчид уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-13

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 50 см х 51 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Өндөрширээт, Өндөрсант, Лүн, Бүрэн, Баян-Өнжүүл сум, Булган аймаг. Баян-Овоо, Дашинчилэн

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн дунд “Тамгын газар” бичсэн нь ямар нэгэн тэмдэглэгээгүй. Хоёр газар сүм зураад “Хамбын хүрээ”, “хүрээ” гэж бичжээ. Худгийг дөрвөлжин □ дүрсээр тэмдэглэж хөхөөр будсан байна. Хошууны нутгийн захыг улаан өнгийн босоо цэгэн зураасаар, захын овоодыг нийлсэн хос гурвалжин тэмдэгээр дүрсэлж, нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**118.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хан уулын аймгийн Булган хан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-14

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 35 см х 48 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Булган, Орхон, Бугат, Сайхан, Ингэт толгой, Тэшиг сум, Сэлэнгэ аймаг. Орхонтуул сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутагт байсан 13 тарианы газрыг дотроо олон зураастай дөрвөлжин тэмдэгтээр тэмдэглэж, “тариа” гэж бичжээ. Нутгийн хойд талын хэсэг нутгийг улаан өнгийн

үргэлжилсэн шугамаар зуржээ. Тэнд “25 дугаар оны хоёр хошууны нутгийн сав энэ”, зүүн баруун талд нь “вангийн авах хэмээдэг нутаг энэ” гэж бичжээ. Улаан, цэнхэр өнгө хосолсон дөрвөлжин зураад доор нь “засгийн гэр”, улаан, шар өнгө хосолсон дөрвөлжин зураад доор нь “Цоржийн хүрээ” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг зураагүй. Баруун өмнө талын захын овоодыг улаан өнгийн гурвалжин тэмдэгээр дүрсэлж, нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**119.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Сэлэнгэ мөрөнд цутгах Эвэрт голын адгийн тарианы газар

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-15

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 49.3 см х 98 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Сэлэнгэ гол, түүнд хойноос цутгах Эвэрт гол хоёрын бэлчирт байх тарианы газрыг хар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Эвэрт голын урсгалыг боосныг “энэ боолт” гэж, тарианы газар руу 3 шуудуу татсныг хөх өнгөөр будаад “энэ шуудуу” гэж бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**120.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Алдархаан уулын хошуу (1923-1929)

**Хошууны өмнөх нэр:** Халхын Сайн ноёны аймгийн Дашпунцаглин хийдийн харьяат нар

**Хошууны хожмын нэр:** Хан Тайшир уулын аймгийн Алдархаан уулын хошуу (1929-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-16

**Он:** он бичээгүй (1922-1924 ?)

**Хэмжээ:** 46.5 см х 47.9 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Улиастай, Алдархаан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 9.3 см х 10 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Завхан голын хойд биед зүүнээс баруун тийш “Гэсэр сүм”, “Улиастайн цэргийн хүрээ”, “худалдааны иргэдийн хот”, “хүрээ” зэргийг цувуулан зурж бичжээ. Хотыг хоосон дөрвөлжингөөр, цэргийн хүрээг давхар дөрвөлжингөөр тэмдэглэжээ. Шавийн нутгийн захыг улаан үргэлжид зураасаар, захын овоодыг онги О дүрсээр тэмдэглэж нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**121.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын дундад адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Хатанбаатар засгийн хошуу (1917-1923)

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Намнан уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-17

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 45 см х 35.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Хутаг-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Сэлэнгэ мөрний хойд биед 2 том хүрээг олон сүмийн барилгатай маш гоёмсогоор том хэмжээтэй зуржээ. Хүрээний нэрийг бичээгүй. Сэлэнгэ мөрөн, түүний цутгал Хануй, Улиастай зэрэг олон голуудын урсгалыг долгиолсон зураасаар зурж, хөх өнгөөр будсан байна. Хошууны нутгийн захыг зураагүй. Зүүн захын 4 овоо, баруун хойд захын 2 овоон дээр 2 давхар суурьтай гурвалжин оройтой том тэгш өнцөгт дөрвөлжин зураад дотор нь “пайз” гэж бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

**122.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Тамир голын хойд хөвөөн дэх нэгэн өртөөний нутаг

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-18

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 51 см х 24.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигийг бичээгүй. Тамир голын хойд биеэрх өртөөний нутгийг хар өнгийн цэгэн зураасаар зааглан зураад зүүн, баруун талд нь “өртөө нутгийн баруун зах”, “өртөө нутгийн зүүн зах” гэж бичжээ. “Өртөөний өвөлжөө” гэж бичсэн ч ямар нэгэн тэмдэгт зураагүй. Өртөөний нутгийн баруун талд сүм зурж, “хошуу хүрээ” гэж бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

**123.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын өрнө замын баруун гарын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Засагт хан аймгийн Далай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Тайшир уулын аймгийн Бүрэнтогтох уулын хошуу (1923-1929), Наранжаргалант уулын хошуу (1929-1931)

**Хөмрөг, данс, хад, нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-2, хн-19

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 78.5 см х 27.7 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгө ялгасан (нутгийн зах)

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Хөвсгөл аймаг. Бүрэнтогтох, Төмөрбулаг сум



**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн дөрвөлжин тор татаагүй. Ертөнцийн зүг чигээс өмнө, хойд зүгийг бичжээ. Уг зурагт буй сонирхолтой нэгэн тэмдэглэгээ бол Сангийн далай нуурны долгиолсон усанд хос цагаан хун, хос шар ангир, Зүүн нууранд гурван цагаан хун, хоёр шар ангир хөвж байгааг зурсан явдал юм. Нуруу, уул, толгой, хоолой, гол, булаг, ой модыг уламжлалт аргаар өнгө ялган зурж, Булнайн нуруунаас эхлээд бүгдийн нэрийг бичсэн байна. Хошууны нутгийн захыг улаан цэгэн болон үргэлжилсэн зураасаар тойруулан зуржээ. Түүн дээр 8 газар овгор дээр модон тэмдэг босгон зурж “шинэ тэмдэг” гэж бичжээ. Захын овоодыг тэмдэглээгүй. Уг нутгийн зургийг өмнө, хойд хоёр зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

### Данс–III хадгалагдаж буй Монгол нутгийн зураг

#### 124.Нутгийн зургийн нэр: Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Шажинбат сэвжидгацал уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-23

**Он:** 1922 (Олноо өргөгдсөний 12 он 10 сарын 19)

**Хэмжээ:** 69 см х 26 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тосонцэнгэл сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 3 см 3 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 этгээдийг бичжээ. Нутгийн төв хэсэгт 2 гэр зураад зүүн, баруун талд нь “засгийн суугаа газар”, “тамгын газар” гэж бичжээ. Хошууны нутагт байх 12 сүмийг зураад нэрийг бичилгүй орхижээ. Нутгийн дундуур өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг бүдэг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зуржээ. Зам хаана хүрэхийг бичээгүй. Зам дээр холбоо 2 онги дүрсэлсэн нь өртөөний газар байж магадгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Захын овоодыг тэмдэглээгүй, нэрийг бичээгүй. Нутгийн зургийн хойд, урд талд ямар хошуутай зах нийлэхийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Ашиглалтын хувьтай.

#### 125.Нутгийн зургийн нэр: Сайн ноён хан аймгийн жүн вангийн зэрэг Илдэн засаг төрийн бэйл Норовжанцангийн хошууны нутгийн зураг (sayin noyan qan ayimaγ-un geγün wang-un jerge ildeng jasaγ törü-yin beyile norbujangčan-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын дундад дахь өмнөд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-24

**Он:** 1922 (Олноо өргөгдсөний 12 он 7 сарын 20)

**Хэмжээ:** 49.5 см х 69.7 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Хужирт, Есөнзүйл, Өлзийт, Сант сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 4 см 4 см хэмжээтэй дөрвөлжин тор татсан нь зургийн гадна талд үлджээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хоосон дөрвөлжин зураад доод талд нь “засгийн суух газар”, гэр зураад “тамгын газар” гэж бичжээ. Гурван газар сүмийн барилга зурж, “сүм” гэж бичжээ. Хоосон дөрвөлжин зураад “Зээрэн өртөөний буурь” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураас, захын овоодыг босоо тэгш өнцөгтөөр тэмдэглэсэн ч заримынх нь нэрийг бичээгүй. Ямар хошуутай зах нийлэхийг хэдэн газар бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал дунд зэрэг. Сэлбэн засварлаж урагдаж алга болсон хэсэгт цаас нааж арлажээ. Ашиглалтын хувьтай.

**126.Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн жүн вангийн зэрэг Илдэн засаг төрийн бэйл Норовжанцангийн хошууны нутгийн зураг (sayin noyan qan ayimaγ-un geγün wang-un jerge ildeng jasaγ töγü-yin beyile norbujiangčan-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умар замын дундад дахь өмнөд хошуу

**Хошууны нэр:** Халхын Сайн ноён хан аймгийн Илдэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг Мандал уулын аймгийн Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-25

**Он:** 1922 (Олноо өргөгдсөний 12 он 7 сарын 20)

**Хэмжээ:** 46.3 см х 77 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Хужирт, Есөнзүйл, Өлзийт, Сант сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 4 см 4 см хэмжээтэй дөрвөлжин тор татсан нь зургийн гадна талдаа үлджээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хүрээтэй дөрвөлжин зураад доод талд нь “засгийн суух газар”, хоосон газар “тамгын газар” гэж бичжээ. Гурван газар сүмийн барилга зураад “сүм” гэж бичжээ. Хоосон дөрвөлжин зураад “Зээрэн өртөөний буурь” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураас, захын овоодыг босоо тэгш өнцөгтөөр тэмдэглэсэн ч заримынх нь нэрсийг бичээгүй. Ямар хошуутай зах нийлэхийг хэдэн газар бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**127.Нутгийн зургийн нэр:** Богд хан уулын аймгийн Дэлгэрцогт уулын хошууны нутгийн зураг (boγda qan aγula-yin ayimaγ-un delgerčoytu aγula-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Манжийн эрхшээлийн үеийн албан ёсны нэр:** Халхын умар замын зүүн гарын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны өмнөх нэр:** Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошуу

**Хошууны албан ёсны нэр:** Богд хан уулын аймгийн Дэлгэрцогт уулын хошуу (1923-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-26

**Он:** 1924 (Монгол улсын 14 он илүү 10 сарын 7)

**Хэмжээ:** 90.5 см х 84 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** даавуу

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Дундговь аймаг. Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Дэрэн, Говь-Угтаал, Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өндөршил, Луус, Төв аймаг. Баян-Өнжүүл, Баянцагаан сум.

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 6 см х 6 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. Хошууны нутгийн төв хэсэгт улаан халзтай гэр зураад доод талд нь “албаны гэр” гэж бичжээ. Давхар дөрвөлжин зурж шараар будаад “их жас”, “шавь жас”, “хорин жас”, “хурал жас”, “чойр жас”, “эмт жас”, “даш жас”, “жадамба жас” зэргээр нэрийг бичжээ. Хошууны нутгийн дундуур уртрагийн дагуу гарах Сайр ус-Нийслэл Хүрээний өртөөний замыг шар үргэлжилсэн зураасаар зурж, “Халхын өртөөдийн зам” гэж бичжээ. Найман өртөөг цэнхэр өнгийн онги О тэмдэгээр тэмдэглэж, нэрийг бичсэн нь Номхон өртөө, Ар ус өртөө, Баян хошуу өртөө, Бор даага өртөө, Тойром өртөө, Модон өртөө, Наран өртөө юм. Хошууны нутгийн урдуух өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг ногоон өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Уг зам хаана хүрэхийг бичээгүй. Хошууны нутгийн захыг улаан өнгийн үргэлжид зураасаар зуржээ. Захын овоодыг П хэлбэрийн дүрс, улаан ба цэнхэр өнгийн өндөр гурвалжин тэмдэгээр тэмдэглэж, нэрсийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**128.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Цэцэрлэг мандал уулын аймгийн Алдархаан уулын хошуу (1923-1929)

**Хошууны өмнөх нэр:** Халхын Сайн ноёны аймгийн Дашпунцаглин хийдийн харьяат нар

**Хошууны хожмын нэр:** Хан Тайшир уулын аймгийн Алдархаан уулын хошуу (1929-1931)

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-27

**Он:** 1924 (Монгол улсын 14 он 10 сарын шинийн 4)

**Хэмжээ:** 51 см х 52 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Улиастай, Алдархаан сум

**Товч тодорхойлолт:** Балын харандаагаар хэмжээсийн 3.2 см х 3.2 см хэмжээтэй дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 зүгийг бичжээ. “Улиастайн цэргийн хүрээ”-г торлосон улаан дөрвөлжин дүрсээр, “худалдааны хот”-ыг том тортой улаан босоо дөрвөлжин дүрсээр, “өвсний газар”-ыг ногоон өнгийн тортой дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Өртөөг онгин чандманиар тэмдэглэж, “Алдар өртөө” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан үргэлжилсэн зураасаар, захын зарим овоодыг дээрээ онгитой гурвалжин дүрсээр тэмдэглэж нэрийг бичжээ. Уг нутгийн өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**129.Нутгийн зургийн нэр:** Богд хан уулын аймгийн Авзага хайрхан уулын хошууны нутгийн зураг (boγda qan ayula-yin ayimaγ-un abjuγ qayirqan ayula-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Монгол улсын Богд хан уулын аймгийн Авзага хайрхан уулын хошуу

**Хошууны өмнөх нэр:** Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-30

**Он:** 1925 (Монгол улсын 15 он 10 сарын 15)

**Хэмжээ:** 63 см х 63.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга 1 удаа дарсан (огноо дээр)

**Одоогийн засаг захиргаа:** Монгол улс.Булган аймаг. Могод, Хишиг-Өндөр, Бүрэг хангай сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 2.8 см х 2.8 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ. Зүг чигийн хүрд ашиглан зурахдаа зургийн гадна талаар хүрээ татаад 24 зүгийг бичжээ. Хошууны нутгийн дундуур уртрагийн дагуу 1, өргөргийн дагуу 1 зам дайран гардагийг шар өнгийн үргэлжид зураасаар зурж, “хуурай зам” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан үргэлжилсэн зураасаар, захын зарим овоодыг дээрээ тэгш гурвалжин дүрсээр тэмдэглэж нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал муу. Нутгийн зургийн багагүй хэсэг зуларч харагдахгүй болжээ. Ашиглалтын хувьтай.

### **130.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Зургийн агуулга:** Монгол улсын нэгэн хошуу, шавийн отгийн нутгийн зураг (Дэлгэр их уулын аймгийн Зогсоол жаргалант уулын хошуу)

**Хошууны нэр:** Дэлгэр их уулын аймгийн Зогсоол жаргалант уулын хошуу (1925-1929)

**Хошууны өмнөх нэр:** Түшээт хан аймгийн Дархан засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-31

**Он:** 1925 (Монгол улсын 15 он 12 сарын 8)

**Хэмжээ:** 36.5 см х 46.8 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Дундговь аймаг. Цагаандэлгэр, Төв аймаг. Баян, Баян-Өнжүүл, Баянжаргалан, Баянцагаан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 3.2 см х 3.2 см хэмжээтэй улаан дөрвөлжин тор татжээ. Ертөнцийн 4 зүг чигийг бичжээ. Хошууны зүүн урд хэсэгт сүм зураад доор нь “Бодь их амгалант сүм” гэж бичжээ. Хошууны нутгийн дундуур уртрагийн дагуу 1 зам дайран гардагийг шар өнгийн үргэлжид зураасаар зурж, “энэ Хүрээ зам” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан үргэлжилсэн зураасаар, захын зарим овоодыг 4 дүрсээр тэмдэглэжээ. Захын овоодыг дугаарлан нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

### **131.Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын ..... замын ..... хошуу

**Зургийн агуулга:** Монгол улсын нэгэн хошуу, шавийн отгийн нутгийн зураг (Дэлгэр их уулын аймгийн Зогсоол жаргалант уулын хошуу)

**Хошууны нэр:** Дэлгэр их уулын аймгийн Зогсоол жаргалант уулын хошуу (1925-1929)

**Хошууны өмнөх нэр:** Түшээт хан аймгийн Дархан засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-32

**Он:** он бичээгүй

**Хэмжээ:** 50 см х 51.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** өнгөт  
**Зурсан эд:** цаас  
**Тамга:** тамга дараагүй

**Одоогийн засаг захиргаа:** Дундговь аймаг. Цагаандэлгэр, Төв аймаг. Баян, Баян-Өнжүүл, Баянжаргалан, Баянцагаан сум

**Товч тодорхойлолт:** Хэмжээсийн 3.3 см х 3.4 см хэмжээтэй улаан өнгийн дөрвөлжин тор татжээ.-Ертөнцийн 4 зүг чигийг бичжээ. Нутгийн зүүн өмнөд хэсэгт сүмийн барилга зураад доор нь “Бодь их амгалант сүм” гэж бичжээ. Хошууны нутгийн дундуур уртрагийн дагуу 1 зам дайран гардагийг шар өнгийн үргэлжилсэн зураасаар зурж, “энэ Хүрээн зам” гэж бичжээ. Хошууны нутгийн захыг улаан үргэлжилсэн зураасаар зурж, захын зарим овоодыг улаан дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Захын овоодыг дугаарлан нэрийг бичжээ. Уг нутгийн зургийг өмнө зүгээс харж үйлджээ. Хадгалалтын байдал сайн. Ашиглалтын хувьтай.

**132.Нутгийн зургийн нэр:** Богд хан уулын аймгийн Зогсоол жаргалантын хошууны нутгийн хязгаар уулзарын булан тохойг гаргаж эрс чигээр болгох байдлыг төлөвлөн зурсан шинэ зураг (boγda qan aγula-yin ayimaγ-un joγsuγaljirγalangtu-yin qosiyun-u nutuγ-un kijaγar aγuljar-un bulung toqui-yin γarγaju eres čige-iyer bolγaqu bayidal-yi tölüblen jiruγsan sin-e jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Богд хан уулын аймгийн Зогсоол жаргалантын хошуу (1923-1925), Дэлгэр их уулын аймгийн Зогсоол жаргалант уулын хошуу (1925-1929)

**Хошууны өмнөх нэр:** Түшээт хан аймгийн Дархан засгийн хошуу

**Хөмрөг, данс, хад. нэгж:** Газрын зургийн цуглуулга. х-460, д-3, хн-33

**Он:** он бичээгүй (1923-1925)

**Хэмжээ:** 47 см х 49.5 см

**Бичвэрийн хэл:** монгол

**Өнгө:** хар цагаан

**Зурсан эд:** цаас

**Тамга:** тамга дараагүй

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй дүрсэлж, хооронд нь улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичсэн байна. Уул, нуруу, толгойг хар бэхээр зураад ногоон, зарим хэсгийг хүрэн өнгөөр давхарлан буджээ. Урт үргэлжлэх “Бүсийн чулууг” онцгой байдлаар хүрэн өнгөөр будаад бүрд, худаг, булгийг цайвар хөх өнгөөр зуржээ. Гүн Гомбожавын албан гэр, номын өргөөг мөн тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах гурван чиглэлийн өртөө замыг цэгэн шугам татаж дүрсэлсэн байна. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим бичвэр ховхорч унасан байна. Зургийн гол хэсэг үрэгдэж цоорсон байна. Хадгалалт хэвийн.

48. **Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн хэвэй засгийн улсад туслагч гүн На-гийн хошууны газар орны зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un kebei jasaγ-un ulus-tur tusalaγči güng na-yin qosiyun-u nutuγ-un γajar orun-u jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дархан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-48

**Он:** 1900 (Бадаргуулт төрийн 26 он зуны дундад сарын 24)

**Хэмжээ:** 51 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Дорноговь аймаг. Иххэт сум, Төв аймаг. Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичсэн байна. Уул, нуруу, толгойг хараар зурж ногоон, зарим хэсгийг хүрэн өнгөөр давхарлан буджээ. Урт үргэлжлэх “Бүсийн чулууг” онцгойлон хүрэн өнгөөр будаад бүрд, худаг, булгийг цайвар хөх өнгөөр зуржээ. Гүн Гомбожавын албан гэр, номын өргөөг тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах гурван чиглэлийн өртөө замыг цэгэн шугам татан дүрсэлсэн байна. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим бичвэр ховхорч унажээ. Хадгалалт хэвийн.

49. **Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн хэбэй засгийн улсад туслагч гүн Нармандахын хошууны нутгийн газар орны зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un kebei jasaγ-un ulus-tur tusalaγči güng naramangdaqu-yin qosiyun-u nutuγ-un γajar orun-u jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дархан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-49

**Он:**1907 (Бадаргуулт төрийн 33 он хаврын сүүл сарын 13)

**Хэмжээ:** 51 см х 55 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Дорноговь аймаг. Иххэт сум, Төв аймаг. Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хараар дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичсэн байна. Уул, нуруу, толгойг хараар зурж ногоон, зарим хэсгийг хүрэн өнгөөр давхарлан буджээ. Урт үргэлжлэх “Бүсийн чулууг” онцгойлон хүрэн өнгөөр будаад бүрд, худаг, булгийг цайвар хөх өнгөөр зуржээ. Гүн Гомбожавын албан гэр, номын өргөөг тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах гурван чиглэлийн өртөө замыг цэгэн шугам татаж дүрсэлсэн байна. Газар усны нэр, тайлбарыг цаасан дээр бичиж наажээ. Гурван хэсэг газар зэргэлдээх хошууны тухай мэдээллийг бичсэн байна. Зарим бичвэр ховхорч унасан бололтой. Хадгалалт хэвийн.

50. **Зургийн нэр:** Хэбэй засгийн улсад туслагч гүнгийн хошууны нутгийн газар орны зураг (*kebei jasaγ-un ulus-tur tusalaγči güng-ün qosiγun-u nutuγ-un γajar orun-u jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дархан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-50

**Он:**1907 (Бадаргуулт төрийн 33 он хаврын сүүл сарын 13)

**Хэмжээ:** 52 см х 57 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Дорноговь аймаг. Иххэт сум, Төв аймаг. Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Улаан шунхаар хошууны хилийг зураад уул, толгойг хар, ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Чулуу зурж хүрэн, ногооноор өнгө

ялгажээ. Гол мөрөн, бүрд, булаг, худгийг хөх өнгөөр давхарлан будсан байна. Ноёны өргөө, албан газрыг дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэсэн байна. Нутгийн дундуур явах гурван чиглэлийн замыг олон жижиг цэгэн шугам татаж тэмдэглэжээ. Газар усны нэр, тайлбарыг цагаан цаасан дээр бичиж наасан байна. Хошууны газар нутаг, байршлын талаар нэмэлт хоёр хэсэг тэмдэглэгээг тусад нь бичиж наажээ. Хадгалалт дунд зэрэг.

**51. Нутгийн зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн хэбэй засгийн улсад туслагч гүн Нармандахын хошууны нутгийн газар орны зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un kebei jasaγ-un ulus-tur tusalaγči gūng naramangdaqu-yin qosiγun-u nutuγ-un γajar orun-u jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дархан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-51

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он хаврын сүүл сарын 29)

**Хэмжээ:** 52 см x 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Дорноговь аймаг. Иххэт сум, Төв аймаг Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см x 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургий дөрвөн талд зүг чигийг бичжээ. Улаан шунхаар хилээ зурсан байна. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичжээ. Уул, нуруу, толгойг хараар зураад цэнхэр, ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, булаг, бүрд, худгийг хөх өнгөөр давхарлан буджээ. Бүрдийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Нутгийн дундуур явах гурван замыг олон жижиг цэгэн шугам татан тэмдэглэжээ. Биет дүрслэлийн аргаар сүм хийд, тамгын газрыг тод зуржээ. Зургийн хадгалалт сайн.

**52. Зургийн нэр:** Хэбэй засгийн улсад туслагч гүн На-гийн хошууны нутгийн газар орны зураг (*kebei jasaγ-un ulus-tur tusalaγči gūng na-yin qosiγun-u nutuγ-un γajar orun-u jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дархан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-52

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он хаврын сүүл сарын 29)

**Хэмжээ:** 52 см x 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** 1 удаа тамга дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дархан сум, Дорноговь аймаг. Иххэт сум, Төв аймаг. Баянжаргалан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийнхаа дөрвөн талд зүг чигийг бичжээ. Улаан шунхаар зураас татан хил зурсан байна. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичжээ. Уул, нуруу, толгойг хараар зураад цэнхэр, ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, булаг, бүрд, худгийг хөх өнгөөр давхарлан будсан байна. Бүрдийг зоос мэт дугуй хэлбэртэй зуржээ. Нутгийн дундуур явах гурван замыг олон жижиг цэгээр тэмдэглэжээ. Сүм хийд, тамгын газрыг биет дүрслэлийн аргаар тод зуржээ. Зургийн хадгалалт сайн.

**53. Зургийн нэр:** Засаг Цэрэндаш, 10 дугаар он (*jasay čeringdasi 10 duqar on*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-53

**Он:** 1805 (Засаг Цэрэндаш 10 он)

**Хэмжээ:** 91 см х 89 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй ажээ. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хоёр ижил улаан гурвалжин хэлбэртэй тэмдэгтээр дүрсэлж, улаан шунх татан хилээ зуржээ. Уул, нуруу, толгойг хараар зурж, хадтай уулсыг улбар, ойт уулсыг хөх, ногоон өнгөөр давхарлан будсан байна. Зарим уулын оройд овоо зуржээ. Тэрэлжийн голыг тод дүрслээд ногоон өнгөөр буджээ. Нуур, гол мөрөн, булгийг хөх өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зах нийлэх хошууны мэдээллийг нутгийн зургийн дөрвөн талд бичжээ. Хадгалалт хэвийн.

**54. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-54

**Он:** Он бичээгүй (1804-1858)

**Хэмжээ:** 64 см х 62 см

**Бичвэрийн хэл:** Монгол



**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зураг тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургийн суурийг ногоон өнгийн шороон будгаар нилэнхүйд нь буджээ. Хил залгаа хошуу нутгийн мэдээллийг зургийн дөрвөн талд бичжээ. Мод, хадтай уул, нуруу, толгодыг өнгө ялган зураад зарим уулын оройд овоо зурсан байна. Гол, нуур, булгийг усан хээгээр угалзлуулан зурж хөх өнгөөр давхарлан буджээ. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Сүм хийд, суурин газрыг дүрслээгүй. Хар өнгөөр нуур зурж “Хар нуур” хэмээн бичжээ. Зургийн зарим хэсэг урагдаж алга болсон байна. Тус нутгийн зураг нэргүй. “Сэцэн хан аймгийн Мэргэн гүний хошууны нутгийн зураг” хэмээн хожуу шинэ үсгээр цагаан цаасан дээр бичээд зургийн зүүн дээд буланд наажээ. Хадгалалт муу.

**55. Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн засаг Дашцэрэндоржийн хошууны нутгийн зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un jasaγ dasiγčerindorji-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-55

**Он:** 1864 (Бүрэнт засагчийн 3 он намрын дундад сарын 25)

**Хэмжээ:** 48 см х 49 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Улаан дугуй хэлбэртэй дүрсээр хилийн овоог зураад өмнө зүгээс эхлэн дугаарлан бичжээ. Уул, нуруу, толгойг хараар зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Нуур, гол мөрөн, булгийг хар өнгөөр товгор дүрслэлийн аргаар угалзлуулан зурж хөх өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Улаан, цэнхэр өнгөөр монгол гэр зураад “албан газар” гэж бичжээ. Сүм хийдийг дүрслээгүй. Нутгийн дундуур явах өртөө замыг цэгэн шугам татан тэмдэглэжээ. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим наалт ховхорч үрэгдсэн бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**56. Зургийн нэр:** Улсад туслагч гүнгийн зэрэг засгийн тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбын хошууны нутгийн зураг (*ulus-tur tusalaγči güng-ün jerge jasaγ-un terigün jerge tayji čeringγombu-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-56

**Он:** 1900 (Бадаргуулт төрийн 26 оны зуны дунд сарын 24)

**Хэмжээ:** 52 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй хэлбэртэй дүрсэлж ягаан шунхаар хүрээ татжээ. Өмнө зүгээс эхлэн дугаарлан бичээд 32 овоог тэмдэглэжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол, нуур, булгийг хараар товгор дүрслэлийн аргаар угалзлуулан зурж, хөх өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Хар бэхээр гэр зурж дээвэр хэсгийг улаанаар давхарлан буджээ. Сүм хийд зураагүй. Нутгийн дундуур явах хоёр замыг жижиг ягаан цэгэн шугам татаж тэмдэглэжээ. Зургийн хадгалалт хэвийн.

57. **Зургийн нэр:** Шадарт явах улсад туслагч гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбын хошууны нутгийн зураг (*sidar-tur yabuqu ulus-tur tusalaγči gūng-ün jerge jasaγ teregün jerge tayiji čeringγombu-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-57

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 оны хаврын дундад сарын 18)

**Хэмжээ:** 50 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог дугуй хэлбэртэй дүрсэлж улаан шунхаар хүрээ татжээ. Хил залгаа хошууны мэдээллийг зургийн дөрвөн буланд бичжээ. Уул, нуруу, толгодыг хараар зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол, нуур, булгийг хар өнгөөр товгор дүрслэлийн аргаар угалзлуулан зурж, хөх өнгөөр буджээ. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Гэрийг хар бэхээр зураад дээвэр хэсгийг улаан өнгөөр давхарлан будсан байна. Сүм хийд зураагүй. Нутгийн дундуур дайран өнгөрөх хоёр өртөө

замыг улаан шугам татаж тэмдэглэжээ. Газрын усны нэр, тайлбарыг цагаан цаасан дээр бичиж наасны дийлэнх нь үрэгдэж алга болсон бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

- 58. Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн шадарт явах улсад туслагч гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбын хошууны нутгийн зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un sidar-tur yabuqu ulus-tur tusalayči güng-ün jerge jasaγ teregün jerge tayiji čeringγombu-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-58

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 оны хаврын сүүл сарын 26)

**Хэмжээ:** 49 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичсэн байна. Уул, нуруу, толгодыг хараар зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, нуур, булгийг хараар угалзлуулан зурж, хөх өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Хошуу тамгын албан газрыг хар бэхээр зураад дээвэр хэсгийг хүрэн улаан өнгөөр буджээ. Сүм хийд зураагүй. Газар усны нэр, тайлбарыг хар бэхээр бичжээ. Улаан цаасан дээр “Чулуу, нүүрсний уурхай буй” гэж бичиж наасан байна. Зургийн хадгалалт хэвийн.

- 59. Нутгийн зургийн нэр:** Шадарт явах улсад туслагч гүнгийн зэрэг засгийн тэргүүн зэрэг тайж Цэрэнгомбын хошууны нутгийн зураг (*sidar-tur yabuqu ulus-tur tusalayči güng-ün jerge jasaγ-un teregün jerge tayiji čeringγombu-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Өндөр цагаан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-59

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он хаврын сүүл сарын 26)

**Хэмжээ:** 51 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Хэрлэн, Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог дугуй хэлбэртэй дүрсэлж улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан бичсэн байна. Уул, нуруу, толгойг хараар зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол, нуур, булгийг хар өнгөөр товгор дүрслэлийн аргаар угалзлуулан зурж, хөх өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Хошуу тамгын албан гэрийг хар бэхээр зурж хүрэн улаанаар давхарлан зуржээ. Сүм хийд зураагүй. Газар усны нэр, тайлбарыг хар бэхээр бичсэн байна. Зургийн хадгалалт хэвийн.

**60. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын зүүн замын баруун гарын дундад өмнө хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-60

**Он:** Он бичээгүй [1779-1808]

**Хэмжээ:** 47 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хил залгаа хошууны ноёдын нэрийг тойруулан тэмдэглэжээ. Уул, нуруу, толгодын хэв шинжийг ялгаатай байдлаар зурж бүдэг ногоон өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуур булаг, шандыг хараар зурж цайвар хөх өнгөөр буджээ. Нуур, булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Уг нутгийн зурагт огноог тэмдэглээгүй боловч зургийн төв хэсэгт засаг Чавагжав хэмээн улаан бэхээр бичсэнээс үзэхэд 1779-1808 оны үед зурсан бололтой. Газар усны нэр, тайлбарыг улаан бэхээр бичжээ. Зургийн хадгалалт хэвийн.

**61. Зургийн нэр:** Засаг Чавагжав, аравдугаар он (*јasaγ čibaγjab arbadaγar on*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын зүүн замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-61

**Он:** 1805 (Сайшаалтай ерөөлтийн 10 он илүү 6 сарын 20)

**Хэмжээ:** 89 см х 58 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Бор цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Зургийг бор муутуу цаасан дээр өнгө ялган зуржээ. Хилийн овоог хос гурвалжин хэлбэртэй дүрслээд хооронд нь бүдэг улаан шунхаар шугам татжээ. Хил залгаа хошуу нутгийн мэдээллийг зургийг тойруулан бичсэн байна. Уул, нуруу, толгойг бүдэг ногоон, хүрэн өнгөөр буджээ. Гол мөрөн, нуур, булаг, худгийг хөх өнгөөр будаад, зарим булаг худгийг огт будаагүй байна. Нуур, булаг, худгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Усан хээгээр голын урсгалыг дүрсэлжээ. Сүм хийд, суурин газрыг огт тэмдэглээгүй. Зургийн булан болон гол хэсэг цоорсон байна. Хадгалалт муу.

62. **Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж Чадраабалын хошууны нутгийн зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un jasaγ-un terigün jerge tayiji čadarabala-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын зүүн замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-62

**Он:** 1864 (Бүрэнт засагчийн 3 оны намрын сүүл сарын шинийн 1)

**Хэмжээ:** 50 см х 51 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татан үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан өнгөтэй дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлан 40 овооны нэр бичжээ. Уул, нуруу, толгойг хараар зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Уулын өндрийн хэмжээг тэмдэглэсэн байна. Зарим уулын оройд овоо зуржээ. Гол мөрөн, нуур, булаг, шандыг хараар зураад хөх өнгөөр будсан байна. Нуур, булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Тамгын газар, хошуу ноёны гэрийг дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэсэн байна. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг жижиг цэгэн шугам татан дүрсэлжээ. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим нь гээгджээ. Зургийн хадгалалт хэвийн.

63. **Зургийн нэр:** Сэцэн хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг засгийн тэргүүн зэрэг тайж арван гурван зэрэг нэмсэн арван зэрэг тэмдэглэсэн Лхамжавсүрэнгийн хошууны нутгийн зураг (*sečen qan ayimaγ-un ulus-tur tusalaγči güng-ün jerge jasaγ-un terigün jerge tayiji arban γurban jerge nemegsen arban jerge temdeglegsен lhamujabsürüng-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын зүүн замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-63  
**Он:**1900 (Бадаргуулт төрийн 26 он зуны дундад сарын 25)

**Хэмжээ:** 51 см х 50 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татжээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлаад 40 овоог тэмдэглэжээ. Уул, нуруу, толгойг хараар зурж ногооноор давхарлан буджээ. Уулын өндрийн хэмжээг тэмдэглэсэн байна. Зарим уулын оройд овоо зуржээ. Гол, нуур, булаг, шандыг хараар зураад хөх өнгөөр будсан байна. Нуур, булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Тамгын газар, хошуу ноёны гэрийг дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэсэн байна. Нутгийн дундуур дайран өнгөрөх хэд хэдэн өртөө замыг цэгэн шугам татаж тэмдэглээд давхарлан шар өнгөөр буджээ. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим гээгдсэн бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

64. **Зургийн нэр:** Засгийн тэргүүн зэрэг тайж долоон зэрэг нэмсэн хоёр зэрэг тэмдэглэсэн Мишигдоржийн харьяат хошууны нутгийн зураг (*ᠵᠠᠰᠢᠭᠢᠨ ᠲᠡᠷᠭᠦᠨ ᠵᠡᠷᠭᠡ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠰᠡᠨ ᠮᠢᠰᠢᠭᠳᠣᠷᠵᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶ᠋ᠠᠲ ᠬᠣᠰᠤᠭᠤ ᠨᠤᠲᠦᠭᠢᠨ ᠵᠡᠷᠭᠡ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠨ ᠴᠣᠶᠠᠷ ᠵᠡᠷᠭᠡ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠭᠰᠡᠨ ᠮᠢᠰᠢᠭᠳᠣᠷᠵᠢ-ᠶᠢᠨ ᠴᠠᠷᠢᠶᠠᠲᠤ ᠴᠣᠰᠢᠬᠤᠨ-ᠤ ᠨᠤᠲᠦᠭᠢᠨ ᠵᠢᠷᠦᠭᠦ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын зүүн замын баруун гарын дундад өмнөх хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дашбалбар уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-64

**Он:**1907 (Бадаргуулт төрийн 33 он гурван сарын 29)

**Хэмжээ:** 52 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Дэлгэрхаан, Баянмөнх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй дүрслээд хар харандаагаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлаад 40 овоог тэмдэглэжээ. Уул, нуруу, толгодыг хараар зурж ногоон, шараар давхарлан будсан байна. Уулын өндрийн хэмжээг бичжээ. Зарим уулын оройд овоо зуржээ. Гол, нуур, булгийг хараар зурж хөх өнгөөр будсан байна. Нуур, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Тамгын газар, хошуу ноёны гэрийг дөрвөлжин хэлбэртэй

дүрсэлжээ. Сүм хийд зураагүй. Нутгийн дундуур дайран өнгөрөх хэд хэдэн өртөө замыг цэгэн шугам татаж тэмдэглээд давхарлан шар өнгөөр будаад “Жибзундамба хутагтын Их Хүрээнээс Долоон нуур орох зам” хэмээн тодотгон бичжээ. Зургийн хадгалалт хэвийн.

- 65. Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн гүнгийн зэрэг засгийн засгийн тэргүүн зэрэг тайж Гомбожавын хошууны нутгийн зураг (*qala-a-yin sečen qan ayimaγ-un güng-ün jerge jasaγ-un teregün jerge tayiji γombujab-un qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянхан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-65

**Он:** 1864 (Бүрэнт засагчийн 3 он намрын тэргүүн сарын 17)

**Хэмжээ:** 39 см х 46 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Жаргалтхаан, Цэнхэрмандал сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Өмнө зүгээс эхлэн хилийн овоог дугаарлан 25 овоог тэмдэглэжээ. Уул, нуруу, толгойг хараар зурж ногооноор давхарлан будсан байна. Зарим уулын өндрийн хэмжээг тэмдэглэжээ. Гол, нуур, булгийг хар бэхээр зурж, хөх өнгөөр буджээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх хоёр замыг цэгэн шугам татаж тэмдэглээд “Энэ зам Жибзундамба хутагтын Их Хүрээ хүрмүй” гэж бичжээ. Хошууны тамгын газар, сүм хийд, суурин газрыг огт тэмдэглээгүй. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим нь гээгдсэн бололтой. Мөн цаас гандаж цайралт өгчээ. Хадгалалт муу.

- 66. Зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн гүнгийн зэрэг засгийн тэргүүн зэрэг тайж Цэрэндондов агсны хошууны нутгийн зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un güng-ün jerge jasaγ-un terigün jerge tayiji čeringdondub aγsan-u qosiγun-u nutuγ-yin jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын баруун гарын дундад зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянхан уулын хошуу (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-66

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он зуны тэргүүн сарын 3)

**Хэмжээ:** 55 см х 56 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Жаргалтхаан, Цэнхэрмандал сум

**Тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог улаан дугуй хэлбэртэй дүрслээд улаан шунхаар хүрээ татжээ. Хилийн овоог өмнө зүгээс эхлэн дугаарлаад 26 овоог тэмдэглэжээ. Уул, нуруу, толгойг хараар зураад ногоон өнгөөр давхарлан будсан байна. Зарим уулын өндрийн хэмжээг бичжээ. Гол, нуур, булаг, шандыг хар бэхээр зураад хөх өнгөөр буджээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх хоёр өртөө замыг улаан өнгө бүхий цэгэн шугам татаж тэмдэглэжээ. Хошууны тамгын газар, сүм хийд, суурин газрыг огт тэмдэглээгүй. Зургийн будаг ууссан байдалтай байна. Хадгалалт дунд зэрэг.

**67. Зургийн нэр:** Засгийн тэргүүн зэрэг тайж Навааншүхэр агсны хошууны нутгийн зураг (*jasaγ-un terigün jerge tayiji nawangsikür aγsan-u qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын дорно замын дундад баруун этгээдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Далай дархан засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хан Хэнтий уулын хошуу

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-67

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он зуны тэргүүн сарын шинийн 6)

**Хэмжээ:** 75 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Хэнтий аймаг. Өмнөдэлгэр, Цэнхэр мандал, Батширээт сум, Төв аймаг. Мөнгөн морьт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6.5 см х 6.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй дүрслээд хооронд нь улаан шунхаар хүрээ татжээ. Өмнө зүгээс эхлэн хилийн овоог дугаарлан 29 овоог тэмдэглэсэн байна. Хошууны ерөнхий байрлал урагшаа сунаж тогтсон байдалтай. Уул, нуруу, толгодыг хараар зурж ногоон өнгөөр давхарлан будаад өндөр уулын оройг будаагүй байна. Зарим уулын өндрийн хэмжээг бичжээ. Гол, нуур, булгийг цэнхэр өнгөөр зурсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Хоёр гэр зурж “албаны газар” гэж тэмдэглээд дөрвөлжин дүрсээр нэг хийд зуржээ. Нутгийн дундуур явах хоёр замыг цэгэн шугам татан дүрсэлж “Энэ зам Жибзундамба хутагтын Хүрээ хүрмүй” гэж бичжээ. Зургийн хадгалалт сайн.

**68. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Сэцэн хан аймгийн Далай Дархан засгийн хошуунаас Түшээт хан аймгийн Дархан засгийн хошуутай зах нийлэх зарим овоодын зураг (Хэрлэн, Онон голын эх)



**Архив:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-68

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 51 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Бор муутуу цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Төв аймаг. Мөнгөнморьт сум, Хэнтий аймаг. Өмнөдэлгэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн доод хэсэгт өмнө зүгийг тэмдэглэжээ. Хилийн овоог хоёр цэг, зарим газар гурван цэг хатгах байдлаар зуржээ. Нутгийн дундуур овоо хооронд хүрэн өнгөөр шугам татжээ. Уул, голыг хар бэхээр зураад уулсыг модтой зуржээ. Сүм хийд, суурин газрыг огт тэмдэглээгүй. Уг зурагт Хэнтий хан уул, Хэрлэн, Онон, Тэрэлж голуудыг зурсан байна. Зургийн төв хэсэгт шинэ байгуулах овоо, мөн эвдэн устгах овооны нэрийг бичжээ. Хошуу хоорондын маргаантай газар нутгийг тэмдэглэсэн бололтой. Хадгалалт хэвийн.

**69. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Орос зүг тавьсан Сэцэн хан аймгийн Тоосог гэр харуулын нутгийн зураг

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-6, хад. нэгж-69

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Баяндун сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Уулсыг хар бэхээр зураад хүрэн, шараар өнгө ялган буджээ. Зарим уулын модтой зуржээ. Гол мөрөн, нуур, булгийг хөх дэвсгэр дээр усан хээгээр дүүргэн зуржээ. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Доосог гэр харуулын нутгийг тэмдэглэсэн бололтой. Зочийн гол, Түргэний голыг зургийн дээд хэсэгт зураад тайлбар бичжээ. Сүм хийд, суурин газрыг зураагүй. Гэр харуулын нутгийг дөрвөлжин хүрэн дотор багтаан дүрсэлсэн байна. Хадгалалт хэвийн.

**70. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Орос зүг тавьсан Сэцэн хан аймгийн Хурц гэр харуулын нутгийн зураг

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-6, хад. нэгж-70

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 49 см х 50 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Баяндун сум

**Товч тодорхойлолт:** Уг харуулын зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Зүг чиг тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хүрэн, шар, цэнхэр өнгөөр будаад зарим уулсын оройг модтой дүрсэлжээ. Гол мөрөн, нуур, бүрдийг өнгө ялган цэнхэр өнгөөр будсан байна. Нуурыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Нутгийн зураг нь өнгөт товгор дүрслэлтэй ажээ. Сүм хийд, суурин газрыг зураагүй. Улзын голын хойно орших Их Түргэний голыг дагасан харуулын нутгийг тэмдэглэжээ. Баруун зүг Бэрхийн харуул, зүүн зүг Доосог гэр харуулын нутгийг зурсан байна. Хадгалалт хэвийн.

#### 4.2. ХАЛХЫН ТҮШЭЭТ ХАН АЙМГИЙН НУТГИЙН ЗУРАГ

##### Данс.МНЗ-II

71. **Зургийн нэр:** Энэ нь журганд бичиг барихад гэж барьсан дүрэм буй ... (ene inu jiryan-du bičig bariqui-dur geju bariyan dūrim bui ...)

**Аймгийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн нутгийн бүдүүвч зураг

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-1

**Он:** Он бичээгүй [1730-1742]

**Хэмжээ:** 96 см x 90 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Булган, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт 25 см х 25 см дөрвөлжин хүрээ татсан байна. Зургийг тойруулан хар гурвалжин хэлбэртэй дүрсээр зүг чигийг тэмдэглэжээ. Хүрээний дотор талд зургийг тойруулан газар усны нэрийг бичсэн байна. Зургийн дотор гурвалжин хэлбэртэй дүрс зураад 18 засаг ноёны нэрийг цувуулан бичжээ. Уул, нуруу, толгод, нуур, гол мөрөн, булаг шандыг зураагүй. Мөн сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зургийн доод хэсэгт “Энэ нь журганд бичиг барихад гэж барьсан дүрэм буй. Тэгэвч журганд 4 зүг 4 зовхисын газрын нэрийг тавьж барьсан нь олон нэрийг бичсэн ... буй” гэж бичжээ. Зургийн дунд хэд хэдэн газар цоорсон байна. Уг зураг тус архивын хамгийн хуучин зураг юм. Хадгалалт муу.

72. **Зургийн нэр:** Дөчин тавдугаар он эрхэлсэн сайдыг айлтган тогтоож зурсан зураг (*dehi sunjači aniya aliha amban-be wesimbume toγtofi niruha niruγan*)

**Аймгийн албан ёсны нэр:** Халхын Түшээт хан аймаг

**Аймгийн нэр:** Түшээт хан аймаг

**Аймгийн хожмын нэр:** Богд хан уулын аймаг (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-2

**Он:** 1780 (Дөчин тавдугаар он)

**Хэмжээ:** 78 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Манж, Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Булган, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймаг

**Товч тодорхойлолт:** Уг зурагт тор татаагүй ажээ. Улаан шунхаар хүрээ татаж хил хязгаараа тэмдэглэсэн байна. Уул, нуруу, толгойг хараар зурж ногоон, шар өнгөөр давхарлан буджээ. Сүм хийдийг дөрвөлжин хэлбэртэй зураад дээвэр хэсгийг хүрэн өнгөөр буджээ. 4 сүм дүрсэлсэн байна. Жибзундамба хутагтын Их хүрээ, Баруун хүрээ зэрэг суурин газруудыг дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэжээ. Гол мөрөн, нуурыг хөхөөр будсан боловч нилээд бүдгэрчээ. Өртөө замыг шараар зурж, өртөөний сууринг дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Тал долоон өртөөний нэрийг бичжээ. Тал долооноос Их Хүрээ, Их хүрээнээс Хиагт, Тал долооноос Улиастай чиглэлийн замыг зуржээ. Зургийн хойд хэсэгт Түшээт ханы харуулын нэрийг тойруулан бичсэн байна. Сүм хийд, суурин газар, засаг ноёдын нэрийг улаан хүрэн, бусад газар усны нэрийг хар бэхээр бичжээ. Зургийн нэрийг зургийн зүүн доод буланд манжаар бичсэн байна. Хадгалалт муу.

73. **Зургийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн хорин засаг хошууны ... нутгийн зураг (*qalq-a-yin tüsiyetü qan ayimaγ-un qorin jasaγ qosiyun-u ... nutuγ-un jiruγ*)

**Аймгийн албан ёсны нэр:** Халхын Түшээт хан аймаг

**Аймгийн нэр:** Түшээт хан аймгийн зураг

**Аймгийн хожмын нэр:** Богд хан уулын аймаг (1923-1931)

**Архив:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-3

**Он:** 1891 (Бадаргуулт төрийн 17 он)

**Хэмжээ:** 100 см х 171 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 5 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Булган, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2 см х 2 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг зурхайн хүрд ашиглаж зуржээ. Хилийн овоог улаан дөрвөлжин хэлбэртэй дүрслээд, хошууны хилийг ногоон өнгөөр зурсан байна. Уул, нуруу, толгойг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр буджээ. Гол мөрөн, нуур, булаг, шандыг цэнхэр өнгөөр будсан байна. Сүм хийд, албан газрыг дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэж улаан өнгөөр давхарлан буджээ. Зарим сүм хийдийн хэлбэр төрхийг дууриалган зуржээ. Өртөөний сууринг улаан гурвалжин хэлбэртэй дүрслээд Харчин өртөөний эзэмшил нутгийг бусад хошууны нутгаас ялган тусад нь зуржээ. Газар усны нэр, тайлбарыг нилээд дэлгэрэнгүй бичсэн байна. Хадгалалт хэвийн.

#### 74. Зургийн нэр: Нэр бичээгүй

**Аймгийн албан ёсны нэр:** Халхын Түшээт хан аймаг

**Аймгийн нэр:** Түшээт хан аймгийн зураг

**Аймгийн хожмын нэр:** Богд хан уулын аймаг (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-3

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 125 см х 40 см

**Бичвэрийн хэл:**

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган, Дундговь, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог улаан гурвалжин хэлбэртэй дүрслээд хооронд нь улаан шунхаар шугам татжээ. Уулсыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр будсан байна. Мод, хадтай хэсгийг тодотгон зуржээ. Гол мөрөн, нуур, булаг, шандыг хараар зураад цэнхэр өнгөөр буджээ. Гэр наймыг зурж дээвэр хэсгийг хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Суурин газрыг улаан дөрвөлжин хэлбэртэй дүрсэлж, хятад маягийн загвартай нэг сүмийг тод зуржээ. Өртөөний сууринг дугуй хэлбэртэй тэмдэглэж, улаанаар буджээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх замыг шар, улаан өнгө давхарлан буджээ. Газар усны нэр, тайлбар бичээгүй. Зургийн тал хэсэг алга болсон байна. Хадгалалт муу.

**75. Зургийн нэр:** Халхын Очирбат Түшээт хан нэг зэрэг нэмсэн Дашнямын хошууны нутгийн зураг (*qalq-a-yin wačirai batu tüsiyetü qan nigen jerge nemegsen dasinima-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын Очирбат Түшээт сайн ханы хошуу

**Хошууны нэр:** Түшээт ханы хошуу

**Хошууны хожмын нэр:** Хангай Хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-5

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 4 сарын 20)

**Хэмжээ:** 75 см х 75 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 3 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Хашаат сум, Өвөрхангай аймаг. Хархорин, Баян-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог ногоон гурвалжин хэлбэртэй дүрслээд хооронд нь хүрэн бэхээр шугам татжээ. Овооны нэрийг тойруулан цэгцтэй бичсэн байна. Хошуу нутгийн байрлалыг хойноос урагш сунаж тогтсон байдалтай дүрсэлжээ. Уулыг хараар зурж ногоон өнгөөр давхарлан будаад, зарим хадтай уулыг хүрэн өнгөөр буджээ. Гол мөрөн, булаг, шандыг хөхөөр будсан байна. Зургийн төв хэсэгт хоосон зайд “тал” хэмээн бичжээ. Эрдэнэ зуу зэрэг 6 сүм хийдийг хятад маягийн загвартай дүрсэлсэн байна. Түшээт хан Дашнямын албан гэрийг зураад дээвэр хэсгийн хүрэн өнгөөр буджээ. Нэг суурин газрыг улаан өнгө бүхий дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэжээ. Шар өнгөөр зам зурсан боловч уусан бүдгэрчээ. Зургийн хадгалалт хэвийн.

**76. Зургийн нэр:** Түшээт ханы хошууны Гөрөөчин ардын нутгийн зураг энэ буй (*tüsiyetü qan-u qosiyun-u görügečin arad-un nutuγ-un jiruγ ene bui*)

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны Гөрөөчин отгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-6

**Он:** Он бичээгүй [1796-1813]

**Хэмжээ:** 26 см х 30 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Тэшиг сум, Хөвсгөл аймаг. Эрдэнэбулган сум

**Товч тодорхойлолт:**

Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Газар зүйн биетүүдийг дээрээс харуулж зуржээ. Уулсыг хар бэхээр зурж ногоон өнгөөр будсан байна. Уулыг нилэнхүйд нь модтой

дүрсэлжээ. Модны дүрслэлүүд өөр өөр хэлбэр төрхтэй байна. Гол мөрөн, нуурыг уран зургийн аргаар угалзлуулан зурж урагш урсаж буй байдлаар долгион үүсгээд хөх өнгөөр буджээ. Сүм хийдийг зургийн голд дөрвөлжин хэлбэртэй тэмдэглээд “Хүрээ” гэж бичжээ. Зургийн дөрвөн талд хил залгаа хошууны мэдээллийг бичжээ. Хадгалалт хэвийн.

**77. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны Гөрөөчин отгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-7

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 42 см х 34 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Тэшиг сум, Хөвсгөл аймаг. Эрдэнэбулган сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Газар зүйн биетүүдийг дээрээс харуулж зуржээ. Уулсыг хар бэхээр зурж ногоон өнгөөр будсан байна. Уулыг нилэнхүйд нь модтой дүрсэлжээ. Модны дүрслэлүүд өөр өөр хэлбэр төрхтэй байна. Гол мөрөн, нуурыг уран зургийн аргаар угалзлуулан зурж урагш урсаж буй байдлаар долгион үүсгээд хөх өнгөөр буджээ. Сүм хийдийг зургийн голд дөрвөлжин хэлбэртэй тэмдэглээд “Хүрээ” гэж бичжээ. Зургийн дөрвөн талд хил залгаа хошууны мэдээллийг бичжээ. Хадгалалт хэвийн.

**78. Зургийн нэр:** Түгээмэл элбэгтийн тэргүүн онд Түшээт хан, Түшээ гүн хоёр хошууны тэмцсэн Эргэнэг зэрэг газрыг байцаан үзээд, хоёр этгээдэд тушааж зуруулсан зураг (*tügemel elbegtü-yin terigün on, du tüsiyetü qan tüsiy-e güng qoyar qosiyun-u temečegsen ergeneg jerge yajar-yi bayičayan üjeged qoyar eteged-dü tusiyaju jiruγuluγsan jiruγ*)

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Түшээт хан Цэрэндорж, Түшээт засаг Балдардоржийн хошууны тэмцэлдсэн Эргэнэг зэрэг нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-7

**Он:** 1851 (Түгээмэл элбэгтийн тэргүүн)

**Хэмжээ:** 54 см х 77 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Баян-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чигийг бичээгүй. Хилийн овоог дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Тус зургийг хошууны маргаан шийдэхийн тулд үйлдсэн бололтой. Хоёр хошууны маргаантай газрыг зурахдаа

овоог дугуй хэлбэртэй тэмдэглээд тойруулан газар усны нэрийг тодорхой бичжээ. Уул, нуруу, гол мөрөн, булаг, шандыг хар бэхээр зурсан боловч будаагүй байна. Суурин газар, сүм хийд огт тэмдэглээгүй. Хадгалалт хэвийн.

**79. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн хэбэй засаг төрийн жүн вангийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un kebei jasaγ törü-yin geyün wang-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хутаг уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-9

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 100 см х 100 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 3 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг. Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сум, Өмнөговь аймаг. Ханбогд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог цэнхэр өнгө бүхий дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Уулыг хар бэхээр зураад хүрэн, ногоон, цэнхэрээр өнгө ялган буджээ. Сүм хийдийг дөрвөлжин хэлбэртэй зурж шар өнгөөр будсан байна. Гэр зураад албан газар гэж бичжээ. Хошууны тамгын газрыг цэнхэр, улаанаар өнгө ялган буджээ. Өртөө зам худалдааны замыг цэгэн шугам татан зуржээ. Өртөөний сууринг улаан дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Өртөөний эзэмшил газрыг нутгийн зурагт зааж тэмдэглэжээ. Мэргэн засгийн хошуу нилээд том газар нутагтай учир 2 цаасан дээр зураад нийлүүлэн наасан байна. Зургийн доод хэсэг алга болжээ. Хадгалалт муу.

**80. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хутаг уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-10

**Он:** 1914 (Олноо өргөгдсөний 4 он 2 сарын 10)

**Хэмжээ:** 40 см х 85 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг. Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сум, Өмнөговь аймаг. Ханбогд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг тэмдэглэсэн бололтой. Хилийн овоог гурвалжин хэлбэртэй тэмдэглэжээ. Уулыг хараар зурж хүрэн, ногоон, цэнхэрээр өнгө ялган буджээ. 4 сүм зураад шар, улаан хүрэн өнгөөр будсан байна. Нутгийн дундуур дайран гарах худалдааны замыг цэгэн шугам татаж зуржээ. Худалдааны зам дагуух худгийн нэрийг дэлгэрэнгүй бичсэн байна. Худаг, булаг, шандыг дугуй хэлбэртэй дүрслээд цэнхэр өнгөөр давхарлан буджээ. Зургийн зүүн талд зэргэлдээх хошууны хилийн овоог давхар тэмдэглэсэн байна. Тус нутгийн зургийн тал хэсэг үрэгдэж алга болжээ. Хадгалалт муу.

**81. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Мэргэн засаг төрийн жүн ван Цэсүнжав манай хошууны нутгийн зураг (*tüsiyetü sayin qan ayimaγ-un mergen jasaγ törü-yin geγün wang česünjab man-u qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хутаг уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-11

**Он:** 1917 (Олноо өргөгдсөний 7 он 6 сарын шинийн 5)

**Хэмжээ:** 100 см х 122 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 8 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг, Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сум, Өмнөговь аймаг. Ханбогд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 5,5 см х 5,5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зурхайн хүрдийг ашиглан зуржээ. Хилийн овоог ягаан бэхээр будаад тойруулан нэрийг бичжээ. Уул, толгодыг хар бэхээр зурж цэнхэр, ногооноор, булаг, худаг, шандыг ягаан өнгөөр будсан байна. Тус зургийн хоосон зайд говь, тал гэж бичжээ. 7 сүм зураад шар өнгөөр давхарлан будсан байна. Хошуу ноёны өргөө, тамгын газрыг ягаан бэхээр зуржээ. Өртөө зам, дархны замыг цэгэн шугам татаж зураад шар өнгөөр давхарлан будсан байна. Өртөөний сууринг дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Өртөөг урд талаас нь Хар мухар ус, Дамбулаг худаг ус, Сүүж булаг, Толь булаг, Төгрөг худаг ус, Мухар гашуун худаг ус, Хоньч худаг ус, Дамбилгэх худаг ус гэж бичжээ. Хадгалалт хэвийн.

**82. Зургийн нэр:** Монгол улсын арван зургаадугаар он долоон сард Богд хан уулын аймгийн Их дулаан уулын хошууны тамгын газраас харьяат хошууны нутгийн



хуучин зургийг хуулан зурж тамга дарж мэдүүлэв (*mongᠣᠯ ulus-un arban jirᠣᠳᠤᠭᠠᠷ on doluᠭᠠᠨ saradu boᠭᠳᠠ qan aᠭᠤᠯᠠ-yin ayimāᠭ-un yeke dulaᠭᠠᠨ aᠭᠤᠯᠠ-yin qosiyun-u tamaᠭ-a-yin ᠶ᠋ᠭᠠᠵᠠᠷ-aᠴᠠ qariyatu qosiyun-u nutuᠭ-un qaᠶuᠴin jiruᠭ-i qaᠶulun jiruju tamaᠭ-a daruju medegülbei*)

**Хошууны албан ёсны нэр:** Богд хан уулын аймгийн Их дулаан уулын хошуу

**Хошууны нэр:** Их дулаан уулын хошуу

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-12

**Он:** 1917 (Олноо өргөгдсөний 7 он 6 сарын шинийн 5)

**Хэмжээ:** 100 см х 122 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 5 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг, Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сум, Өмнөговь аймаг. Ханбогд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 5,5 см х 5,5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зурхайн хүрдийг ашиглан зуржээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй дүрслээд хооронд нь ягаан бэхээр шугам татжээ. Уул, толгодыг хар бэхээр зурж цэнхэр, ногооноор, булаг, худаг, шандыг хөхөөр будсан байна. Худаг, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Тус зургийн хоосон зайд говь, тал гэж бичжээ. 4 сүм зураад шар, хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Зургийн дээд талд нэг гэр зураад тамгын газар гэжээ. Худалдааны замыг цэгэн шугам татаж зураад хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Зургийн зарим хэсэг цоорч өгөршсөн байдалтай байна. Хадгалалт муу.

**83. Зургийн нэр:** Засаг тэргүүн зэрэг тайж Бадамлэгдэнзулын хошууны нутаг газар орны хэмжээ байдлын зураг (*ᠵᠠᠰᠠᠭ тeᠷᠭᠦᠨ jerge tayiji badmalegdengjula-yin qosiyun-u nutuᠭ ᠶ᠋ᠭᠠᠵᠠᠷ orun-u kemjiy-e bayidal-yin jiruᠭ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундад хошуу

**Хошууны нэр:** Цогтой засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Сүүж уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-13

**Он:** 1891 (Бадаргуулт төрийн 17 он 10 сарын шинийн 6)

**Хэмжээ:** 51 см х 51 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг. Эрдэнэ сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 1.5 см х 1.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Нутгийн зургийн гадна хэсэгт зурхайн хүрдний 24 зүг чигийг тойруулан бичээд ард нь хүрэн

өнгөөр хоорондын зайг тэмдэглэсэн байна. Хошууны нутаг жижиг ажээ. Хилийн овоог хүрэн дугуй хэлбэртэй дүрслээд хар бэхээр шугам татан хилээ зуржээ. Зургийн гадна талд овооны нэрийг доош нь цувуулан бичсэн байна. Уул дүрсэлсэн боловч гол мөрөн, булаг, шанд огт тэмлэглээгүй. Талбайн ихэнхи зайг хүрдэн цагираг, овооны тайлбар эзлэнэ. Зурагт сүм хийд, хошууны тамгын газрыг зуржээ. Хадгалалт хэвийн.

**84. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж нэг зэрэг нэмсэн, гурван зэрэг тэмдэглэсэн Цэрэндоржийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ terigün jerge tayiji nigen jerge nemegsen γurban jerge temdeglegsен čerindorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын зүүн этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Ноён уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-14

**Он:** 1868 (Бүрээнт засагчийн 7 он 4 сарын шинийн 1)

**Хэмжээ:** 44 см х 75 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Түнхэл, Мандал, Баянгол сум, Төв аймаг. Борнуур, Жаргалант, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй хэлбэртэй тэмдэглээд нэрийг улаан цаасан дээр бичиж наажээ. Уул, нуруу, ой хөвчийг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан будаад уулын өндрийн хэмжээг бичсэн байна. Нуур, тойром, гол мөрөн, булаг, шандыг хөхөөр будаж, сүм хийд, суурин газрыг улаан өнгө бүхий дөрвөлжин хэлбэртэй дүрсэлсэн байна. Гэр зурж дээвэр хэсгийг улаан өнгөөр будаад “Албаны газар” гэж бичжээ. Нутгийн дундуур явах өртөө замыг ногоон бэхээр зурж, өртөөний сууринг улаан дугуй хэлбэртэй дүрсээр тэмдэглэжээ. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим нь ховхорч унасан бололтой. Зургийн хадгалалт сайн.

**85. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Түшээт хан аймгийн Дархан засаг Сүндэвдоржоос Сэцэн хан аймгийн Сэцэн засагтай нутаг маргасан зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-15

**Он:** Он бичээгүй [1774-1789]

**Хэмжээ:** 81 см х 120 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Бор муутуу цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Баян, Баянжаргалан, Баянцагаан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй хэлбэртэй тэмдэглээд уулсын хооронд ягаан бэхээр шугам татжээ. Уулыг хар бэхээр зураад хүрэн, цэнхэр өнгөөр буджээ. Худаг, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Дэрс зураад газрын нэрийг бичсэн байна. Мөн хоёр араг яс зураад “Хүүр” гэж бичсэн нь оршуулгын газрыг тэмдэглэсэн бололтой. Бодит дүрслэлийн аргаар 1 сүм зурсан байна. Улаан хүрэн цаасан дээр газар усны нэр, тайлбарыг бичиж наасны зарим нь ховхорч унасан байна. Хадгалалт хэвийн.

**86. Зургийн нэр:** Засаг тэргүүн зэрэг тайж Жамьянхорлоо агсны хошууны нутгийн зураг (*jasaγ terigün jerge tayiji jamiyangqorlu-a aγsan-u qosiqun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундад хошуу

**Хошууны нэр:** Цогтой засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Сүүж уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-16

**Он:** 1892 (Бадаргуулт төрийн 18 оны цагаан сарын 24)

**Хэмжээ:** 49 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорноговь аймаг. Мандах сум, Дундговь аймаг. Өлзийт, Өндөршил сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 5.5 см х 5.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг тойруулан зурхайн хүрдний зүг чигийг бичжээ. Хилийн овоог босоо дөрвөлжин тэмдэгтээр дүрсэлж, нэрийг тойруулан бичсэн байна. Уул, нуруу, толгодыг хараар зураад хүрэн, цэнхэр өнгөөр давхарлан буджээ. Булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрслээд цэнхэр өнгөөр будсан байна. Сүм хийд, суурин газрыг дөрвөлжин хэлбэртэй зурсан ажээ. Өртөөний сууринг хошууны хилийн гадна талд гурвалжин хэлбэртэй тэмдэглээд замыг хүрэн бэхээр зуржээ. Хадгалалт хэвийн.

**87. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Ачит гүн Бадрахын хошууны нутгийн зураг (*tüsiyetü sayin qan ayimaγ-un açitu güng badarqu-yin qosiqun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Ачит засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Ашиг Хорго уулсын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-17

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 оны 5 сарын 29)

**Хэмжээ:** 51 см х 70 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Муутуу цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дундговь аймаг. Өлзийт, Өндөршил сум, Дорноговь аймаг. Мандах сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн гадна талд зүг зурхайн хүрдний зүг чигийг тэмдэглэжээ. Хилийн овоог улаан гурвалжин хэлбэртэй дүрсэлж өмнө зүгээс эхлэн дугаарлаад 34 овооны нэрийг бичжээ. Уул, талыг ногоон, ягаан өнгөөр, зарим уулыг цэнхэр, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Уулын өндрийн хэмжээг бичсэн байна. Гол мөрөн, нуурыг хөх өнгөөр зуржээ. Нуур, булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Хятад маягийн загвартай 2 сүмийг улаан өнгөөр дагнан зуржээ. Хар бэхээр гэр зураад “Албан гэр” хэмээн бичжээ. Өртөө замыг шар өнгийн бэхээр зурсан байна. Өртөөний сууринг тэмдэглээгүй. Хадгалалт хэвийн.

**88. Зургийн нэр:** Засаг Азарын хошууны нутгийн зураг энэ амуй (*јasaγ ајar-a-yin qosiγun-u nutuγ-un јiruγ ene amui*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Эетэй засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хоёр Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-16

**Он:** Он бичээгүй [1789-1812]

**Хэмжээ:** 33 см х 38 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Манлай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй ажээ. Зургийг тойруулан зүг чигийг бичжээ. Хилийн овоог ногоон өнгө бүхий дугуй, шовх хэлбэртэй тэмдэгтийг хослуулан тэмдэглэжээ. Хилийн овоод хооронд улаан, шар өнгийн зураас татаж хилээ зурсан байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Тойром, булаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй дүрслээд хөх өнгөөр зурсан байна. Урсгал гол мөрнийг тэмдэглээгүй. Хоосон зайд “Говь” хэмээн хэд хэдэн удаа бичжээ. Дөрвөлжин улаан хүрэн дотор хар бэхээр дугуй зураад “засаг Азарын гэр” гэж бичсэн байна. Хадгалалт дунд зэрэг.

**89. Зургийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн засаг Дарамсэнгийн хошууны нутаг газрын зургийг тодорхойлон зурж өргөх нь (*qalq-a-yin tüsietü qan ayimaγ-un јasaγ darmasengge-yin qosiγun-u nutuγ γajar-un јiruγ-yi todurqayilan јiruju ergükü anu*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Эетэй засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хоёр Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-19

**Он:** 1866 (Бүрэнт засагчийн 5 он 6 сарын шинийн 3)

**Хэмжээ:** 44 см х 73 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Манлай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийн тойруулан бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй тэмдэглэжээ. Уулыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр будсан байна. Модтой хэсгийг тусад нь зуржээ. Гол мөрөн, нуурыг хар бэхээр зураад хөхөөр будсан аж. Булаг, худаг, шандыг зоос мэт дугуй хэлбэртэй зуржээ. Зургуун төв хэсэгт нэг гэр зураад дээвэр, туурга хэсгийг улаан хүрэн өнгөөр буджээ. Зургийн баруун урд талаар өртөөг тэмдэглэжээ. Өртөөний сууринг дугуй хэлбэртэй дүрслээд замыг шар бэхээр зуржээ. Өртөөний эзэмшил нутгийг хошууны нутгаас тусад нь тэмдэглэсэн байна. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр хар бэхээр бичээд наасны зарим нь ховхорч унасан бололтой. Хадгалалт хэвийн.

**90. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж Агваандоржийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ teregün jerge tayiji aγwangdorjiyin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Эетэй засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хоёр Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-20

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 4 сарын 29)

**Хэмжээ:** 59 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Манлай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог цэнхэр, улаан өнгө бүхий дугуй хэлбэртэй тэмдэглээд нэрийг нь тойруулан бичжээ. Уул, толгой, гол мөрөн, булаг, шанд зэрэг газар зүйн биетүүдийг бүдэг дүрсэлсэн байна. 2 суурин зурж “Тамгын

газар”, “Дөчин лам нарын ном унших газар” хэмээн бичжээ. Өртөөний эзэмшил газрын тэмдэглэгээг улаан цаасан дээр бичиж наагаад өртөө замыг хүрэн өнгөөр нутгийн зургийн дундуур зуржээ. Хадгалалт хэвийн.

**91. Зургийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Агваандоржийн хошууны нутгийн зураг (*qalq-a-yin tüsiyetü qan ayimaγ-un ulus-tur tusalaγči güng-ün jerge jasaγ terigün jerge tayiji aγwangdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын дундад этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Эетэй засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хоёр Өлзийт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-21

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 5 сарын 18)

**Хэмжээ:** 60 см х 48 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Манлай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог цэнхэр, улаан өнгө бүхий дугуй хэлбэртэй тэмдэглээд нэрийг нь тойруулан бичсэн байна. Уул, толгой, гол мөрөн, булаг, шанд зэрэг газар зүйн биетүүдийг бүдэг дүрсэлсэн байна. Зургийн төвд 2 суурин зураад “Тамгын газар”, “Дөчин лам нарын ном унших газар” гэж бичжээ. Хоосон зайд “Говь” хэмээн бичжээ. Улаан хүрэн өнгөөр өртөө замыг зурсан байна. Өртөөний сууринг тэмдэглээгүй. Хадгалалт хэвийн.

**92. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж таван зэрэг тэмдэглэсэн Цэрэндондовын хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ terigün jerge tayiji tabun jerge temdeglegsен čerindondub-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Зүүнбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-22

**Он:** 1868 (Бүрэнт засагчийн 7 он 4 сарын шинийн 1)

**Хэмжээ:** 52 см х 98 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 3 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Алтанбулаг, Хүдэр, Сант, Ерөө, Жавхлант, Хушаат, Орхон, Дулаанхаан, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур сум. Дархан-Уул аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй дүрсээр тэмдэглэж, ой хөвчит уул, нуруудыг ногоон, гол мөрөн, нуурыг хөх өнгөөр буджээ. Хятад маягийн хэлбэр төрхтэй 5 сүм зураад шар өнгөөр будсан байна. Сүмийн нэрийг шар цаасан дээр бичиж наажээ. Өртөө замыг ногоон өнгөөр зураад өртөөний сууринг дугуй дүрсээр тэмдэглэжээ. 5 өртөөний суурин зураад нэрийг бичсэн байна. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим нь ховхорч алга болжээ. Хадгалалт хэвийн.

93. **Зургийн нэр:** Түшээт хан аймгийн гүн Намсрайн хошууны нутагт нээн хагалсан газрын зураг (*tüsiyetü qan ayimaγ-un güng namsarai-yin qosiyun-u nutuγ-dur negegen qaγalaγsan γajar-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Зүүнбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-21

**Он:** 1906 (Бадаргуулт төрийн 32 оны 5 сарын 15)

**Хэмжээ:** 54 см х 78 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Муутуу цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Алтанбулаг, Хүдэр, Сант, Ерөө, Жавхлант, Хушаат, Дулаанхаан, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур сум, Дархан-Уул аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Нутгийн хилийг нарийн улаан шунхаар зуржээ. Уул, нуруу, толгодыг хараар зурж ногоон, хүрэн өнгөөр буджээ. Гол мөрөн, булаг шандыг цэнхэр өнгөөр будсан байна. Голын сав дагуу тариан талбайг дүрслэн зураад ногоон, хүрэн өнгөөр буджээ. Голын сав дагуух тариан талбайд хэн, хэдий хэмжээний газар нутаг эзэмшиж буйг цаасан дээр дэлгэрэнгүй бичээд наасан байна. Зургийн өнгө уусаж нилээд бүдгэрсэн ажээ. Зургийн төв хэсэгт нэгэн тариан талбайг хүрэн өнгөөр тод дүрсэлж цэнхэр бэхээр “Монголчууд таримой” гэж бичжээ. Газар усны нэр, тайлбарыг цэнхэр цаасан дээр бичиж наасны зарим бичвэр ховхорч унасан бололтой. Хадгалалт хэвийн.

94. **Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошууны Мянгадарын голын тарианы зураг

**Хошууны хожмын нэр:** Зүүнбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-24

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 26 см х 44 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Сант, Хушаат сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн нэрийг бичээгүй. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Уул, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр буджээ. Гол мөрнийг угалзлуулан зураад цэнхэр өнгөөр будсан байна. Голын сав дагуу хэд хэдэн тариан талбай зуржээ. Зургийн голд зүүн тийш харсан байдалтай Гэсэр сүмийг зуржээ. Мөн уулын энгэр газар 3 өвөлжөө зураад шар, хүрэн өнгөөр буджээ. Огноог бичээгүй, ноорог байдалтай үйлдсэн бололтой байна. Хадгалалт хэвийн.

**95. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад зүүн гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошууны Шурунгийн голын тарианы зураг

**Хошууны хожмын нэр:** Зүүнбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-25

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 54 см х 150 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Цагааннуур сум.

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар өнгөөр зурж, ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрнийг угалзлуулан усан хээгээр дүүргэн зурж, цэнхэр өнгөөр будсан байна. Голын сав дагуу тариан талбай, өвөлжөө, сангийн байшин зэргийг зуржээ. Суурин газруудыг дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах зам харгуйг хүрэн бэхээр зуржээ. Зурагт нэр байхгүй, огноог бичээгүй. Тус зургийг ноорог байдлаар үйлдсэн бололтой. Хадгалалт хэвийн.

**96. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж нэг зэрэг тэмдэглэсэн

Уржинжавын хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ terigün jerge tayiji nigen jerge temdeglegsen urjingjab-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баруун бүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-26

**Он:** 1868 (Бүрэнт засагчийн 7 он 4 сарын шинийн 3)



**Хэмжээ:** 55 см х 49 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардмал цагаан даавуу

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхонтуул, Сант, Цагааннуур, Сайхан, Баруунбүрэн сум, Булган аймаг. Хангал сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглэж хошууны хилийг улаан шунх татан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Уулын өндрийн хэмжээг бичсэн байна. Гол мөрөн, нуур, булгийг хөх өнгөөр будсан нь нэлээд бүдгэрчээ. Дөрвөлжин хэлбэртэй хүрээн татаж 1 сүм, хар бэхээр нэг зурж улаан өнгөөр давхарлан будаад “Албан газар” гэж бичсэн байна. Зургийн дүр төрх хойноос урагшаа сунаж тогтсон хэлбэртэй байна. Зургийн зүүн доод буланд гарын үсэг зурсан бололтой. Хадгалалт муу.

**97. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж нэг зэрэг нэмсэн, гурван зэрэг тэмдэглэсэн Уржинжавын хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ terigün jerge tayiji nige jerge nemegsen γurban jerge temdeglegsen ürjanjab-un qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баруунбүрэн хан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-27

**Он:** 1867 (Бүрээнт засагчийн 7 он 4 сарын шинийн 3)

**Хэмжээ:** 56 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардмал цагаан даавуу

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сант, Сайхан, Баруунбүрэн сум, Булган аймаг. Хангал сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглэж хошууны хилийг улаан шунх татан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Уулын өндрийн хэмжээг бичсэн байна. Гол мөрөн, нуур, булгийг хөх өнгөөр будсан нь нэлээд бүдгэрчээ. Дөрвөлжин хэлбэртэй хүрээн татаж 1 сүм, хар бэхээр нэг зурж улаан өнгөөр давхарлан будаад “Албан газар” гэж бичсэн байна. Зургийн дүр төрх хойноос урагшаа сунаж тогтсон хэлбэртэй байна. Зургийн зүүн доод буланд гарын үсэг зурсан бололтой. Хадгалалт муу.

- 98. Зургийн нэр:** Жибзундамба хутагтын шавь, засаг Уржинжавын хошуу хоёр этгээдийн тэмцсэн Жаргалант, Бумбат зэрэг газрын зураг (*jibjundamba qutuγtu-yin šabi jasaγ urjanjab-yin qosiyu qoyar eteged-ün temečegsen jirγalangtu bumbatu jerge γajar-un jiruγ*)
- Хошууны нэр:** Жибзундамба хутагтын шавь, Уржинжавын хошуу хоёр этгээдийн тэмцсэн Жаргалант, Бумбат зэрэг газрын зураг
- Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-28
- Он:** 1872 (Бүрэнт засагчийн 11 он 6 сарын 23)
- Хэмжээ:** 53 см х 52 см
- Бичвэрийн хэл:** Монгол
- Өнгө:** Өнгөт
- Зурсан эд:** Цаас
- Тамга:** Тамга дараагүй
- Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум
- Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмлдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон, хүрэн, хөхөөр давхарлан буджээ. Гол мөрнийг цэнхэр өнгөөр будаж, угалзруулан усан хээгээр дүүргэн зурсан байна. Гол мөрний сав дагуу тариан талбай, суурин газар хэд хэдийг зураад дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэжээ. Намаг шавартай газрыг нутгийн зурагт тод дүрсэлсэн байна. Хадгалалт хэвийн.
- 99. Зургийн нэр:** энэ Түшээт хан аймгийн засаг Лувсанхайдавын хошууны нутаг Бургалтай хэмээх голын Жибзундамба хутагтын сангийн тарианы нутаг (*ene tüsiyetü qan ayimaγ jasaγ lubsangqayidub-yin qosiyun-u nutuγ burγaltai kemekü γool-un jibjundamba qutuγtu-yin sang-un tariyan-u jiruγ*)
- Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-29
- Он:** Он бичээгүй [1884-1923]
- Хэмжээ:** 52 см х 100 см
- Бичвэрийн хэл:** Монгол
- Өнгө:** Хар цагаан
- Зурсан эд:** Цаас
- Тамга:** Тамга дараагүй
- Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум
- Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийг тойруулан зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулсан зурсан байна. Голын хойно орших уулсыг урдаас, голын өмнө байх уулсыг хойноос нь харж дүрсэлжээ. Уул, нуруу, толгод, гол мөрнийг хар бэхээр зуржээ. Гол мөрний сав дагуу, тариан талбай, сангийн байшин, айлын өвөлжөө, суурин газар, намаг шалбааг, дэрс, зэгс, мод хад зэргийг зурж тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах хоёр

замыг хүрэн бэхээр зуржээ. Хар зураг хэдий ч газар зүйн биетийн дүрслэл сайтай юм. Хадгалалт хэвийн.

**100. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны Бургалтай голын тарианы зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-30

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 58 см х 90 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Чингэхдээ уулын орой, голын сав дагуух хэсгийг тод бусан байна. Гол мөрнийг хар бэхээр угалзруулан зураад хөх өнгөөр будаад гол мөрний сав дагуу тариан талбай, сангийн байшин хэд хэдийг тэмдэглэжээ. Газар зүйн биетүүдийг тод дүрсэлсэн байна. Уг зураг нэлээд өвөрмөц дүрслэлтэй гоёмсог зураг ажээ. Зурагт ямар нэгэн нэр, он бичээгүй, ноорог байдалтай үйлдсэн бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**101. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны Бургалтай голын тарианы зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-31

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 102 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрнийг хар бэхээр угалзруулан зураад хар ногоон өнгөөр будсан байна. Гол мөрний сав дагуу тариан талбай, сангийн байшин, өвөлжөө зураад ногоон өнгөөр буджээ. Мөн намаг, шавар, дэрс, мод, хадтай газрыг шар өнгөөр тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах замыг хүрэн бэхээр зурсан байна. Газар зүйн биетийн дүрслэл сайтай юм. Тус нутгийн зурагт нэр, он бичээгүй. Зургийн хадгалалт хэвийн.

**102. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны Бургалтай голын тарианы зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-32

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 104 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хөх өнгөөр давхарлан буджээ. Гол мөрнийг хар бэхээр зураад хөхөөр будсан байна. Гол мөрний сав дагуу тариан талбай, сангийн байшин зураад ногоон өнгөөр буджээ. Мөн намаг, шавар, дэрстэй газрыг шараар тэмдэглэжээ. Нутгийн дундуур явах замыг хүрэн бэхээр зурсан байна. Газар зүйн биетийн дүрслэл сайтай ажээ. Тус нутгийн зурагт нэр, он бичээгүй. Ноорог зураг бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**103. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны Эвэрт голын тарианы зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-33

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 54 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс нь харуулан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хөх өнгөөр давхарлан буджээ. Гол мөрнийг хар бэхээр зураад хөхөөр будсан байна. Гол мөрний сав дагуу тариан талбай зураад ногоон өнгөөр буджээ. Газар зүйн биетийн дүрслэл сайтай ажээ. Тус нутгийн зурагт нэр, он бичээгүй. Ноорог зураг бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**104. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны Бургалтай голын тарианы зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-34

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Орхон, Сайхан, Баруунбүрэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хөх, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Хад, модтой уулыг онцгойлон тод дүрсэлсэн байна. Гол мөрнийг хар бэхээр зураад хөхөөр будсан байна. Гол мөрний сав дагуу тариан талбай зураад ногоон өнгөөр буджээ. Газар зүйн биетийн дүрслэл сайтай ажээ. Тус нутгийн зурагт нэр, он бичээгүй. Ноорог зураг бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**105. Зургийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн чуулганы дэд дарга засаг улсын түшээ гүн Ча-гийн хошууны нутгийн зураг (*qalq-a-yin tüsiyetü qan ayimaγ-un čiyulγan-u ded daruγ-a jasaγ ulus-un tüsiy-e güng ča-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын умард хошуу

**Хошууны нэр:** Түшээт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дэлгэрхангай уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-35

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 5 сарын шинийн 9)

**Хэмжээ:** 146 см х 104 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмгөговь аймаг. Номгон, Баян-Овоо, Цогтцэций, Ханхонгор, Булган, Цогт-Овоо, Мандал-Овоо сум, Дундговь аймаг. Өлзийт, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг тойруулан зурхайн хүрдийн зүг чигийг тэмдэглэсэн байна. Хошууны хилийн овоог босоо дөрвөлжин тхэлбэртэй зуржээ. Уул, нуруу, толгойг хараар зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Зургийн суурийг нилэнхүйд нь буджээ. Чингэхдээ Дэлгэрхангай уулаас хойш Хангай газрыг ногоон, Дэлгэрхангай уулаас өмнөх тал, говийг улбар шар өнгөөр буджээ. Гол мөрөн, тойром, булгийг хөх өнгөөр будсан байна. Хятад маягийн загвартай 5 сүм зурсан байна. 1 гэр зураад “дэд түшээ гүн Ча-гийн суух албаны гэр” гэж бичжээ. Нутгийн умард хэсгээр дайран өнгөрөх Харчин өртөөг гурвалжин дүрсээр тэмдэглэжээ. Өртөөний эзэмшил нутгийг хошууны зургаас ялгаж зураад нийт 10 өртөөний сууринг тэмдэглэжээ. Хадгалалт хэвийн.

**106. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг улсад туслагч гүн нэг зэрэг нэмсэн, таван зэрэг тэмдэглэсэн Найдансүрэнгийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ ulus-tur tusalaγci güng nigen jerge nemegsen tabun jerge temdeglegsen nayidangsürün-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундад баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Сүжигт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баян-Эрхэт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-36

**Он:** 1868 (Бүрэнт засагчийн 7 он 4 сарын шинийн 8)

**Хэмжээ:** 44 см х 46 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардмал цагаан даавуу

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог ногоон өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглээд нэрийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр буджээ. Уулын өндрийн хэмжээг бичсэн байна. Гол мөрөн, нуур тойрмуудыг хөх өнгөөр будсан байна. Шар өнгөөр бүдэг зураас татаад “Элс” гэж бичжээ. 1 сүм зураад “Дөчид лам нарын сууж ном унших газар” гэжээ. 1 гэр зурж “гүн Найдансүрэнгийн тус суух албаны газар” хэмээн бичсэн байна. Хадгалалт хэвийн.

**107. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн засаг улсад туслагч гүн нэг зэрэг нэмсэн, таван зэрэг тэмдэглэсэн Найдансүрэнгийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un jasaγ ulus-tur tusalaγci güng nigen jerge nemegsen tabun jerge temdeglegsen nayidangsürün-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундад баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Сүжигт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баян-Эрхэт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-37

**Он:** 1868 (Бүрэнт засагчийн 7 он 4 сарын шинийн 8)

**Хэмжээ:** 52 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Баян-Өнжүүл, Өндөр ширээт, Лүн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог ногоон дугуй дүрсээр тэмдэглээд нэрийг тойруулан бичсэн байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Уулсын өндрийн хэмжээг бичжээ. Гол мөрөн, нуур тойрмуудыг хөх өнгөөр будсан байна. Шар өнгөөр бүдэг зураас татаад “Элс” гэж бичжээ. 1 сүм зураад “Дөчид лам нарын сууж ном унших газар” гэжээ. 1 гэр зурж “гүн Найдансүрэнгийн тус суух албаны газар” хэмээн бичсэн байна. Газар усны нэр, тайлбарыг бор цаасан дээр бичиж наасны зарим нь ховхорч унасан бололтой. Хадгалалт хэвийн.

**108. Зургийн нэр:** Дэд сайд жанжин жонон гүн Ванчигравдангийн хошууны нутгийн зураг (*ded sayid jangjun jinong güng wangčuγrabdan-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Жонон засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Бүрэг хангай уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-38

**Он:** 1913 (Олноо өргөглсөний 3 он илүү 12 сарын 12)

**Хэмжээ:** 69 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардмал цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Заамар сум, Булган аймаг. Бүрэгхангай сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Нутгийн зургийн гадна хэсэгт зурхайн хүрдний 24 зүг чигийг тойруулан бичжээ. Хилийн овоог дундаа цэгтэй босоо дөрвөлжин тэмдэгтээр зурж тойруулан нэрийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, цэнхэр өнгөөр давхарлан будсан байна. Тахилгатай 3 уулыг онцлон дүрслээд, зарим уулын өндрийн хэмжээг бичжээ. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр будан, зургийн суурийг нилэнхүйд нь шар ногоон өнгөөр буджээ. Хятад, түвэд маягийн 2 сүм зураад улаан өнгөөр буджээ. 2 гэр зуржээ. Өртөөний суурин тэмдэглээгүй. Өртөө замыг бор шар өнгөөр буджээ. Зургийн суурь усанд ууссан байдалтай байна. Зарим бичвэр уншигдахааргүй болжээ. Хадгалалт муу.

**109. Зургийн нэр:** Зарлигаар зарсан Ховдод сууж туслан хэрэг шийтгэгч сайд шадард явах Хан уулын чуулганы дарга найман зэрэг нэмсэн, долоон зэрэг тэмдэглэсэн засаг хошой чин вангийн хошууны нутгийн зураг (*jarliγ-iyar jaruγsan qobdu-tur saγuju tusalan kereg sidkegči sayid sidar-tur yabuqu qan aγula-yin čiyulγan-u daruγ-a naiman jerge nemegsen doluγan jerge temdeglegsен jasaγ qošui čin wang-un qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын хошуу  
**Хошууны нэр:** Эрдэнэ Дайчин засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Булган хан уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-39  
**Он:** 1867 (Бүрээнт засагчийн 7 он 4 сарын шинийн 1)  
**Хэмжээ:** 58 см х 92 см  
**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Сайхан, Орхон, Бугат, Хангал, Тэшиг, Хутаг-Өндөр сум Сэлэнгэ аймаг. Орхонтуул, Баруунбүрэн сум. Орхон аймаг.

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй дүрсээр тэмдэглээд тойруулан нэрийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж цэнхэр, ногоон, хүрэн өнгөөр өнгө ялган будсан байна. Зарим уулын өндрийн хэмжээг бичжээ. Гол мөрөн, нуурыг хөх өнгөөр, зургийн суурийг нилэнхүйд нь цайвар ногоон өнгөөр буджээ. Гол мөрний сав дагуу хэд хэдэн тариан талбайг зуржээ. Сүм хийдийг 4 ширхэг улаан цэг хатган тэмдэглэсэн байна. Зургийн төв хэсэгт улаан цэг хэд хэдийг хатгаад “эцэг өвөг, авга нарын бумба хүүр хадгалах газар” гэж бичжээ. Зургийн зарим хэсэгт газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны ихэнхи нь унаж гээгдсэн бололтой. Хадгалалт хэвийн.

**110. Зургийн нэр:** Амбан ван Эфүтэний хошууны нутгийн зураг (*amban wang efü ten-ü qosiyun-u nutuy-un jiruy*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад дахь баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хүнцэлцавчит уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-40

**Он:** Он бичээгүй [1738-1778]

**Хэмжээ:** 52 см х 32 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Лүн, Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант, Өндөрширээт сум, Булган аймаг. Баяннуур, Дашинчилэн сум, Өвөрхангай аймаг. Бүрд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй дүрсээр тэмдэглээд хүрэн өнгөөр буджээ. Уул, нуруу, толгойг хар бэхээр зураад ногоон, хадтай хэсгийг хүрэн өнгөөр



өнгө ялган буджээ. Уулсын хэв шинжийг харилцан адилгүй дүрсэлсэн байна. Гол мөрөн, булаг, шанд, нуурыг цэнхэр өнгөөр буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зурагт дамга дарж баталгаажуулагүй. Зургийг ноорог маягаар үйлдсэн бололтой. Хадгалалт хэвийн.

**111. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад дахь баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Зоригт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хүнцэлцавчит уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-41

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Нимгэн муутуу цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Лүн, Дэлгэрхаан, Бүрэн, Эрэдэнэсант, Өндөрширээт сум, Булган аймаг. Баяннуур, Дашинчилэн сум, Өвөрхангай аймаг. Бүрд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар өнгө бүхий хос гурвалжин хэлбэртэй тэмдэглээд нэрийг тойруулан бичжээ. Овоо хооронд ягаан бэхээр шугам татаж хилээ зуржээ. Уул, нуруу, толгойг хар бэхээр зуржээ. Уулсын хэв шинжийг харилцан адилгүй дүрсэлсэн байна. Гол мөрөн, булаг, шанд, нуурыг цэнхэр өнгөөр буджээ. Худгийг дөрвөлжин хэлбэртэй дүрсэлсэн байна. 2 сүм зураад нэрийг нь бичжээ. Албан газрыг тэмдэглээгүй. Зурагт дамга дарж баталгаажуулагүй. Зургийн урд талын хэсэг урагдаад нэр мэдэгдэхгүй болсон бололтой. Хадгалалт хэвийн.

**112. Зургийн нэр:** Халхын Түшээт хан аймгийн засаг улсад туслагч гүн нэг зэрэг тэмдэглэсэн Билигтэйдоржийн хошууны нутгийн зураг (*qalq-a-yin tüsiyetü qan ayimaγ-un jasaγ ulus-tur tusalaγči güng nigen jerge temdeglegsен belgeteidorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын зүүн этгээдийн дундад адгийн хошуу

**Хошууны нэр:** Сэцэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дэлгэрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-39

**Он:** 1868 (Бүрэнт засагчийн 7 он 4 сарын шинийн 1)

**Хэмжээ:** 53 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Дэлгэрхаан сум, Өвөрхангай аймаг. Бүрд, Баян-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичсэн боловч хууларч унасан бололтой. Хилийн овоог ногоон дугуй дүрсээр тэмдэглэж тойруулан нэрийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Нуур, цөөрмийг зоос мэт дугуй хэлбэртэй тэмдэглээд цэнхэр өнгөөр будсан байна. 1 сүмийг улаан дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Газар, усны нэрийг улаан, хүрэн цаасан дээр бичиж наасны дийлэнх нь хууларч унасан байна. Зургийн зарим хэсэг урагдсан байдалтай байна. Хадгалалт муу.

**113. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Сэцэн засаг улсад туслагч гүн Гүрсоронзонгомбосүрэнгийн нутгийн зураг (*tüsiyetü sayin qan ayimaγ-un sečen jasaγ ulus-tur tusalaγči güng gürüsorungjanggambusürün-yin nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын зүүн этгээдийн дундад адгийн хошуу

**Хошууны нэр:** Сэцэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дэлгэрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-43

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он илүү 12 сарын 24)

**Хэмжээ:** 46 см х 44 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардсан цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Дэлгэрхаан сум, Өвөрхангай аймаг. Бүрд, Баян-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2,5 см х 2,5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дөрвөлжин дүрсээр тэмдэглээд хошууны хилийг улаан шунхаар татжээ. Зургийн суурийг бүхэлд нь шар ногоон өнгөөр будсан байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Булаг, худаг, цөөрмийг хөх өнгөөр давхарлан будаад, зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Дэрстэй газрыг тод тэмдэглэсэн байна. Улаан бэхээр 2 гэр зурж “засаг Гүрсоронзонгомбосүрэнгийн гэр”, “Албаны гэр” гэж бичжээ. Хятад маягийн загвартай 1 сүмийг зургийн төв хэсэгт зураад дээвэр хэсгийг улаан өнгөөр буджээ. Хадгалалт хэвийн.

**114. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Сэцэн засаг төрийн жүн ван Гүрсоронзонгомбосүрэнгийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü sayin qan ayimaγ-un sečen jasaγ törü-yin geyün wang gürüsorungjanggambusürüng-ün qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын зүүн этгээдийн дундад адгийн хошуу

**Хошууны нэр:** Сэцэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Дэлгэрхаан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-44

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он 4 сарын 30)

**Хэмжээ:** 52 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Бор цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Дэлгэрхаан сум, Өвөрхангай аймаг. Бүрд, Баянбүрд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2.5 см х 2.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг тойруулан зурхайн хүрдний зүг чигийг бичжээ. Хилийн овоог улаан өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглээд хошууны хилийг улаан шунхаар татжээ. Зургийн суурийг нилэнхүйд нь ногоон өнгөөр будсан байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Булаг, худаг, цөөрмийг хөх өнгөөр давхарлан будаад зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Дэрстэй газрыг тод тэмдэглэжээ. Улаан бэхээр 2 гэр зурж “засаг Гүрсоронзонгомбосүрэнгийн гэр”, “Албаны гэр” гэж бичжээ. Хятад маягийн загвартай 1 сүмийг зургийн төв хэсэгт зураад дээвэр хэсгийг улаан өнгөөр буджээ. Хадгалалт хэвийн.

**115. Зургийн нэр:** Түшээт хан аймгийн Үйзэн гүн Түдэвдоржийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü qan ayimaγ-un üjeng güng түдүбдоржи-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундадын зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Үйзэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Их Хорго уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-45

**Он:** 1914 (Олноо өргөгдсөний 4 он 2 сарын 17)

**Хэмжээ:** 31 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардсан цагаан даавуу

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг, Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2,3 см х 2,3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Нутгийн зургийн гадна хэсэгт зүг чигийн хүрдний 24 зүгийг тойруулан бичжээ. Хилийн овоог улаан гурвалжин дүрсээр тэмдэглэж тойруулан нэрийг бичжээ. Зургийнхаа суурийг нилэнхүйд нь ногоон өнгөөр будсан байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан будсан байна. Уг зургийн ихэнхи хэсэг норж

балархайшсан учир гол мөрөн, нуур, тойрмын дүрслэл газар усны нэр, тайлбар уншигдахгүй болжээ. Хадгалалт муу.

**116. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Үйзэн гүн Дондовдоржийн хошууны нутгийн зураг (*tüsiyetü sayin qan ayimaγ-un üjeng güng dondubdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын дундадын зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Үйзэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Их Хорго уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-46

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он 6 сарын 10)

**Хэмжээ:** 51 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2,3 см х 2,3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Нутгийн зургийн гадна хэсэгт зүг чигийн хүрдний 24 зүгийг тойруулан бичжээ. Хилийн овоог улаан гурвалжин тэмдэгээр дүрсэлж тойруулан нэрийг бичжээ. Зургийн суурийг нилэнхүйд нь ногоон өнгөөр, уул, нуруу, толгодыг цэнхэр өнгөөр зурж ногоон өнгөөр давхарлан будсан байна. Уулсын өндөрлөг газрыг хар ногоон өнгөөр тодотгожээ. Булаг, шандыг цэнхэр өнгөөр буджээ. Хүрэн улаан өнгөөр 2 гэр зураад “албаны газар”, “засаг гүн” гэж бичжээ. Хятад маягийн загвартай 1 сүм зураад “Дөчит ламын суух газар” гэж бичжээ. Зургийн суурь норж ууссан байна. Хадгалалт муу.

**117. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Авзага хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-44

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 55 см х 70 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Могод, Хишиг-Өндөр, Сайхан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж хүрэн, ногоон өнгөөр

давхарлан буджээ. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр зурж, газар усны нэр, тайлбарыг хар бэхээр бичжээ. Зарим уулын оройд суварга зурж, суваргуудыг холбосон шар өнгийн зам татжээ. Суурин газрыг дөрвөлжин дотор дугуй хэлбэртэй тэмдэглэсэн байна. Зураг нэлээд элэгджээ. Газар усны нэр, тайлбарыг бор цаасан дээр бичиж наасны зарим бичвэр гээгдсэн бололтой. Хадгалалт хэвийн.

- 118. Зургийн нэр:** Улсын түшээ гүнгийн зэрэг засаг улсад туслагч гүн арван долоон зэрэг нэмсэн, найман зэрэг тэмдэглэсэн Цэдэнсономын хошууны нутгийн зураг (*ulus-un түсий-е гүнг-үн жерге жасаγ ulus-tur тусалаγчи гүнг арбан долуγан жерге nemegsen naiman жерге темдеглегсен čedengsonum-un qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Авзага хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-48

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 4 сарын 25)

**Хэмжээ:** 52 см х 50 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Могод, Хишиг-Өндөр сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дөрвөлжин хэлбэртэй тэмдэглэж нэрийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, булаг, шандыг хөх өнгөөр зурсан байна. 1 гэр зурж “Хошууны тамгын газар”, “Ноёны өргөө” гэж бичжээ. Хятад маягийн загвартай 1 сүм дүрсэлсэн байна. Нутгийн зураг тайлбар бичээс ихтэй ажээ. Зургийн дүрслэл бүдэг хэдий боловч бичвэр нь тод юм. Хадгалалт сайн.

- 119. Зургийн нэр:** Түшээт сайн хан аймгийн Бишрэлт засаг улсад туслагч гүн Сундуйн хошууны нутгийн зураг (*түсийетү сайн қан айимаγ-un bisiriltü жасаγ ulus-tur тусалаγчи гүнг sungdui-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Авзага хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-49

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 12 сарын 20)

**Хэмжээ:** 67 см х 59 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Булган аймаг. Могод, Хишиг-Өндөр, Сайхан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог босоо гурвалжингаар тэмдэглэж, тойруулан нэрийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, булаг шандыг хөх өнгөөр будсан байна. Зургийн суурийг нилэнхүйд нь цайвар ногоон өнгөөр буджээ. Өртөөний сууринг тэмдэглээгүй. Өртөө замыг бор шар бэхээр зуржээ. Хятад маягийн загвартай 1 сүм дүрсэлжээ. Гэр зурж “Хошууны тамгын газар”, “Ноёны өргөө” гэж бичсэн байна. Нутгийн зураг тайлбар бичээс ихтэй боловч бичиг нь нэлээд бүдгэрчээ. Хадгалалт муу.

**120. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Түшээт хан аймгийн Орос зүг тавьсан Хавтгай гэр харуулын нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-50

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 18 см х 25 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Түшиг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаагүй. Зүг чиг бичээгүй байна. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Хилийн овоог цэцэг мэт хэлбэртэй дүрсэлжээ. Нутгийн төв хэсэгт нэг голыг хөндлөн зураад эргэн тойрон мод тэмдэглэжээ. Зургийн төв хэсэгт хятад маягийн загвартай нэг сүм зуржээ. Хил залгаа хошуу нутгийн мэдээллийг хоёр талд бичсэн байна. Зургийн хадгалалт хэвийн.

**121. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Сэлэнгэ, Орхоны бэлчир, Хиагт орчмын зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-51

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 54 х 31 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Сэлэнгэ аймаг. Сүхбаатар, Алтанбулаг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 7 см х 7 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хар дугуй хэлбэртэй тэмдэглэжээ.

Уул, нуруу, толгойг хар бэхээр зураад орой хэсгийг хар, бэлийг ягаан өнгөөр будсан байна. Гол мөрнийг олон салаа байдалтай дүрслэн голын бэлчир дагуу өтгөн шугуй зуржээ. Зургийн зүүн дээд буланд Хиагт хотын хэлбэр төрхийг зүүн тийш хандуулсан байдалтай зурсан байна. Хиагт хотод Монгол, орос сүм зураад хотын гудмыг ягаан бэхээр буджээ. Зургийн хадгалалт хэвийн.

**122. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Монгол өртөө, харуулыг тэмдэглэсэн бүдүүвч зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-52

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 63 см х 67 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол Улс. БНХАУ. ӨМӨЗО. Хөлөнбуйрын Барга, Шинжаан Уйгар.

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаагүй. Зүг чигийг бичээгүй байна. Газар зүйн биетийн дүрслэлийг тэмдэглээгүй. Өртөө, харуулын нэрийг дугаарлан бичжээ. Суурин газрыг тод дүрсэлсэн байна. Өртөө, харуулын хүн ам, мал сүргийн тоог бичжээ. Хадгалалт хэвийн.

**123. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Их Хүрээ-Хиагтын Хунцал, Баянбаруухай, Хараа, Баянгол өртөөдийн нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-53

**Он:** Он ичээгүй

**Хэмжээ:** 24 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Төв аймаг. Борнуур сум, Сэлэнгэ аймаг. Мандал сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн хоёр талд зүг чигийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол мөрнийг хөх өнгөөр будсан байна. Тус зураг нь өртөөний эзэмшил нутаг юм. Нутгийн дундуур хүрэн бэхээр өртөөний замыг зуржээ. Зам дагуу хятад тариан талбай, байшин зэргийг зурсан байна. Зургийн хадгалалт хэвийн.

**124. Зургийн нэр:** Жибзундамба хутагтын шавь хар Дархад ардын нутгийн зураг (*jibjungdamba qutuγtu-yin šabi qar-a darqad arad-un nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Дархад 3 отог

**Хошууны нэр:** Жибзундамба хутагтын Дархад шавь

**Хошууны хожмын нэр:** Дэлгэр их уулын аймаг (1924-1926)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-2, хад. нэгж-54

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 4 сарын шинийн 8)

**Хэмжээ:** 70 см х 64 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Хөвсгөл аймаг. Баянзүрх, Цагаан-Үүр, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт 12 см х 12 см хэмжээтэй тор татсан байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог шар өнгө бүхий гурвалжин дүрсээр зургаа тойруулан тэмдэглэсэн ажээ. Нутгийн хилийг улаан шунхаар татжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Уулсын хэв шинжийг хооронд нь нилээд ялгаатай тэмдэглэжээ. Гол мөрөн, нуурыг хөх өнгөөр дүүргэн будаж, нуурыг усан хээгээр дүрсэлсэн байна. Нуурыг тойруулан модтой хэсгийг ногооноор зуржээ. Нутгийн дундуур явах зам харгуйг шар өнгөөр буджээ. Зургийн төвд дөрвөлжин шар дүрсээр 1 сүмийг зуржээ. Газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасны зарим нь гээгдэн бололтой. Хадгалалт хэвийн.

#### 4.3. ХАЛХЫН САЙН НОЁН АЙМГИЙН НУТГИЙН ЗУРАГ

##### Данс.МНЗ-III

125. **Зургийн нэр:** Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын Сайн ноён чуулганы дарга, засаг чин ван Намнансүрэнгийн хошууны нутгийн зураг (*badaraqultu törü-yin qičin qurbaduqar on-du üileddügsen qalq-a-yin sayin noyan čiqulqan-u daruγ-a jasaγ čin wang namnangsürün-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын Сайн ноён засгийн хошуу

**Хошууны нэр:** Сайн ноён ханы хошуу



**Хошууны хожмын нэр:** Хан хөгшин уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-1

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 10)

**Хэмжээ:** 64 см х 66 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цардсан цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Баруунбаян-Улаан, Гучин ус, Хайрхандулаан, Нарийнтээл, Уянга, Бат-Өлзий сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 4,5 см х 4,5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг улаан бэхээр бичжээ. Хил зурсан боловч ууссан бололтой. Уул, нуруу толгодыг хар бэхээр зурж ногоон, цэнхэр өнгөөр даврахлан буджээ. Зарим уулын оройд мод дүрсэлсэн байна. Гол мөрөн, нуур, тойрмыг хөх өнгөөр зуржээ. Газар усны нэр, тайлбарыг тойруулан дэлгэрэнгүй бичсэн байна. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Нутгийн зургийн ихэнх хэсгийг тайлбар бичээс эзлэнэ. Зурагт буй газар зүйн биетүүдийн өнгө уусаж дүрслэл нь бүдгэрсэн байдалтай байна. Хадгалалт муу.

126. **Зургийн нэр:** Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын умар замын зүүн гарын баруун этгээдийн засаг Балдангийн хошууны нутгийн зураг (*badaraqultu törü-yin yučin yurbaduγar on-du üleddügsen qalq-a-yin umar-a jam-un jegün γar-un baraγun eteged-ün jasaγ baldan-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын зүүн гарын баруун этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Ёст засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Гурвансайхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-2

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 4)

**Хэмжээ:** 61 см х 67 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Баяндалай, Ноён, Сэврэй, Гурвантэс сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан эсэх нь сайн мэдэгдэхгүй болжээ. Зургийн дөрвөн талд зүг чигийг улаан бэхээр бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй бололтой. Газар усны нэр, тайлбарыг тойруулан дэлгэрэнгүй бичжээ. Уул, нуруу толгодыг хар бэхээр зураад цэнхэр өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуур, булгийг хөх өнгөөр зуржээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Нутгийн зурагт буй газар зүйн биетүүдийн өнгө ууссан байдалтай байна. Зургийн

тайлбар нэрсүүд нилээд уусаж бүдгэрсэн боловч уншиж болохоор байна. Хадгалалт дунд зэрэг.

- 127. Зургийн нэр:** Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын умар замын дунд дахь өмнөд засаг бэйл Дондовжанцангийн хошууны нутгийн зураг (*badarayultu törü-yin yučin yurbaduyar on-du üilüdügen qalq-a-yin umar-a jam-un dumdadaki emün-e-dü jasaу beyile dongdubjančan-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)  
**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дунд өмнөд этгээдийн зүүн гарын хошуу  
**Хошууны нэр:** Үйзэн засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Арвайхээр уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-3  
**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 оны 9 сарын шинийн 3)  
**Хэмжээ:** 65 см х 66 см  
**Бичвэрийн хэл:** Монгол  
**Өнгө:** Өнгөт  
**Зурсан эд:** Цагаан даавуу  
**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан  
**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Хужирт, Өлзийт, Сант сум, Архангай аймаг. Хотонт сум  
**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан эсэх нь сайн мэдэгдэхгүй болжээ. Зургийн дөрвөн талд зүг чигийг улаан бэхээр бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй бололтой. Газар усны нэр, тайлбарыг тойруулан бичжээ. Уул, нуруу толгодыг хар бэхээр зураад цэнхэр өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуур, булгийг хөх өнгөөр буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Нутгийн зурагт буй газар зүйн биетүүдийн өнгө ууссан байдалтай байна. Зургийн тайлбар нэрсүүд нилээд уусаж бүдгэрсэн боловч уншиж болохоор байна. Хадгалалт дунд зэрэг.
- 128. Зургийн нэр:** Сайд Сайн ноён хан аймгийн бэйсийн зэрэг Ахай засаг Цэрэндоржийн хошууны нутгийн зураг (*sayid sayin noyan qan ayimaγ-unn beyise-yin jerge aqai jasaγ çerengdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)  
**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын зүүн этгээдийн адгийн хошуу  
**Хошууны нэр:** Ахай засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Дөлгөөн уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-4  
**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 11 сарын 21)  
**Хэмжээ:** 51 см х 30 см  
**Бичвэрийн хэл:** Монгол  
**Өнгө:** Өнгөт  
**Зурсан эд:** Даавуу  
**Тамга:** Тамга дараагүй  
**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Зүүнбаян-Улаан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг хар бэхээр бичжээ. Хилийн овоог нэгдсэн байдлаар тэмдэглээгүй. Гурвалжин дугуй зэрэг хэд хэдэн дүрслэлийг ашигласан байна. Хилийн шугам татаагүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад будаагүй байна. Мөн гол мөрөн, тал зэрэг газар зүйн биетүүдийг товгор дүрслэлийн аргаар зуржээ. Хошууны нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг шар зураасаар тэмдэглэжээ. Өртөөний сууринг зураагүй. Нутгийн төв хэсэгт 1 сүм зуржээ. Нутгийн зургийн өнгө, будаг уусаж газар усны нэр, тайлбаруудыг уншиж болохооргүй болжээ. Хадгалалт муу.

- 129. Зургийн нэр:** Сайд Сайн ноён хан аймгийн бэйлийн зэрэг Сүжигт Өөлдийн засгийн хошууны бэйс Чимиддэлэгийн хошууны нутгийн зураг (*sayid sayin noyan qan ayimaγ-un beyile-yin jerge süjügtü ögeled-ün jasaγ qosiqun-u beyise čimeddelig-yin qosiqun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн өмнөд хошуу

**Хошууны нэр:** Сүжигт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Хотонт уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-5

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 11 сарын арван 9)

**Хэмжээ:** 48 см х 46 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Хотонт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог дугуй дүрсээр тэмдэглэж, нэрийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан буджээ. Зарим уулын оройд мод дүрсэлж, гол мөрөн, нуур цөөрмийг хөх өнгөөр будсан байна. Зургийн хойд хэсэгт хятад маягийн загвартай 1 сүмийг гоёмсог төрхтэй зурж, тойруулан суурин газруудыг дөрвөлжин дүрсээр тэмдэглээд шар өнгөтэй дугуй дүрсээр хүрээ татжээ. 2 гэр зураад дээвэр хэсгийг хүрэн өнгөөр будаад “Засгийн өргөө”, “Яам” гэж бичжээ. Нутгийн дундуур явах өртөө замыг шар өнгөөр зуржээ. Эвдэрхий хэрэмний туурийг дөрвөжин дүрсээр тэмдэглэж, зургаа тойруулан тайлбар бичжээ. Зургийн зарим хэсэг гэмтсэн байна. Хадгалалт муу.

- 130. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-6

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 53 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургаа эгц дээрээс харуулан зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, цэнхэр, хүрэн өнгөөр давхарлан буджээ. Зарим уулын оройг хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуурыг усан хээгээр дүүргэн зураад цэнхэр өнгөөр буджээ. Сүм хийд тэмдэглээгүй. Зургийн төв хэсэгт нэг суурин газрыг зураад нэр бичээгүй байна. Газар усны нэр, тайлбарыг хар бэхээр бичээд ногоон өнгөөр давхарлан буджээ. Хадгалалт хэвийн.

**131. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-7

**Он:** 1805 (Сайшаалтай ерөөлтийн 10 он 5 сарын шинийн 8)

**Хэмжээ:** 54 см х 55 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Зарим уулыг модтой, зарим уулын оройд овоо дүрсэлжээ. Гол мөрөн, нуур цөөрмийг усан хээгээр дүүргэн угалзруулан зураад хөх өнгөөр буджээ. Нуур, булаг зэргийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Голын сав дагуух газрын суурийг ногоон өнгөөр нилэнхүйд нь буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Хадгалалт хэвийн.

**132. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-8

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 56 см х 50 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум  
**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулсан зурсан байна. Ууд, нуруу, толгодыг хар бэхээр зуржээ. Зарим уулын оройд овоо, хад дүрсэлсэн байна. Гол мөрөн, нуур, булгийг хар бэхээр зураад уусан хээ зуржээ. Нуур, цөөрөм, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Сүм хийд, суурин газрыг огт зураагүй. Хадгалалт хэвийн.

**133. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-9

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 52 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зуржээ. Зарим уулын оройд хад, мод дүрсэлсэн байна. Гол мөрөн, нуур, булгийг хар бэхээр зураад огт будаагүй ажээ. Нуур, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрслээд усан хээгээр дүүргэн зуржээ. Зургийн баруун дээд хэсэгт дөрвөлжин хүрээн дотор нэг сүм дүрсэлсэн байна. Суурин газрыг тэмдэглээгүй. Зургийг ноорог байдалтай үйлджээ. Хадгалалт хэвийн.

**134. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-10

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 22 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаагүй байна. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Зургийг эгц дээрээс харуулж зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад будаагүй. Зарим уулын оройд овоо, мод зуржээ. Гол мөрөн, нуур, булгийг хар бэхээр зурсан байна. Голын сав дагуу шугуйг дүрсэлжээ.

Нуур, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Хэд хэдэн суварга зурсан байна. Зургийг ноорог байдалтай үйлджээ. Зургийн урдуур урагдаж цоорсон байна. Хадгалалт муу.

**135. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-11

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 48 см х 29 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийг эгц дээрээс харуулж зуржээ. Зүг чиг, хилийн овоог тэмдэглээгүй. Байгалийн дүрслэл нь хилийн овоо мэт харагдана. Уул, нуруу, толгодыг хар өнгөөр зуржээ. Зарим уулсыг хад, модтой дүрсэлжээ. Гол мөрөн, нуур, цөөрмийг хар өнгөөр зураад будаагүй байна. Голын дагуу шугуй зуржээ. Сүм хийд, суурин газрыг огт тэмдэглээгүй. Газар усны нэр, тайлбарыг бичээгүй ноорог байдалтай үйлдсэн зураг ажээ. Зургийн хадгалалт хэвийн.

**136. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-12

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 48 см х 28 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургаа эгц дээрээс харуулж зуржээ. Хилийн овоо, зүг чигийг тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад будаагүй байна. Гол мөрөн, нуурыг олон салаалууж зуржээ. Голыг хар бэхээр буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зургийн хадгалалт хэвийн.

**137. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-13  
**Он:** Он бичээгүй  
**Хэмжээ:** 48 см х 28 см  
**Бичвэрийн хэл:** Монгол  
**Өнгө:** Хар, цагаан  
**Зурсан эд:** Цаас  
**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум  
**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургаа эгц дээрээс харуулж зуржээ. Хилийн овоо, зүг чигийг тэмдэглээгүй. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад будаагүй байна. Гол мөрөн, нуурыг олон салаалууж зуржээ. Голыг хар бэхээр буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зургийн хадгалалт хэвийн.

138. **Зургийн нэр:** Халхын Сайн ноён аймгийн чуулганы дэд дарга бэйс Чагдаржилын хошууны нутгийн зураг (qalq-a-yin sayin noyan ayimay-un ciqulyan-u ded daruγ-a beyise čaγdurjil-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу  
**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-14  
**Он:** Он бичээгүй [1817-1878]  
**Хэмжээ:** 46 см х 32 см  
**Бичвэрийн хэл:** Монгол  
**Өнгө:** Өнгөт  
**Зурсан эд:** Цаас  
**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум  
**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар батаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй боловч улаан цэгэн шугам татаж хилээ тодруулсан байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн, хар өнгөөр давхарлан буджээ. Зарим уулын оройд овоо, мод зуржээ. Гол мөрөн, нуур, булгийг хар бэхээр зураад хөх өнгөөр буджээ. Нуур, булгийг зоос мэт дугуй хэлбэртэй дүрсэлжээ. Зургийн төв хэсэгт 1 сүм, 1 суурин газрыг зурсан байна. Хадгалалт хэвийн.

139. **Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу  
**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу  
**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-15

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 50 см х 31 см

**Бичвэрийн хэл:** Монгол, манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 6 см хэмжээтэй дөрвөлжин тор татан үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургаа эгц дээрээс харуулан зуржээ. Зургийн дөрвөн талд зүг чигийн монгол, манж хэлээр бичжээ. Хилийн овоог цэнхэр өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглээд хооронд нь улаан бэхээр холбож хилээ зурсан байна. Зургийн суурийг нилэнхүйд нь шар, ногоон өнгөөр буджээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, хүрэн, саарал өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр будаад усан хээгээр дүүргэн зуржээ. Гол мөрний дагуу шугуй зурсан байна. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Уг нутгийн зураг бичвэр багатай боловч өнгө үзэмж сайтай юм. Тус зургийг ноорог байдлаар үйлдсэн бололтой. Зургийн хадгалалт хэвийн.

**140. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-16

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 48 см х 25 см

**Бичвэрийн хэл:** Монгол, манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 5 см х 5 см хэмжээтэй дөрвөлжин тор татан үйлджээ. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургаа эгц дээрээс харуулан зуржээ. Зургийн дөрвөн талд зүг чигийн монгол, манж хэлээр бичжээ. Хилийн овоог цэнхэр өнгө бүхий дугуй дүрсээр тэмдэглээд хооронд нь улаан цэгэн шугам татаж хилээ зуржээ байна. Зургийн суурийг нилэнхүйд нь ногоон, шар өнгөөр буджээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр будсан байна. Зарим уулсыг хад, модтой дүрсэлжээ. Гол мөрөн, нуур, цөөрмийг хар бэхээр зураад хөх өнгөөр будсан байна. Голын дагуу шугуй зуржээ. Дөрвөлжин хүрээн дотор хятад, төвөд загвартай хэд хэдэн сүмийг зурсан байна. Газар усны нэр, тайлбарыг цаасан дээр бичиж наасны зарим бичвэр гээгдсэн бололтой. Зургийн хадгалалт хэвийн.



- 141. Зургийн нэр:** Халхын Сайн ноён аймгийн баруун хоёр аймгийн харуулыг бүгд захирах бэйс Дагдандоржийн хошууны нутгийн зураг (qalq-a-yin sayin noyan ayimaγ-un baraγun qoyar ayimaγ-un qaraqul-i бүгүде jakirqu beyise daγdangdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)
- Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу
- Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу
- Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)
- Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-17
- Он:** Он бичээгүй [1879-1903]
- Хэмжээ:** 30.5 см х 22.5 см
- Бичвэрийн хэл:** Монгол
- Өнгө:** Өнгөт
- Зурсан эд:** Цаас
- Тамга:** Тамга дараагүй
- Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум
- Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2 см х 2 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Зургийг дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хоёр хос тэгш өнцөгт дүрсээр тэмдэглээд хооронд нь улаан цэгэн шугам татаж хилээ зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, шар, хүрэн өнгөөр буджээ. Гол мөрөн, нуурыг хар бэхээр зураад хөх өнгөөр будсан байна. Зургийн төв хэсэгт дөрвөлжин дүрсээр ноёны өргөө, албан газрыг тэмдэглэжээ. Зургийг тойруулан зэргэлдээх хошууны мэдээллийг бичсэн байна. Хадгалалт хэвийн.
- 142. Зургийн нэр:** Халхын Сайн ноён аймгийн баруун хоёр аймгийн харуулыг бүгд захирах бэйс Дагдандоржийн хошууны нутгийн зураг (qalq-a-yin sayin noyan ayimaγ-un baraγun qoyar ayimaγ-un qaraqul-i бүгүде jakirqu beyise daγdangdorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ)
- Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу
- Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу
- Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)
- Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-18
- Он:** Он бичээгүй [1879-1903]
- Хэмжээ:** 31 см х 23 см
- Бичвэрийн хэл:** Монгол
- Өнгө:** Өнгөт
- Зурсан эд:** Цаас
- Тамга:** Тамга дараагүй
- Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум
- Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 2 см х 2 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг эгц дээрээс харуулан зуржээ. Зургийг дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог хоёр хос тэгш өнцөгт дүрсээр тэмдэглээд хооронд нь улаан цэгэн шугам татаж хилээ зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, шар, хүрэн өнгөөр

буджээ. Гол мөрөн, нуурыг хар бэхээр зураад хөх өнгөөр будсан байна. Зургийн төв хэсэгт дөрвөлжин дүрсээр ноёны өргөө, албан газрыг тэмдэглэжээ. Зургийг тойруулан зэргэлдээх хошууны мэдээллийг бичсэн байна. Хадгалалт хэвийн.

- 143. Зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Өөлдийн бэйлийн зэрэг Бишрэлт засаг хошууны бэйс Бадамгаравын хошууны газар нутгийн зураг (*sayin noyan qan ayimaγ-un ögeled-ün beyile-yin jerge biseriltü jasaγ qosiyun-u beyise badmagarba-yin qosiyun-u γajar nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Хавсран захирагдсан Өөлдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Бишрэлт засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Баянбайшир уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-19

**Он:** 1921 (Олноо өргөгдсөний 11 он)

**Хэмжээ:** 47 см х 46 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгий нуур, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 4 см х 4 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийг эгц дээрээс харуулан зурсан байна. Зургийг дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог гурвалжин хэлбэртэй тэмдэглээд хооронд нь улаан бэхээр зураас татан хилээ зуржээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр будсан байна. Зургийн зүүн доод буланд улаан дөрвөлжин хүрээ татжээ. Зургийн дийлэнх хэсгийг тайлбар бичээс эзлэнэ. Зургийн дээд, доод хэсэг норж газар зүйн биетүүдийн дүрслэл, бичвэр уусаж бүдгэрсэн байна. Хадгалалт муу.

- 144. Зургийн нэр:** Шадар сайд Сайн ноён хан аймгийн засаг улсад туслагч Саруул гүн Гэлэгийн хошууны нутгийн зураг (*sidar sayid sayin noyan qan ayimaγ-un jasaγ ulus-tur tusalaγči saraγul güng gelüg-ün qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын өмнөд хошуу

**Хошууны нэр:** Саруул засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Чунхайлан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-20

**Он:** Он бичээгүй [1912-1923]

**Хэмжээ:** 51см х 49 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Хайрхан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 4 см х 4 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Хилийг улаан шунх татан зуржээ. Овооны нэрийг зургийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад хөх өнгөөр будсан байна. Зарим уулын оройд мод зурсан байна. Гол мөрөн, нуур, цөөрмийг хөх өнгөөр буджээ. 2 гэр зурж дээвэр хэсгийг улаан өнгөөр давхарлан будсан байна. Хятад, түвд маягийн загвартай 2 сүм зуржээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг шар зураасаар тэмдэглэжээ. Өртөөний сууринг зураагүй. Зургийн дөрвөн талд газар усны нэр, тайлбарыг бичсэн байна. Хадгалалт хэвийн.

- 145. Зургийн нэр:** Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын умард замын баруун гарын умард засаг Мөнх-Очирын хошууны нутгийн зураг (*badaraγultu törü-yin γučin γurbaduγar on-du üileddügsen qalq-a-yin umar-a jam-un barayun γar-un umardu jasaγ möngkewačar-un qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын умард хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цагаан сүм уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-21

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 6)

**Хэмжээ:** 57 см х 67 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Хөвсгөл аймаг. Рашаант сум, Архангай аймаг. Цэцэрлэг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан эсэх нь мэдэгдэхгүй. Хилийн овоог тэмдэглээгүй. Хилийн шугам татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг улаан бэхээр бичжээ. Зургийг тойруулан овооны нэрийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад цайвар ногоон өнгөөр будсан байна. Гол мөрөн, нуурыг хар бэхээр зураад хөх өнгөөр буджээ. Сүм хийд, суурин газрыг тэмдэглээгүй. Зургийн газар усны нэр, тайлбарууд уусаж нэлээд бүдгэрчээ. Хадгалалт муу.

- 146. Зургийн нэр:** Сайд Сайн ноён хан аймгийн Мөнх-Очирын хошууны нутгийн зураг (*sayid sayin noyan qan ayimay-un ulus-tur tusalaγči güng-ün jerge mergen jasaγ terigün jerge tayiji möngke-wčir-un qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын умард хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цагаан сүм уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-22

**Он:** Он бичээгүй [1911-1919]

**Хэмжээ:** 40 см х 59 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Хөвсгөл аймаг. Рашаант сум, Архангай аймаг Цэцэрлэг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон өнгөөр давхарлан буджээ. Зарим уулын оройд овоо зурсан байна. Гол мөрөн, нуурыг хар бэхээр зураад хөх өнгөөр буджээ. 7 сүм зурсан байна. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг шар өнгөөр зуржээ. Зарим газар зүйн биетийн дүрслэл харагдахгүй болтол бүдгэрчээ. Зургийн газар усны нэр, тайлбарууд ууссан байдалтай байна. Хадгалалт муу.

147. **Зургийн нэр:** Сайд Сайн ноён хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг Мэргэн засаг тэргүүн зэрэг тайж Мөнх-Очирын хошууны нутгийн зураг (*sayid sayin noyan qan ayimaγ-un ulus-tur tusalaγci güng-ün jerge mergen jasaγ terigün jerge tayiji möngkewačar-yin qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун гарын умард хошуу

**Хошууны нэр:** Мэргэн засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цагаан сүм уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-23

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 39 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Даавуу

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Хөвсгөл аймаг. Рашаант сум, Архангай аймаг. Цэцэрлэг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй ажээ. Зургийн дөрвөн талд зүг чигийг бичжээ. Хилийн овоог тэмдэглэсэн эсэх мэдэгдэхгүй байна. Уул, нуруу, толгодыг хар бэхээр зураад ногоон, гол мөрөн, нуур, булгийг хөхөөр буджээ. Нутгийн дундуур явах өртөө замыг шараар зурсан байна. Сүм хийд суурин газрыг хэд хэдийг зурсан бололтой. Зургийн газар зүйн биет, газар усны нэр, тайлбарууд уусаж нэлээд бүдгэрчээ. Хадгалалт муу.

148. **Зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Эрдэнэ мэргэн ноён хутагтын шавийн нутгийн зураг (*sayin noyan qan ayimaγ-un erdeni mergen noyan qutuγtu-yin šabinar-un nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Эрдэнэ мэргэн хутагтын шавь

**Хошууны нэр:** Эрдэнэ мэргэн хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Гурван сайхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-24

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он илүү 12 сарын шинийн 19)

**Хэмжээ:** 51 см х 44 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өмнөговь аймаг. Богд сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан эсэх мэдэгдэхгүй байна. Зургийн дөрвөн талд улаан бэхээр зүг чигийг бичжээ. Хилийн овоог гурвалжин дүрсээр тэмдэглээд зургийг тойруулан овооны нэрийг бичсэн байна. Уул, нуруу, толгодыг хараар зураад ногоон өнгөөр буджээ. Гол мөрөн, булаг, тал хээр зэрэг газар зүйн биетүүдийг хараар зуржээ. Зурагт 1 сүм, 2 гэр зурсан байна. Зургийн дүрслэл сайн мэдэгдэхгүй болжээ. Даавууны ихэнхи хэсгийг тайлбар бичээс эзэлнэ. Газар, усны нэр, тайлбарыг уншиж болохгүй болжээ. Хадгалалт муу.

**149. Зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад барын гарын адгийн хошуу

**Хошууны нэр:** Ачит засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Цэцэрлэг голын хошуу

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-25

**Он:** Он бичээгүй [1907-1911]

**Хэмжээ:** 33,5 см х 35 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Булган, Төвшрүүлэх сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Тэгш дөрвөлжин хэлбэртэй хүрэн өнгийн хүрээ татжээ. Зургийн суурийг ногоон өнгөөр бүхэлд нь буджээ. Уул, нуруу, толгодыг хараар зураад хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, булаг, шандыг цэнхэр өнгөөр буджээ. 1 сүм, 2 гэр зуржээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг шар өнгөөр тэмдэглэжээ. Өртөөний сууринг тэмдэглээгүй. Зургийг тойруулан тайлбар бичжээ. Хадгалалт хэвийн.

**150. Зургийн нэр:** Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын Эрдэнэ

бандида хутагтын шавь нарын нутгийн зураг (*badaraγultu törü-yin γučin γurbaduγar on-du üileddügsen qalq-a-yin erdeni bandida qutuγtu-yin šabinar-un nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Эрдэнэбандида хутагтын шавь

**Хошууны нэр:** Эрдэнэбандида хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Баянзүрх уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-26

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 оны 9 сарын шинийн 9)

**Хэмжээ:** 57 см х 65 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Баянхонгор аймаг. Баянлиг, Баянговь, Богд, Жинст, Өлзийт сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зургийн дөрвөн талд зүг чигийг улаан бэхээр бичжээ. Хилийн овоог тэмдэглээгүй. Овооны нэр, хил залгаа хошууны газар усны нэрийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толголдыг хараар зураад орой хэсгийг цэнхэр өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр буджээ. Шавийн нутгийн төв хэсэгт 1 сүм зурж “Соёл бадаргуулагч сүм” хэмээн бичжээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх хоёр өртөөний нэрийг бичжээ. Өртөөний сууринг тэмдэглээгүй. Хадгалалт муу.

- 151. Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Эрдэнэ Зая бандида хутагтын шавь нарын нутгийн зураг (*sayin noyan qan ayimaγ-un erdeni jay-a bandida qutuγtu-yin šabinar-un nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Эрдэнэ Зая бандида хутагтын шавь

**Хошууны нэр:** Эрдэнэ Зая бандида хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Эрдэнэбулган уулын хошуу(1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-27

**Он:** 1922 (Олноо өргөгдсөний 12 он)

**Хэмжээ:** 131 см х 66 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталагаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай аймаг. Өгийнуур, Цэнхэр, Их тамир, Эрдэнэ мандал сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 4.5 см х 4.5 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог хар өнгөтэй гурвалжин дүрсээр тэмдэглээд газар усны нэрийг тойруулан бичжээ. Уул, нуруу, толгодыг хар өнгөөр зураад орой хэсгийг тод ногоон өнгөөр давхарлан будсан байна. Нутгийн зургийн суурийг нилэнхүйд нь цайвар ногоон өнгөөр буджээ. Зарим уулыг модтой дүрсэлсэн байна. Гол мөрөн, нуур, булгийг цэнхэр өнгөөр зураад цэнхэр өнгөөр дүүргэн буджээ. Зургийн зүүн урд хэсэгт хятад маягийн загвартай 2 сүм, түвд маягийн загвартай 1 сүмийг зуржээ. 3 том, 1 жижиг гэр зурсан байна. Нутгийн дундуур явах өртөө замыг шар өнгөөр зурж тэмдэглэжээ. Өртөөний сууринг тэмдэглээгүй байна. Хадгалалт муу.

- 152. Нутгийн зургийн нэр:** Бадаргуулт төрийн 33 онд үйлдсэн Халхын умард замын дундах зүүн этгээдийн засаг хуйвин сайд жүн вангийн зэрэг бэйл Цэдэнсономын хошууны нутгийн зураг (*badaraγultu törü-yin жүчин үurbaduγar on-du üilleddүgsen qalq-a-*

*yin umar-a jam-un dumdaki jegün eteged-ün jasaγ quubi-yin sayid kebei giyün wang-un jerge beyile čedensonam-un qosiγun-u nutuγ-un jiruγ)*

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Далай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Чандмань-Өлзийт далайн уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-28

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 7)

**Хэмжээ:** 64 см х 64 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тосонцэнгэл, Их-Уул, Идэр сум, Хөвсгөл аймаг. Галт, Шинэ-Идэр, Жаргал сум, Архангай аймаг. Тариат, Хангай, Цахир сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Овооны нэрсийг тойруулан бичжээ. Хил залгаа хошуу нутгийн газар усны нэр, тайлбарыг нутгийн зургаа тойруулан бичсэн байна. Уул, нуруу, толгойг хар өнгөөр зураад гол мөрнийг цэнхэр өнгөөр зуржээ. Сүм хийд, суурин газрыг зураагүй. Зургийн газар усны нэр, тайлбар урсаж бүдгэрчээ. Хадгалалтын муу.

**153. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад дахь зүүн этгээдийн хошуу

**Хошууны нэр:** Далай засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Чандмань-Өлзийт далайн уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-29

**Он:** 1922 (Олноо өргөгдсөний 11 он 4 сарын 28)

**Хэмжээ:** 48.5 см х 90 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Тосонцэнгэл, Их-Уул, Идэр сум, Хөвсгөл аймаг. Галт, Шинэ-Идэр, Жаргал сум, Архангай аймаг. Тариат, Хангай, Цахир сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 3 см х 3 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургийн дөрвөн талд дэлгэрэнгүй тайлбар бичжээ. Уул, нуруу, толгодыг хар өнгөөр зураад хар хөх өнгөөр давхарлан буджээ. Зарим уулын бэлд мод дүрсэлсэн байна. Гол мөрнийг цэнхэр өнгөөр будаж, нуурыг усан хээгээр угалзлуулан дүрсэлжээ. Нуурын голд улаан өнгөөр нэгэн уулыг тод зурсан байна. Хятад маягийн загвартай 4 сүм зурж дээвэр хэсгийг нь улаан хүрэн өнгөөр буджээ.

2 гэр зурсан байна. Нутгийн дундуур явах өртөө замыг шар өнгөөр тэмдэглэжээ. Идэр, Тэрхийн сав газруудыг сайн мэдэгдэхээр дүрсэлжээ. Хадгалалт хэвийн.

**154. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Наран хутагтын шавь

**Хошууны нэр:** Наран хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Хүрээ-Марал уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-30

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 10 сарын 20)

**Хэмжээ:** 60 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Шилүүстэй сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургаа тойруулан хилийн овооны нэрийг бичжээ. Нутгийн зургийг хойноос нь урагш 5 хэсэгт хуваасан байна. Зургийн суурийг нилэнхүйд нь ногоон өнгөөр буджээ. Уул, нуруу, толгодыг хар болон улаан, ногоон өнгөөр тус тус буджээ. Зургийн дээд хэсэгт сүм хийд, хошууны тамгын гэрийг зурсан байна. Хадгалалт хэвийн.

**155. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Наран хутагтын шавь

**Хошууны нэр:** Наран хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Хүрээ-Марал уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-31

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 он 10 сарын 20)

**Хэмжээ:** 60 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Шилүүстэй сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургаа тойруулан хилийн овооны нэрийг бичжээ. Нутгийн зургийг хойноос нь урагш 5 хэсэгт хуваасан байна. Зургийн суурийг нилэнхүйд нь ногоон өнгөөр будаад уулсыг хар болон улаан, ногоон өнгөөр тус тус буджээ. Зургийн дээд хэсэгт сүм хийд, хошууны тамгын гэрийг зурсан байна. Хадгалалт хэвийн.

**156. Нутгийн зургийн нэр:** Сайн ноён хан аймгийн Наран хутагтын харьяат шавийн нутгийн зураг (*sayin noyan qan ayimaγ-un naran qutuγtu-yin qariyatu šabi-yin nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Наран хутагтын шавь



**Хошууны нэр:** Наран хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Хүрээ-Марал уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-32

**Он:** 1914 (Олноо өргөгдсөний 4 Он аан сарын шинийн 3)

**Хэмжээ:** 58 см х 56 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Баянхонгор аймаг. Баянбулаг сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан эсэх нь сайн мэдэгдэхгүй байна.

Хилийн овоог дөрвөлжин дүрсээр тэмдэглэж газар усны нэр, тайлбарыг тойруулан бичжээ. Зургийн суурийг нилэнхүйд нь цэнхэр өнгөөр будаад тайлбарыг хар бэхээр бичсэн байна. Уул, гол мөрөн, тал хээр зэрэг газарзүйн биетүүдийг хар бэхээр зуржээ. Хадтай уулсыг хар хүрэн өнгөөр будсан байна. Хятад маягийн загвартай хоёр давхар том сүм зурж урд талаар нь 3 гэр зуржээ. “Энэ дагналттай” хэмээх бичээсийг нутгийн зургийг бүтэн тойруулан бичжээ. Хадгалалт хэвийн.

**157. Нутгийн зургийн нэр:** Халхын Сайн ноён аймгийн засаг төрийн жүн ван Гэлэгжамцын хошууны нутгийн зураг (*qalq-a-yin sayin noyan ayimaγ-un jasaγ-un törü-yin giüyin vang gelegjamču-yin qosiγ-un-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын баруун гарын баруун этгээдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-33

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 140 см х 54 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Баянхонгор аймаг. Бууцагаан, Хүрээмарал, Заг, Жаргалант сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг 6 см х 8 см хэмжээтэй дөрвөлжин тор татаж үйлдсэн байна. Нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг дурдаагүй. Хилийн овоог тэмдэглээгүй. Зургаа тойруулан овооны нэрийг бичжээ. Уул, нуруу, толгод болон хангай газрыг хар бэхээр зурж ногоон өнгөөр давхарлан будсан байна. Гол мөрөн, нуурыг цэнхэр өнгөөр будаад тал газрыг хүрэн өнгөөр буджээ. Хятад маягийн загвартай 1 сүмийг зураад сүмийн хажууд 1 гэр зуржээ. Говь, хангай газрыг ялган дүрслээд модтой уулс, хадтай уул нурууг онцгойлон зуржээ. Хадгалалт хэвийн.

**158. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны албан ёсны нэр:** Халхын хойд замын баруун гарын баруун этгээдийн хойд хошуу

**Хошууны нэр:** Эрдэнэ засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Богд хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-34

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 47 см х 60 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Баянхонгор аймаг. Бууцагаан, Хүрээмарал, Заг, Жаргалант сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татсан, эсэх нь мэдэгдэхгүй байна. Хошууны хилийн овоог тэмдэглээгүй. Хил залгаа хошууны зах нийлсэн газруудыг тэмдэглэжээ. Уулсыг хар бэхээр зураад ногоон өнгөөр будсан байна. Гол мөрөн, нуурыг хөх өнгөөр буджээ. Заг, Байдраг голыг зурж Цагаан нуурыг дүрсэлжээ. Хадгалалт хэвийн.

**159. Нутгийн зургийн нэр:** Бадаргуулт төрийн 33 онд үйлдсэн Халхын умард замын баруун этгээдийн адгийн засаг Бирваарагчаагийн хошууны нутгийн зураг (*badaraγultu törü-yin γučin γurbaduγar on-du üileddügsen qalq-a-yin umaradu jam-un baraγun eteged-ün adaγ-un jasaγ birvaraγca-un qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын баруун этгээдийн адгийн хошуу

**Хошууны нэр:** Баатар засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Шажинбатсэвжидгацал уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-35

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 4)

**Хэмжээ:** 53 см х 30 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Өвөрхангай аймаг. Зүүнбаян-Улаан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Уул, гол мөрөн, нуур, тал хээр зэрэг газар зүйн биетүүдийг товгор дүрслэлийн аргаар зуржээ. Хошууны нутгаар дайран өнгөрөх өртөө замыг зуржээ. 1 сүмийг тод зуржээ. Зургийн цаас уусаж дээрх газар усны нэр, тайлбар уншигдахааргүй болжээ. Хадгалалт муу.

**160. Нутгийн зургийн нэр:** Бадаргуулт төрийн 33 онд үйлдсэн Халхын умар замын дундад умард засаг хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржавын хошууны нутгийн зураг (*badaraγultu törü-yin γučin γurbaduγar on-du üileddügsen qalq-a-yin umar-a jam-un dumdadu umaradu jasaγ kebei beyise-yin jerge güng duγarjab-un qosiγun-u nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Халхын умард замын дундад умард хошуу

**Хошууны нэр:** Хошууч засгийн хошуу

**Хошууны хожмын нэр:** Отгон хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-36

**Он:** 1907 (Бадаргуулт төрийн 33 он 9 сарын шинийн 4)

**Хэмжээ:** 64 см х 65 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Отгон, Цагаанчулуут, Цагаанхайрхан сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Овооны нэр, газар усны нэр, тайлбарыг тойруулан бичжээ. Уулсыг хар бэхээр зурсан байна. Зарим уулын оройг модтой дүрсэлжээ Гол мөрөн, булгийг хар бэхээр зураад хөх өнгөөр буджээ. Улиастайн цэргийн хүрээг дөрвөлжин дүрсээр тэмдэглэж нэрийг нь бичжээ. Суурин газруудыг хоёр тэгш өнцөгт дүрсээр тэмдэглэжээ. 2 сүм зуржээ. Зураг урсаж балархайшсан байдалтай. Зургийн ихэнхи хэсгийг газар усны нэр, тайлбар эзлэнэ. Хадгалалт хэвийн.

**161. Нутгийн зургийн нэр:** Олноо өргөгдсөний гуравдугаар дугаар онд үйлдсэн Нару ванчин хутагтын шавийн нутгийн зураг (*olan-a ergügdegsen-ü yurbaduγar on-du üiledügsen naruvančīn qutuγtu-yin qariyatū šabi-yin nutuγ-un jiruγ*)

**Хошууны албан ёсны нэр:** Нару ванчин хутагтын шавь

**Хошууны нэр:** Нару ванчин хутагтын шавь

**Хошууны хожмын нэр:** Отгон хайрхан уулын хошуу (1923-1931)

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-37

**Он:** 1913 (Олноо өргөгдсөний 3 дугаар он 10 сарын 17)

**Хэмжээ:** 32 см х 37 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цагаан даавуу

**Тамга:** Тамга 1 удаа дарсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Завхан аймаг. Шилүүстэй сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Хилийн овоог тэмдэглээгүй. Овооны нэр, газар усны нэр, тайлбарыг тойруулан бичжээ. Уулсыг хар бэхээр зураад зарим уулын оройг модтой дүрсэлжээ. Гол мөрөн, булгийг хар бэхээр зураад хөх өнгөөр будсан байна. Улиастайн цэргийн хүрээг дөрвөлжин дүрсээр тэмдэглэж нэрийг нь бичжээ. Суурин газруудыг хоёр тэгш өнцөгт дүрсээр тэмдэглээд 2 сүм зуржээ. Зураг урсаж балархайшсан байдалтай. Зургийн ихэнхи хэсгийг газар усны нэр, тайлбар эзлэнэ. Хадгалалт хэвийн.

**162. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Сэцэн хан, Засагт хан, Түшээт хан аймгийн цагдах газрыг тэмдэглэсэн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-3, хад. нэгж-38

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 47 см х 71 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Архангай, Завхан, Хөвсгөл, Булган

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Дугуй хүрээ татаж дотор нь хар бэхээр уулс, гол мөрөн, булаг шанд, суурин газруудыг зуржээ. Зургийн дундуур ягаан бэхээр шулуун шугам 4 хэсэгт хуваан татсан байна. Тойруулан гурван аймгийн цагдах газрын нэрийг бичжээ. Зургийн дэлгэрэнгүй тайлбарыг зүүн доод буланд хоёр хэсэг болгон бичсэн байна. Уг зургийн зүүн дээд хэсэг нь үрэгдэж алга болжээ. Бичвэрүүд нь бүдгэрчээ. Хадгалалт муу.

#### **4.4. ХОВДЫН ХЯЗГААРЫН НУТГИЙН ЗУРАГ**

Данс.МНЗ-IV

**163. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-1

**Он:** 1890 (Бадаргуулт төрийн 16 он 6 сарын 28)

**Хэмжээ:** 63 см х 110 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 2 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Увс аймаг. Завхан, Хяргас, Малчин, Зүүнговь, Тэс, Давст сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг хүрд ашиглаж зурсан байна. Тор татаагүй ажээ. Увс, Хяргас нуурыг хөх өнгөөр угалзлуулан дүүргэж зурсан. Уулсыг цэнхэр, улаан, хүрэн өнгөөр, нуур, гол мөрнийг хөх өнгөөр будсан. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг дүрсэлсэн. Нэмэлт тайлбарыг улаан цаасан дээр бичиж наажээ. Нэг дор хоёр тамга дарсан байна. Хадгалалт хэвийн байна.

**164. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-2

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 78 см х 79 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Увс аймаг. Завхан, Хяргас, Малчин, Зүүнговь, Тэс, Давст сум

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг хүрд ашиглаж зурсан байна. Тор татаагүй ажээ. Увс, Хяргас нуурыг хөх өнгөөр угалзлуулан дүүргэж зурсан. Уулсыг цэнхэр, улаан, хүрэн өнгөөр, нуур, гол мөрнийг хөх өнгөөр будсан. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замыг дүрсэлсэн. Нэмэлт тайлбарыг улаан цаасан дээр бичиж наажээ. Нэг дор хоёр тамга дарсан байна. Хадгалалт хэвийн байна.

## ХАЛХ-БАРГЫН ХАРУУЛЫН НУТГИЙН ЗУРАГ

### Данс.МНЗ-V

**165. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошуу Баргатай зах нийлэх нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-1

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 21 он таван сарын 18)

**Хэмжээ:** 80 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Халх гол сум

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Тарваган дах уулын Хайч овооноос Соёлз уул хүртэл хил харуулыг тэмдэглэжээ. Хилийн овоог гурвалжин дүрсээр, харуулыг дугуй дүрсээр тэмдэглэж, хүрэн өнгөөр буджээ. Харуул, хилийн овооны хооронд цэг хатган холбожээ. Гол мөрөн, нуур цөөрмийг ногоон өнгөөр, уулсыг хөх өнгөөр буджээ. Зургийн дээд хэсэгт улаан өнгөөр хожуу 1849 гэж бичсэн байна. Зургийн дүрслэл тод, хадгалалт хэвийн.

**166. Нутгийн зургийн нэр:** Хөлөн Буйр газрын Халхын Сэцэн хан аймгийн засаг төрийн жүн ван Тогтохтөрийн хошууны хамт нутгийн зах нийлэх газар орныг байцаан шийтгэж, хоёр этгээд нийлж нэгэн адил үйлдсэн зах хөвөөний газар орны зураг (*kulun buir ba-i qalqai ōeŋen han aimaγ-i jasaγ doroi giγün wang toγtohoturu-i γūsai emgi nuγtei ujen ačara ba na-be baičame ičihiyafi juwe ergi ačafi emu adali araha ujen hešen-i ba na-i niruγan*)

**Хошуу нутаг:** Сэцэн хан аймгийн Илдэн засаг Тогтохтөрийн хошуу Баргатай зах нийлэх нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-2

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он 5 сарын 18)

**Хэмжээ:** 48 см х 56 см

**Бичвэрийн хэл:** Манж хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймгийн нутаг

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Харуулын хоёр захын хязгаарыг улаан бэхээр тэмдэглэж, харуулын овоог гурвалжин дүрсээр зурсан. Нэр тайлбарыг манжаар бичиж тэмдэглэсэн. Уулсыг цэнхэр ногоон өнгөөр давхарлан буджээ. Зургийн хадгалалт хэвийн байна.

**167. Нутгийн зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн засаг төрийн жүн ван Тогтохтөрийн хошуу, Хөлөн Буйрын Хүрээт шинэ Барга лугаа нутгийн хязгаар нийлэх газар орныг байцаан хоёр этгээд нийлж нэгэн адил бичсэн хязгаар хэлхээний газар орны зураг (*qalq-a-yin seŋen qan ayimaγ-un jasaγ törü-yin geyün wang toγtaqutörü-yin qosiγu, kölün buyir-un küriyetü sin-e barγu luγ-a nutuγ-un kijaγar neyilekü γajar orun-ni baičaγan qoyar eteged neyilejü nigen adali bičigsen kijaγar kilkiy-e-ü γajar orun-u jiruγ*)

**Хошууны нэр:** Халхын Сэцэн хан аймгийн Илдэн засаг ван Тогтохтөрийн хошууны Хөлөн Буйрын Баргатай зах нийлэх нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-3

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он 5 сарын 10)

**Хэмжээ:** 53 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Халх гол сум

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Улаан шунхаар харуулын овооны хоорон дахь зайг зурсан. Овоог бадамлан асаж буй зул хэлбэртэй дүрсэлсэн. Харуулын зураг Орхон гол, Буйр нуурыг дайран гарсан байна. Уулс, голыг хар бэхээр зурж нэр, тайлбарыг хар бэхээр бичжээ. Зургийн хадгалалт сайн.

**168. Нутгийн зургийн нэр:** Халхын Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж Минжүүрдорж миний хошуу Шинэ Барга лугаа нутгийн зах нийлсэн газрыг байцаан шийтгэж, хоёр этгээд нийлж нэгэн адил бичсэн зах хэлхээний газрын зураг (*qalq-a-yin sečen qan ayimaγ-un jasaγ-un terigün jerge tayiji mingjürdorji minu qosiyu sin-e barγu luγ-a nutuγ-un jiq-a neyilegsen γajar-yi bayiĉayan sidkejü, qoyar eteged neyilejü nigen adali biĉigsen jiq-a kelkiyen-ü γajarun jiruγ*)

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн харуул

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-4

**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он 5 сарын 16)

**Хэмжээ:** 52 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл, манж хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Чойбалсан, Булган, Баянтүмэн, Сэргэлэн, Гурван загал сум

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Харуулын хоёр зах хязгаарыг улбар шунхаар зурж, харуулын гол овоог дугуй дүрсээр тэмдэглэж улбар өнгө бүхий тэмдэгээр зурсан. Буйр нуурын өмнөд хойд хэсгийн харуулыг тэмдэглэсэн. Тайлбар, нэрийг монгол, манж хэлээр бичсэн. Туслагч Цэрэнгэмпил бат, захирагч Үржингэмпил үнэн гэсэн гарын үсэгтэй ажээ.

**169. Нутгийн зургийн нэр:** Хөлөн буйр ба Халхын Сэцэн хан аймаг засгийн оч зэрэг тайж Мижиддоржийн хошууны нутгийн зураг (*kölün buyir ba qalq-a-yin sečen qan ayimaγ jasaγ-un oĉi jerge tayiji mijiddorji-yin qosiyun-u nutuγ-un jiruγ*)

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн харуул

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-5

**Он:** 1835 (Төр гэрэлтийн 16 он)

**Хэмжээ:** 42.5 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Харуулын хоёр захын хязгаарыг улбар шунхаар тэмдэглэж, харуулын гол овоог дугуй, улбар өнгө бүхий хүрээт тэмдэгээр тэмдэглэсэн. Халхын Ар булгаас Шивээт уул хүртэлх харуулын хэсгийг зурсан. Тайлбар бичээсийг манжаар бичжээ.

**170. Нутгийн зургийн нэр:** Хөлөн Буйр газрын Халхын Сэцэн хан аймгийн засаг, тэргүүн зэрэг тайж Минжүүрдоржийн хошууны хамт нутгийн зах нийлэх газар орныг байцаан шийтгэж хоёр этгээд нийлж, нэгэн адил үйлдсэн зах хөвөөний газар орны зураг (*kulun buir ba-i qalqai ceceen han aimaγ-i jasaγ uju jergi taiji mingjurdorji-i γūsai emgi nuγtei ujan ačara ban a-be baičame ičihuyafi juwe ergi ačafi emu adali araha ujan hešen-i ba na-i niruγan*)

**Хошуу нутаг:** Халхын Сэцэн хан аймгийн Ачит засаг Минжүүрдоржийн хошууны Хөлөн Буйрын Баргатай зах нийлэх нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-6

**Он:** 1849 (Төр гэрэлтийн хорин есдүгээр он таван сарын)

**Хэмжээ:** 48 см х 43 см

**Бичвэрийн хэл:** Манж хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Чойбалсан, Булган, Баянтүмэн, Сэргэлэн, Гурван загал сум

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Харуулын хоёр захын хязгаарыг улбар шунхаар тэмдэглэж, харуулын гол овоог дугуй, улбар хүрээт тэмдэгээр тэмдэглэсэн. Халхын Ар булгаас Шивээт уул хүртэлх харуулын хэсгийг зурсан. Тайлбар бичээсийг манжаар бичжээ.

**171. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн харуул

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-7

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 46 см х 38 см

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод. Хэнтий аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Буйр нуур, Хөлөн нуурыг багтаан зуржээ. Зарим хэсгийн тайлбарыг улаан цаасан дээр бичиж наажээ. Зургийн тайлбарыг манжаар бичжээ.

**172. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Халх-Баргын Хөвөлзөхөөс Хавцгайт хүртэлх харуулын нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-8



**Он:** 1849 (Төр гэрэлтийн 29 он 5 сарын 18)

**Хэмжээ:** 77 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Харуулын хоёр захын хязгаарыг улаан бэхээр тэмдэглэж, харуулыг улаан өнгийн дугуй дүрсээр, хилийн овоог улаан өнгийн гурвалжин дүрсээр тэмдэглэжээ. Уулсыг хөх, нуур цөөрөм булгийг ногоон өнгөөр буджээ. Халхын Хөвөлзөх харуулаас Соёолж уул хүртэл томоохон орон зайг хамруулан зурсан байна. Зарим тайлбарыг улаан цаасан дээр бичиж наасан боловч хууларч унасан ажээ. Зурган дээр хятад ханзаар хожуу тайлбар бичсэн байна. Зургийн хадгалалт хэвийн.

**173. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн хайч, хязгаар овоо харуулын зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-9

**Он:** 1841 (Төр гэрэлтийн 21 он 5 сарын 18)

**Хэмжээ:** 80 см х 47 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга 1 удаа дарж баталгаажуулсан

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Уг зурагт зүг чигийг тэмдэглэсэн байна. Тор татаагүй ажээ. Тарваган дах уулын Хайч овооноос Соёлз уул хүртэл хил харуулыг тэмдэглэжээ. Овоог улаан өнгө бүхий гурвалжин дүрсээр, харуулыг улаан өнгийн дугуй дүрсээр тус тус тэмдэглэжээ. Харуулууд болон хилийн овооны хооронд улаан бэхээр шугам татан холбожээ. Гол мөрөн, нуур цөөрмийг ногоон, уулсыг хөх өнгөөр будсан байна. Хадгалалтын нөхцөл дунд зэрэг.

**174. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн харуулын зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-10

**Он:** Бичээгүй

**Хэмжээ:** 52 см х 32 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Хар

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг, БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг тэмдэглээгүй. Уулс, гол мөрөн, булаг шанд, харуулыг хар бэхээр зуржээ. Хилийн овоог дугуй дүрсээр тэмдэглэж хооронд нь цэг хатган холбожээ. Харуулын нутгийг тэмдэглэсэн байна. Зурагт Буйр нуур, Хөлөн нуурыг багтаан зуржээ. Зургийн тайлбарыг манжаар бичжээ. Хадгалалт хэвийн.

**175. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Шинэ Барга хошуу

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-11

**Он:** 1849

**Хэмжээ:** 63 см х 64 см

**Бичвэрийн хэл:** Манж хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Хүрд ашиглаж зурсан. Тор татаагүй байна. Буйр нуурын сав дахь Шинэ Баргын газар нутгийг дүрсэлжээ. Уулсыг хар бэхээр зурсан. Гол мөрөн, нуурыг зурж хөх өнгөөр будсан. Газар усны нэрийн ихэнхи тайлбарыг хар бэхээр бичсэн ба нэмэлт тайлбаруудыг улаан цаасан дээр бичиж наажээ. Хошууны нутаг дахь сүм хийдүүдийг дүрсэлсэн. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замуудыг зуржээ. Зургийн газар усны нэр, тайлбарыг манжаар бичжээ. Хэд хэдэн цагаан цаасыг зүүж наан зургаа үйлдсэн байна.

**176. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Халх-Баргын нутгийн харуул

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-12

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 47 см х 39

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Хар цагаан

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг, БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зурагт тор татаагүй байна. Зүг чиг тэмдэглээгүй. Уулс болон гол мөрнийг хар бэхээр зуржээ. Буйр нуур, Хөлөн нуурыг багтаан зурсан байна. Зарим газар усны нэр, тайлбарыг улаан цаасан дээр бичиж наажээ. Газар усны нэр, тайлбаруудыг манжаар бичжээ. Хадгалалт хэвийн.

**177. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Хөлөн Буйрын Барга нарын нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-13

**Он:** 1849 (Төр гэрэлтийн хорин есдүгээр он таван сарын арван найман)

**Хэмжээ:** 74 см x 74 см

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг хүрд ашиглан зуржээ. Тор татаагүй байна. Буйр нуурын сав дахь Шинэ Баргын газар нутгийг дүрсэлжээ. Уулсыг хар бэхээр зураад шар, цэнхэр өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, нуурыг ногоон өнгөөр будсан байна. Нутгийн зурагт харуулыг улаан өнгийн гурвалжин, дугуй дүрсээр тэмдэглээд хооронд нь улаан зураасаар холбожээ. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замуудыг улбар өнгөөр зурж, өртөөний суурингуудыг улаан өнгөтэй дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Газар усны нэрийн ихэнхи тайлбарыг хар бэхээр бичсэн ба нэмэлт тайлбаруудыг улаан цаасан дээр бичиж наажээ. Зургийн газар усны нэр, тайлбарыг манжаар бичжээ. Хэд хэдэн цагаан цаасыг зүүж наан зургаа үйлдсэн байна.

**178. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Хөлөн Буйрын Барга нарын нутгийн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-14

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 63 см x 64 см

**Бичвэрийн хэл:** Манж хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** БНХАУ. ӨМӨЗОрон. Хөлөн буйр аймаг

**Товч тодорхойлолт:** Уг нутгийн зургийг хүрд ашиглан зуржээ. Тор татаагүй байна. Буйр нуурын сав дахь Шинэ Баргын газар нутгийг дүрсэлжээ. Уулсыг хар бэхээр зураад ногоон болон цэнхэр өнгөөр давхарлан буджээ. Гол мөрөн, нуурыг ногоон өнгөөр буджээ. Газар усны нэрийн ихэнхи тайлбарыг хар бэхээр бичээд нэмэлт тайлбаруудыг улаан цаасан дээр бичиж наажээ. Хошууны нутагт буй сүм хийдүүдийг хар бэхээр зураад улаан өнгөөр давхарлан будсан байна. Нутгийн дундуур дайран өнгөрөх өртөө замуудыг улбар өнгөөр зурж, өртөөний суурингуудыг улаан өнгөтэй дөрвөлжин дүрсээр тэмдэглэжээ. Харуулуудыг дугуй улаан өнгөөр зуржээ. Зургийн газар усны нэр, тайлбарыг манжаар бичжээ. Хэд хэдэн цагаан цаасыг зүүж наан зургаа үйлдсэн байна. Хадгалалт хэвийн.

#### **4.6. БУСАД НУТГИЙН ЗУРАГ**

Данс МНЗ.VI

- 179. Нутгийн зургийн нэр:** Ноёдын оршуулгыг тэмдэглэсэн газар орны зураг  
**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-4, хад. нэгж-16  
**Он:** Он бичээгүй  
**Хэмжээ:** 47 см х 71 см  
**Бичвэрийн хэл:** Монгол хэл  
**Өнгө:** Өнгөт  
**Зурсан эд:** Цаас  
**Тамга:** Тамга дараагүй  
**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол Улс. Сэлэнгэ аймаг. Алтанбулаг хот

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Хилийн овоог гурвалжин дүрсээр тэмдэглэж, хүрэн өнгөөр буджээ. Хилийн овооны хооронд хүрэн өнгийн бэхээр цэг хатгажээ. Уулсыг цайвар хөх өнгөөр, гол мөрөн булгийг хөх өнгөөр буджээ. Хадгалалт хэвийн.

**1. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Өртөөний эзэмшил нутаг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-7, хад. нэгж-2

**Он:** Тамга дараагүй

**Хэмжээ:** 24 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Манж

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Тодорхойгүй

**Товч тодорхойлолт:** Уг зураг нь өртөөний эдэлбэр газар нутгийг тэмдэглэсэн манжаар бичсэн зураг юм. Нэр болон зургийг үйлдсэн Он ийг бичээгүй байна. 4 өртөөний газар нутгийг зуржээ. Гол, нуур цөөрмийг хар бэхээр зурж хөх өнгөөр буджээ. Тариалан эдэлбэр газрыг ногоон өнгөөр будсан байна.

**2. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Хулгай этгээдийн оргосон газар орны зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-6, хад. нэгж-83

**Он:** Он бичээгүй

**Хэмжээ:** 47 см х 71 см

**Бичвэрийн хэл:** Монгол

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол Улс.

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Хилийн овоог гурвалжин дүрсээр тэмдэглэж, хүрэн өнгөөр буджээ. Хилийн овооны хооронд хүрэн өнгийн бэхээр цэг хатгажээ. Уулсыг цайвар хөх өнгөөр, гол мөрөн булгийг хөх өнгөөр буджээ. Зарим газар усны нэрийг цагаан цаасан дээр бичиж наасан боловч гээгдсэн байна. Сүм хийдийн эдэлбэр газрыг дугуй хүрээгээр дүрслэн дотор талд нэрийг нь бичжээ. Зургийн баруун доод буланд дэлгэрэнгүй тайлбар бичсэн байна. Хадгалалт хэвийн.

**3. Нутгийн зургийн нэр:** Нэр бичээгүй

**Хошуу нутаг:** Ачит засаг Минжүүрдоржоос Баргатай шинээр байгуулсан хил, овооны зургаас хуулбарлан өргөсөн зураг

**Архивын хөмрөг, данс, хад. нэгж:** Монгол нутгийн зураг, данс-1, хад. нэгж-12

**Он:** Он бичээгүй (1850 ?)

**Хэмжээ:** 45 см х 53 см

**Бичвэрийн хэл:** Монгол хэл

**Өнгө:** Өнгөт

**Зурсан эд:** Цаас

**Тамга:** Тамга дараагүй

**Өнөөгийн засаг захиргаа:** Монгол улс. Дорнод аймаг. Чойбалсан, Баянтүмэн Чулуун хороот, Матад сумд

**Товч тодорхойлолт:** Уг зурагт хүрд ашиглаагүй, тор татаагүй байна. Хилийн овоог гурвалжин дүрсээр тэмдэглэж, хүрэн өнгөөр буджээ. Хилийн овооны хооронд хүрэн өнгийн бэхээр цэг хатгажээ. Уулсыг цайвар хөх өнгөөр, гол мөрөн булгийг хөх өнгөөр буджээ. Зарим газар усны нэрийг цагаан цаасан дээр бичиж наасан боловч гээгдсэн байна. Сүм хийдийн эдэлбэр газрыг дугуй хүрээгээр дүрслэн дотор талд нэрийг нь бичжээ. Зургийн баруун доод буланд дэлгэрэнгүй тайлбар бичсэн байна. Хадгалалт хэвийн.

## ДҮГНЭЛТ

Дээрх архив, номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй XVIII–XX зууны эхэн үеийн нутгийн зургууд нь Монголын аймаг, хошуудын нутаг дэвсгэр, газарзүйн төлөв байдал, нутгийн захын овоод, уул овоодын нэрс, зүг чиг, засаг ноёдын орд өргөө, гол сүм хийд, хилийн харуул, өртөө, замын чиглэл, Халх-Баргын нутгийн зах заагийг судлах түүхэн газарзүйн чухаг сурвалж юм.

Монголчууд нутаг дэвсгэрээ хэд хэдэн удаа зурж үзэж баримжаа тогтож байсныг Сайн ноён аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зургийн хувирал өөрчлөлтөөс харж болдог. Тус хошууны нутгийн зураг 12 байгаагаас эхэн үеийн нутгийн 2 зурагт ямар нэгэн гарчиг, он цаг, ертөнцийн зүг зүгийг тавиагүй, нутгийнхаа цөөн хэдэн уул, нуурыг зурж бичсэн байдаг. Харин дараа дараагийн зурагт зүг чигээ тавьж, олон уул овоо, ус нуур зэргийг нэмэн зурж бүрэн гүйцэд дүрсэлж тэмдэглэх болсон байна.

Халхын аймаг, хошуудын нутгийн хил заагийг зарим үед чуулганаар хэлэлцэн тогтоодог байсныг нутгийн зурагт дахь тэмдэглэл бичвэр харуулна. Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зурагт бичсэнээр тус хошууны нутгийн дөрвөн захыг 1772 оны Ширээ нуурын чуулганаар тогтоож байсан ажээ. Энэ зөвхөн нэг хошууны талаарх мэдээ хэдий ч Халх Монголын бусад олон хошуудын нутгийг бас чингэж тогтоосон гэсэн үг билээ. Тодотгон хэлбэл, Халхын ноёдын Ширээ нуурын чуулганаар ганц хошууны нутгийг бус, олон хошуудын нутаг дэвсгэрийн зах заагийг тогтоожээ хэмээн үзнэ.

Мөн нөгөөтэйгүүр Монголын хошуудын нутгийн зах хязгаарыг тогтоох нь уг хэрэгтээ олон жил үргэлжилсэн үйл явц байсныг нутгийн зураг бүрэн нотолно. Бидний олонх судлаачид Монголын хошуудыг байгуулахад нутаг бэлчээр тасалж өгөөд хил заагийг тэр даруй тогтоож байсан хэмээн боддог нь өрөөсгөл ойлголт ажээ. Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зах заагийг тогтоох үйл явц Мөнгө, Сономцэмбэл, Пагважав, Чивагжав гэсэн дөрвөн засаг ноёныг дамнан 1742-1792 оны хооронд явагдсан байна. Бусад хошууд ч ийм үйл явцаас ангид байж чадаагүй нь илэрхий юм.

Хошууны засаг ноёдын угийн бичигт тухайн ноёны захирч байсан хошууны нутгийн дөрвөн захын газрыг тэмдэглэдэг байсан тухай мэдээг Бишрэлт засгийн хошууны нутгийн зурагт бичиж үлдээжээ. Энэ нь нутгийн зураг судлахад бусад бичгийн сурвалжийн мэдээг давхар ашиглахын чухлыг сануулж буй хэрэг юм.

Зарим үед зэргэлдээ орших хошуудын нутгийн зургийг нэг хүн зурдаг явдал байжээ. 1907 онд Халхын Сайн ноён аймгийн Сайн ноён Намнансүрэнгийн хошуу (9-р сарын шинийн 10), түүний урд талын Ёст засаг Балдангийн хошуу (9-р сарын шинийн 4), зүүн талын Илдэн засаг Дондовжанцангийн хошуу (9 сарын шинийн 3), хойд захын Мэргэн засаг Мөнх-Очирын (9 сарын шинийн 6) хошууны нутгийн зургийг нэг хүн зурж, бичсэн нь зургийн гарчиг, зурсан байдал, тайлбар бичвэрийн адил төстэй байдлаас илт мэдэгдэнэ. Морь унасан түшмэд долоо хоногийн дотор дөрвөн хошуугаар явж нутгийн зургийг үйлдсэн гэдэгт хэн ч үнэмшихгүй. Таамаглахул, Сайн ноён аймгийн чуулган даргын газарт хадгалж байсан дээрх хошуудын өмнөх нутгийн зургийг нэг хэлбэр болон бичлэгт оруулан шинэчлэн зурж, бичсэн байна. Чингэх болсны гол учир нь 1907 онд Монгол хошуудын нутгийн зургийг шинээр зурж ирүүлэх тухай Манжийн хааны зарлиг гарсныг биелүүлэх гэж яаравчилсантай холбоотой биз ээ.

1869, 1883 онд Ар Монголын баруун хойд нутаг дэвсгэрээс багагүй газрыг Хаант Орос улсад таслан өгснийг<sup>65</sup> Дөрвөд хоёр аймгийн нутгийн зургаас харж болдог. Мөн Дөрвөд хоёр аймгийн ноёдоос Дамбийжанцан хутагтад нутаг өргөж байсан, түүний эзэмшил болох “Ноён хутагтын шавь” хошууд байгуулсан зэрэг нь нутгийн зурагт тэмдэглэгдэн үлджээ.

Хошуудын нутгийн зургаас тэр нутагт адгуулж байсан албаны тэмээ мал, тариалангийн тухай мэдээг олж харна. Эл мэдээлэл нэн товч, тодорхойн дээр чухам байрлалыг нь зураглан харуулснаараа бичгийн мэдээнээс илүү ач тустай. 1868 оны үед Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин засгийн хошуунд 68 газар тариа тарьдаг байсныг гэж тэмдэглээд “Монгол амуугийн газар” гэж бичжээ. Мэдээж тэдгээр нь ноёд язгууртнууд, сүм хийд лам нар, энгийн ардын “амь ульжих тариалан” байсан бололтой. XX зууны эхэн үед Эрдэнэ засаг Намсрайн хошууны 76 газар тариа тарьж байсныг улаан хүрэн өнгөөр зурж, хэний тариа болохыг бичсний дийлэнх хятад иргэдийнх, цөөнх нь Монголын сүм хийдийнх байв. Мөн аймгийн Түшээт засгийн хошууны нутаг дэвсгэрт албаны тэмээн сүрэг, Дөрвөдийн хоёр аймгийн нутагт албаны адуу адгуулж байсныг нутгийн зурагт тэмдэглэжээ.

Цөөнгүй нутгийн зурагт үндсэн дүрслэл, бичвэрийн гадуур дугуй хүрээ татаад 24 зүг чигийг дарааллын дагуу тойруулан бичсэн байдаг. Харин Түшээт хан аймгийн Үйзэн засаг Түдэвдоржийн хошууны нутгийн зурагт тэдгээрийг зүг (гахай зүг), өнгө (цагаагчин

<sup>65</sup> Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгийн зургаар нягтлах нь. Акта Хисторика. т.XIX. УБ., 2018. т. 144-156

өнгө), өнцөг (эвэрхүү өнцөг), зовхис (мөнх зовхис) дөрвөөр тодотгон тэмдэглэсэн нь их онцлог юм.

Нутгийн зурагт уул нуруудын өндрийг газар, хувь, алд гэсэн уртын хэмжүүрээр бичихээс гадна өргөнийг бичсэн тохиолдол нэг бус удаа тааралдана. Түшээт хан аймгийн Үйзэн засаг Түдэвдоржийн хошууны нутгийн зурагт “Буурал хан уул, өндөр нь найман газар, өргөн нь таван газар таван хувь” гэх мэтээр том уул нуруудын өндөр ба үргэлжлэх урт өргөнийг хамтад бичжээ.

Зарим нутгийн зурагт тухайн хошууны нутаг дэвсгэрийг урдаас хойш, баруунаас зүүн тийш болон эргэн тойрон ямар хэмжээтэй, нийт хэдэн захын овоотой зэрэг нутгийн цэсэнд байдаг мэдээллийг товчоор бичиж оруулсан байдаг. Сонирхолтой нь, Түшээт хан аймгийн Бишрэлт засаг Сундуйн хошууны нутгийн зурагт баруун өмнөх зовхисоос зүүн хойдох зовхис хүртэл, баруун хойдох зовхисоос зүүн өмнөх зовхис хүртэл хэмжиж бичсэн байдаг.

Дийлэнх нутгийн зурагт нэг бол уул нуруудын өндрийг, нөгөө бол тэдгээрийн үргэлжлэх уртыг өгүүлсэн байдаг ахул Сэцэн хан аймгийн Эрхэмсэг засаг Цэрэннямын хошууны 1897 оны нутгийн зурагт булаг, бүрд, голын урсацын үргэлжлэх уртыг газар, хувь, алдаар хэмжиж бичжээ. Цөөн нутгийн зурагт голын урсгалын чигийг зааж бичсэн байна. Сэцэн хан аймгийн Илдэн засаг Тогтохтөрийн хошууны 1864 оны нутгийн зурагт “зүүн этгээдээс баруун тийш урсах Халх гол” гэж бичжээ. Бас зарим хошууны нутгийн зурагт өөрийн нутгаар дайран явах гол замын уртыг бас хэмжиж бичсэн байдаг. Сэцэн хан аймгийн Хурц засаг Түдэнгийн хошууны 1907 оны нутгийн зурагт “энэ Их Хүрээний зам, нэг зуун дөчин хоёр газар” хэмээн бичжээ.

Их Юань улсын төгсгөл үед холбогдох Хэрлэн Барс хотын туурин дээр хоёр том суварга байсныг 1805 оны Сэцэн хан аймгийн Саруул засгийн хошууны нутгийн зургаас мэдэж авна. Одоо тэнд саяхан сэргээн засварласан ганц суварга буй. Мөн Сэцэн хан аймгийн Саруул засгийн хошуунд Чингис хааны хар сүлдийг Баян эрхт уулын орой дээр хадгалж, тахиж байсныг ихэд бодит байдлаар зурж үлдээжээ.

Монгол нутгийн зураг түүхийн сурвалжийн нэг төрөл болохын хувьд бусад баримт бичигт буй алдаатай зүйлийг залруулж өгдөг ач тустай. Үүнд тухайлан хошууны засаг ноёдын нэр усыг дурдаж болох юм. “Монгол улсын илтгэл шастир”-т Түшээт хан аймгийн Эетэй засгийн хошууны ноён Агваандоржийн нэрийг Наваандорж хэмээн, Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошууны ноён Дондовжанцангийн нэрийг Дэндэвжанцан гэж буруу бичснийг тэдгээр хошууны нутгийн зургийн гарчигаас мэдэж авна. Хошууны нутгийн зурагт засаг ноёныхоо нэрийг буруу бичнэ гэдэг ямар ч үндэсгүй юм.

Манжийн засаг захиргаанаас Чуулалт хаалга-Улиастайн өртөө байгуулахдаа хошуудын нутаг дэвсгэрээс газар таслан өгснийг нутгийн зургаас тодорхой мэдэж авна. Түшээт хан аймгийн Эетэй засаг Агваандоржийн хошууны нутгийн зурагт өөрийн хошууны нутгаас “цэргийн өртөөдөд тавин олгосон нутгийн захад анх овоо тэмдэг байгуулах” болсон тухайгаа бичиж, тэдгээр захын овоодыг тэмдэглэсэн байдаг.

Монгол нутагт оршиж байсан өртөөний болон худалдааны замуудын нэр ус, явах чиглэл, суурин өртөөдийн байрлал, харьяалах нутаг бэлчээрийг тодруулах хамгийн чухал сурвалж нь хошуудын нутгийн зураг болж байна. Чуулалт хаалганаас Улиастай хүрэх гол өртөөний замын дагуух Түшээт хан, Сайн ноён аймгийн 13 хошууны нутгийн зургаас ямар өртөө аль хошууны нутагт, чухам хаана байсныг мэдэж тодруулна.

Халхын нутгийн зах хязгаарыг хятадууд нууцаар даван байгалийн баялаг ухаж олзворлох, ан хийх, ховор өвс ургамал түүх явдлыг зогсоохоор 1782, 1788 онд Алтайн нурууны урдуур говь цөл нутагт байгуулсан Алтны харуул чухам хаана байсныг хошуудын нутгийн зургаас харж болдог.<sup>66</sup> Алтны харуул нийт 20 байсны зүүн захын Хорсуун, Боом, Таац, Зулхунай гэсэн 4 харуул Сайн ноён аймгийн Ёст засгийн хошууны баруун өмнө

<sup>66</sup> Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2002. т. 148, 206



хэсэгт, Эрдэнэ бандида хутагтын шавийн урд хэсэгт Бамбуу харуул байсныг тэдний нутгийн зурагт тэмдэглэсэн ажээ.

Нутгийн зургаас уул усны нэрийн хувирал өөрчлөлтийг тод томруун харж болно Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутагт буй Инэл уул (хайрхан) эдүгээ Дэлгэрхангай уул, мөн хошууны нутагт байх Хурган өлөн хэмээх нуур Улаан нуур гэх нэртэй болсон байна. Одоогийн Увс нуурыг тухайн Дөрвөд хоёр аймгийн нутгийн зурагт Усуб нуур гэж бичсэн байдаг нь хожим аман ярианы болон бичгийн хэлэнд Увс нуур болон хэлбэржин тогтжээ.

Дийлэнх хошууны нутгийн зурагт буй ганц нэг хуурамч мэдээллийг дурдах нь зүйн хэрэг билээ. Тэр нь “дөчин ламын ном унших газар” гэж бичээд жижиг дуган зурсан тэмдэглэгээ юм. “Дөчин лам” гэх хэллэг Манжийн төрөөс Монголд лам нар хэт ихэдснийг хязгаарлахаар нэг хошуунд байх ламын тоог 40-өөр тогтоосноос үүдэлтэйг бид мэднэ. Үнэн хэрэг дээрээ лам нар аль хэдийн 40-өөс хол давж, хүрээ хийд, сүм, ном унших газар “жалгын нэг” болсон ч түүнийг нутгийн зурагт тэмдэглэдэггүй, албаны данс хараад бичилгүй явсаар ирсэн билээ. Мөн үүнийг нөгөө талаас нь, хошуудын гол хүрээ хийдийг зурж бичээд бусад хийд, сүм, дуган, хурлын газрыг тэмдэглэлгүй орхидог байсан гэж тайлбарлаж болох талтай. Дарьгангын сүрэгчин хошууны нутгийн зурагт 17 сүм, 3 хурлын газрыг зурж, нэр усыг тэмдэглэсэн нь ховорт тооцогдоно.

Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зураг бол монголчуудын бүтээсэн түүх, соёлын үнэт өвийн нэг юм. Монгол нутгийн зураг нь сурвалж судлал, түүхэн газарзүй, газрын нэр судлал, уран зураг, газарзүйн уламжлалт мэдлэг зэрэг олон салбар ухааны чухал баримт хэрэглэгдэхүүн болдог.

Нутгийн зураг бол түүхэн тодорхой үеийн нутаг дэвсгэрийг цаас, даавуун дээр зурж, тэмдэглэж, бичиж үлдээсэн түүхэн сурвалж, тэр дотроо түүхэн газарзүйн салбар ухааны сурвалж хэрэглэгдэхүүн болдог. Нутгийн зургаас тэр цагийн засаг захиргааны зохион байгуулалтын нэгжүүд болох аймаг, хошууны газарзүйн төлөв байдал, захын овоод, уул овоодын нэрс, засаг ноёдын орд өргөө, гол сүм хийд, өртөө, худалдааны замын чиглэл, албаны мал сүрэг, тариалангийн газрын байрлал зэргийг мэдэж авна.

Монгол нутагт оршиж байсан өртөө, худалдааны замуудын чиглэл, нэр ус, тэдгээрийн байрлал, харьяалах нутаг бэлчээрийг тодруулах чухал сурвалжийн нэг нь хошуудын нутгийн зураг юм. Орос зүг тавьсан гэр харуул, суман харуул, Халх-Баргын нутгийн харуул, Алтайн нурууны өмнөх “Алтны харуул”-ын байрлал, нэрсийг судлах үндсэн баримтын нэг бол нутгийн зураг билээ.

Монголын сүм хийдийн түүхийн судалгаанд нутгийн зураг бас багагүй ач тустай. Дийлэнхи нутгийн зурагт ганцхан “дөчин ламын ном унших газар”-ыг тэмдэглэсэн байдаг ч зарим зурагт хэд хэдэн гол хүрээ хийдийг зурсан байдаг нь тэдгээрийн нэр, байсан газрыг тодруулах чухал баримт болдог.

Нутгийн зурагт монголчуудын газарзүйн уламжлалт мэдлэг, зураг үйлдэх арга барил, түүний хувирал өөрчлөлт тод томруун тусч үлдсэн байдаг. Зургийн гарчиг болон төгсгөлийн бичвэр, ертөнцийн зүг чигийг тодорхойлсон, 24 зүгийн хүрд ашигласан, хэмжээс (масштаб)-ийн дөрвөлжин тор хэрэглэх ёс, газарзүйн биетүүдийн төрөл бүрийн тэмдэглэгээ, өнгө ялгаж зурсан эсэх, уулын өндөр, голын уртыг хэмжиж тэмдэглэсэн, нутгийн захын овоод хоорондын зайн тэмдэглэгээ, тамга дарж баталгаажуулсан, нутгийн өмнөд болон умард зүгээс харж зурсан зэрэг олон зүйлийг мэдэж болно.

Монголын уран зургийн зарим нэгэн дүрслэл болон уламжлалт хээг уул, овоо, мод, гол, мөрөн, нуурыг зурахад ашиглаж байжээ. Голын урсгал, нуурын долгионд төрөл бүрийн хээг ашиглах бол уулыг хурц өнцөгт шулуун үзүүр байдлаар зурсан нь цөөнгүй тааралдана.

Монгол нутгийн зурагт тэмдэглэсэн уул усны нэрс нь газрын нэр судлалын чухал сурвалж хэрэглэгдэхүүн болдог. Мөн нутгийн зургаас уул усны нэрийн хувирал өөрчлөлт тод харагдана. Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутагт буй Инэл уул

(хайрхан) эдүгээ Дэлгэрхангай уул, мөн хошууны нутагт байх Хурган өлөн хэмээх нуур Улаан нуур гэх нэртэй болсон байна. Одоогийн Увс нуурыг тухайн тэр цагийн нутгийн зурагт Усуб нуур гэж бичсэн байдаг нь хожим аман ярианы болон бичгийн хэлэнд Увс нуур болон хэлбэржин тогтжээ.

## **НОМ ЗҮЙ**

### **НЭГ. МОНГОЛ ХЭЛЭЭР**

#### **а. Архивын эх сурвалж, хэрэглэгдэхүүн**

1. Монгол улс. Үндэсний Төв Архив. "Газрын зургийн цуглуулга" хөмрөгийн Манж Чин улсын үеийн байнга хадгалах баримтын данс. (1791-1909). хөмрөг-460, данс-1;
2. Монгол улс. Үндэсний Төв Архив. "Газрын зургийн цуглуулга" хөмрөгийн Богд хаант Монгол улсын үеийн байнга хадгалах баримтын данс (1913-1921). хөмрөг-460, данс-2
3. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-9, д-3, хн-4883, б-2. Хамаарсан да хэбэй түшээ гүнгийн бичиг

4. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-172, б-39. Хар дэл засаг Гомбожавын тамгын туслагч, түшмэдийн бичиг
5. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-172, б-5. Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин хэбэй амбаст өргөсөн бичиг
6. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-9, д-3, хн-5289, б-17. Өргөх цэс
7. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-А-56, д-1, хн-114, б-1. Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас харуул нутгийн зураг өгүүллийг нарийн тодорхой зурж ирүүлэхийг мэдэгдэн тушаасан хэрэг.
8. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-М-31, д-2, хн-5233, б-19. Харьяат аймгийн бүх нутгийн зураг цэс үйлдэж олон хошууны зургуудын хамтаар хүргүүлсэн учрыг сайдтанаа мэдүүлэх бичгийн эх
9. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. х-23. д-1. хн-17. х-57. Ардын засгийн Дотоод явдлын яамнаас Судар бичгийн хүрээлэнд илгээсэн бичиг
10. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Дэвтэр. 45
11. Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. Х-А-47, д-1, хн-139. Хан тайшир уулын чуулган даргын жасаа. хуулга данс
12. МУ-ын ҮНС-ийн Монгол судлал-Гар бичмэлийн сан хөмрөг
13. Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн газрын архив. Монгол нутгийн зургийн сан хөмрөг. Данс-1-6.
14. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986,
15. Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1986;
16. Халхын Засагт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987,
17. Халхын Түшээт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987,
18. Халхын Сайн ноён хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987
19. Гэр харуулын түүхэнд холбогдох архивын баримтууд. I. Халхын Сайн ноён аймгийн гэр харуул. Эмхэтгэсэн Э.Жигмэддорж, Г.Намнансүрэн. УБ., 2019.

#### **б. Судалгааны зохиол**

1. Л.Алтанзаяа. Монголын зарим тамгатай хутагтын шавь нарын нутгийн зургийн асуудалд. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012.
2. Б.Багана. Хятан нарын асуудал. ШУА. Түүхийн хүрээлэн. ГБС.
3. Газрын шинжийн Монгол судар. монгол, англи хэлнээ орчуулсан Б.Няммыгмар. УБ., 2012.
4. Г.Гонгоржав. Монголчуудын эрдэм ухааны уламжлал (эртний үеэс 1920-иод он). УБ., 2008.
5. Б.Гончигдорж. Монголчуудын газар зүйн зургийн түүхийн зарим асуудал. ШУАМэдээ. № 1. 1970.
6. Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2002.
7. Ж.Гэрэлбадрах. Ойрад-Халхын хилийн асуудалд (XVI–XVIII зуун). Studia Historica. t. XXX. УБ., 1997.
8. Ж.Гэрэлбадрах. Илдэн засгийн хошууны газар нутаг, хил хязгаарын тухай. ШУАМ. № 2. УБ., 1996.
9. Ж.Гэрэлбадрах. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нэгэн зургийн судалгаа. УБ., 2015. Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015.

10. Ж.Гэрэлбадрах. Дарьгангын гурван газрын зургийг нягтлах нь. Акта Хисторика. t.XVII. УБ., 2016.
11. Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгаар зургаар нягтлах нь. Акта Хисторика. t.XIX. УБ., 2018.
12. Ж.Гэрэлбадрах. Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн хэдэн зураг. Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. УБ., 2018.
13. Ж.Гэрэлбадрах. Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга. Культурное наследие монголов: Коллекции рукописей и архивных документов. III. УБ., 2019;
14. Ж.Гэрэлбадрах. Даавуун дээр зурсан Монгол нутгийн зургууд (XVIII-XX зууны эхэн). Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал. ЭШ-онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2019.
15. Ж.Гэрэлбадрах. Дундговь аймгийн музейд буй хошууны нутгийн хоёр зураг. Дундговь судлал-II. УБ., 2019.
16. А.Камимүра. Монголын хошуу нутгийн зургийн зураг зүйн хувьсал ба Чин улсын Монгол захиргаа. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012.
17. А.Камимүра. Алтайн Урианхайн долоон хошууны газрын зургийн тухай. Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015.
18. Ш.Мөнхбаатар. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутгийн гурван зураг. УБ., 2018. Евразийн нүүдэлчдийн түүхэн замнал: Төр, нийгэм, соёл” УБ., 2018.
19. Ш.Мөнхбаатар. Жалханз хутагтын шавийн нутгийн хоёр зураг. УБ., 2018. Acta Historica.t.XIX.УБ., 2018.
20. Ч.Нарантуяа. Монгол дахь Монгол гар бичмэл судрын гарчиг. УБ., 2008;
21. Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. Мюнхен. Хирмер хэвлэлийн газар. 2005.
22. Ж.Урангуа. Монгол судлаач Херманн Констен (1878-1957 он). Түүхийн судлал. Tomus. XLVIII. УБ., 2019.
23. Х.Фүтаки. Японы судлаач, цэргийн хүний үлдээсэн XX зууны эхний Ар Монголын зүүн хэсгийн газарзүйн тухай мэдээлэл. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012.
24. Николас Поппе. Дуртгал. Англи хэлнээс орчуулсан М.Саруул-Эрдэнэ. УБ., 2009.
25. О.Пүрэв. XX зууны эхэн үеийн Ар Монгол (1900-1930 он). УБ., 2004.
26. Х.Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959.
27. Э.Равдан. Эртний болон дундад эртний Монгол гүрний нутаг дэвсгэр, газарзүйн биетүүдийн нэр дэлхийн болон бүс нутгийн газрын зурагт туссан тоймоос. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012.
28. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын уламжлалт газрын зураг. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991.
29. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын газрын зургийн уламжлал, түүнийг судалсан тойм, үр дүн. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012.

## **ХОЁР. ГАДААД ХЭЛЭЭР**

### **а. Орос хэлээр**

1. Б.Я.Владимирцов. Объяснения к карте С.-З. Монголии, составленной монголами. ИИРГО. 1911. том. XLVII.
2. Ж.Гэрэлбадрах. Некоторые особенности землевладения в Монгольских хошунах (XVII–начало XIX вв). *Altaica*. t.VIII. М., 2002.
3. Мэнь-гу-ю-му-цзи. Записки о Монгольских кочевьяхъ. Переводъ съ китайскаго П.С.Попова. С-Петербургъ. 1895.
4. Фан Е. История поздней династии Хань, глава 79. Повествование о южных Сюнну. Материалы по истории Сюнну (по китайским источникам) вып. II. Предисловие, перевод и примечания В.С.Таскина. М., 1973.

#### **б. Англи хэлээр**

1. Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014
2. Catalogue of the Mongolian manuscripts in the National library of Mongolia. compiled by Ch.Narantuya and D.Enkhtungalag. Edited by Tachibana Makoto. Bulletin of Waseda institute for Mongolian studies. A separate volume Waseda University. 2011
3. L.Altanzaya. A consideration on Shindai kenryuu-ki kobudo kyouiki-zu (The frontier-area map of Hobd in Qianlong era of Qing dynasty). Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015.
4. Аояма Садао. Юань улсын үеийн нутгийн зургийн тухай (япон хэлээр). The Toho gakuho. VIII. Journal of Oriental studies. 1938. Tokyo.
5. Günter Klüser. Zum Quellenwert von handgezeichneten Altkarten mongolischer Siedlungsgebiete des späten 19. und frühen 20. jahrhunderts-insbesondere im Hinblick auf deren historisch-geographische bearbeitung. Verlag Dr.Kovač. 1999. Hamburg
6. N.Atsushi, Sh.Munkhbaatar. Preliminary Analysis of the Southbound Ikh Khuree Route with Fourteen Relay Stations. Tokyo. 2019. Inner Asian Studies, No.34 Tokyo. 2019.
7. Masaaki Sugiyama. World maps originating in Asia. Changes in History: Real, representative and imaginary. Collection of papers and abstracts on history I. Beyijing forum. 2005.
8. Magaddürin Haltod. Mongolische Ortsnamen. Teil I. (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) –VOHD, Supplementband 5, I, Wiesbaden, 1966
9. In the heart of Mongolia. 100<sup>th</sup> anniversary of W.Kotwicz's expedition to Mongolia in 1912. Cracow. 2012.
10. Inoue Osamu. Old maps showing Erdene zuu monastery from the private archive of prof. W.Kotwicz. In the heart of Mongolia. 100<sup>th</sup> anniversary of W.Kotwicz's expedition to Mongolia in 1912. Cracow. 2012.
11. Landscapes reflected in old Mongolian maps. Edited by F.Hiroshi and K.Akira. Tokyo. 2005
12. Walter Fuchs. The 'Mongol atlas' of China. Monumenta serica. Monograph VIII. Peiping. 1946.
13. Walther Heissig. Mongolische Ortsnamen. Teil II. (Mongolische Manuskriptkarten in Faksimilia) –VOHD, Supplementband 5, 2, Wiesbaden, 1978
14. Heissig, Walther: Mongolische Handschriften, Blockdrucke, Landkarten (Verzeichnis der orientalischen Handschriften in Deutschland, Band 1, Franz Steiner Verlag Wiesbaden, 1961
15. Rashiduddin Fazlullah's Jami'u't-tawarikh: (Compendium of Chronicles. A history of the Mongols. Part three. Section fifteen. English translation and annotation by W.M.Thackston. Cambridge. 1999.

16. Shagdarsürüng. Ts. la connaissance géographique et la carte des Mongols. SM. Tom. III. (11). Fasc. 20. №.1. UB. 1975.

## **ХАВСРАЛТ**

**Эрдэм шинжилгээний өгүүлэл (Зохиогч тус бүрээр):**

### **Ж.Гэрэлбадрах**

1. Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгийн зургаар нягтлах нь. Акта Историка. т.XIX. УБ., 2018. т. 144-156
2. Ж.Гэрэлбадрах. Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн хэдэн зураг. Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. УБ., 2018. т. 79-93

3. Ж.Гэрэлбадрах. Монгол улсын Газар зохион байгуулалт, Геодези зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга. Культурное наследие монголов: Коллекции рукописей и архивных документов. III. УБ., 2019.
4. Ж.Гэрэлбадрах. Даавуун дээр зурсан монгол нутгийн зургууд (XVIII-XX зууны эхэн). Даавуун артай соёлын баримтад өвийн өнөөгийн байдал. ЭШ онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 18-22
5. Ж.Гэрэлбадрах. Дундговь аймгийн музейд буй хошууны нутгийн хоёр зураг. Дундговь судлал-II. УБ., 2019.

### **Ш.Мөнхбаатар**

1. Ш.Мөнхбаатар. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутгийн гурван зураг. Евразийн нүүдэлчдийн түүхэн замнал: Төр, нийгэм, соёл” УБ., 2018. т. 34
2. Nakumara Atsushi, Sh.Munkhbaatar. Preliminary Analysis of the Southbound Ikh Khuree Route with Fourteen Relay Stations. Tokyo. 2019. Inner Asian Studies, No.34 Tokyo. 2019. pp.95-118
3. Sh.Munkhbaatar. qalq-a-yin jasaγtu qan ayimaγ-un jalkangja qutuγtu-yin šabi-yin nutuγ-un qoyar jiruγ. Budapest., 2019. pp.24
4. Ш.Мөнхбаатар, Г.Алтансүх. Монголын нууц товчоон дахь бүрги-ерги-ийн байршлын тухай. УБ., 2020. Монголын нууц товчоон: Түүхэн газар нутгийн судалгаа. УБ., 2020. т.73-78
5. Ш.Мөнхбаатар. Халхын дөрвөн аймгийн өртөөний байршлыг нутгийн зургаар тодруулах нь. УБ., 2020. Монгол нутгийн зургийн судалгааны зарим асуудал. 2020. т.75-136

Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгийн зургаар нягтлах нь. Акта Хисторика. т.XIX. УБ., 2018. т. 144-156

### **ХИХ ЗУУНД АР МОНГОЛЫН БАРУУН ХОЙД ХИЛ ӨӨРЧЛӨГДСНИЙГ ГАЗРЫН ЗУРГААР НЯГТЛАХ НЬ**

### **AN INVESTIGATION OF CHANGES IN THE NORTH-WEST BORDERLINE OF THE QUTER MONGOLIAIN IN THE 19TH CENTURY BY THE MAPS**

*The approval of the border agreement with 10 chapters of Manchu Qing dynasty and Russian Empire on September 25 of 1864 in Tarbagatai (Chuguchak) was the amendment done to the Beijing Treaty of 1860.*

*The demarcation was committed in 5 years later, in 1869. As a result of the agreement, the north-west borderline of the Quter Mongolia was decreased. Firstly, the territory of the two banners of the Oirad Mongols or Altan nuur (Altan lake) Uriankhai were given to the Russian Empire, which had belonged to the Qovd province of the Quter Mongolia.*

*Secondly, Not a small territory of north-west of the Durvud (rear part of Siilkhem range, Galuut lake basin) aimag had to be managed the under Russian control and moved the border guards (sumun qaruul) to the South.*

*Thirdly, another 7 border guards' (sumun qaruul) and land around them were given to Russia, which were located in the northern part of Altai range.*

*However, another 4 border guards (sumun qaruul)'s land of Altai Uriankhai were given to the Russian Empire, which were Shine Khar Tarbagatai, Nisekh taban belchir, Khaljirbas, Maanit gatalgan in 1883.*

*Accordingly, the north-west border of the Quter Mongolia was considerably changed between 1869-1883. With regard to those changes, 11 border guards (sumun qaruul) and the territories around them such as Sogog, Darkhint, Ider, Ukheg, Chandagat, Urluu, Chingistei, Khar Tarbagatai, Nariin, Khul (Khul azarga), Khoni mailakh, were given to the Russian Empire, so the north-west borderline of the Quter Mongolia was decreased. This paper describes the base of maps of Mongolian province (aimag), region (khizgaar) and all the changes marked on those maps.*

Ар Монголын хойд хилийг 1727 оны 8-р сарын 25-нд Манж, Орос хоёр улс Халхын хойд нутаг дахь Буур голын (Сэлэнгэ, Алтанбулаг сум) гэрээгээр тогтоож, хилийн шугамын дагуу Монголын талаас гэр харуул, Оросын талаас хилийн тосгон байгуулан хамгаалах болсон билээ. Эл гэрээгээр зүүн хойд зүг Баргын нутгийн Авгайт уулаас баруун зүг Тагнын Урианхайн баруун хойд Шавинайн даваа хүртэл хил тогтоосон байна.

1864 оны 9-р сарын 25-нд Тарвагатай хотод Хаант Орос улс–Манж чин гүрний хооронд 10 зүйл бүхий хилийн гэрээ байгуулсан нь 1860 оны Бээжингийн гэрээний нэмэлт гэрээ байсан юм. Үүнийг Орос улсын түүх бичлэгт “Чугучакийн гэрээ” хэмээдэг. Гэрээ байгуулахад Орос улсын талаас Хулжид суух ерөнхий консул И.Захаров, хурандаа И.Бабков хоёр, Манжийн талаас Улиастай жанжин Мин И, Тарвагатайн амбан Си линь, цэргийн жанжин Болгосу нар оролцжээ. Уг нэмэлт гэрээгээр Тагнын Урианхайн баруун хойд Шавинайн даваанаас баруун урагш Цунлин уул хүртэл Ар Монголын баруун хойд, хуучин Зүүнгарын улсын баруун хойд, баруун хилийг тогтоосон ажээ.

Тарвагатайн гэрээний 1, 4, 6-р зүйл Ар Монголын нутаг дэвсгэрт хамаарна. Эхний зүйлд Шавинайн даваанаас Зайсан нуурт цутгах Хар Эрчис голын адгийн Мааньт гаталган харуул хүртэлх хилийг нарийвчлан тогтоожээ. Тэнд “Шавинайн давааны хилийн тэмдэгээс хил эхлээд баруун зүг, дараа нь Саяны нуруугаар өмнө зүг, Тагна уулын баруун захын

---

\* Дуутан Ж.Гэрэлбадрах, профессор. МУБИС, НХУС, Түүхийн тэнхим, gerelbadrakh@msue.edu.mn



төгсгөлд хүрнэ, тэндээс Сийлхэмийн нуруугаар баруун урагш”<sup>67</sup> гэх зэргээр нилээд нарийн зааж бичсэн байдаг. Энэ хэсэгт хил тогтооход тааралдах усны хагалбарын тухайд зүүн, өмнө зүг урсч байгаа голын бүх сав газрыг Манж улсад, баруун, хойд зүг урсах голын бүх сав газрыг Орос улсад харьяалуулахаар заасан байдаг.

4-р зүйлд Алтайн их уулсын хойгуур байрлаж байсан Ар Монголын Улиастай, Ховдын харьяа Үхэг зэрэг суман харуулын нутаг Орос улсад харьяалагдах болсныг бичжээ. 6-р зүйлд Шавинайн даваанаас Согог харуул хүртэлх хилийн дагуу тэмдэг босгоход Улиастайн жанжин, харин Согог харуулаас Мааньт гаталган харуул хүртэл хилийн шугамд Ховдын сайд очихыг заасан байдаг.<sup>68</sup> Хоёр тал Тарвагатайн гэрээг солилцсноос 240 хоногийн дараа бүрэн эрхэт төлөөлөгчдийг томилон хилийн шугамыг газар дээр нь тогтоохоор заасан ч бараг 5 жилийн дараа 1869 онд л уг ажлыг хийсэн билээ.

Хилийг газар дээр тэмдэглэж, овоо тэмдэг босгох (демаркация) ажил 1869 оны 8-р сард Ховд, Улиастайд явагджээ. Үүнийг Хятадын түүх бичлэгт Улиастайн хилийн баганы гэрээ (1869.9.4), Ховдын хилийн баганы гэрээ (1869.8.13), Тарвагатайн хилийн баганы гэрээ (1870.8.12) гэж үздэг.<sup>69</sup> Үнэндээ тэр нь Тарвагатайн гэрээний дагуу гурван газар хилийн овоо тэмдгийг үргэлжлүүлэн босгосон ажиллагаа бөгөөд эхний хоёр нь Ар Монголын нутагт хамаарна.

1864 онд Тарвагатайн гэрээ байгуулахаас аль өмнө Ар Монголын баруун хойд нутаг нь Алтайн нурууны баруун хойд салбар уул болох Хатун, Хуурай, Чуй нуруу, Алтан нуур (Телец?) хүрч байв. Алтай зүгийн суман харуул Сийлхэмийн нурууны ар бие хөндий, Галуут нуурын сав газрын хойгуур байрлан хилээ хамгаалж байв. Харин Алтан нуурын Урианхай хилийн харуулын хойно байрлах хэдий ч Ар Монголд харьяалагдан Ховдын сайдад захирагдаж байжээ.

Чингэж 1864 оны Тарвагатайн гэрээгээр Ар Монголын Ховдын хязгаарын “Алтан нуурын Урианхай”-г бүхлээр нь, Дөрвөд ба Алтайн Урианхайн багагүй нутаг Орос улсын мэдэлд орсныг Монголын газрын зургуудад түшиглэн хөндөн авч үзсү.

XIX зуунд Ар Монголын баруун хойд хил хэрхэн өөрчлөгдөж хумигдсныг XX зууны эхэн үеийн “Дөрвөд хоёр аймгийн нутгийн зураг” (1907), “долоон хошууны Урианхайн харьяат нутгийн зураг” (1913), “Тагна Урианхайн бүс нутгийн нарийвчилсан зураг” (1907?), “Алтайн Урианхайн долоон хошууны нутгийн зураг” (1928) зэрэгт тэмдэглэн үлдээжээ.

**“Алтан нуурын Урианхай”-н нутаг Орос улсад орсон нь.** Монгол Алтайн нурууны хойд үргэлжлэл хэсгээр тухайн үеийн албан бичигт гардагаар “Алтан нуурын Урианхай” нар нутаглаж байв. “Алтан нуурын Урианхай” гэдэг нь угаас буруу нэр агаад тэнд Урианхай нар бус, харин ойрад монголчууд голлон амьдарч байжээ. Алтан нуур бол одоогийн Телец буюу Тугал нуур юм. Телец нь бас алт, эд баялаг гэсэн утгатай<sup>70</sup> бөгөөд

<sup>67</sup> Чугучакский протокол о размежевании Русско-Китайской границы. Русско-Китайские отношения. 1689-1916. Официальные документы. М. 1958. с. 46

<sup>68</sup> Чугучакский протокол о размежевании Русско-Китайской границы. Русско-Китайские отношения. 1689-1916. Официальные документы. М. 1958. с. 48

<sup>69</sup> Ли Үйшү. Гадаад Монголын автономитыг цуцалсан нь. Гадаад Монголын дотоод нууц. Орчуулсан Б.Гэрлээ. УБ., 2016. т. 388-389

<sup>70</sup> С.И.Ожегов. Словарь русского языка. М., 1968. с. 780

эл нуур тэр цагт Алтан нуур гэдэг нэртэй байсан байж магадгүй. Энэ нь эдүгээгийн ОХУ-ын БНАлтайн Улсын нэг хэсэг нутаг билээ.<sup>71</sup>

Тэдгээр ойрад монголчууд Алтайн нурууны хойд хэсгийн Хатун, Хуурай, Чуй нуруу ба тэднээс эх авдаг Уйман, Чуй голууд болон Телец нуурын саваар оршиж байжээ. 1756 оны 5, 6 сарын үест Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан (1735-1796) Хан Хатан голын Урианхайн бослогыг даруулахаар жанжин Хадаха, Халхын ван Чингүнжав нарыг илгээж байв.<sup>72</sup> Тэрхүү Хан Хатаны Урианхай бол чухамдаа “Алтан нуурын Урианхай” буюу ойрад монголчуудын нэг хэсэг юм. Хатун гол Хатаны нуруунаас эх авна. Мөн Чингүнжав вангийн очсон хэмээн нэр гарах Чуй гол бас Чуйн нуруунаас эх авдаг. Чингэж Алтайн нурууны хойд хэсгийн Ойрад монголчууд 1756 оноос Манж чин гүрний харьяанд орж, Ховдын сайдад захирагдах болов.

Манжийн албан түүх бичлэгт “Алтан нуурын Урианхай”-г 1764 онд дагаар орсон гэж бичдэг. Энэ хоёр хошууг Бүгдийн дарга захирч байв. Хоёр хошуу нийлээд алба барих (60+116) нийт 176 өрх айлтай ажээ.<sup>73</sup> Тэд булга, хэрэмний арьсаар үст алба барих ба түүнийг жил бүрийн цагаан сараар Ховдоос цэргийн түшмэл очиж хурааж авна.

1869 онд хилийн шугам тогтооход “Алтан нуурын Урианхай” гэгдэх Алтайн нурууны Ойрад монголчууд Орос улсын мэдэлд орсон талаар сурвалжид “Бас Алтай нуурын Урианхай хоёр хошуу Алтай нуурын ойрхид буй. Урьд мөн Ховдын хуувийн сайдын харьяат бөлгөө. Эдүгээ тэр газрыг хасаж Оросын харьяат болгов”<sup>74</sup> хэмээн өгүүлсэн байдаг. Энд Алтан нуурыг Алтай нуур гэж андуурсан бичсэн юм.

Тэр 2 хошуу нь Алтан нуурын хошуу, Чулышман (Хөх мод)-ы хошуу ажээ. Ховдын сайдад харьяалагдаж байсан тэр нутгийг Орос улсад өгснийг хятадууд “Бүрэнт засагчийн (Тун-чжи. 1862-1875) үед Хятадын талаас хил тогтоож байсан түшмэл нь тухайн газрын нэрийг сайн мэдэхгүй тул Алтан нуурын урианхайн 2 хошууг Оросын нутаг дэвсгэрт оруулжээ”<sup>75</sup> гэж тайлбарласанд үнэмшихэд бэрхтэй. Учир нь 1864 оны Тарвагатайн гэрээнд Алтан нуурын Урианхай гэж бичээгүй авч тэдний нутгийг Орос улсад оруулахаар заасан байдаг.<sup>76</sup>

Алтайн нурууны хойд биеийн Ойрад монголчууд Ар Монголын Дөрвөд аймгийн баруун хойгуур, Тагнын Тува-гийн баруун талд оршиж байв. Дээрх газрын зургуудад мэдээж өөрсдийн нутаг дэвсгэрээ зурах тул “Алтан нуурын Урианхай”-н нутгийг тэмдэглээгүй ч, түүнтэй хэрхэн нутаг залгадаг тухай дурдсан байдаг. Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зурагт “Энэ Үнэгтийн пайз овоогоос Зэс даваанд хүртэл Оросын харьяат Алтан нуурын Урианхай ман лугаа хэлхээ нийлсэн”<sup>77</sup> хэмээн тэмдэглэснээс Дөрвөдийн нутаг дахь Хатуу Улиастайн харуулын хойд талын Үнэгт уулнаас баруун урагш Алтайн

<sup>71</sup> Орос дахь Монгол угсааны улсууд. нягталсан Хэрээд Л.Жамсран. УБ., 1995. т. 123-126

<sup>72</sup> Н.Ишжамц. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. (Амарсанаа, Чингүнжав нарын бослого). УБ., 1962. т. 52-53

<sup>73</sup> Ховдын засгийн хэргийн бүгд цэс. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд. II. Хэвлэлд бэлтгэсэн На.Сүхбаатар. УБ., 2002. т. 81-82


<sup>74</sup> Хойд газрын аймгийн ойллого. Удиртгал, галиг, хөрвүүлэг, тайлбар бичсэн Дуутан Ж.Гэрэлбадрах. МНГМ. томus III. УБ., 2016. т. 109-110

<sup>75</sup> Ли Йишу. Гадаад Монголын автономитыг цуцалсан нь. Гадаад Монголын дотоод нууц. Орчуулсан Б.Гэрлээ. УБ., 2016. т. 393

<sup>76</sup> Чугучакский протокол о размежевании Русско-Китайской границы.Русско-Китайские отношения. 1689-1916. Официальные документы. М.1958. с. 46

<sup>77</sup> Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг (1907). Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 18

Урианхайтай зах нийлэх Зэс даваа хүртэлх газрын хойгуур Алтан нуурын Урианхай нутаглаж байсныг мэдэж болно. (зураг № 1-ийг үзнэ үү)



Зураг № 1. Дөрвөдийн нутгийн зураг (1907)

Мөн Тагнын Урианхайн хошууны 1907 оны нутгийн зурагт Алтайн нурууны ойрадуудыг Тэлэнгид гэж бичсэн хийгээд түүнтэй баруун талаараа зах нийлж байсныг “долдугаар гадаад Орос улсын харьяат Тэлэнгид лугаа манай Тагна Урианхайг захирах мэйрэний зангийн зэрэг бүгдийн дарга Гомбодоржийн харьяат Урианхайн хошуудын нутгийн хязгаар зах нийлэх Богосог давааны хилийн овоо”<sup>78</sup> хэмээсэн байдаг. Богосог даваа Тагнын Урианхайн нутгийн баруун урд талд оршино.

“Алтан нуурын Урианхай”-г Орос улсад өгснөөр Тагнын Урианхай буюу Тува нар баруун талаараа Суурь даваа, Чулча ус, Хөсөр даваа, Цавчаал, Хараа уул, Тасхил уул, Богосог даваанд босгосон хилийн овоодоор Алтан нуурын Урианхайтай хиллэх болсон байна.

Чингэж 1760-аад оны үеэс Ховдын сайдад захирагдаж байсан “Алтан нуурын Урианхай” гэх Ойрад монголчуудыг Орос улсад өгснөөр Ар Монголын баруун хойд нутаг ихэд дотогшилж, зарим суман харуулыг урагш нүүлгэхэд хүрсэн байна. 1860-аад оноос өмнө “Алтан нуурын Урианхай”-н нутаг лавтайяа Хатуу Улиастай, Хаг нуур, Согог ямаат, Дархинт, Идэр, Үхэг гэсэн 6 харуулаар Ар Монголтой зах нийлж байв. Харин 1869 оноос хойш Хатуу Улиастай, Хаг нуур, Шинэ Согог, Ойгор, Шинэ Идэр гэсэн 5 харуулаар хил нийлэх болж цөөрчээ.

<sup>78</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuid Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 100

**Дөрвөдийн баруун хойд нутгийг алдсан нь.** 1864 онд Тарвагатайн гэрээ байгуулахаас аль хэдийн Дөрвөдийн нутаг баруун хойд талаар Сийлхэмийн нуруунаас хойгуур байсныг өмнө өгүүлсэн билээ. Тэр байтугай тэдний нутгийн араар байрлах хилийн харуулуудыг хойшлуулан нүүлгэж, газар нутгийг нь өргөтгөсөн явдал гарсан юм. 1794 онд Дөрвөдийн хан Магсаржав харьяат аймгийн ард өсч үржин нутагтаа багтахгүй болсон учрыг гаргаж, нутаг бэлчээр гуйн мэдүүлсэн ажээ. Ховдын амбан Гүн үүнийг байцаан үзээд Орос зүг суулгасан Ойгор зэрэг долоон суман харуулын нутгийг гадагш нь бага зэрэг түлхэж, суларсан газрыг өгөхөөр шийдвэрлэснийг Манжийн хаан зөвшөөрөн баталжээ.

Тэр тухай “Тэнгэрийн тэтгэсний тавин есдүгээр онд, Дөрвөдийн хан Магсаржав түүний харьяат ард төрж үржсэн нь олон тул мал улмаар үлэмж үржжээ. Язгуураас шагнасан нутгийн газраа магадаар чухам багтахгүй байцаан шийтгэх ажаамуу хэмээн өргөжээ. Урьд тушаалын хэбэй амбан Күн түүний нутгийн чухал магад явдлыг байцаан тодорхойлж ойр хязгаар нийлсэн Ойгорын зэргийн долоон харуулыг гадагш бяцхан эгүүлж султсан газрыг түүнд шагнаж нутаг болгох явдлыг айлтгахуйд зарлигаар Улиастайн жанжин Хэнд тушааж, Ховдын хэбэй амбан Гүнийн лугаа нийлж хамт харуулд илгээж байцаан тодорхойлж Ойгорын зэргийн долоон харуулыг гадагш эгүүлж султсан газрыг хуваан шагнажээ”<sup>79</sup> хэмээн өгүүлдэг.

1864 оны Тарвагатайн гэрээгээр тогтоосон хилийн шугам, овоо тэмдгийг 1869 онд тогтоохдоо 1794 онд хойш нь болгосон Ар Монголын нутгийн баруун хойд талын хилийн шугамыг өөрчлөн Согог ямаат, Дархинт, Идэр гэсэн 3 харуулын нутгийг дотогшуулж, Үхэг харуулыг бүр үгүй хийжээ. Чингэж Сийлхэмийн нурууны ар бие, хормой, Галуут нуурын сав зэрэг Ар Монголд харьяалагдаж байсан нилээд нутаг Орос улсын мэдэлд орсон байна.

Уг тохиролцоогоор Сийлхэмийн нурууны хойно байсан Согог ямаат харуулыг урд нь аваачин Шинэ Согог харуул хэмээн, мөн нуруунаас баруун хойно орших Дархинт харуулыг урд талд нь буюу Ойгор нуурын зүүн хойно болгоод Ойгор хэмээн, Галуут нуурын хойд уулсын арын Идэр харуулыг түүний урьдах Сийлхэмийн нурууны өмнөд бэл хормойд буюу Ойгор нуурын баруун талд тавьж Шинэ Идэр харуул хэмээн тус тус дотогшлуулан байрлуулаад нэрийг нь өөрчилсөн ажээ.<sup>80</sup>

Чингэж 4 суман харуулын нутаг хилийн гадна үлдснийг Дөрвөдийн хоёр аймгийн газрын зурагт тэмдэглэсэн байдаг. Тус зурагт Дөрвөдийн баруун хойд талын нутгийн хилийг шинэчлэн тогтоосон талаар “Байцааваас Хатуу Улиастай харуулаас Зэс даваа хүртэл Бүрэнт засагчийн наймдугаар онд Ховдын хэбэй амбан Хүй-н газраас Орос улсын амбан Ба лугаа нийлж шинэ тогтоожээ”<sup>81</sup> хэмээжээ. Тэдгээр хүмүүс бол Ховдын хил тогтоох түшмэл Күй чан, Орос улсын хил тогтоох түшмэл Бабуков (И.Бабков) нар ажээ.<sup>82</sup>

Тус газрын зурагт Орос улсын нутагт орсон 4 харуул болох Согог ямаат, Дархинт, Идэр, Үхэг харуулыг хуучин газарт нь хилийн овоо-баганыг заадаг уламжлалт босоо тэгш өнцөгт □ тэмдгээр зурж, бүтэн нэрийг бичсэн байна. Ингэхдээ “Байцааваас овоо дотор


<sup>79</sup> Ховдын засгийн хэргийн бүгд цэс. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд. II. Хэвлэлд бэлтгэсэн На.Сүхбаатар. УБ., 2002. т. 118-119

<sup>80</sup> Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 18

<sup>81</sup> Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 18

<sup>82</sup> Ли Үйшү. Гадаад Монголын автономитыг цуцалсан нь. Гадаад Монголын дотоод нууц. Орчуулсан Б.Гэрлээ. УБ., 2016. т. 391

хөх будаг түрхэх нь бүрнээ Орос улсад хуваан өгсөн, хөх будаг түрхэх үгүй нь эдүгээ хоёр улсын хязгаар хэлхээн овоо болмуй. Гагцхүү энэ Үхэг харуулыг Алтай Урианхай нутаг Хотон нуурт шилжүүлж суулгасан”<sup>83</sup> гэж бичжээ. Газрын зурагт Орос улсын нутагт харьяалагдах болсон Хуучин Согог, Дархинт, Идэр, Үхэг харуулын нутгийн овооны тэмдэглэгээг хөх өнгөөр будаж ялгажээ. Тэдгээр 4 харуулыг Шинэ Согог, Ойгор, Шинэ Идэр гэсэн 3 харуул болгож цөөлөн зохион байгуулжээ. (зураг № 2-ыг үзнэ үү)



Зураг № 2. Дөрвөдийн нутгийн зураг (1907)

Эл газрын зурагт Сийлхэмийн нурууны баруун хойд талд байсан Үхэг харуулыг Алтайн Урианхайн нутагт шилжүүлсэн гэж бичсэн авч Тарвагатайн гэрээнд “Үхэг зэрэг харуулыг”<sup>84</sup> Оросын нутагт оруулахаар заасны дагуу бүрмөсөн үгүй хийжээ.

Тийнхүү Ар Монголын баруун хойд нутаг болох буюу Сийлхэмийн нурууны ар бие, Галуут нуурын сав газар зэрэг багагүй хэмжээний нутаг Орос улсын мэдэлд орсон байна. Хоёр улсын хилийг Сийлхэмийн нурууны яг ар бэлээр урагшлуулан авчирч, суман харуулыг нуруунаас урагш татан суулгажээ. Тодруулж хэлэхүл, Дөрвөд аймаг баруун хойд талаараа Шинэ Согог, Ойгор, Шинэ Идэр гэсэн 3 харуулаар Алтан нуурын Урианхай буюу Алтайн нурууны ойрадуудтай хиллэх болсон ажээ.

**Алтайн Урианхайн зарим нутгийг алдсан нь.** 1864 оны Тарвагатайн гэрээгээр Ховдын хязгаарт харьяалагдах Алтайн урианхайчууд бас багагүй нутгаа алдсан юм. Үүнийг 1913, 1928 онд үйлдсэн Алтайн Урианхайн газрын зургуудад бараг адилхан бичиж, мөн зурсан байдаг. 1913 оны газрын зурагт “Энэ Хадулай (Хатууль ?) даваанаас Мааньтгаталган харуулд хүртэл, урьд Чин улсын Бүрэнт засагчийн наймдугаар онд

<sup>83</sup> Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 18

<sup>84</sup> Чугучакский протокол о размежевании Русско-Китайской границы. Русско-Китайские отношения. 1689-1916. Официальные документы. М. 1958. с. 47

Ховдын хэбэй амбан Хүй Орос улсын түшмэдийн хамт нийлж хуваан тогтоож хэлхээ байгуулсан”<sup>85</sup> гэж бичиж үлдээжээ.

Уг мэдээний дагуу тус газрын зурагт Орос улсад өгсөн нутгийг улаан цэгэн шугамаар зааглан зуржээ. Газрын зурагт бичсэн мэдээ ба зурсан зураасаас харахад, 1869 онд Ховдын амбан, Орос улсын түшмэд хил нийлэх газрын хэлхээг тогтоохдоо 1864 оны Тарвагатайн гэрээнд заасны дагуу Алтайн нурууны Хадулай даваанаас баруун тийш Алтайн нурууны хойд биеэр орших Чандагат, Өрлүү, Чингистэй, Хар Тарвагатай, Нарийн, Хул (Хул азарга), Хонь майлах гэсэн 7 суман харуулын болон түүний эргэн тойрны нутгийг Орос улсад өгсөн байна. (зураг № 3-ыг үзнэ үү)



Зураг № 3. Дөрвөдийн баруун аймгийн сул сайд Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны Урианхайн харьяат нутгийн зураг (1913)

Ингээд зогссонгүй, 14 жилийн дараа 1883 онд Алтайн Урианхайн их хэмжээний газар нутгийг дахин Орос улсад алдсан байдаг. Энэ бол 1864 оны Тарвагатайн гэрээнээс тусдаа, сүүлд болсон хэрэг явдал ажээ. Үүнийг 1928 оны газрын зурагт “Энэ Зэс даваагаас Алахабиг харуулд хүртэл Орос улс лугаа хэлхээ нийлсэн. Бадаргуулт төрийн есдүгээр онд Илийн хэбэй амбан Шэн, Ховдын туслагч амбан Э, Орос улсын амбан Ба хамт нийлж шинэ нийлж хэлхээ байгуулсан”<sup>86</sup> хэмээн тэмдэглэжээ. Тэрхүү дахин шинээр тогтоосон хилийн шугамыг улаан босоо дөрвөлжин тасархай зураасаар зуржээ. (зураг № 4-ийг үзнэ үү)

<sup>85</sup> Дөрвөдийн баруун аймгийн сул сайд гүн Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны Урианхайн харьяат нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 23

<sup>86</sup> Landscapes reflected in old Mongolian maps. Edited by F.Hiroshi and K.Akira. Tokyo. 2005. pp. 64, 80, 94-95




Зураг № 4. Алтайн Урианхайн долоон хошууны нутгийн зураг(1928)

Энэ удаад урьд өмнө 1869 онд Орос улсад баруун талын хэсэг нутгаа өгөөд зүүн зүг дотогшлуулан байгуулсан Шинэ Хар Тарвагатай, Нисэх таван бэлчир, Халжирбас, Хар Эрчис голын адаг урсгалын Мааньт гаталган гэсэн 4 суман харуулын нутгийг нэмж алдсан ажээ.

Тийнхүү 1883 онд дахин Зайсан нуурын зүүн бие хүрч байсан Ар Монголын Ховдын хязгаарын, тодруулан хэлбэл Алтайн Урианхайн баруун талын үлэмж нутгийг Орос улсад алджээ. Алтайн Урианхайн нутгийн баруун зах нь Алтайн нурууны Зэс даваа, Хадулай даваа, Хужиртбулаг, Сэс уул, Алахабиг харуул, баруун урд талдаа Хар Эрчис голын дунд урсгал, Өрөнгөр буюу Кизилбаш нуур, Өрөнгө голын адаг урсгалын газрыг хамрах болсон байна. Чингэж багассан Алтайн Урианхай нутгийн Орос улстай нийлэх хилийг 8 харуул хамгаалах болов. Тэдгээрийг өмнөөс хойш нь дараалуулан дурдвал Алахабиг, Агтас (Хадас?), Хижил аш, Сэс (Сас ?), Хужиртбулаг, Усанхужирт, Хомсомтолгой, Хотон нуур харуул юм. (зураг № 4-ийг үзнэ үү)

**Төгсгөл.** Ийнхүү 1864 оны Тарвагатайн гэрээ, түүнийг дагалдан 1869 онд Ховд, Улиастай, Тарвагатайд явагдсан хил тогтоох хэлэлцээгээр хоёр улсын хилийн дагуу Монголын талаас байгуулсан Согог, Дархинт, Идэр, Үхэг, Чандагат, Өрлүү, Чингистэй, Хар Тарвагатай, Нарийн, Хул (Хул азарга), Хонь майлах гэсэн 11 суман харуулын болон

түүний эргэн тойрны нутгийг Орос улсад өгсөн байна. Ихэд урагшуулан тогтоосон шинэ хилийн дагуу Дөрвөдийн нутгийн баруун хойд талаар Шинэ Согог, Ойгор, Шинэ Идэр гэсэн 3 харуул, Алтайн Урианхайн нутгийн баруун талаар Хотон нуур, Хомсомтолгой, Усанхужирт, Хужиртбулаг, Сэс, Хижил аш, Агтас (Хадас?), Алахабиг гэсэн 8, нийт 11 харуул байгуулсан ажээ (зураг № 5-ыг үзнэ үү)



Ж.Гэрэлбадрах, О.Пүрэв. XIX-XX зууны эхэн үеийн Монгол. Газрын зураг. УБ., 2016

Хаант Орос, Манж чин улсын түшмэд Ар Монголын баруун, баруун хойд нутгийн хилийг тогтооход “Алтан нуурын Урианхай” хэмээгдэх Алтайн нурууны Ойрад монголчуудыг Орос улсад бүрэн өгөөд зогсохгүй, Дөрвөд аймаг, Алтайн Урианхайн баруун хойд нутгаас багагүй алдсныг 1864 оны Тарвагатайн гэрээний дагуу шийдсэн болохыг гэрээний заалтаас түвэггүй харж болно. 1689 онд уг нутгуудыг Орос улсад албан ёсоор өгснийг дээрх газрын зургуудад бичиж, бас зуржээ.

Харин 1883 онд Ар Монголын Ховдын хязгаарын Алтайн Урианхайн баруун хилийг дахин дотогшлуулан тогтоосны учир шалтгааныг яг таг хэлэхэд хэцүү юм. Ямар боловч энэ нь Тарвагатайн гэрээнээс тусдаа өөр зүйл ажээ. Хаант Орос, Манж чин улсын хооронд том өгөө авааны тохиролцоо хийгдсэн нь ойлгомжтой хийгээд Ар Монголын баруун хойд талын багагүй нутаг дэвсгэрийг өгсний хариуд Манж чин гүрэн өөр ямар нэгэн газар зүйлийг Хаант Орос улсаас авсан байлтай юм.

Бас Монголын түүх бичлэгт Алтай зүгийн суман харуулд Согогоос Хонь майлах хүртэлх 11 харуулыг багтаан бичсээр ирсэн нь тэднийг XIX зуунд аль хэдийн Орос улсад алдсныг мэдэхгүйгээс үүдэлтэй ажээ.

#### Ашигласан ном зохиол, баримт

1. Ж.Гэрэлбадрах, О.Пүрэв. XIX-XX зууны эхэн үеийн Монгол. Газрын зураг. УБ., 2016
2. Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986



3. Дөрвөдийн баруун аймгийн сул сайд гүн Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны Урианхайн харьяат нутгийн зураг. Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986
4. Н.Ишжамц. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. (Амарсанаа, Чингүнжав нарын бослого). УБ., 1962
5. Landscapes reflected in old Mongolian maps. Edited by F.Hiroshi and K.Akira. Tokyo. 2005
6. Ли Ыйшү. Гадаад Монголын автономитыг цуцалсан нь. Гадаад Монголын дотоод нууц. Орчуулсан Б.Гэрлээ. УБ., 2016
7. С.И.Ожегов. Словарь русского якука. М., 1968
8. Орос дахь Монгол угсааны улсууд. нягталсан Хэрээд Л.Жамсран. УБ., 1995
9. Ховдын засгийн хэргийн бүгд цэс. Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд. II. Хэвлэлд бэлтгэсэн На.Сүхбаатар. УБ., 2002
10. Хойд газрын аймгийн ойллого. Удиртгал, галиг, хөрвүүлэг, тайлбар бичсэн Дуутан Ж.Гэрэлбадрах. МНГМ. томус III. УБ., 2016
11. Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014
12. Чугучакский протокол о размежевании русско-китайской границы. Русско-Китайские отношения. 1689-1916. Официальные документы. М. 1958

Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа. УБ., 2018.8.20-нд болсон хурлын илтгэл. УБ., 2018. т. 79-93

### Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн хэдэн зураг

1725 онд Манжийн Найралт төв хаан Халхын Түшээт хан аймгаас 19 хошуу таслан Сайн ноён аймгийг байгуулжээ. Манж чин улсын төрийн албан түүхэнд 1692 онд дагаар орсон Цэрэнг 1707 онд засаг ноён болгосон<sup>87</sup> гэж өгүүлсэн нь Сэцэн засгийн хошуу үүссэн он цаг юм. Харин “Монгол улсын шастир”-т Цэрэнг 1708 онд “засаг болгожээ”<sup>88</sup> гэж бичснээр бол Сэцэн засгийн хошуу 1708 онд байгуулагдсан болж таарч байна. Ц.Сономдагва аругайн судалснаар Сэцэн засгийн хошууг 1721 онд Сайн ноёны хошуунаас тасалж байгуулсан ажээ.<sup>89</sup>

Тус хошууны Манжийн эрхшээлийн үеийн албан ёсны нэр нь “Халхын умар замын дундад зүүн этгээдийн адаг хошуу” юм. Хошуу дотоод зохион байгуулалтын хувьд 4 сум, 4 хамжлага, 10 отгоос бүрдэж байв. Тэдгээр нь Их Баруун сум, Их Зүүн сум, Зүүн Цахар сум, Баруун Цахар сум, Жас хамжлага, Жамсран бэйлийн хамжлага, Эсэр Магнай гүний хамжлага, Баруун Дашравдан гүний хамжлага, Их отог, Бага отог, Дүйнхэр тэргүүний отог, Баруун отог, Намхай тэргүүний отог, Даланбаярын отог, Төмөр тайжийн отог, Эрэгзэн мэргэний отог, Бизьяа дайчингийн отог, Ширээт гэгээний шавь отог юм.<sup>90</sup> 1912 онд Монголын улсын Богд Жибзундамба хаанаас Ширээт хутагтад албан ёсоор тамга олгосноор Сэцэн засгийн хошуунаас салж, биеэ даасан засаг захиргааны нэгж-тамгатай хутагтын шавь болжээ. Мөн 1911 оноос Халхын Сайн ноён аймгийг Монгол улсын Сайн ноён хан аймаг хэмээн нэрийдэх болсон билээ.

1923 онд Ардын засгийн газраас хамжлагат ёсыг халсантай холбоотойгоор хошуудыг ноёны цол, хэргэмээр нэрлэдэг байсныг болиулж, уулын нэрээр нэрийдэх болсноор Цэцэрлэг Мандлын аймгийн Хан Өндөр уулын хошуу хэмээх болов. Тэр үед 1912 онд салгасан Шиваа ширээт хутагтын шавийн захиргааг устгаад тус хошуунд эргүүлэн нийлүүлэв. Дотроо 13 сумтай болсон нь Баянзүрхийн зүүн, Баянзүрхийн баруун, Баясгалант, Баянмандал, Баянхайрхан, Дашванзад, Дэлгэр Өндөр, Их Тэнгэр, Дашлүн, Тусгалт, Үлэмжбадрах, Цогт хайрхан, Чимэдлүн зэрэг ажээ. 1931 онд БНМАУ-д засаг захиргааны өөрчлөл хийж, шинээр 13 аймаг байгуулахад тус хошуу Архангай аймгийн Их Тамир, Чулуут, Өндөр-Улаан сумдын нутаг болжээ.

Сэцэн засгийн хошууны нутаг хожмын түүх судлаач Н.Жагварал<sup>91</sup> (1953), О.Пүрэв<sup>92</sup> (2004), Ж.Гэрэлбадрах<sup>93</sup> (2016) нарын газрын зургийн бүтээлд тодорхой хэмжээгээр туссан байдаг. (зураг № 1, 2-ыг үзнэ үү)

Зураг № 1. Архангай аймгийн Чулуут сум Сэцэн засгийн хошуу байх үеийн дотоод зохион байгуулалт. Н.Жагварал. 1953

\* Дуутан Ж.Гэрэлбадрах –МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч, профессор

<sup>87</sup> Зарлигаар тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир. Далдугаар дэвтэр. Монгол улсын Үндэсний номын сан.

<sup>88</sup> Зарлигаар тогтоосон Халхын Сайн ноён хан аймгийн ван гүнгүүдийн итгэл шастир. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир. Тэргүүн боть. Далдугаар дэвтэр.


<sup>89</sup> Ц.Сономдагва. Халхын дөрвөн аймгийн олон хошуу тэдгээрийн гарал нэрсийн өөрчлөлт (1691-1924). Түүхийн судлал. Tomus VIII. УБ., 1969. т. 177

<sup>90</sup> Ц.Сономдагва. Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэл. Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан. УБ., 1998. т. 176


<sup>91</sup> Mongᠣᠯ daᠻi ʋaᠵaᠭ-un asaᠶudal. (Монгол дахь газрын асуудал) Н.Жагварал. 1953. Машиндмал эх. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн түүхэн баримтын бүртгэл. I. х-4, д -1, хн-84

<sup>92</sup> XX зууны эхэн үеийн Ар Монгол (1900-1930). Газрын зураг. Зохиогч: Хар Дархад О.Пүрэв. УБ., 2004

<sup>93</sup> XIX-XX зууны эхэн үеийн Монгол. Газрын зураг. Зохиогч: Ж.Гэрэлбадрах, О.Пүрэв. УБ., 2016



Зураг № 2. Халхын Сайн ноён аймгийн Сэцэн засгийн хошуу. О.Пүрэв. 2004



Эдүгээ Халхын Сайн ноён аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг 6 байгаа нь мэдэгдэж байна. Түүний гурав нь аймгийн бүх хошуудыг багтаасан том зураг, нөгөө гурав нь тухайлан үйлдсэн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг юм. Аймгаар нь зурсан том зураг нь,

-1891 оны (Бадаргуулт төрийн 17 он) Сайн ноён аймгийн бүх хошуудын нутгийн зураг. Монгол улсын Үндэсний номын санд 1357/96 гэсэн дугаартай хадгалагдаж буй 350см х 400 см хэмжээтэй даавуу дээр зурсан энэ зураг харьцангуй томд тооцогдоно. Тийм ч учраас хувилах боломжгүй гээд уншигчдад уг эхийг нь үзүүлдэггүй.

-1907 он (Бадаргуулт төрийн 33 он)-д зурагдсан “Халхын Сайн ноён аймгийн хорин гурван засаг хошууны нутгийн зураг”. Эл зураг ХБНГУ-ын Берлин хотын Номын санд хадгалагдаж буй. Цахим хуудсанд тавьсан тул нарийн сайн уншигддаггүй муу талтай. Дөрөв хуваан цахим хуудсанд тавьсныг энд нийлүүлэн толилуулж байна (зураг № 3-ыг үзнэ үү).

Зураг № 3. Халхын Сайн ноён аймгийн хорин гурван засаг хошууны нутгийн зураг. (1907) ХБНГУ-ын Берлин хотын Номын сан



-1909 онд (Хэвт ёсны 1 он) зурагдсан Сайн ноён аймгийн хошуудын нэгдсэн зураг<sup>94</sup> гурав юм. (зураг № 4-ийг үзнэ үү)

Зураг № 4. Халхын Сайн ноён аймгийн хошуудын нэгдсэн зураг. (1909) Японы Тэнгэр ИС-ийн номын сан

<sup>94</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchuud Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 073



Уг илтгэлд Сэцэн засгийн хошууны тухайлсан нутгийн зургийн талаар өгүүлнэ. Тэдгээр нь


А. 1874-1921 оны хооронд гэж таамаглаж буй Сэцэн засгийн хошууны нутгийн зураг,

Б. Сэцэн засгийн хошууны нутгийн 1921 оны хоёр зураг ажээ.

А. Японы Тэнгэр ИС-ийн номын санд хадгалагдаж буй Монголын аймаг хошуудын нутгийн зураг дотор Сайн ноён аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг байв.<sup>95</sup> (зураг № 5-ыг үзнэ үү) 2004 онд эдгээр зургийг судлаач Оюунбилиг, Насандалай нар хэвлүүлэхдээ Сэцэн засгийн хошууны нутгийн зургийн он цагийг 1874-1921 оны хооронд хамаатуулсан нь бага зэрэг эргэлзээтэй. Уг нутгийн зургийг монголчууд тусгаар тогтнолоо сэргээсэн 1911 оноос өмнө үйлдсэн хэмээн үзэх нь илүү үндэслэлтэй юм. Учир нь эл зурагт 1912-1923 оны хооронд тус хошуунаас тасран тусгай нэгж болсон Шиваа ширээт хутагтын шавийн нутаг хуучин хэвээр байна. Иймд эл нутгийн зургийг 1912 оноос өмнө үйлдсэн болж таарна.

Зураг № 5. Сайн ноён аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг. (? -1911) Японы Тэнгэр ИС-ийн номын сан

<sup>95</sup> Studies in Mongolian manuscript maps preserved in the Tenri central library, Tenri university, Japan. Borjigidai Oyunbilig, Bukhchud Nasundalai. Peking university press. Beijing. 2014. p. 073



Нутгийн зургийг 26см х 23.5 см хэмжээтэй муутуу цаасны гол дунд босоогоор 4, хөндлөнгөөр 5, нийт 20 дөрвөлжинд багтаан зуржээ. Харин нэг дөрвөлжинд хэдэн газар багтааснаа бичээгүй ажээ. Нутгийн зураг тэмдэглэгээ цөөтэй. Нийт гурван сүм (Сайныг эрхэмлэгч сүм, Өлзий бататгагч сүм, Цэнгэл амаржуулагч сүм), урд ба хойд Тамир, Хүнүй, Хануй, Чулуут голууд болон 23 уул давааны нэрийг монгол ба хятадаар зэрэгцүүлэн хадаж бичсэн байна. Тэдгээрийн Өгөөмөр, Шарбулаг, Өвөр хошинт, Хөх даваа, Обосор, Гүдгэр даваа, Хормосго, Эг уул, Их даваа, Өлөнт, Бумбат, Хэртэнги, Дэлгэрмөрөн, Буурал, Даага нуруу, Нарст, Халзанбумбат, Цохиот гэсэн 18 уулыг монголоор, бусад 5-ыг хятадаар бичжээ.

Б. Нөгөө хоёр зураг Монгол улсын Үндэсний номын сангийн хөмрөгт хадгалагдаж байна. Эхнийх нь “Сайн ноён аймаг Сэцэн засаг хошой чин ван Наянтын хошууны нутгийн зураг” гэсэн нэртэй, 708/96 хадгаламжийн дугаартай. Уг нутгийн зургийг 68см х 62см хэмжээтэй муутуу цаасан дээр өнгө ялган зуржээ. 1987 онд Улсын Геодези зураг зүйн газраас эрхлэн гаргасан “Халхын Сайн ноён хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом”-д уг зургийг хэвлэн нийтийн хүртээл болгосон байдаг.<sup>96</sup> Чингэхдээ зургийн он, сар, өдөр дээр дарсан дундаа соёмботой “Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууг захирагч тамга”-ыг авчихсан байна.

Хоёрдахь нь мөн “Сайн ноён аймаг Сэцэн засаг хошой чин ван Наянтын хошууны нутгийн зураг” нэртэй, 8599/96 хадгаламжийн дугаартай, 58см х 67 см хэмжээтэй муутуу цаасан дээр өнгө ялгасан нутгийн зураг ажээ.

Харин эхний нутгийн зургийг Үндэсний номын санд бүртгэхдээ худамаар бичсэн “нэгдүгээр” гэдэг үгийг “есдүгээр” гэж буруу уншаад “Олноо өргөгдсний 19-р он” гэж алдаж бичжээ. Тийнхүү Монголын Үндэсний номын санд Сэцэн засгийн хошууны 1921, 1930 оны нутгийн зураг байгаа гэж бусдад ойлгогдохоор болжээ. Гэтэл угтаа 1921 онд хоёр хувь үйлдсэн нутгийн зураг юм.


Нэг өдөр буюу “Олноо өргөгдсний арван нэгдүгээр он найман сарын арван есөн”-д зурсан эл хоёр зурагт онцын гойд ялгаа байхгүй. Ялгагдах дөрвөн зүйл бий. Нэгт, нутгийн зургийн цаасны хэмжээ өөр өөр байна. Хоёрт, эхний зургийн өнгө арай тод бол хоёрдахь

<sup>96</sup> Халхын Сайн ноён хан аймгийн хошууны нутгийн зургийн альбом. УБ., 1987. т. 21

зураг арай цайвар харагдана. Гуравт, эхний зурагт хойд этгээдийн гаднах 4 тайлбар бичвэрийн 2-ыг шахаж бичсэн ахул хоёрдахь зурагт салгаж бичсэн. Дөрөвт, эхний зурагт зүүн этгээдэд Зая бандида хутагтын шавийн нутагтай хэрхэн залгах талаар бичсэн тайлбарыг зургийн он, сар, өдөрт тулган бичсэн бол хоёрдахь зурагт түүний доогуур хөндлөн бичсэнээрээ ялгагдана.


Үндэсний номын санд нутгийн зургийн уг эхийг судлаачдад цахимаар үзүүлдэг авч судалгаанд хэрэглэхээр өгдөггүй журамтай тул тэр хоёр зургийг харьцуулан харуулах боломжгүй байна. Эхний зургийг Улсын Геодези зураг зүйн газраас эрхлэн гаргасан альбомд хэвлэснээр энд үзүүлж байна. (зураг № 6-г үзнэ үү)

Зураг № 6. Сайн ноён аймаг Сэцэн засаг хошой чин ван Наянтын хошууны нутгийн зураг. (1921). Монгол улсын Үндэсний номын сан



Энэхүү хоёр нутгийн зургийн нэг онцлог бол 24 зүг чигийг нарийвчлан заадаг уламжлалт хүрд хэрэглээгүй, ердөө зургийн дөрвөн талд зүүн этгээд, өмнө этгээд, баруун этгээд, хойд этгээд гэсэн 4 тэмдэглэгээтэй. Чухам ийм учраас зүг чигийн баримжаа нилээд алдсан болов уу хэмээн бодож байна. Зурагт бичсэн “хойд этгээд” бараг л баруун зүгт, “өмнө этгээд” нь ерөнхийдөө зүүн зүгт байгаагаас (зураг № 7-г үзнэ үү) харахад дөрвөн этгээдийн тэмдэглэгээ үндсэндээ буруу болжээ.

. Зураг № 7. Сэцэн засгийн хошууны нутгийн зургийн зүг чигийн иймэрхүү байдалтай харагдана.



Мөн нутгийн зурагт хошууны захын овоодыг бүрэн гүйцэд тэмдэглээгүйн дээр бас дугаарлаагүй. Өөр бусад хошуудтай зах нийлэх газрын хоёр захын нуруудыг тэмдэглэсэн нь бүгд 16 нуруу юм.

Нутгийн зургийг 120 жижиг дөрвөлжинд багтаан зурсан нь босоогоор 10, хөндлөнгөөр 12 эгнээ байна. Манжийн эрхшээлийн үед хошууны нутгийн зургийг зурахдаа нэг бол 100, эсвэл 50 газар (1 газар–576 метр орчим) багтаасан дөрвөлжин хэрэглэдэг байв. 1913 онд Монгол Улс аймаг, хошуудынхаа нутгийг шинээр зуруулахдаа нэг дөрвөлжинд 20 газар багтаах болжээ. Тэр онд Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас бүх аймаг, хошуу, харуул, өртөөдөд нутгийн зургаа гурван хувь зурж ирүүлэхийг тушаан илгээсэн бичигт хэрхэн яаж зурах тухай өгүүлэхдээ “Нэг дөрвөлжин ямхын дотор хорин газар багтаан уул хадыг уул өнгийг аядуулах буюу хуучин удаагаар зурмуу”<sup>97</sup> хэмээжээ. Харин хожим 1918 оны үед батлагдсан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн Нутгийн зургийн хуульд “Гурван зуун жаран алд газрыг нэгэн газар, гучин зургаан алдыг нэгэн хувь, хувьд үл хүрэхийг алдын тоогоор хэмжиж хорин таван газрыг нэгэн ямхын хэмжээнд багтааж дөрвөлжин хүснэгт татаж”<sup>98</sup> зураг зурахыг заажээ. Уг нутгийн зурагт нэг дөрвөлжинд 20, эсэхүл 25 газрын алиныг багтаасныг тэмдэглээгүй байна.

Уг хоёр нутгийн зурагт уул бүрийн нэрийг бичсэн төдийгүй ой модтой уул гэдгийг нь харуулахын тулд ногооноор будаад ихэнх ууланд жижиг ногоон модыг дүрсэлжээ. Урд ба хойд Тамирын голын сав дагуух ой, бургастай шугуйг олон ногоон мод зурж харуулсан байна. Нутгийн зурагт тус хошууны нутгаар урсах урд Тамир, хойд Тамир, Хануй, Хүнүй

<sup>97</sup> Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яам. Монголын улсын Үндэсний төв архив. Х–А–3. д–1. Хн –499; Засагт хан аймгийн чуулган даргын жасаа. Монголын улсын Үндэсний төв архив. Х–А–47. д–1. Хн –38


<sup>98</sup> Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Дөчин нэгдүгээр дэвтэр. Өртөөний засаг. Дээд. Монгол улсын Үндэсний төв архив. Х–А–35. данс -1. Хн-47



Чулуут голуудыг нэрийг бичээд урсгалыг цэнхэр өнгөөр буджээ. Ингэхдээ урд, хойд Тамир, Хануй, Чулуутын голын эхэн урсгалыг салаалуулан мэдэгдэхээр зуржээ. Мөн Хөх нуурыг голын адил хөх өнгөөр будсан байна.

Нийслэл Хүрэнээс Улиастай хүртэлх 30 өртөөнөөс<sup>99</sup> Сэцэн засгийн хошууны нутагт орших Заан хошууны, Улалзай, Зуун мод, Галуут (зүүнээс баруун тийш дараалуулвал) гэсэн 4 өртөөний нэрийг бичээд эзэмшил газрыг нь зуржээ. Өртөөний сууринг тэмдэглэх уламжлалт гурвалжин Δ тэмдгийг тавиагүй ч өртөөдийн эзэмшил газрыг дугуй, зуйван хэлбэртэйгээр улаан зураасаар тойруулсан байна. (зураг № 8-ыг үзнэ үү)

Зураг № 8. Сэцэн засгийн хошууны нутгийн зурагт өртөөдийн нутгийг улаанаар тойруулан зуржээ.



Чингэж өртөөний нутгийг тойруулан зурах нь Монгол улсын үеэс нэг мөр болж жигдэрсэн зүйл болов уу. 1913 оны Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас нутгийн зургаа зурж ирүүлэхийг даалган илгээсэн бичигт “Хошуу ба харуул, өртөөний тойрныг цөм улаанаар зурмуу”<sup>100</sup> хэмээн журамласны дагуу нийтэд нь ингэж зурах болсон бололтой. Манжийн эрхшээлийн үед өртөөний нутгийг дугуйлан зурах нь цөөвтөр, ихэнхидээ тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй дүрсэлдэг байв. Мөн бичигт “Хуурай замыг шар өнгөөр зурмуу” гэж заасны дагуу өртөөний замыг шар өнгөөр буджээ.

Өртөөний хуяг, тэдний гэр бүлийн амьдран суух, албаны болон амины мал сүргээ бэлчээх эзэмшил газар тухайн хошууны нутаг дэвсгэрт харьяалагдах боловч тогтоосон зааг хязгаартай байдаг. Нийслэл Хүрээ–Улиастайн “өртөө тутам найман хуяг өрх, өрх тутам тоогоор байгуулсан албаны морь хорь, тэмээ тав, шүүс хонь хорь”<sup>101</sup> байсныг тэрхүү газарт маллан адгуулах ёстой.

Энд зурагдсан байдлаас харахад Заан хошууны өртөө хойд Тамирын голын газар, түүнээс баруун тийш Улалзай өртөө мөн Тамирын голын эхэн урсгалын газраар (одоогийн Улаалзайн давааны орчим ?) байв. Заан хошууны ба Улалзай хоёр өртөөний дунд хойд Тамирын голын хойд биед засаг ноёны өргөө, хошууны тамгын газрын Монгол гэр, асрыг

<sup>99</sup> Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Дөчин нэгдүгээр дэвтэр. Өртөөний засаг. Дээд. Монгол улсын Үндэсний төв архив. Х–А–35. данс -1. Хн-47

<sup>100</sup> Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яам. Монголын улсын Үндэсний төв архив. Х–А–3. д–1. Хн –499

<sup>101</sup> Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. Дөчин нэгдүгээр дэвтэр. Өртөөний засаг. Дээд. Монгол улсын Үндэсний төв архив. Х–А–35. данс -1. Хн-43

улаан өнгөөр зурж, хар бэхээр бичжээ. Хошууны засаг ноёны өргөөний баруун урдхан талд зэргэлдээ орших Сайныг эрхэмлэгч сүм, Өлзий бататгагч сүмийн барилга, хашааг улаан өнгөөр зуржээ. Улалзай өртөөний баруун хойно Хануйн голын эх хавиар Зуун мод өртөө, түүний баруун талд Галуут өртөө Чулуут голын эхэн урсгалын газраар тус тус оршиж байв.


1912 онд тус хошууны Ширээт гэгээн лам Монголын улсын Богд Жибзундамба хаанаас тамга авснаар түүний шавийн отог Шиваа Ширээт хутагтын шавь болон биеэ даасан нь эл нутгийн зурагт Чулуутын голын урсгалын газар дундаасаа өм цөм алга болсноос илт харагдана.

Тус нутгийн зураг нийт 169 бичвэртэйгээс 138 газрын нэр, голын нэр 6, нуур 1, булаг 6, сүм 3, өртөө 4, орд өргөө-2, хаагуур хэрхэн бусад хошуу, хутагтын шавьтай нутаг залган орших тэмдэглэл-13, зургийн нэр ба үйлдсэн он сар өдөр-2 байна.

Нутгийн зурагт тэмдэглэсэн байдлаас харахад Сэцэн засгийн хошуу нь зүүн талаараа Түшээт засгийн хошуутай 10 газар, Зая бандида хутагтын шавьтай 100 газар, Ачит засгийн хошуутай 90 газар, урдуураа Эрдэнэ бандида хутагтын шавьтай 40 газар, Дайчин засгийн хошуутай 60 газар, Цогтой засгийн хошуутай 40 газар, Номун хан хутагтын шавьтай 90 газар, баруун талаараа Эрдэнэ засгийн хошуутай 60 газар, Шивээ ширээт хутагтын шавьтай 150 газар, Далай засгийн хошуутай 40 газар, хойд талаараа Эетэй засгийн хошуутай 20 газар, Зая бандида хутагтын шавьтай 60 газраар нутаг нийлж байв. (Хавсралт № 1-ийг үзнэ үү) Хошууны нутгийн зах хязгаар нийт 760 газар (760 газар х576 метр =437.760 метр) байсан нь багцаагаар 437 километр гаран болох юм.

Энд хамгийн их сонирхол татаж байгаа нь Сэцэн засгийн хошуу зүүн талаар Түшээт засгийн хошуутай 10 газар (10 газар х576 метр =5760 метр) буюу 5 орчим километр газраар нутаг залгадаг тухай мэдээ юм. Халхын Сайн ноён аймгийн 1907, 1909 оны нутгийн зураг болон хожмын судлаачдын бүх зурагт тус хошууг зүүн талдаа Зая бандида хутагтын шавьтай зах нийлдэгээр зурдаг. Гэтэл Зая бандида хутагтын шавийн зүүн талд байх Түшээт засгийн хошуу уг хутагтын шавийн нутгийн дундуур Сэцэн засгийн хошуутай “Бага Халзангийн нуруунаас Их Халзангийн нуруу хүртэл арваны газарт” нутаг залгадаг байсан ажээ. Тэр хавь газар нь Хүнүйн голын эхэн урсгалын газар бололтой харагдаж байна. Сайн ноён хан аймгийн Сэцэн засгийн хошууны зах нийлэх хошуу, шавийн байрлалыг шинээр зурвал доор байдалтай харагдана. (зураг № 9-ийг үзнэ үү)

Зураг № 9. Сэцэн засгийн хошуу бусад хошуу, шавьтай хэрхэн нутаг залгаж байсныг шинэчлэн харуулав.



Энэ чухал мэдээ судлаач биднийг өөрсдийн үйлдсэн газрын зураг байгаа уг алдаатай хэсгийг засахыг зүй ёсоор шаардаж байна.

Хавсралт № 1. “Сайн ноён аймаг Сэцэн засаг хошой чин ван Наянтын хошууны нутгийн зураг” дахь бусад хошуу, шавьтай зах нийлэх талаарх бичвэр

- Эг даваанаас Зуун модны хяр хүртэл жарны газарт нэгэн аймаг жанжин Эрдэнэ чин вангийн хошуун лугаа савламуй.
- Цохиотын даваанаас Эг даваа хүртэл ерний газарт нэгэн аймаг Чин сүжигт Номун ханы шавь лугаа савламуй.
- Гүдгэрийн булуугаас Цохиотын даваа хүртэл дөчний газарт нэгэн аймаг хамаарсан чуулганы дарга Цогтой гүн Гомбосүрэнгийн хошуун лугаа савламуй.
- Хөх даваанаас Гүдгэрийн булуу хүртэл жарны газарт нэгэн аймаг чуулганы дарга Дайчин вангийн хошуун лугаа савламуй.
- Хошигтын нуруунаас Хөх даваа хүртэл дөчний газарт нэгэн аймгийн Эрдэнэ бандида хутагтын шавь лугаа савламуй.
- Нарийн Тээлийн нуруунаас Хошигтын нуруу хүртэл ерний газарт нэгэн аймаг Ачит гүн Довчинжамцын хошуун лугаа савламуй.
- Их халзангийн нуруунаас Нарийн тээлийн нуруу хүртэл нэгэн зууны газарт нэгэн аймаг Зая бандида хутагтын шавь лугаа савламуй.
- Бага Халзангийн нуруунаас Их Халзангийн нуруу хүртэл арваны газарт нэгэн аймаг Түшээт гүн Ширзагдын хошуун лугаа савламуй.
- Даагын нуруунаас Бага Халзангийн нуруу хүртэл жарны газарт нэгэн аймаг Зая бандида хутагтын шавь лугаа савламуй.
- Чулуут голоос Даагын нуруу хүртэл хорины газарт нэгэн аймаг Эетэй гүн Намсрайжавын хошуун лугаа савламуй.
- Шаварын баруун нуруунаас Чулуут гол хүртэл дөчний газарт нэгэн аймаг Далай чойнхор чин ван Цэдэнсономын хошуун лугаа савламуй.
- Хуурай Хануйгаас Бумбатын усаар хувааж Шар булаг, Нэрстийн нуруу дайруулан Аяга шанагын тээлийн баруун нуруугаар Чулуут голыг хойш гаталж Шаварын баруун нуруу хүртэл ерний газарт мөн шавь лугаа савламуй.
- Зуун модны хяраас Баянбулагийн баруун нуруу дайруулан Чулуут гол гаталгаж Их Тээлийн усаар хувааж Цахиуртын зүүн нуруугаар Хуурай Хануй хүртэл жарны газарт нэгэн аймаг Ширээт хутагтын шавь лугаа савламуй.

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба Архивын баримтын цуглуулга. ОУ-ын эрдэм шинжилгээний хурал. УБ., 2019.4.18-19.

Ж.Гэрэлбадрах\*

**Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын  
архивт буй нутгийн зургийн цуглуулга**

*ABSTRACT*

*The pictorial maps collection in Archives of the Agency of Land management, Geodesy and Cartography of Mongolia*

*The Archives of the Agency of Land management, Geodesy and Cartography of Mongolia has a valuable Mongol pictorial maps fund. By the decision of Soviet of Ministry (Government) of the Mongolian People's Republic to study, collect and print of old maps, a special fund of pictorial maps of the Mongols was created in the middle of 1980s. Some of the maps were published in 4 volumes in 1986 and 1987.*

\* МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч

gerelbadrakh@msue.edu.mn

*In the fund, totally 182 local maps are being preserved which included of old Mongolian aimags, banners, border guards, post-station. There are Setsen qan aimag of Qalqa-71, Tusheet qan aimag of Qalqa-52, Sain noyon aimag of Qalqa-38, Jibjundamba's Great sabi (buddhist admin. unit)-2, Qobd region-2, Barga banners of the Kulunbuir-2, border guards-11 and other maps-4.*

*In chronology, the earliest map belongs to 1780 while as the latest one is in 1927. These pictorial maps may be classified by their affiliation, chronology, material, colours, map scale and seal.*

*The Mongol pictorial maps, which is being preserved in Archives of the Agency of Land management, Geodesy and Cartography of Mongolia is become valuable sources to study of correction of territory dispensation of Mongolian aimags and banners, position main monasteries and post stations, road direction, state border guards and Qalqa-Barga border guards of 18<sup>th</sup> and early 20<sup>th</sup> centuries.*

**Түлхүүр үг:** нутгийн зураг, зургийн он цаг, харьяалал, үйлдсэн эд, хэмжээс

Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын архивт нутгийн зургийн нэгэн сайхан цуглуулга бий. Юуны өмнө тэдгээр Монгол нутгийн зургуудыг тусгай хөмрөг болгон энд цуглуулсан, хадгалах болсон түүхийг товч хэдий ч өгүүлэх хэрэгтэй.

1980 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс Монголын эртний аймаг, хошуудын нутгийн зургийг төвлөрүүлэн хадгалах тухай нууцын зэрэглэлтэй тогтоол гаргажээ. СнЗ-ийн 1980 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 149-р тогтоолын 7 дугаар зүйлд “БНМАУ-ын нутаг дэвсгэр, эртний аймаг, хошуудын нутгийн хуваарийг тогтоосон түүхийн холбогдолтой газрын зургуудыг нэгтгэн төвлөрүүлж, эмхэтгэн хадгалуулах зорилгоор Барилга-Архитектурын комиссын Улсын геодези, зураг зүйн газарт шилжүүлэхийг” НАХЯ болон ШУА-д даалгасан байдаг. Нууцын зэрэглэлтэй дээрх тогтоолын дагуу НАХЯ-ны харьяа Улсын Түүхийн Төв Архив, ШУА-ийн харьяа Улсын Төв Номын Сангийн сан хөмрөгт тус тус хадгалагдаж байсан Монголын аймаг, хошуудын нутгийн зургийг Улсын геодези, зураг зүйн газарт татан төвлөрүүлэн ажил эхэлжээ. Чингэж 1980-ад оны эхэн үед БНМАУ-ын Улсын геодези, зураг зүйн газарт Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн нэгдсэн сан хөмрөг бий болсон байна.

Төдий удалгүй Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн цомог хийх ажил эхэлжээ. Уг ажилд зохиолч, түүхч Лха.Дарьсүрэн аругайн тэргүүлэн Улсын геодези, зураг зүйн газрын ажилтан А.Суусар, Б.Рагчаа нарын 10 гаруй хүн оролцсон байна. Цомог хийх ажил 1984 оноос эхлэн явагдаж, нийт 5 дэвтэр цомог хэвлэн гаргажээ.

Эхний хоёр дэвтэр “Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом” (26 зурагтай), “Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом” (26 зурагтай) гэсэн нэрээр 1986 онд хэвлэгдэн гарав.<sup>102</sup> Удаах гурван дэвтэр 1987 онд гарсан нь Засагт хан аймаг (21 зурагтай), Түшээт хан аймаг (22 зурагтай), Сайн ноён хан аймгийн (32 зурагтай) хошууны нутгийн зургийн альбом юм.<sup>103</sup> Дээрх 5 цомогт,

- нутгийн зургийг 70 x 50 см хүрээнд багтаан хэвлэсэн,
- зарим хар цагаан нутгийн зургийг өнгөт болгосон,
- нутгийн зурагт буй уул, овоо, гол, нуур булаг, сүм хийд, гэр өргөөг араб тоогоор дугаарласан,


-тэрхүү дугаарын дагуу хуудам монгол бичгээс шинэ үсэгт хөрвүүлэн тусад нь жагсаан бичсэн зэрэг ажилбарууд хийгдсэн юм.

Нутгийн зургийн цомгийг өргөн олон нийтэд бус, албан хэрэгцээнд зориулан хэвлэснийг “нууц” гэсэн улаан өнгийн тэмдэг дарснаас харж болно. Эдгээр цомгийг Улсын геодези, зураг зүйн газарт цөөн тоогоор хэвлэсэн тул эдүгээ нүдний гэм болжээ.

<sup>102</sup> Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986, Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1986

<sup>103</sup> Халхын Засагт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Түшээт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987, Халхын Сайн ноён хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1987

Гэрэл зураг № 1. Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн зургийн цомог (1986-1987)




Монголын аймаг, хошуудын нутгийн зургийн цомгийг хэвлэсний дараагаас Улсын Түүхийн төв архив, Улсын Төв номын санд цөөнгүй нутгийн зургийг эргүүлэн өгсөн ажээ. Уг хөмрөгт Халхын Засагт хан аймгийн хошууны нэг ч зураг байхгүй нь тэр бүгдийг эргүүлэн өгсөн гэдгийг нотолно. Мөн анхнаасаа архив, номын сан хоёр нутгийн бүх зургаа шилжүүлэн өгөөгүй нь цомогт орсон нутгийн зургаас ямар нэгэн байдлаар мэдэгддэг. Харин авсан нутгийн зургуудыг буцаан өгч болох талаар Засгийн газрын ямар нэгэн тогтоол шийдвэр байдаггүй тул тухайн үеийн дарга, захирал нарын хоорондын тохироо, гэрээгээр хийгдсэн бололтой. Мөн нутгийн зураг олноор цугларч, нэгдсэн данс бүртгэл хийгдээгүй байсан тухайн цаг үеийн сул задгай байдлын улмаас цөөнгүй нутгийн зураг хувь хүмүүсийн гарт орсон байдаг.

Хэдий тийм алдаа завхрал гарсан хэдий ч БНМАУ-ын Улсын геодези, зураг зүйн газарт биеэ даасан нутгийн зургийн сан хөмрөг үлдэж хоцорчээ. Эдүгээ Улсын газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын архивт XVIII–XX зууны эхэн үеийн Монголын аймаг, хошуу, шавь, харуул, өртөөний нутгийн 182 зураг хадгалагдаж байна..

Тэдгээр нь Халхын Сэцэн хан аймаг, Түшээт хан аймаг, Жибзундамба хутагтын Их шавь, Сайн ноён хан аймаг, Ховдын хязгаар, Халх-Баргын харуул, Барга хошуу, харуул, өртөөний нутгийн зураг зэрэг юм. Хамгийн том нутгийн зурагт Сэцэн хан аймгийн 23 хошууны газар орны 123 см х 255 см хэмжээтэй даавуун зураг, удаад нь Түшээт хан аймгийн 21 хошууны 100 см х 171 см даавуун дээр зурсан зураг орно. Хамгийн олон тоотой нь Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зураг ажээ. Тэдгээр нутгийн зургийг харьяалах аймаг, он цаг, үйлдсэн эд, зурсан өнгө, хүрд болон ямар хэмжээс бүхий хүснэгт тор ашиглан зурсан зэргээр дэлгэрүүлэн авч үзье.


**Нутгийн зургийн харьяалал.** Уг сан хөмрөгт Халхын Сэцэн хан, Түшээт хан, Сайн ноён хан, Жибзундамба хутагтын Их шавь, Ховдын хязгаар, Хөлөн Буйрын харьяат Шинэ Барга хошуу, харуул, өртөөний нутгийн зургууд бий.

*Бүдүүвч № 4. ГЗБГЗГазрын архивт буй нутгийн зургийн харьяалал*




Халхын Сэцэн хан аймгийн хошуудын нутгийн зураг хамгийн олон нь юм. Сэцэн хан аймгийг бүхэлд нь зурсан нэг зураг бий. Сэцэн хан аймгийн 26 хошуунаас 18 хошууны 67 зураг, 3 гэр харуулын тус бүр 1 нутгийн зураг байна. Зарим хошууны нутгийн зураг 9 хувь байдаг. Харин тамгатай хутагтын шавийн нутгийн зураг байхгүй ажээ.

Бүдүүвч № 5. Сэцэн хан аймгийн нутгийн зураг



Түшээт хан аймгийг бүхэлд нь зурсан нутгийн зураг 4 байна. Түшээт хан аймгийн 21 хошуунаас 17 хошууны 44 зураг бий. Зарим хошуу 1-9 хүртэл нутгийн зурагтай нь он цагийн хувьд өөр өөр үед хамаарна. Харуул өртөөний бүдүүвч зураг нь гадуураа харуулын, дундаа өртөөдийн чиглэлийг зурж, нэрсийг бичсэн нийтэд тархсан зургийн нэг хувилбар юм.


*Бүдүүвч № 6. Түшээт хан аймгийн нутгийн зураг*



Халхын шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтын Их шавийн нутгийн зураг 2 байгаагийн нэг нь түүний 202 отгоос өөрийн гэсэн нутагтай Хар Дархад 3 отог шавийн нутгийн зураг, нөгөө нь Түшээт хан аймгийн Ахай засгийн хошууны нутаг дэвсгэр дээр орших Их шавийн отгуудаас тус хошуутай бэлчээр нутаг булаалдсан зураг юм.

Сайн ноён хан аймгийн 24 хошуунаас 11 хошуу, 8 тамгатай хутагтын шавиас 4 шавийн нутгийн зураг байна. Хошуудын нутгийн зураг 1-12 хүртэл бий. Хамгийн олон 12 нутгийн зурагтай нь Сайн ноён хан аймгийн Бишрэлт засгийн хошуу юм.

*Бүдүүвч № 7. Сайн ноён хан аймгийн нутгийн зураг*




Ар Монголын Ховдын хязгаарын нутгийн зураг 2 бий. Эхнийх нь Дөрвөдийн хоёр аймгийн нутгийн зураг юм. Удаах 1912 оны нутгийн зурагт Дөрвөд аймгуудаас гадна Ховдын хязгаарын бусад 17 хошуунаас Алтайн Урианхайн Зүтгэлт засгийн, Өөлдийн Үйзэн засгийн, Дамбийжаажанцан хутагтын шавь хошуу, Мянгадын Дайчин засгийн, Ховдын тариачин хошууны, хамгийн урд талын Захчин бэйлийн, Захчин гүний гэсэн 7 хошууны нутаг туссан байдаг. Халх-Баргын нутгийн хилийн харуул, Халхын хошуудаас Баргатай нийлэх зах нийлэх нутгийн 11 зураг буй нь 1841-1866 онд хамаарна. Хөлөн Буйрын Барга монголчуудын нутгийн зураг 2 байгааг манж хэлээр бичжээ. Бусад гэсэн ангилалд орж болохуйц 2 зураг байгаа нь язгууртны оршуулга, хулгайч этгээдийн оргосон зураг юм.

**Нутгийн зургийн он цаг.** Уг сан хөмрөгт буй 180 зургийн 123-т үйлдсэн огноо (он, сар, өдөр)-г тэмдэглэжээ. Хамгийн эхний зураг 1730-1742 оны хооронд үйлдсэн Халхын Түшээт хан аймгийн нутгийн бүдүүвч зураг бол, сүүлийнх нь 1927 онд хийсэн Монгол улсын Богд хан уулын аймгийн Их дулаан уулын хошууны нутгийн зураг юм. Тэдгээрээс 1907 онд хамгийн олон буюу 44 нутгийн зураг үйлджээ. Энэ нь Манжийн Шинэ засгийн бодлогыг явуулахад хэрэглэх зорилгоор нутгийн зургийг дахин зуруулах Манжийн хааны зарлиг 1907 онд гарсантай холбоотой. Түүний дараа 1805, 1913 он 9 зураг, 1849, 1900 онууд 7 нутгийн зургаар удаална. Нутгийн зургийг бичсэн оны дагуу жагсаавал бүдүүвч доорх байдалтай харагдана.

*Бүдүүвч № 8. Нутгийн зургийн он*





Үйлдсэн он цагийг тэмдэглээгүй нутгийн зураг 57 байна. Үүнээс нэлээд зургийн оныг хошууны засаг ноёны цаг хугацааг баримтлан ойролцоогоор тодорхойлов.

**Нутгийн зургийг үйлдсэн эд.** Монголчууд нутгийн зургийг их төлөв цаас, даавуун дээр зурдаг. Тус сан хөмрөгт буй нутгийн зургийн 152-ыг цаас, 28-ыг даавуун дээр зуржээ. Он цагийн эрхээр цаасан дээр зурсан цөөнгүй зургийн хадгалалтын байдал тааруу болж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй.

**Нутгийн зургийг үйлдсэн арга.** Энэ талаар жаахан тогтож хэлэхэд, нутгийн зургийг үйлдэхийн өмнө эхлээд түшмэд нутгаараа явж нарийн дэлгэрэнгүй цэс бичдэг. Нутгийн цэсийг бичихдээ хүрд ашиглан захын овоо хоорондын зүг чигийг тодорхойлж, зайг дээсээр хэмжинэ. Цэсэд хошууны захын овоод болон тэдний хоорондын зүг чиг, зайг заах төдийгүй нутгийн дотор буй уул овооны өндрийн хэмжээ, ямар мод ургадаг зэргийг бичиж тэмдэглэнэ. Цэс бэлэн болсны дараа нутгийн зургийг үйлдэнэ. Ингэхдээ зүг чигийн хүрд ашиглан нутгийн зургийг урд морь зүгээс эхлэн нар зөв тойруулан зурдаг. Тэрхүү хүрдээр дөрвөн зүг, найман зовхис, улмаар хорин дөрвөн зүгийг нарийн тодорхойлдог. Тус сан хөмрөгт хадгалагдаж байсан дийлэнхи нутгийн зургийг зүг чигийн хүрд ашиглан үйлдсэн байна.

**Нутгийн зургийн өнгө.** Тэдгээр Монгол нутгийн зургийн 161-т ямар нэгэн байдлаар өнгө ялгасан, өнгөт зураас орсон байдаг бол 19 нь дан хар цагаанаар зурагдсан байна. Ер нь Монгол нутгийн зургийн дийлэнхийг өнгө ялган зурдаг. Тухайлбал “Нуур ба гол булаг усыг цөм хөх өнгөөр зурмуу. Бэлчээр газрыг ногоон, элс ба говь шил газрыг бүдэг ягаан өнгөөр зурмуу” гэх зэргээр заасан байдаг. Нутгийн зургийн бичвэрийн тухайд 172 зураг монгол бичгээр, 8 зургийг манж бичгээр үйлдсэн ажээ.

**Нутгийн зургийн хэмжээсийн тор.** Монголын аймаг, хошуудын нутгийн зурагт хэмжээс (масштаб)-ийн дөрвөлжин тор татдаг байсан нь арай хожуу үед билээ. Тус сан хөмрөгт хадгалагдаж буй 94 нутгийн зурагт хэмжээсийн дөрвөлжин тор татсан бол 86 нутгийн зураг дөрвөлжин торгүй байна. Дийлэнх нутгийн зурагт нэг дөрвөлжинд хэдэн (100, 50, 25, 20) газар багтаасныг бичээгүй тул тухайн хошууны нутаг дэвсгэрээр

баримжаалан хэдэн газар (1 газар-576 метр) тооцож хийснийг тодруулах хэрэгтэй болж байна. Мөн хэмжээсийн торын хэмжээ харилцан адилгүй өөр өөр юм.

**Нутгийн зургийн тамга.** Уг сан хөмрөгт буй нутгийн зургийн 102-ыг тамга дарж баталгаажуулжээ. Зарим нутгийн зурагт тамгыг 1-8 удаа хүртэл дарсан байна. Харин 78 нутгийн зурагт тамга дарж баталгаажуулаагүй тул албан ёсны баримт хэмээн үзэхэд учир дутагдалтай. Гэхдээ тэдгээрт агуулагдаж буй мэдээлэл судалгааны чухал ач тустай.

Тус газрын архивын сан хөмрөгт хадгалагдаж буй зарим нутгийн зурагт захын овоодын дугаар, нэрийг бичилгүй тусад нь улаан өнгийн цаасан дээр бичиж наажээ. Энэ нь зургийн үндсэн бичвэрт буй бусад газрын дүрслэл, нэрийг дарах, эсхүл тэрхүү наалт цаас үрэгдэж алга болсноор мэдээлэлгүй хоцрох зэрэг сөрөг талтай. Мөн хөх ногоон өнгөөр бүх нутгийг нийтэд нь будсан зарим нэг нутгийн зураг тэрхүү гүн өнгөн дээр хараар бичсэн уул, усны зарим нэр гаргагдахгүй дутагдал дагуулна. Нэг хэсэг нутгийн зурагт захын овоодыг нэгдмэл байдлаар дугаарласан бол нөгөө нутгийн зургуудад дугаарлахгүйгээр нэрийг бичсэн, эсхүл зэргэлдээх хошуу тус бүртэй зах нийлэх овоодыг тусгайлан дугаарласан байдаг.

Нутгийн зургийг ихэвчлэн хавар, зун, намрын урин дулаан цагт үйлддэг байсан нь төгсгөлийн бичвэр—огноогоос харагдана. Учир нь түшмэд урин дулаан цагт хошууныхаа нутаг дэвсгэрээр явж цэс болон зургаа үйлддэг, мөн өмнө хийсэн зургаа нягтлан шалгаж шинэчилдэг байжээ. Өвөл нутгийн зураг үйлдсэн цөөн хэдэн тохиолдол бас цөөнгүй тааралддаг.

Нутгийн зургийн бичвэрт худам монголоор бичих дүрэм нэг мөр тогтоогүй, сургалтын нэгдсэн тогтолцоо байхгүй байсны улмаас, мөн бичээчийн чадвараас шалтгаалан үгийг алдаатай бичих, үгийн нөхцлийг буруу залгах зэрэг зөв бичих дүрмийн алдаа элбэг тааралдана. Үүнийг хэл шинжээчид тусгайлан судлах буй за.

**Монгол нутгийн зурагт буй мэдээллийн үнэ цэнэ.** Газар зохион байгуулалт, Геодези, зураг зүйн газрын архивт хадгалагдаж буй XVIII–XX зууны эхэн үеийн нутгийн зургууд нь Монголын аймаг, хошуудын нутаг дэвсгэр, газарзүйн төлөв байдал, нутгийн захын овоод, уул овоодын нэрс, зүг чиг, засаг ноёдын орд өргөө, гол сүм хийд, хилийн харуул, өртөө, замын чиглэл, Халх-Баргын нутгийн зах заагийг судлах түүхэн газарзүйн чухал сурвалж юм.

Монголчууд нутаг дэвсгэрээ хэд хэдэн удаа зурж үзэж баримжаа тогтож байсныг Сайн ноён аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зургийн хувирал өөрчлөлтөөс харж болдог. Тус хошууны нутгийн зураг 12 байгаагаас эхэн үеийн нутгийн 2 зурагт ямар нэгэн гарчиг, он цаг, ертөнцийн зүг зүгийг тавиагүй, нутгийнхаа цөөн хэдэн уул, нуурыг зурж бичсэн байдаг. Харин дараа дараагийн зурагт зүг чигээ тавьж, олон уул овоо, ус нуур зэргийг нэмэн зурж бүрэн гүйцэд дүрсэлж тэмдэглэх болсон байна.

Халхын аймаг, хошуудын нутгийн хил заагийг зарим үед чуулганаар хэлэлцэн тогтоодог байсныг нутгийн зурагт дахь тэмдэглэл бичвэр харуулна. Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зурагт бичсэнээр тус хошууны нутгийн дөрвөн захыг 1772 оны Ширээ нуурын чуулганаар тогтоож байсан ажээ. Энэ зөвхөн нэг хошууны талаарх мэдээ хэдий ч Халх Монголын бусад олон хошуудын нутгийг бас чингэж тогтоосон гэсэн үг билээ. Тодотгон хэлбэл, Халхын ноёдын Ширээ нуурын чуулганаар ганц хошууны нутгийг бус, олон хошуудын нутаг дэвсгэрийн зах заагийг тогтоожээ хэмээн үзнэ.

Мөн нөгөөтэйгүүр Монголын хошуудын нутгийн зах хязгаарыг тогтоох нь уг хэрэгтээ олон жил үргэлжилсэн үйл явц байсныг нутгийн зураг бүрэн нотолно. Бидний олонх судлаачид Монголын хошуудыг байгуулахад нутаг бэлчээр тасалж өгөөд хил заагийг тэр даруй тогтоож байсан хэмээн боддог нь өрөөсгөл ойлголт ажээ. Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошууны нутгийн зах заагийг тогтоох үйл явц Мөнгө, Сономцэмбэл, Пагважав, Чивагжав гэсэн дөрвөн засаг ноёныг дамнан 1742-1792 оны хооронд явагдсан байна. Бусад хошууд ч ийм үйл явцаас ангид байж чадаагүй нь илэрхий юм.

Хошууны засаг ноёдын угийн бичигт тухайн ноёны захирч байсан хошууны нутгийн дөрвөн захын газрыг тэмдэглэдэг байсан тухай мэдээг Бишрэлт засгийн хошууны нутгийн зурагт бичиж үлдээжээ. Энэ нь нутгийн зураг судлахад бусад бичгийн сурвалжийн мэдээг давхар ашиглахын чухлыг сануулж буй хэрэг юм.

Зарим үед зэргэлдээ орших хошуудын нутгийн зургийг нэг хүн зурдаг явдал байжээ. 1907 онд Халхын Сайн ноён аймгийн Сайн ноён Намнансүрэнгийн хошуу (9-р сарын шинийн 10), түүний урд талын Ёст засаг Балдангийн хошуу (9-р сарын шинийн 4), зүүн талын Илдэн засаг Дондовжанцангийн хошуу (9 сарын шинийн 3), хойд захын Мэргэн засаг Мөнх-Очирын (9 сарын шинийн 6) хошууны нутгийн зургийг нэг хүн зурж, бичсэн нь зургийн гарчиг, зурсан байдал, тайлбар бичвэрийн адил төстэй байдлаас илт мэдэгдэнэ. Морь унасан түшмэд долоо хоногийн дотор дөрвөн хошуугаар явж нутгийн зургийг үйлдсэн гэдэгт хэн ч үнэмшихгүй. Таамаглахул, Сайн ноён аймгийн чуулган даргын газарт хадгалж байсан дээрх хошуудын өмнөх нутгийн зургийг нэг хэлбэр болон бичлэгт оруулан шинэчлэн зурж, бичсэн байна. Чингэх болсны гол учир нь 1907 онд Монгол хошуудын нутгийн зургийг шинээр зурж ирүүлэх тухай Манжийн хааны зарлиг гарсныг биелүүлэх гэж яаравчилсантай холбоотой биз ээ.

1869, 1883 онд Ар Монголын баруун хойд нутаг дэвсгэрээс багагүй газрыг Хаант Орос улсад таслан өгснийг<sup>104</sup> Дөрвөд хоёр аймгийн нутгийн зургаас харж болдог. Мөн Дөрвөд хоёр аймгийн ноёдоос Дамбийжанцан хутагтад нутаг өргөж байсан, түүний эзэмшил болох “Ноён хутагтын шавь” хошууд байгуулсан зэрэг нь нутгийн зурагт тэмдэглэгдэн үлджээ.

Хошуудын нутгийн зургаас тэр нутагт адгуулж байсан албаны тэмээ мал, тариалангийн тухай мэдээг олж харна. Эл мэдээлэл нэн товч, тодорхойн дээр чухам байрлалыг нь зураглан харуулснаараа бичгийн мэдээнээс илүү ач тустай. 1868 оны үед Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин засгийн хошуунд 68 газар тариа тарьдаг байсныг ■ гэж тэмдэглээд “Монгол амуугийн газар” гэж бичжээ. Мэдээж тэдгээр нь ноёд язгууртнууд, сүм хийд лам нар, энгийн ардын “амь ульжих тариалан” байсан бололтой. XX зууны эхэн үед Эрдэнэ засаг Намсрайн хошууны 76 газар тариа тарьж байсныг улаан хүрэн өнгөөр зурж, хэний тариа болохыг бичсний дийлэнх хятад иргэдийнх, цөөнх нь Монголын сүм хийдийнх байв. Мөн аймгийн Түшээт засгийн хошууны нутаг дэвсгэрт албаны тэмээн сүрэг, Дөрвөдийн хоёр аймгийн нутагт албаны адуу адгуулж байсныг нутгийн зурагт тэмдэглэжээ.

Цөөнгүй нутгийн зурагт үндсэн дүрслэл, бичвэрийн гадуур дугуй хүрээ татаад 24 зүг чигийг дарааллын дагуу тойруулан бичсэн байдаг. Харин Түшээт хан аймгийн Үйзэн засаг Түдэвдоржийн хошууны нутгийн зурагт тэдгээрийг зүг (гахай зүг), өнгө (цагаагчин өнгө), өнцөг (эевэрхүү өнцөг), зовхис (мөнх зовхис) дөрвөөр тодотгон тэмдэглэсэн нь их онцлог юм.

Нутгийн зурагт уул нуруудын өндрийг газар, хувь, алд гэсэн уртын хэмжүүрээр бичихээс гадна өргөнийг бичсэн тохиолдол нэг бус удаа тааралдана. Түшээт хан аймгийн Үйзэн засаг Түдэвдоржийн хошууны нутгийн зурагт “Буурал хан уул, өндөр нь найман газар, өргөн нь таван газар таван хувь” гэх мэтээр том уул нуруудын өндөр болон үргэлжлэх урт өргөнийг хамтад бичжээ.

Зарим нутгийн зурагт тухайн хошууны нутаг дэвсгэрийг урдаас хойш, баруунаас зүүн тийш болон эргэн тойрон ямар хэмжээтэй, нийт хэдэн захын овоотой зэрэг нутгийн цэсэнд байдаг мэдээллийг товчоор бичиж оруулсан байдаг. Сонирхолтой нь, Түшээт хан аймгийн Бишрэлт засаг Сундуйн хошууны нутгийн зурагт баруун өмнөх зовхисоос зүүн хойдох зовхис хүртэл, баруун хойдох зовхисоос зүүн өмнөх зовхис хүртэл хэмжиж бичсэн байдаг.

<sup>104</sup> Ж.Гэрэлбадрах. XX зуунд Ар Монголын баруун хойд хил өөрчлөгдснийг нутгийн зургаар нягтлах нь. Акта Хисторика. т.XIX. УБ., 2018. т. 144-156

Дийлэнх нутгийн зурагт нэг бол уул нуруудын өндрийг, нөгөө бол тэдгээрийн үргэлжлэх уртыг өгүүлсэн байдаг ахул Сэцэн хан аймгийн Эрхэмсэг засаг Цэрэннямын хошууны 1897 оны нутгийн зурагт булаг, бүрд, голын урсацын үргэлжлэх уртыг газар, хувь, алдаар хэмжиж бичжээ. Цөөн нутгийн зурагт голын урсгалын чигийг зааж бичсэн байна. Сэцэн хан аймгийн Илдэн засаг Тогтохтөрийн хошууны 1864 оны нутгийн зурагт “зүүн этгээдээс баруун тийш урсах Халх гол” гэж бичжээ. Бас зарим хошууны нутгийн зурагт өөрийн нутгаар дайран явах гол замын уртыг бас хэмжиж бичсэн байдаг. Сэцэн хан аймгийн Хурц засаг Түдэнгийн хошууны 1907 оны нутгийн зурагт “энэ Их Хүрээний зам, нэг зуун дөчин хоёр газар” хэмээн бичжээ.

Их Юань улсын төгсгөл үед холбогдох Хэрлэн Барс хотын туурин дээр хоёр том суварга байсныг 1805 оны Сэцэн хан аймгийн Саруул засгийн хошууны нутгийн зургаас мэдэж авна. Одоо тэнд саяхан сэргээн засварласан ганц суварга буй. Мөн Сэцэн хан аймгийн Саруул засгийн хошуунд Чингис хааны хар сүлдийг Баян эрхэт уулын орой дээр хадгалж, тахиж байсныг ихэд бодит байдлаар зурж үлдээжээ.

Монгол нутгийн зураг түүхийн сурвалжийн нэг төрөл болохын хувьд бусад баримт бичигт буй алдаатай зүйлийг залруулж өгдөг ач тустай. Үүнд тухайлан хошууны засаг ноёдын нэр усыг дурдаж болох юм. “Монгол улсын илтгэл шастир”-т Түшээт хан аймгийн Эетэй засгийн хошууны ноён Агваандоржийн нэрийг Наваандорж хэмээн, Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошууны ноён Дондовжанцангийн нэрийг Дэндэвжанцан гэж буруу бичснийг тэдгээр хошууны нутгийн зургийн гарчигаас мэдэж авна. Хошууны нутгийн зурагт засаг ноёныхоо нэрийг буруу бичнэ гэдэг ямар ч үндэсгүй юм.

Манжийн засаг захиргаанаас Чуулалт хаалга-Улиастайн өртөө байгуулахдаа хошуудын нутаг дэвсгэрээс газар таслан өгснийг нутгийн зургаас тодорхой мэдэж авна. Түшээт хан аймгийн Эетэй засаг Агваандоржийн хошууны нутгийн зурагт өөрийн хошууны нутгаас “цэргийн өртөөдөд тавин олгосон нутгийн захад анх овоо тэмдэг байгуулах” болсон тухайгаа бичиж, тэдгээр захын овоодыг тэмдэглэсэн байдаг.

Монгол нутагт оршиж байсан өртөөний болон худалдааны замуудын нэр ус, явах чиглэл, суурин өртөөдийн байрлал, харьяалах нутаг бэлчээрийг тодруулах хамгийн чухал сурвалж нь хошуудын нутгийн зураг болж байна. Чуулалт хаалганаас Улиастай хүрэх гол өртөөний замын дагуух Түшээт хан, Сайн ноён аймгийн 13 хошууны нутгийн зургаас ямар өртөө аль хошууны нутагт, чухам хаана байсныг мэдэж тодруулна.

Халхын нутгийн зах хязгаарыг хятадууд нууцаар даван байгалийн баялаг ухаж олзворлох, ан хийх, ховор өвс ургамал түүх явдлыг зогсоохоор 1782, 1788 онд Алтайн нурууны урдуур говь цөл нутагт байгуулсан Алтны харуул чухам хаана байсныг хошуудын нутгийн зургаас харж болдог.<sup>105</sup> Алтны харуул нийт 20 байсны зүүн захын Хорсуун, Боом, Таац, Зулхунай гэсэн 4 харуул Сайн ноён аймгийн Ёст засгийн хошууны баруун өмнө хэсэгт, Эрдэнэ бандида хутагтын шавийн урд хэсэгт Бамбуу харуул байсныг тэдний нутгийн зурагт тэмдэглэсэн ажээ.

Нутгийн зургаас уул усны нэрийн хувирал өөрчлөлтийг тод томруун харж болно Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутагт буй Инэл уул (хайрхан) эдүгээ Дэлгэрхангай уул, мөн хошууны нутагт байх Хурган өлөн хэмээх нуур Улаан нуур гэх нэртэй болсон байна. Одоогийн Увс нуурыг тухайн Дөрвөд хоёр аймгийн нутгийн зурагт Усуб нуур гэж бичсэн байдаг нь хожим аман ярианы болон бичгийн хэлэнд Увс нуур болон хэлбэржин тогтжээ.

Дийлэнх хошууны нутгийн зурагт буй ганц нэг хуурамч мэдээллийг дурдах нь зүйн хэрэг билээ. Тэр нь “дөчин ламын ном унших газар” гэж бичээд жижиг дуган зурсан тэмдэглэгээ юм. “Дөчин лам” гэх хэллэг Манжийн төрөөс Монголд лам нар хэт ихэдснийг хязгаарлахаар нэг хошуунд байх ламын тоог 40-өөр тогтоосноос үүдэлтэйг бид мэднэ. Үнэн хэрэг дээрээ лам нар аль хэдийн 40-өөс хол давж, хүрээ хийд, сүм, ном унших газар

<sup>105</sup> Ж.Гэрэлбадрах. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. УБ., 2002. т. 148, 206

“жалгын нэг” болсон ч түүнийг нутгийн зурагт тэмдэглэдэггүй, албаны данс хараад бичилгүй явсаар ирсэн билээ. Мөн үүнийг нөгөө талаас нь, хошуудын гол хүрээ хийдийг зурж бичээд бусад хийд, сүм, дуган, хурлын газрыг тэмдэглэлгүй орхидог байсан гэж тайлбарлаж болох талтай. Дарьгангын сүрэгчин хошууны нутгийн зурагт 17 сүм, 3 хурлын газрыг зурж, нэр усыг тэмдэглэсэн нь ховорт тооцогдоно.

**Дүгнэлт.** Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газрын Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй нутгийн зургууд нь XVIII-XX зууны эхэн үеийн Халх Монголын аймаг, хошуудын нутаг дэвсгэрийн хуваарилалт, газарзүйн байдал, нутгийн захын овоод болон дотор буй уул овоодын нэрс, зүг чиг, дэс дараалал, засаг ноёдын орд өргөө, гол сүм хийд, өртөөдийн байрлал, замын чиглэл, хилийн гэр харуул, Халх-Баргын нутгийн харуулын байрлал, нутаг орны байдлыг судлах үнэт түүх, соёлын сурвалж хэрэглэгдэхүүн юм.

Ж.Гэрэлбадрах. Даавуун дээр зурсан монгол нутгийн зургууд (XVIII-XX зууны эхэн). Даавуун артай соёлын баримтад өвийн өнөөгийн байдал. ЭШ онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2019. т. 18-22

Ж.Гэрэлбадрах  
(МУБИС. Түүхийн тэнхим)

**Даавуун дээр зурсан Монгол нутгийн зургууд**  
(XVIII-XX зууны эхэн)

Монголын эртний нутгийн зураг монголчуудын эртний өвөг Хүннү улсын үеэс эхлэлтэйг бид мэднэ. Хятадын Хожуу Хань улсын түүхийн зохиолд Хүннү нар нутгийн зурагтай байсан талаар тэмдэглэсэн байдаг. Монголын Хятан улсад 1070 онд нутгийн зургаа зурсан байжээ.<sup>106</sup> Монголын эзэнт гүрний үе Их Юань улсын цагт тухайн цагийн дэлхийн нутаг дэвсгэрийг зурж байсан мэдээ бий. Ойрад монголчуудын байгуулсан Зүүнгар улсад нутгийн зургаа нарийн нягт зурдаг байсныг Галданцэрэн хаанаас Шведийн олзлогдсон офицер Ренатыг эх орондоо буцахад нь бэлэглэсэн нутгийн зураг гэрчилнэ. Уг зургийг хуулбар эх Монгол улсын Үндэсний номын санд хадгалагдаж байна.

Монгол улсад Үндэсний номын сан, Үндэсний төв архив, Улсын Геодези, зураг зүйн газар, Дундговь аймгийн Орон нутаг судлах музей болон соёлын дурсгал цуглуулагч хүмүүсийн сан хөмрөгт Монголын аймаг, хошуу, өртөө, харуулын нутгийн зургууд бий. Бас хилийн чанадад Монголын нутгийн зураг цөөнгүй байгаа нь Швед, ХНБГУ, Тайван, БНХАУ, Япон, Польш зэрэг улсын номын сан, их сургуулийн номын санд хадгалагдаж байна. Уг илтгэлд Монгол улсад хадгалагдаж байгаа XVIII-XX зууны эхэн үеийн нутгийн зураг, тэр дундаа даавуун дээр зурсан нутгийн зургийн талаар тогтож өгүүлнэ.


Юуны өмнө XVIII-XX зууны эхэн үеийн Монголын аймаг, хошуу, өртөө, харуулын нутгийн зургууд хаана, хэдэн тоогоор хадгалагдаж байгааг нэгтгэн харуулбал доорхи байдалтай болно. Үүнд,

Үндэсний номын сан = 380

Үндэсний төв архив =113

Улсын геодези, зураг зүйн газрын архив =171

Дундговь аймгийн Орон нутаг судлах музей =2. (Бүдүүвч № 1)



Монгол улсын Үндэсний номын сангийн сан хөмрөгт 380 нутгийн зураг хадгалагдаж байгаагийн 215 нь даавуун дээр, 2 нь торгон дээр, 163 нь цаасан дээр зурагдсан байна. (Бүдүүвч № 2)

<sup>106</sup> Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн альбом. УБ., 1986. т. 2



Архивын Ерөнхий газрын Үндэсний төв архивт Манжийн эрхшээлийн үеийн 1791-1909 онд хамаарах Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний 93 нутгийн (даавуу-1) зураг<sup>107</sup>, Монгол улсын цагт 1913-1921 онд үйлдсэн 20 (даавуу-6) нутгийн зураг<sup>108</sup>, нийт 113 нутгийн зураг хадгалагдаж байна. Тэдгээрээс ердөө 7 нь даавуун дээр, 106 цаасан дээр зурагдсан ажээ. (Бүдүүвч № 3)




Улсын геодези, зураг зүйн газрын сан хөмрөгт XVIII-XX зууны эхэн үеийн Ар Монголын аймаг, хошуу, харуул, өртөөний нутгийн 171 зураг хадгалагдаж байна. Тус сан хөмрөгт буй нутгийн зургийн 29-ийг даавуун дээр, 142-ыг муутуу цаасан дээр зуржээ. (Бүдүүвч № 4)

<sup>107</sup> Үндэсний төв архив. Хөмрөг- 460. д-1. Газрын зургийн цуглуулга хөмрөгийн Манж чин улсын үеийн байнга хадгалах баримтын данс. 1791-1909

<sup>108</sup> Үндэсний төв архив. Хөмрөг- 460. д-2. Газрын зургийн цуглуулга хөмрөгийн Богд хаант Монгол улсын үеийн байнга хадгалах баримтын данс. 1913-1989



Дундговь аймгийн Орон нутаг судлах музейд дурдан буй үеийн хоёр хошууны нутгийн зураг байгаагийн нэг нь Халхын Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошууны нутгийн 1891 онд даавуун дээр үйлдсэн зураг юм. (Зураг № 1)



Соёлын өвийг цуглуулагч хувь хүмүүст буй аймаг, хошууны нутгийн зургийг бүртгэхээр завдаж байгаа тул энд тодорхой тоо хэлэх боломжгүй байгааг та бүхэн болгооно буй за.

Ингээд Монгол улсад хадгалагдаж буй бүрэн бус тоогоор 666 нутгийн зургийн 252 даавуун дээр, 414 нь цаасан дээр зурагдсан байна. (Бүдүүвч № 5)





Хувиар тооцвол нийт нутгийн зургийн 38 хувь даавуун дээр, 62 хувийг цаасан дээр зурсан ажээ. Монголын аймаг, хошуу, өртөө, харуулын нутгийн зургийн багахан хэсгийг даавуун зурсан гэсэн үг юм. (Бүдүүвч № 6).



Нутгийн зургийг үйлдсэн эд түүний хадгалалтад их чухал нөлөөтэй юм. Монголчууд нутгийн зургийг их төлөв даавуу болон цаасан дээр зурдгийг бид бэлхэнээ мэднэ. Ажиглалтаас үзэхэд, даавуун дээр том хэмжээний зургийг их төлөв зурдаг байсан төлөв харагдана. Тухайлбал, 123 x 255 см хэмжээтэй цагаан даавуун дээр Халхын Сэцэн хан аймгийн 23 хошууны нутгийн газар орныг, 100x171 см хэмжээтэй цагаан даавуун дээр Түшээт хан аймгийн 21 хошууны нутгийн зургийг зурсан байдаг. Мөн нэг хошууг дангаар нь даавуун дээр зурах нь бий ч тэр харьцангуй цөөн юм.

Муутуу цаасан дээр зурсан ихэнхи зураг он цагийн эрхээр сэмэрч урагдах болсон тул хадгалалтын байдал тааруу байгааг хэлэх хэрэгтэй. Харин цагаан даавуун дээр үйлдсэн ихэнхи нутгийн зураг арай дээр байдалтай байна. Мэдээжээр даавуун дээр зурсан нутгийн зураг цаасан зургийг бодоход эвхэх, нугалахад хадгалалтын ая даадаг боловч байнга удаан хугацаагаар хадгалахад муудаж элэгдэх нь илэрхий билээ.

Тун ойрын үед бүх нутгийн зургийг хадгалах арга барилаа эрс өөрчлөх хэрэгтэй байна. Нутгийн зургийг эвхэж нугалж хадгалдагаа больж, дэлгэн тэнийлгэсэн байдлаар том хавтгай хавтсан хийж, өргөн тавиурт эсвэл шүүгээнд хийж байхгүй бол болохгүй байна. Ингэхгүй бол эвхэж нугалсан хэсгээрээ сэмрэх, урагдах, бүдгэрэх, түүнээс болэ тэр хэсэгт буй зурмал ба бичвэрийн зүйлс гаргагдахгүй болох зэрэг хүндрэлүүд үүсч байна.

Нутгийн зургийг зориулалтын дагуу дэлгэж хадгалахад дээр дурдсан номын сан, архивуудад газрын зургийн тусгайлсан нягтруулсан шүүгээ нэмж авах нэмэлт мөнгө санхүү шаардагдах болов уу.

Ж.Гэрэлбадрах\*

#### Дундговь аймгийн музейд буй хошууны нутгийн хоёр зураг

Монголын түүх, соёлыг судлах түүхэн сурвалж хэрэглэгдэхүүний нэг бол нутгийн зураг билээ. Монголчууд XVIII зууны үеэс хошуу нутгийнхаа зургийг өргөн дэлгэр зурж эхэлсэн юм. Нутгийн зургаас тухайн үеийн нутаг дэвсгэр, хошуудын нутгийн хил зааг, газар усны нэр, худалдаа, өртөөний зам, албаны мал сүрэг, тариалангийн газар, хүрээ хийд байрлал, захын овоодын байрлал зэрэг олон зүйлийг мэдэж авч болдог.

Монгол улсын 21 аймгийн музейгээс ганц Дундговь аймгийн музейн сан хөмрөгт дунд үеийн Халх Монголын хошуудын нутгийн зураг хадгалагдаж байна. Тэдгээр нь Манжийн эрхшээлийн үеийн Халх Монголын Түшээт хан аймгийн Дайчин засаг Төрболдын хошууны нутгийн зураг, Халхын Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг хоёр юм.

**А. Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошууны нутгийн зураг.** Халхын Түшээт хан аймгийн Дайчин засаг Төрболдын хошууны нутгийн зураг 56 см х 76 см хэмжээтэй, даавуун дээр зурсан зураг юм. Ү.67.1.36 бүртгэлийн дугаарт “Газрын зураг” гэсэн нэртэй хадгалагдаж байна. Нутгийн зургийн уг нэр нь “Түшээт хан аймгийн улсад туслагч гүнгийн зэрэг засгийн тэргүүн зэрэг тайж гурван зэрэг нэмсэн гурван зэрэг тэмдэглэсэн Төрболдын хошууны нутгийн газар орны зураг” юм. Уг нутгийн зургийг 1891 он (Бадаргуулт төрийн 17)-ы 9-р сард үйлджээ.

1923 онд хамжлагат ёсыг халсны улмаас аймаг, хошуудыг уулын нэрээр нэрлэх болоход Дайчин засгийн хошууг Богд хан уулын аймгийн Дэлгэрцогт уулын хошуу хэмээн өөрчлөн нэрийдэх болсон билээ. 1931 онд БНМАУ-д засаг захиргааны том өөрчлөлт хийж, хуучны аймгуудыг нийлүүлэн 13 аймаг болгоход тус хошуу Төв аймгийн нутагт орсон байна. 1942 онд Төв, Өмнөговь аймгаас 14 сум таслан Дундговь аймгийг байгуулахад түүний харьяанд орсон байна. Одоогийн Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Дэрэн, Говь-

---

\* Дуутан Ж.Гэрэлбадрах –МУБИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч

Угтаал, Баянжаргалан, Цагаандэлгэр, Гурвансайхан, Өндөршил, Луус, Төв аймгийн Баян-Өнжүүл, Баянцагаан сумдын өмнөд нутаг юм.


Уг нутгийн зургийг үйлдэхдээ зүг чигийн хүрдийг ашигласнаа тун дэлгэрэнгүй тэмдэглэн үлдээжээ. Тодруулж хэлбэл, нутгийн зургийн гадуур улаан тойрог татаад “хорин дөрвөн зүг чиг”-ийг улаан өнгийн бэхээр бичсэн байна.

Зүг чигийн хүрд. Тус хүрд 24 зүг чигийн нарийвчлалтай. Үүнийг хуваарь хэмээнэ. Хүрдийн 24 зүг нь Монголын 12 жилийн амьтан, 8 өнгө, дорнын зурхайн 4 хүлэлээс бүрдэнэ. Эл гурван зүйлийг дэлгэрүүлэн тоочвол доорх байдалтай болно. Үүнд,

12 жилийн амьтан: хулгана (хойд зүг), үхэр, бар, туулай (зүүн зүг), луу, могой, морь (урд зүг), хонь, бич, тахиа (баруун зүг), нохой, гахай,

8 өнгө: хар (эр өнгө), харагчин (эм өнгө), хөх, хөхөгчин, улаан, улаагчин, цагаан, цагаагчин, цагаагчин,

4 хүлэл: зогсолт (зүүн хойд зовхис) , оролт (зүүн өмнөд зовхис), иевэрхүү (баруун өмнөд зовхис), мөнх (баруун хойд зовхис)



Зургийн нэр гарчиг, он цагийн зэрэгцээ зүүн, баруун хоёрт талд нилээд дэлгэрэнгүй тайлбар бичснээрээ бусад хошуу нутгийн зургаас ялгагдана.

Зургийн нэр гарчгийн дараа эхлээд ямар хэмжээсээр, цаг улирлын зүг чигийг ашиглан зурсныг өгүүлжээ. Ингэхдээ “Зарлигаар тогтоосон мужийн зураг хэмжээний дүрэм зовхис тутам чигч тийш нэг зуун газар болгомуй, олон мужийн урт өргөн тийш адилгүй зовхисын үлэмж цөөнийг бодохгүй зургийн дүрэм их боловч бага боловч зүй нь энэхүү хэмжээ мөрдвөөс зохимуй. Бас олон мужид зураг зурж зовхис хувааваас цөм тэдгээрийн дүрмийг дагаж бодол зуруулж болохул хандсан тийш ташаарсан газаргүй газрын тоо нийлэлцвээс болмуй за хэмээснийг хичээнгүйлэн дагаж хянаваас харьяат хошууны нутаг газар орныг зураг доторх зовхисын хэмжээ өргөн уудам учир засаг түшмэд бид уг тогтоон заасан дүрмийг баримталж уул зургийг хураангуйлан зурахуйд морин үсгийг өмнөх болгож уул дөрвөлжин хэмжээний зовхис тутам нэг зуун газар болгон багтааж уул ус бичих нэр

тэргүүтнийг багтахыг хэрцүүлж чүгжлэн зуруулж зах тойрон нийлсэн газрын хоорондох зах хэлхээний нэр бүхий овоодын тоог зураг ба дагах цэсний сүүлд тодорхойлон бичиж басхүү зовхис хувааваас зохих хэмжээ тоог цаг улирлын бичгийн хорооны доторх хорин дөрвөн зүг чигт тохируулан газрын хэмжээ тоог зургийн өмнөх морин үсгээс эхэлж заасан дүрмийн ёсоор хандсан тийш тойруулан тэмдэглэж бичээд бусад нарийн өгүүллийг хойно жагсаан бичсэн нутгийн зураг” хэмээжээ.

Эл бичвэрт 1. уг зургийг Манжийн төрийн “Зарлигаар тогтоосон мужийн зураг хэмжээний дүрэм”-ийн дагуу нутаг дэвсгэрийн хэмжээсийн нэг дөрвөлжинд хаашаа хаашаагаа 100 газар (газар-576 метр) багтаан зурсан, 2. “хорин дөрвөн зүг чиг”-т тохируулан зурахдаа “морин үсэг” буюу морин зүг (урд зүг)-ээс эхлүүлснийг тус дурджээ. Мөн аливаа нутгийн зургийг нутгийн цэсийг дагалдуулан хамт өргөдөг, эсэхүл тэр хоёрыг хамтад нь хошууны тамгын газарт хадгалдаг байсныг дээрх бичвэрээс мэдэж болно.


Хошууны нутаг дэвсгэрийг бүтэн таван дөрвөлжин, долоон хагас дөрвөлжинд багтаан зуржээ. Нэг дөрвөлжинд 100 газар багтнаар багцаалан тооцвол тус хошуу урдаас хойшоо 450 орчим газар буюу 259 (259.200 м) километр урт, зүүнээс баруун тийш 144 (144.000 м) километр өргөн нутагтай байжээ.

Нутгийн зургийн төгсгөлд зах нийлсэн газруудад чулуугаар овоо тэмдэг байгуулсан, хошууны нутгаар хойшоо явж буй “Халхын өртөө”, баруун захаас нутаг таслан “Алтайн замын цэргийн өртөө” байгуулсан нь “Харчин” өртөө байсан, Их шавийн харьяат нартай хамт нутаглан суудаг, албаны тэмээ үржүүлэх зүүн анги байгаа, дөрвөн талдаа нутаг залгах хошуудын ноёд, байгаль орчны төлөв байдал, засаг ноён Төрболдын юуны учир улсад туслагч гүнгийн хэргэм хүртсэн, “дөчит лам”-ын суух сүмийг зурсан зэргийг өгүүлсэн байна.

Тэр нь “манай хошуу болбоос босоо тийш зах нийлсэн газруудад **чулуугаар овоо тэмдэг** байгуулж Жибзундамба хутагтын шавийн олон ард лугаа цэсийг дагаж хамт нутаглах ба, **Алтай замын цэргийн** Хэрийн жирэмээс Хөтөл долоон хүртэл бүгд долоон өртөөний өртөө цагдаа туслах улаагийн түшмэл хуяг цэрэг улаач нар Хүрээний өмнөх Халхын Наран өртөөнөөс Солгой хүртэлх долоон өртөөний түшмэл хуяг бас зүүн анги **тэмээ үржүүлэх адгуулах** занги хуягууд хамтаар нутаглан суумуй. Харьяат хошууны тайж ард уул газрын шим дөрвөн зүйл малын үржилд итгэж аж төрөн Дээдийн түргэн чухал албаныг залгамжлуулж хойд этгээдэд ван Одсэрбазар, гүн Наваанцэрэн, Пунцагцэрэн, зүүн этгээдэд Сэцэн хан аймгийн жанжин Цэрэнсандув, өмнө этгээдэд засаг Жамьянхорлоо агсан, баруун этгээдэд **Алтай замын цэргийн өртөөг** уул нутгийн зах дундуур байгуулж тусгай нутаг **таслан олгож** овоо тэмдэг боссон авч түшээ гүн Гадинпэл манай хоёр хошуу угаас замын дагуу савлан хэмжээлж гүн Мишигдорж нарын хошууд лугаа зах нийлж нутаглан суумуй. Бас харьяат хошууны нутаг их төлөв тал говь шал урсгал усгүй хужир дэрс элс үргэлжилсэн хахир хатуу газар болмуй. Ер уул газраас гарах алт мөнгөний зэрэг зүйлгүй гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж Тө би Бүрэнт засагчийн наймдугаар онд их цэргийн хэрэглэлд хонины үнэ мөнгө туслан барьсанд учирт улсад туслагч гүнгийн хэргэм нэмэн дэвшүүлснээс өөр урьд удаа дэвшсэн буурсан нэмсэн хассан зүйл үгүй. Хүрээний өмнөх **Халхын өртөө** зам **Харчин** Модон өртөөний зүүн этгээдээр орж уул хошууны нутгийн зүүн хойд этгээд Хонгилт уулын овооны зүүн этгээдээр гарч нэг аймгийн бэйс Пунцагцэрэнгийн хошууны нутаг орж одсноос гадна харьяат нутагт бүхий засаг тайж Тө миний албаны гэр ба дөчит лам нар суух сүм олон

өртөөд их зам зах нийлсэн газрын хил овоо тэмдэглэлийг уг дүрэмд нийлүүлэн зурсан явдлыг хамтаар гаргаж өргөн мэдүүлэв” хэмээн бичсэн байна. Монголын хошуудын нутгийн зурагт ингэж хоёронтоо тодорхой бичвэр хийсэн нь тун цөөхөн тааралддаг.

Нутгийн зураг №1. Түшээт хан аймгийн Дархан засгийн хошууны нутгийн зураг



Тус хошууны нутаг дундуур өмнөөс хойш чиглэх Тал долоон буюу Сайр уснаас Их Хүрээ рүү явах “Халхын” гэж тодотгосон өртөөний замыг улаан цэгэн зураасаар зурж, суурь өртөөнд уламжлалт гурвалжин  $\Delta$  тэмдэг тавьж, нэрийг бичжээ. Тэдгээр нь Солгой (soluyai), Билгэх (bilgekü), Баян хошуу (bayan qosiu), Даага (day-a), Тойром (toorim), Модон (modun), Наран (naran) гэсэн 7 өртөө юм. Эндээс Баянхэсэлгэх өртөөний өөр нэг нэрийг Билгэх, Борбүрэн өртөөнийх Даага байсныг мэдэж болно. Солгой өртөөний өмнөх Сүүж (seüji) өртөөг түүний урд талаар орших мөн аймгийн Түшээт засгийн хошууны нутагт байснаар тэмдэглэжээ.

Мөн хошууны нутгийн баруун урд талаар оршиж байсан “Алтай замын цэргийн өртөө” буюу Чуулалт хаалган-Улиастайн өртөөний “Харчин” хэмээх 7 суурь өртөөний замыг бас улаан цэгэн зураасаар зурж, нэрсийг тэмдэглэжээ. Тэдгээр нь Хөтөл долоон (kötüldolun), Тал долоон (taladolun), Модон (modun), Тамарбараа (tamarbaray-a), Шувуутай (sibiutai), Луус (luus), Хэрийн жирэм (kereyin jirim) зэрэг юм. Уг зургаас 1891 оны үед Алтай замын цэргийн өртөөний Харчин нарын хариуцсан хэсэгт Тамарбараа, Хэрийн жирэм гэсэн 2 өртөө байсныг мэдэж авна. Учир нь бусад зургуудад дээрх 2 өртөөг тэр бүр тэмдэглээгүй ажээ.

Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошууны нутгийн зургийн бас нэг онцлог нь захын овоодыг маш дэлгэрэнгүй бичсэнд байна. Бусад хошуудтай зах нийлэх газруудад “чулуугаар овоо тэмдэг” босгосон 89 овоо болон 5 усыг тодорхойлон бичсэн нь нийтдээ 94 болж байна. Харин тэдгээрийг дугаарлалгүйгээр дээд ба доод талд жагсаан бичээд нутгийн зураг буй тухайн газартай нь тасархай цэгээр холбожээ. Нөгөө нэг онцлог нь эл нутгийн зурагт өртөөдийг эс оруулбал ердөө 14 газрын нэрийг бичсэн нь бусад зургаас хэт цөөнд тооцогдоно. Тэдгээр нь Аварга овоо (aburqu obuγ-a), Хан жаргалан (qan jirγalang), Их газар (yeke γajar), Баянзүрх (bayan jirüke), гүн Төрболдын тамга (güng törübolud-yin tamaq-a), Дөчит лам нарын газар (döcütü lamanar-un γajar), Эмт ус (emtü usu), Бага газар (baγ-a γajar), Жаргалант хонгор (jirγalangtu qongqur), Улаан залаа (ulayan jalaγ-a), Баян бараат (bayan baraγatu), Их хаданцаг (yeke qadančay), Хайрхан уул (qayirqan uula), Бүрд (bүridү) зэрэг юм.

Нутгийн зургаа бага хэмжээтэй зурж, тун цөөн газрыг тэмдэглэсэн нь дөрвөлжин хэмжээст 100 газрыг багтаах гэж нутгаа арай их багасган зурснаас болсон болов уу хэмээн үзэж байна.

**Б. Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг.** Халхын Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зургийг 48 см х 48 см хэмжээтэй, муутуу цаасан дээр үйлдсэн ажээ. Нутгийн зурагт гарчиг, он цагийг бичээгүй. Бүртгэлийн дугаар Y.67.1.34 бөгөөд бүртгэлд буй нэр нь “Нутгийн тойм зургийн эх” юм. Муутуу цаас нь хадгалалтын улмаас дунд хэсэгт үйрч алга болсон тул зарим бичвэр харагдахгүй болжээ.

Энэ бол Халх Монгол даяар Боржигин Сэцэн вангийн хошуу гэдгээрээ ихэд алдаршсан нутаг юм. Тэнд Монголын их хаадын гарсан Боржигин овгийн соёлын улбаа болох Боржигин найрын дэг ёсыг саяхан хүртэл хадгалсаар ирсэн билээ.

Түшээт хан аймгийн нутагт Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг хадгалагдан үлдснийг зарим хүн гайхаж болно. Үүний тайлбар нь Сэцэн засгийн хошууны нутгийн өмнөд хэсэг одоогийн Дундговь аймгийн зүүн хойд талын сумдын (Баянжаргалан, Цагаандэлгэр) нутагтай залгаа байгаа тул нутгийн хүнээс дамжин ирсэн байж магадгүй юм.

1923 оноос Сэцэн засгийн хошууг Хан Хэнтий уулын аймгийн Оцолсансар уулын хошуу гэх болсон билээ. 1931 онд Дорноговь аймгийн Чойр, Даланжаргалан, Айраг сумдын нутагт орсон юм. 1994 онд Чойр сум Говьсүмбэр гэдэг тусгай аймаг болсон билээ.

Уг нутгийн зурагт эхлэлийн ба төгсгөлийн бичвэр байхгүй байгаа нь үүнийг бүрэн гүйцэд зураг биш хэмээн үзэхэд хүргэж байна. Угтаа зургийн эхэнд ямар аймаг, хошууны нутгийн зураг болох, төгсгөлд хэдэн оны хэдэн сарын хэдэнд зурсан болохыг бичээд тамга дарж баталгаажуулдаг билээ.

Нутгийн зураг № 2. Сэцэн хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутгийн зураг



Сэцэн засгийн хошууны нутгийн зурагт түүний нутаг дэвсгэрээр дайран гарсан олон замыг зурж тэмдэглэсэн нь түүний нэг давуу тал юм. Нийтдээ 7 замыг хар цэгэн зураасан шугамаар тэмдэглэснээс 2 зам нутгийн дунд хэсэгт нийлж байна. Хамгийн их сонирхол татаж буй нь зэргэлдээ (паралель) шулуун шугамаар зурсан зам юм. Энэ бол тухайн цагийн Хиагт-Их Хүрээ-Чуулалт хаалганы худалдааны гол зам агаад одоогийн Монгол улсаас БНХАУ хүрэх төмөр замын дагуу байсан ажээ.

Нутгийн зургийг үйлдэхдээ тодорхой хэмжээс бүхий улаан тор татсан нь нийтдээ 33 бүтэн дөрвөлжин, 20 хагас дутуу жижиг дөрвөлжин байна. Харин нэг дөрвөлжинд хэдэн газар багтаасныг тэмдэглээгүй тул тус хошууны нутаг дэвсгэрийг хэмжээг багцаа байдлаар гаргах боломжгүй болж байна.



Сэцэн засгийн хошууны нутгийн зураг Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошууны нутгийн зургийг бодвол уул, овоо, усны бичвэр ихтэй. Нийтдээ 250 газар усны нэр байгаа нь харьцангуй их мэдээлэлтэй нутгийн зураг тооцогдоно. Эдгээр нутгийн нэрс нь түүх, соёл, газрын нэрийн, орон нутаг судлалын чухал эх хэрэглэгдэхүүн болж өгнө.

Ш.Мөнхбаатар\*

**ХАЛХЫН ТҮШЭЭТ ХАН АЙМГИЙН ЭРДЭНЭ ЗАСГИЙН ХОШУУНЫ НУТГИЙН ГУРВАН  
ЗУРГИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ**


**Түлхүүр үг:** Нутгийн зураг, хилийн овоо, сүм хийд, өртөө зам

Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошуу 1694 онд байгуулагджээ. 1924 онд БНМАУ-ын Богд хан уулын аймгийн Зүүнбүрэн хан уулын хошуу гэж нэрээ өөрчилж 1931 онд татан буугдсан юм. Хошуу нутгийн түүхийг судлахад нутгийн зургууд чухал хэрэглэгдэхүүн болдог билээ. Эрдэнэ засгийн хошууны нутгийн зураг лавтайяа 6 бий. 1907, 1922, 1930 онуудад зурагдсан 3 зураг Монгол Улсын ҮНС-ийн сан хөмрөгт бүрэн эхээрээ хадгалагдаж байна. Уг өгүүлэлд тус гурван зургийн талаар товч өгүүлнэ.

№	Хошууны нутгийн зураг	Зургийн нэр	Он, сар, өдөр	Тамганы бичиг	Он	Хадгалагдаж буй
1		<i>tūsiyetū qan ayimay-un gūng namsarai-yin qosiyun-u nutuy-in jiruy</i>	<i>badarayultu törū-yin yučin yurbaduyar on</i>	Тамганы бичиг бүдгэрсэн.	1907	Монгол Улсын Үндэсний Төв номын сан, Германы Бонны их сургуулийн номын сан
2		<i>tūsiyetū sain ayimay-un šidar sayid erdeni čin wang namsarai-yin qosiyu</i>	<i>Olan-a ergūgdegsen-ū arban qoyarduyar on</i>	<i>tūsiyetū qan ayimay-un erdeni jasay qosiyun-u jakiruyči tamay-a</i>	1922	Монгол Улсын Үндэсний Төв номын сан

<sup>109</sup> Ш.Мөнхбаатар-МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн докторант [Mogi89181119@gmail.com](mailto:Mogi89181119@gmail.com)



3		<p><i>tüsiyetü wang ayimay šidar sayid erdeni čin wang namsarai-yin qosiyun-u nutuy-in jiruy</i></p>	<p><i>mongyol ulus-un 20 duyar on</i></p>	<p><i>Boyda qan ayula ayimay jegün būrin qan qosiyun-u jakiruyči tamay-a</i></p>	<p>1930</p>	<p>Монгол Улсын Үндэсний Төв номын сан, Улсын геодези, зураг зүйн газар. Халхын Түшээт хан аймгийн хошуудын нутгийн зургийн альбом. УБ., 1986</p>
---	---	--	---	--	-------------	---

1. *tüsiyetü qan ayimay-un güng namsarai-yin qosiyun-u nutuy-un jiruy* (Түшээт хан аймгийн гүн Намсрайн хошууны нутгийн зураг) гэсэн нэртэй бор цаасан дээр хар бэхээр зурсан зураг юм.

Нутгийн зураг 74 см х 75 см хэмжээтэй. Зургийн зүүн дээд буланд бүртгэлийн дугаарыг “912(517.3).Т.924” гэж ягаан өнгийн бэхээр бичсэн. Энэ зургийн одоогийн бүртгэлийн дугаар нь 835/96. 4880 юм.

Тус нутгийн зургийн зүүн дээд буланд Бадаргуулт төрийн гучин гуравдугаар он таван сарын арван есөн (1907) гэж бичээд тамга даржээ. Эл зурагт нийт 6 тамга дарсан байна. Тамга 11 х 11см хэмжээтэй, бичиг нь бүдгэрсэн тул унших боломжгүй болжээ.

Зургийг тойруулан улаан шунхаар дугуй хүрээ татаж, нутгийн зураг зурахад хэрэглэдэг зурхайн хүрдний зүг чигийг заасан морь (урд зүг), туулай (зүүн зүг), тахиа (баруун зүг), хулгана (хойд зүг) зэрэг 4 зүг, 4 зовхис, 8 өнгө, 8 өнцгийг (Хүснэгт №1 үзнэ үү) тойруулан тэмдэглэжээ. Дотор талд нь өмнө зүгээс эхлэн 43 овоог дугаарласан (Хүснэгт №3 А-г үзнэ үү) ба овоог дугуй дотор цэг хатгах байдлаар зуржээ.

Хошууны нутгийн зургийг фү-гийн дүрэм хэмжээгээр нэг дөрвөлжинд 50 газар гэсэн хэмжээсээр тооцож, сүм хийд, гол мөрөн, нуур, уул нуруу, булаг, өртөө зам, захын овоо, ноёны өргөөг зохих тэмдгээр дүрсэлсэн байна. Бадаргуулт төрийн 17-р он (1891)-д гарсан “Зарлигаар тогтоосон Дайчин улсын хураангуй хууль бичгийн зураг” -т буй “Газрын зургийн зүүн дээд талыг хойд зүг, доод талыг өмнө зүг, зүүн талыг баруун зүг, баруун талыг зүүн зүг гэж үзнэ”<sup>110</sup> гэсэн газрын зураг зурах аргачлалын дагуу хийжээ.

Уг нутгийн зургийг яаж зурсан, тэр нь одоо цагийн хэмжээстэй хэрхэн дүйж буйг тодруулж болохоор байгаа юм. Нэг дөрвөлжинд 50 газар (1 газар -576 метр) багтаасан уг хэмжээсийг баримтлан тооцвол, Эрдэнэ засгийн хошуу хойноос урагш 9,3 дөрвөлжин буюу 267 километр (9.3 х 50 газар х 576 метр = 267.840) урт болохоор байна. Өнөөгийн Монгол Улсын газрын зургийн хэмжээсээр үзвэл тус хошууны нутаг уртрагийн дагуу буюу хойд захын Баруун Асгатын овооноос (Сэлэнгэ аймгийн Түшиг сум) өмнөд цэг Хараа голын адаг (Сэлэнгэ аймгийн Баянгол сум) хүртэл 145 километр байгаагаас харахад фү-

<sup>110</sup> А.Камимүра, Монголын хошуу нутгийн зураг зүйн хувьсал ба Чин улсын Монголын захиргаа.

//Фүтаки.Х, Камимүра.А, Равдан.Э. Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд. УБ., 2012. т.8

гийн дүрмээр зурсан хэмжээс нилээд алдаатай нь харагдана. Энд лавтайяа 120 километрийн зөрүү байна.

Тус нутгийн зүүнээс баруун хүртэлх хэмжээ өргөргийн дагуу Шаргалт, Зэлтэр (Сэлэнгэ аймгийн Түшиг сум) хоёр голын бэлчирээс Манхай, Хурих (Сэлэнгэ аймгийн Ерөө сум) хоёр голын бэлчирийн овоо хүртэл 15 дөрвөлжин буюу 432 километр (15 х 50 газар х 576 метр= 432,000) байна. Одоогийн газрын зургийн хэмжээсээр бол дээрх нутгуудын хооронд 245 километр байгаа юм. Энэ хооронд 180 гаруй километрийн зөрүү гарч байна. Үүнээс уг нутгийн зургийн хэмжээс алдагдсан, бодитой биш хэмээн дүгнэж болохоор байна.

Уг хошууны нутгийн зурагт бүтэн дөрвөлжин хавтгай 87, хагас хавтгай 20 байна. Хагас хэсгүүдийг нэгтгэвэл 10 бүтэн хавтгай болохоор байгаа юм. Эрдэнэ засгийн хошууны 97 дөрвөлжин нь 139.680.000 хавтгай дөрвөлжин метр (97 х 50 х 50 х 576 =139.680.000 ) буюу 139.680 хавтгай дөрвөлжин километр нутаг болох билээ.

Нутгийн зурагт нийтдээ 94 уулыг ногоон өнгөөр зурж, 17 уулын нэрийг хар бэхээр бичжээ. Уулсын тогтоц, хэв шинжийг харуулах маягаар дуурайлгасан болов уу гэлтэй зурж, зарим уулын ард өндрийн хэмжээг тавьжээ. Үүнийг метрийн хэмжээст шилжүүлж болно. Тухайлбал:

1. Банх уулын өндөр нэг газар (576 метр)
2. Сайхан уулын өндөр нэг газар (576 метр)
3. Бүрэн уулын үргэлжилсэн нурууны өндөр гурван газар (1728 метр)
4. Цог-Өндөр уулын өндөр хоёр газар (1152 метр)
5. Ноён уулын өндөр нэг газар (576 метр)
6. Жаргалант уулын өндөр гурван газар (1728 метр)
7. Товхор хан уулын өндөр гурван газар (1728 метр) Суврага уул хүртэл үргэлжилнэ.
8. Суврага уулын өндөр хоёр газар (1152 метр)
9. Тулган уулын өндөр гурван газар (1728 метр)
10. Сэлмэн уулын өндөр гурван газар (1728 метр)
11. Шоргоолжин Өндөр уул өндөр нь таван газар (2880 метр)
12. Май уулын өндөр таван газар (2880 метр)
13. Чамаган уулын өндөр гурван газар (1728 метр)
14. Цайдам уулын өндөр нэг газар (576 метр)
15. Жаргалант уулын өндөр хоёр газар (1152 метр) гэжээ. Харин Тужийн

нарс болон Зүүн нарсын өндрийг бичээгүй байна. Эдгээр уулсыг 2011 оны Сэлэнгэ аймгийн 500.000 хэмжээстэй газрын зургаас хайж үзэхэд 9 уул олдож байгаа юм. Зургаас олдоогүй зарим уулын нэр 100 гаруй жилийн дотор өөрчлөгдсөн байж болох талтай. Аль эсвэл газрын зурагт тухайн уулын нэрийг тэмдэглээгүй үлдээсэн ч байж болох юм.

Нутгийн зургаас сүм хийд, суурин газар, уул нуруудын байршлыг баримжаалан олоход гол мөрөн, нуур чухал байдаг. Уг нутгийн зурагт ганц нуур тэмдэглэсэн байгаа нь *цагаан нуур* (Цагаан нуур) юм. Одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд бий. Гол, нууыг уламжлалт аргаар цэнхэр өнгөөр угалзлуулан зурж, хар бэхээр нэрийг бичжээ. Фүгийн хэмжээсийг баримтлан гол мөрнийг зурсан нь урсацын талбайг олж болохоор байна. Тухайлбал:

1. Сэлэнгэ гол 7 хавтгай дөрвөлжин ( 201 км 600 м)
2. Орхон гол 6,5 хавтгай дөрвөлжин (187 км 200 м )
3. Хараа гол 5,5 хавтгай дөрвөлжин (158 км 400 м )
4. Ерөө гол 4 хавтгай дөрвөлжин (115 км 200 м )
5. Хурхын гол 4 хавтгай дөрвөлжин(115 км 200 м )
6. Бугат гол 2 хавтгай дөрвөлжин (57 км 600 м )
7. Шар гол 1,5 хавтгай дөрвөлжин (43 км 200 м )
8. Мухар гол 1,5 хавтгай дөрвөлжин (43 км 200 м )

9. Элбэг гол 1,5 хавтгай дөрвөлжин (43 км 200 м )

10. Хөшөөтийн гол 1 хавтгай дөрвөлжин (28 км 800 м) байх ажээ. Нийт 15 голыг тэмдэглэжээ. Үүнийг 2011 оны Сэлэнгэ аймгийн 1:500.000 хэмжээтэй газрын зургаас хайж үзэхэд 5 голын нэр огт мэдэгдэхгүй байна. Гол мөрний нэр өөрчлөгдөх нь ховор байдаг. Тиймээс уг голууд 100 гаруй жилийн хугацаанд багассан эсвэл ширгэсэн байж болох талтай.

Эрдэнэ засгийн хошууны нутгийн дундуур Их Хүрээ-Хиагт чиглэлийн өртөө зам дайран гардаг билээ. Тус хошууны онцлог бол Хаант Орос улстай шууд хил залгаж, худалдаа арилжаа, ахуй соёлын гол зангилаа болсон газар байв.

Нутгийн зурагт өртөө замыг хүрэн өнгийн цэгээр тасалдуулан зуржээ. Өртөөний сууринг Δ гурвалжин дүрсээр тэмдэглэж, хүрэн өнгөөр буджээ. Эдгээр суурин өртөө нь урд талаасаа *nomtu ᠔rtege* (Номт өртөө), *deresūtū bulung ᠔rtege* (Дэрст булан өртөө), *irūge yool ᠔rtege* (Ерөө гол өртөө), *narin moyai ᠔rtege* (Нарийн могой өртөө), *giluyan nayur ᠔rtege* (Гялаан нуур өртөө) юм. Нутгийн зургийн хэмжээсээр баримжаалбал суурин өртөө хоорондын зай 1,5 дөрвөлжин хавтгай байгаа нь 43 километр (1.5 x 50 x 576 метр= 43.200) болно. Энэ нь өртөөний хэмжээг нилээд алдаж тэмдэглэснийг харуулж байна. Учир нь өртөөний дундаж зай 25-32 километр байдаг.

Хошууны засаг ноёны тамгын газар буюу гүн Намсрайн гэрийг Цагаан нуураас баруун урагш Сэлэнгэ мөрний бэлчирт (одоогийн Сэлэнгэ аймаг Цагааннуур сум Хуурч баг) тэмдэглэсэн байна. Чингэхдээ монгол гэр зураад хүрэн өнгөөр буджээ.

Сүмүүдийг нэгэн ижил загвараар зурсан ба хар бэхээр зурж, хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Зургийн баруун дээд буланд Товхор хан уулын бэлд “Жибзундамба хутагтын харьяат Өршөөлийг соёрхогч сүм” (одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Оргих, Хуурч багийн нутаг)-ийг тэмдэглэжээ. Цагааннуурын зүүн талд Ноён уулын бэлд “Дөчит лам нарын ном унших сүм” (одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум Хуурч баг)-ийг тэмдэглэжээ. Зургийн баруун урд буланд Бүрэн уулын бэлд “Жибзундамба хутагтын харьяат Амарбаясгалант сүм” (одоогийн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум Ивэн баг)-ийг, мөн “Жибзундамбын Дашчоймбалан сүм” (одоогийн Дархан-Уул аймгийн Шарын гол сум)-ийг Шарын голын бэлчирт тэмдэглэсэн байна. Нөгөө нэг сүм болох “Жибзундамба хутагтын харьяат Дашчойнхорлин сүм” (одоогийн Сэлэнгэ аймаг Ерөө гол Баянцагаан баг)-ийг Ерөө голын хөндийд, Халиар уулын баруун талд “Жибзундамба хутагтын харьяат Дашчойнхорлин сүм” (одоогийн Сэлэнгэ аймаг Сайхан сум Номгон баг)-ийг тус тус дүрсэлсэн. Ийнхүү тус хошуу нутгийн зурагт 6 сүм, 1 тамгын газрыг тэмдэглэжээ.

Нутгийн зурагт буй захын овоогоор баримжаалан зэргэлдээх хошуу нутгуудыг мэдэх боломжтой ажээ. Тус хошуу урд талаараа Баатар засгийн хошуутай, баруун талаар Ахай засгийн хошуутай, хойд талаараа гэр харуулын нутагтай, зүүн талаар харуулын нутагтай савлана. Уг хошууны нутгийн зурагтай ижил зураг Герман улсын Боннын их сургуулийн номын санд хадгалагдаж байна.<sup>111</sup>

Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошуу нь мал аж ахуй, газар тариалан эрхэлэхэд тохиромжтой, зүүн тийш сунаж тогтсон байдалтай, газар нутаг нь ой хөвчит уулс, гол мөрнөөр баялаг юм. Эдгээр газарзүйн биетүүдийг дээрх нутгийн зурагт дэлгэрэнгүй дүрслэн үзүүлжээ.

2. *tūsiyetū sain qan ayimay-un šidar sayid erdeni čin wang namsarai-yin qosiyu* (Түшээ сайн хан аймгийн Шадар сайд Эрдэнэ чин ван Намсрайн хошуу) гэсэн нэртэй, бор даавуун дээр хар бэхээр зурж талбайг цэнхэр ногоон өнгөөр дүүргэн будсан нутгийн зураг Монгол Улсын ҮНС-ийн гар бичмэлийн сан хөмрөгт бий.

Уг зураг 142 см x 112 см хэмжээтэй. Зургийн зүүн дээд буланд ягаан өнгийн бэхээр бүртгэлийн дугаарыг 912(517.3)T924 гэж бичжээ. Энэ зургийн одоогийн бүртгэлийн дугаар

<sup>111</sup> Walther Heissig. Mongolische Ortsnamen. Franz Steiner Verlag GMBH-Wiesbaden. 1966. p.729

нь 938/69 4932 юм. Нутгийн зургийн зүүн дээд буланд Олноо өргөгдсөний арван хоёрдугаар он (1922) хоёр сарын хорин долоон гэж бичээд тамга дарсан байна. Эл зурагт нийт 5 тамга даржээ. Тамганы хэмжээ 10,5 см х 10,5 см юм. Тамган дээр *tüsiyeü qan ayımay-un erdeni jasay-un qosiyun-u jakıruyıcı-yin tamay-a* (Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны захирагч тамга) хэмээн бичжээ. Чингэхдээ зургийн баруун дээд буланд гарчиг дээр, зургийн зүүн дээд буланд огноо дээр, зургийн доод хэсэгт тус тус даржээ. Улаан шунхаар дугуй хүрээ татаж, нутгийн зураг зурахад хэрэглэдэг зурхайн хүрдний 24 зүгийг тойруулан тэмдэглэжээ (Хүснэгт №1 үзнэ үү).

Хошууны нутгийн зургийг фү-гийн дүрэм хэмжээгээр нэг дөрвөлжинд 20 газар гэсэн хэмжээсээр тооцож тэмдэглэсэн<sup>112</sup> ба зурагт нийт бүтэн дөрвөлжин 152, тал хавтгай 26 байна. Энэ нь 165 бүтэн дөрвөлжин болох юм. Намсрайн хошууны нийт хэмжээ 38.016 хавтгай дөрвөлжин километр (165 х 20 х 20 х 576 =38.016.000) газар нутагтай болж байна. Өмнөх зурагнаас даруй 37.876 хавтгай дөрвөлжин км бага юм.

Эл нутгийн зурагт нийт 13 голыг зурж, нэрийг нь хар бэхээр бичжээ. Голыг цэнхэр өнгөөр будаж, урагш урсаж буйгаар дүрсэлжээ. Нутгийн дундуур урсах голын урсацын хэмжээг мэдэх боломжтой. Тухайлбал:

1. Орхон 9 дөрвөлжин (103 км 680 м)
2. Сэлэнгэ 8 дөрвөлжин (92 км 160 м)
3. Хараа 6 дөрвөлжин (69 км 120 м)
4. Ерөө гол 5 дөрвөлжин (57 км 80 м)
5. Шарын гол 4 дөрвөлжин (57 км)
6. Хурхын гол 4 дөрвөлжин (57 км)
7. Хүйтэн гол 3 дөрвөлжин (34 км 560 м)
8. Хар гол 2 дөрвөлжин (23 км)
9. Ивэн гол 2 дөрвөлжин (23 км)
10. Манхтай гол 2 дөрвөлжин (23 км)
11. Мухар гол 1 дөрвөлжин (11 км 520 м)
12. Элбэг гол 1 дөрвөлжин (11 км 520 м)
13. Хөшөөтийн гол 1 дөрвөлжин (11 км 520 м) болж байна.

Богдын булаг, Тойрог булаг, Сахиралт булаг зэрэг гурван булгийн нэрийг бичсэн байна.

Тус нутгийн зурагт уулсыг урд талаас нь харсан байдлаар зурж, ногоон өнгөөр буджээ. Уулсын хэв шинжүүд хоорондоо адилгүй харагдана. Нийт 66 уул зурсан ба 17 уулын нэрийг хар бэхээр бичиж, 15 уулын өндрийн хэмжээг тэмдэглэснийг метрийн хэмжээсээр тооцож үзэхэд дараах байдалтай. Үүнд:

1. Май уул өндөр таван газар (2880 метр)
2. Чамган уул өндөр гурван газар (1728 метр)
3. Банхын уул өндөр нэг газар (576 метр)
4. Сайхан уул өндөр нэг газар (576 метр)
5. Бүрэн уулын үргэлжилсэн нурууны өндөр гурван газар (1728 метр)
6. Товхор хан уул өндөр нь гурван газар (1728 метр) Суварга уул хүртэл үргэлжилнэ.
7. Сэлмэн уул өндөр гурван газар (1728 метр) энэ уул Долоон уултай үргэлж
8. Хүдэр уул өндөр нь таван газар (2280 метр)
9. Цайдам уул өндөр нь нэг газар (576 метр)
10. Авгуулант уул өндөр нь хоёр газар (1152 метр)
11. Долоон уул өндөр нь гурван газар (1728 метр)
12. Цог өндөр уул өндөр нь хоёр газар (1152 метр)
13. Ноён уул өндөр нь нэг газар (576 метр)
14. Аргалант уул өндөр нь гурван газар (1728 метр)

<sup>112</sup> Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны өргөх цэс. МУҮНС.441/96-912(517.3) т-834

15. Халиар уулын өндөр хоёр газар (1152 метр) хэмээн тэмдэглээд Зүүн нарс болон

Тужийн нарсын өндрийн хэмжээг бичээгүй. Эдгээрийг ташуу зураасаар тэмдэглэсэн нь уулсын хэв шинжээс ялгаж дүрсэлсэн мэт. Мөн Шарын гол, Ерөө голын дунд тариан талбай, бэлчээрийн талбайг зурсан нь өмнөх зургаас онцлог болох юм.

Улаан хүрэн өнгөөр 2 гэр зурсан ба хоорондох зай нь хагас дөрвөлжин (5 км 760 м) юм. Эхний гэрийг *sayid erdeni wang sayuqu-a alban-u yajar* (сайд Эрдэнэ ван суух албаны газар) гэжээ. Хойно нь буй удаах гэрийг *sayid erdeni wang sayuqu-a ger* (Сайд Эрдэнэ ван суух гэр) хэмээн бичжээ. Эрдэнэ ван Намсрайн албан үүрэг явуулах газар, аж төрөн суух гэрүүд нь тус тусдаа байсныг дээрх зургаас мэдэж болно. Намсрайн албан өргөөг Ноён уулын бэлд Сэлэнгэ мөрний ард зурсан нь одоогийн Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Хуурч багийн нутаг юм. Эл нутгийн зурагт Алтанбулаг хотыг хүрэн бэхээр зурж, нэрийг нь хар бэхээр бичсэн нь нөгөө хоёр зургаас өөр ажээ. Тухайн үеийн хилийн дотор Алтанбулаг хот багтсан учир ийнхүү зурсан бололтой байна.

Сүм хийдийг хүрэн өнгийн бэхээр давхарлан зурж, дээврийг хүрэн өнгөөр будсан байна. Сүм хийдүүдийн байршил хэвээрээ байх ба нэр нь нилээд өөрчлөгдсөн ажээ. Тухайлбал, Товхор Хан уулын бэлд Өршөөн соёрхогч сүм, Ноён уулын энгэрт Хотол чуулган хамаг олон Баясгалант сүм, Бүрэн уулын хормойд Амарбаясгалант сүм, Халиар уулын урд Дашчойнхорлин сүм, Ерөө голын ард Дашчойнхорлин сүм, Хурхын голын зүүн талд Дашчоймбалан сүм зэрэг нийт 6 сүмийг зурж, нэрийг нь бичжээ. Сүм хийдийн нэрийг өмнөх зурагтай ижил Жибзундамба хутагтын хэмээн хамаатуулж бичээгүй нь 1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн Ардын засгийн газрын 21-р тогтоолын 1-р зүйлтэй холбоотой. Үүнд “Монгол Улсын Богд хаан Жибзундамба хутагт шарын шашны Богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй...”<sup>113</sup> хэмээн Богдын улс төрийн эрх хэмжээг шууд хязгаарласан байдаг. Уг үйл явдалтай уялдаж тус нутгийн зурагт сүм хийдийн нэрийг Жибзундамба хутагтын харьяа гэж бичээгүй ажээ.

Өртөөний сууринг хар гурвалжингаар дүрсэлж, зургийн урд талаасаа *nomtu örtege* (Номт өртөө), *kütel örtege* (Хөтөл өртөө), *irüge yool örtege* (Ерөө гол өртөө), *narín moyai örtege* (Нарийн могой өртөө) хэмээх 4 өртөөний нэрийг бичиж замыг тод шар өнгөөр зурсан ба хажуугаар нь хар бэхээр дугуйруулж нэгэн замыг давхар тэмдэглэжээ. Энэ нь төмөр утасны шугам юм. Нэг өртөө хасагдсан нь засаг захиргааны зохион байгуулалттай холбоотой юм. Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт Их Хүрээнээс Хиагт чиглэлийн 10 өртөөг заасан байдаг.<sup>114</sup> Уг өртөөний өөрчлөлтийг дээрх нутгийн зурагт тэмдэглэжээ. Мөн уг зурагт өөр хоёр замыг шараар тэмдэглэсэн байгаа нь Амарбаясгалант сүмээс урагш явсан зам, нөгөө нэг нь тус хошууны нутаг дундуур Алтан булаг зүг нэвтэрсэн их зам буюу Хиагтаас баруун тийш Орхон, Сэлэнгэ голыг хөндлөн гарсан зам юм.

Дээрх өртөөгөөр захидал, албан бичиг явахаас гадна элч төлөөлөгчид, худалдаачид, аялагчид, жинчид зэрэг төрөл бүрийн хүмүүс дайран өнгөрдөг байв. Энэхүү өртөө зам нь харилцааны гол үүрэг гүйцэтгэхээс гадна тус хошууны хүн амын хөдөлгөөнд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байсан бололтой. Өртөөний албанаас бугсадын зарим нь төрөлх хошуу нутагтаа эргэн очих нь жил бүр цөөрч уг өртөөний хавьд идээшин нутаглах нь улам элбэгшсэний дээр энэ албанд тохогдсон шинэ хүмүүсээр өртөө хавийн хүн ам нэмэгдсээр иржээ. Тухайлбал, 1921онд Ардын журамт цэрэгт элсэгчдийн 61% нь Эрдэнэ засгийн хошуу, Баатар засгийн хошуунаас бүрдсэн байдаг. Хиагт хотыг чөлөөлөх байлдаанд оролцсон 112 цэргийн 13,1% нь урьд өмнө Хүрээ-Хиагтын өртөөний албанд

<sup>113</sup> Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. УБ., 1954. т.31

<sup>114</sup> Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг. Кирилл бичигт буулгасан. Батсайхан.О, Лонжид.З,Хажидсүрэн.Ч. УБ., 1995. т.165

зүтгэж байжээ.<sup>115</sup> Тиймдээ ч Эрдэнэ засгийн хошууны нутагт шилжин ирэгсдийг захирах “Цоохор отог” хэмээх орон нутгийн тусгай захиргаа байгуулахад хүрч байсан тухай мэдээ байна.<sup>116</sup> Өртөө замын дагуу гол гатлах хэсэгт усан онгоц зурсан нь бусад нутгийн зургаас нилээд ялгаатай юм. Орхон, Сэлэнгэ голыг гатлах Их Хүрэнээс-Хиагт чиглэлийн өртөөний Ерөө голыг гатлах газарт тус тус завь зурж, *alban-u ongyuca* (албаны онгоц) хэмээн бичжээ.

Уг зураг өмнөх зургаас хэд хэдэн зүйлээр ялгаатай байна. Нэгт, Зургийн суурийг бүхэлд нь будсан байна.

Хоёрт, Хилийн овоодыг гурвалжин улаан өнгөөр дүрсэлжээ.

Гуравт, тариалангийн талбай, бэлчээрийн талбай хэдийг дүрсэлжээ.

Дөрөвт, Алтанбулаг хотыг зурж тэмдэглэсэн байна.

Тавд, Тус нутгийн дундуур явах өртөөний 5 сууринг 4 болгосон байна

Зургаад, Өртөө зам, худалдааны зам зэргийг тус тусад нь тэмдэглэсэн.

Долоод, Төмөр утасны шугамыг зуржээ.

Наймд, Сүм хийдийн нэрээс Жибзундамба хутагтын харьяат гэдэг үгийг хассан.

Есд, Албаны онгоц буюу завь зурсанаараа илүү болжээ.

3. *tüsiyetü qan ayimaу šidar sayid erdeni čin wan namsarai-yin qosiyun-u nutuy-un* жіуу (Түшээт хан аймаг шадар сайд Эрдэнэ чин ван Намсрайн хошууны нутгийн зураг) гэсэн цагаан даавуун дээр хар бэхээр зурсан зураг юм.

Тус зураг 142 см х 112 см хэмжээтэй. Зургийн зүүн дээд буланд ягаан өнгийн бэхээр бүртгэлийн дугаарыг 912(517.3)Т924 гэж бичжээ. Энэ зургийн одоогийн бүртгэлийн дугаар нь 938/96 4932 юм. Нутгийн зургийн баруун дээд буланд Монгол Улсын хорьдугаар (1930) он гурван сар гэж бичээд тамга дарсан байна. Эл зурагт ганцхан удаа тамга даржээ. Тамганы хэмжээ 10,5 х 10,5 см юм. Тамганы бичигт *Boйда qan ayula-yin ayimaу jegün burin qan qosiyun-u jakiruyči tamaу-a* (Богд хан уулын аймаг Зүүнбүрэн хан хошууны захирагчийн тамга) хэмээн бичжээ.

Улаан шунхаар дугуй хүрээ татаж нутгийн зураг зурахад хэрэглэдэг зурхайн хүрдний 4 зүг, 4 зовхис 8 өнгө, 8 өнцгийг нар тойруулан бичжээ. (Хүснэгт №1 үзнэ үү.) Зургийн суурийг нилэнхүйд нь цэнхэр өнгөөр будсан. Хошууны нутгийн зургийг фү-гийн дүрэм хэмжээгээр нэг дөрвөлжинд 20 газар гэсэн хэмжээсээр тооцож тэмдэглэсэн бөгөөд нийт бүтэн дөрвөлжин 200 (200 х 20 х 20 х 576 =46.800.000) байгаа нь 46,000 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай болж байгаа нь өмнөх зурагнаас даруй 8,000 хавтгай дөрвөлжин километр их юм.

Уулсыг хэв шинжийг хөх өнгийн бэхээр давхарлан гаргаж, цэнхэр өнгөөр будаж, нэрийг нь бичжээ. Нийт 17 уулын өндрийн хэмжээг тавьжээ. Гол мөрөн, нуурыг урагш урсаж буй байдалтайгаар зурж, хөх өнгөөр будаж илүү дэлгэрэнгүй тэмдэглэжээ.

Сүм хийдүүдийг өмнөх хоёр зургийн ижил зурж, Дашчойнхорлон сүм, Амарбаясгалант сүм, Дашчойнхорлин сүм, Дашчомбилин сүм, Өршөөлийг соёгч сүм, Хотол чуулган хамаг олон баясгалант сүм хэмээн нэрийг нь хараар бичжээ. Албан тамгын гэрийг Сэлэнгэ, Орхон хоёр мөрний бэлчирт зурж хар бэхээр *jegünbúrin-yin tamaу-a-un yajar* (Зүүнбүрэнгийн тамгын газар) хэмээн бичсээс хошууны тамгын газар зүүн тийшээ нүүснийг тодорхой харж болно. Энэ нь одоогийн Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сум юм. 1923 онд Засгийн газраас хошуу, сум отгийг ноёдын хэргэм цолоор нэрлэж байсныг зогсоож, уулын нэрээр солих шийдвэр гаргасан билээ. Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууг Богд хан уулын Зүүнбүрэн хан уулын хошуу хэмээн нэрийдэх болов.<sup>117</sup>

<sup>115</sup>Монгол Ардын Хувьсгалт Цэргийн дуртгалууд. Улсын хэвлэлийн газар. УБ., 1961. т 48, 59,74, 77, 117, 118, 188, 202, 255, 217, 417

<sup>116</sup>Пүрэв.О. Монгол улсын улс төр, эдийн засгийн түүхэн газарзүй. УБ., 2003. т. 83

Өртөөний замыг шар өнгөөр зурсан боловч өртөөний сууринг тэмдэглээгүй байна. Харин өртөө замын хажууд дахин нэгэн замыг шар өнгөөр зурж *ayur-un tergen-ü jam* (уурын тэрэгний зам) хэмээн бичжээ. Эл тэмдэглэгээ уурын тэрэг буюу автомашин 1930 онд Их Хүрээ-Хиагтын чиглэлд явж байсныг харуулна.

Уг нутгийн зураг өмнөх хоёр зургаас ялгаатай нь Нэгд, Хошууны зургийг нилээд том хэмжээтэй даавуун дээр дүүргэж зурсан байна.

Хоёрт, Хилийн овооны байршил нилээд өөрчлөгдөж зүүн тийшээ тэлсэн байдалтай байна.

Гуравт, Нутгийн зургийн баруун дээд буланд он сарыг тавьж тамга даржээ.

Дөрөвт, Уурын тэрэгний замыг тодорхой зурж өгчээ.

Тавд, Тамгын гэрийг Сэлэнгэ, Орхон хоёр мөрний бэлчирт тэмдэглэжээ.

Зургаад, Зургийн суурийг нилэнхүйд цэнхэр, ногоон өнгөөр будсан.

Долоод, Уулсын хэв шинжийг давхарлаж будалгүй ногоон дэвсгэрт дээр хөх бэхээр шууд зурсан байна


Наймд, Уул, толгой, гол, горхи, булгийн нэрийг өмнөх хоёр зургаас илүү баялаг тэмдэглэж иржээ. Үүнийг 500,000 масштабтай 2011 оны Сэлэнгэ аймгийн газрын зурагтай харгалдуулан үзэж, 40 нэрний 34 нэрийг өдгөө хэрэглэж буйг мэдэж болно.

Дээрх гурван нутгийн зураг 10-15 жилийн зайтай зурагдсан. Энэ хооронд газар, усны нэр орхигдсон, нэмэгдсэн, өөрчлөгдсөн зүйл хэд хэд байна (Хүснэгт №2 үзнэ үү). Энэ нь засаг захиргааны зохион байгуулалт, нутгийн зургийг үйлдэж байсан хүмүүсийн үнэлэмж зэрэг олон хүчин зүйлээс улбаатай бололтой. Харин орчин цагийн газрын зурагт зарим уул, усны нэрийг санаатай болон санамсаргүй алдаж бичсэн бололтой байна. Банх уул-Банк уул, Бүрэн уул-Бүрэн Хан уул, Товхор Хан уул-Товхон Хан уул, Халиар уул-Найдаг уул, Ухаа уул-Ухмал уул, Хөшөөт гол-Хөшөөт худаг, Манхдайн гол-Шар Манхдайн гол гэх мэт жишээг дурдаж болно.

Эрдэнэ засгийн хошууны гурван газрын зургийг одоогийн Монгол улсын засаг захиргааны хуваарь дээр тавьж үзэхэд доорхи байдалтай харагдана. (Зураг №1)

---

<sup>117</sup>Сономдагва.Ч, Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997). УБ., 1998. т.28



























Энэ нь тойм байдлаар тавьсан харьцуулалт тул зарим сумдын нутаг орохгүй байгаа юм. Учир нь одоогийн газарзүйн солбицлыг нарийн баримталбал уг эх зургийн хэлбэр хэт алдагдахад хүрч байна. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны газар нутагт одоогийн Монгол Улсын Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Түшиг, Цагааннуур, Шаамар, Зүүнбүрэн, Дулаанхаан, Хушаат, Сант, Орхон, Сайхан, Баруунбүрэн, Алтанбулаг, Жавхлант, Ерөө, Хүдэр, Дархан-Уул аймгийн Дархан, Шарын гол, Хонгор сумд бүхэлдээ багтана.

Гурван зургийн дүрслэл, онцлог зэргийг доорх харьцуулалтаас тодорхой харж болно. (Зураг № 2)

№	Нэр	1907 оны зураг	1922 оны зураг	1930 оны зураг
1.	<i>sūme</i> (сүм)			
2.	<i>ger</i> (гэр)			
3.	<i>örtege sayurin</i> (өртөө суурин)			



4.	<i>örtege jam</i> (өртөө зам)			
5.	<i>kili-yin oboу-a</i> (хилийн овоо)			
6.	<i>naуur</i> (нуур)			
7.	<i>уool</i> (гол)			
8.	<i>ауula, нiruуи</i> (уул, нуруу)			
9.	<i>tariу-a-yin talbai</i> (тариан талбай)			
10.	<i>narasu</i> (нарс)			
11.	<i>temúr utasu</i> (Төмөр утас)			
12.	<i>alban-u onгуица</i> (албаны онгоц)			

13	<i>kili-yin šuyam</i> (хилийн шугам)			
14	<i>altanbulay</i> (Алтанбулаг)			
15	<i>aγur-un tergen-ū jam</i> (уурын тэрэгний зам)			

Дүгнэлт: Халхын Түшээт хан аймгийн нутгийн гурван зурагт нутгийн хил зааг, дотоод байдлыг тодорхой дүрсэлж, газар, усны нэрийг дэлгэрэнгүй бичиж үлдээжээ. Мөн фү-гийн хэмжээсийг баримталж, зурхайн хүрдийг ашиглан талбайн төвд зуржээ. Хилийн овоо болон уулсын хэв шинж, гол мөрний урсац, нуурын тогтоц, сүм хийдийн барилга, албан тамгын гэр, өртөө замын дүрслэл зэрэг газарзүйн биетүүдийг ижил төстэй зуржээ. Нийгмийн өөрчлөлтөөс улбаатай зарим тэмдэглэгээг орхигдуулсан, мөн баяжуулан дүрсэлж ирсэн нь харагдаж байна. Газар усны нэр багагүй хугацаанд хэрхэн өөрчлөгдөж, солигдож, орхигдож ирснийг ч харж болно. Одоогийн газрын зурагтай харьцуулан үзвэл хэмжээ багагүй алдсан, газрын зургийг нилээд хураан агшаасан мэт байна. Тиймээс хошууны түүхийн элдэв асуудлыг тодруулан судлахад нутгийн зургийн ач тус их болохыг дээрх гурван нутгийн зураг батлан харуулж байгаа юм.

#### ABSTRACT

**Sh.Munkhbaatar**

Erdene zasag banner of Qalqa Mongolia Tusheet khan province was establish in 1694, exited for 237 years and dissolved in 1931. There are 5 distinct maps of the territory of Tusheet zasag banner and 3 of them were created in 1907, 1922 and 1930. These three maps are stored in the National library of Mongolia. Some objects are drawn as they appear to us in realistic forms and therefore it is easy to understand what kind of objects they represent. Boundary lines and relay stations are drawn in red or black, but expert for these, unpaved roads are drawn in yellow rivers and lakes in bluish color and grassland and forests in green.

#### Хавсралт

Хүснэгт №1 Зурхайн хүрдний зүг чиг

№	Нэр	Нэр	24 хуваарь
01	<i>Qoyidu quluγan-a jūg</i>	Хойд хулгана зүг	зүг
02	<i>Qarayčïn</i>	Харагчин	өнгө
03	<i>Ūker</i>	Үхэр	өнцөг
04	<i>Josγulta</i>	Зогсолт	зовхис
05	<i>Baras</i>	Барс	өнцөг
06	<i>Köke</i>	Хөх	өнгө
07	<i>Jegūn eteged taulai</i>	зүүн этгээд туулай	зүг
08	<i>kökegčïn</i>	хөхөгчин	өнгө
09	<i>Luu</i>	Луу	өнцөг
10	<i>Oruly-a</i>	Оролго	зовхис

11	<i>Moγai</i>	Могой	өнцөг
12	<i>Ulayan</i>	Улаан	өнгө
13	<i>Emūn-e morin jūg</i>	өмнө морин зүг	зүг
14	<i>Ulayayčin</i>	Улаагчин	өнгө
15	<i>Qoni</i>	Хонь	өнцөг
16	<i>Eyebirkūū</i>	Эевэргүү	зовхис
17	<i>Biči</i>	Бич	өнцөг
18	<i>Čayan</i>	Цагаан	өнгө
19	<i>Barayun eteged takiy-a</i>	Баруун этгээд тахиа	зүг
20	<i>Čayayčin</i>	Цагаагчин	өнгө
21	<i>Noqai</i>	Нохой	өнцөг
22	<i>Möngke</i>	Мөнх	зовхис
23	<i>Qaqai</i>	Гахай	өнцөг
24	<i>Qar-a</i>	Хар	өнгө

*Хүснэгт №2 Нутгийн зурагт буй газар, усны нэрүүд*

№	1907 оны нутгийн зурагт буй газар, усны нэр	1922 оны нутгийн зурагт буй газар, усны нэр	1930 оны нутгийн зурагт буй газар усны нэр	Орчин цагийн газрын зурагт буй газар усны нэр
1	Банх уул	Банх уул	Байнхи уул	Банк уул
2	Сайхан уул	Сайхан уул	Сайхан уул	Сайхан хөтөл
3	Бүрэн уул	Бүрэн уул	Бүрэн уул	Бүрэн Хан уул
4	Цог Өндөр уул	Цог Өндөр уул	Цог уул	-
5	Ноён уул	Ноён уул	Ноён уул	-
6	Жаргалант уул	-	-	
7	Товхор Хан уул	Товхор Хан уул	Давхар Хан уул	Товхон Хан уул
8	Суварга уул	-	Сувраа уул	Ногоон Суварга уул
9	Тулган уул	-		-
10	Сэлмэн уул	Сэлмэн уул	Сүлмэн уул	
11	Шоргоолжин-Өндөр уул	-	-	Шоргоолжин-Өндөр Цагаан-Уул
12	Май уул	Май уул	Маань уул	Май Сант Өндөр
13		Халиар уул	Халиар уул	Найдаг уул
14	-	-	Ухаа уул	Ухмал уул
15	-	Хүдэр уул	Хүдэр уул	Хүдэр
16	-	Цайдам уул	-	Цайдам
17	-	Авгуулант	-	-
18	-	Долоон уул	-	-
19	-	Аргалант уул	-	-
20	-	-	Олон толгой	-
21	-	-	Салхит уул	Салхит уул
22	-	-	Хүүш уул	-
23	Чамаган уул	Чамаган уул	Чамаган уул	-
24	Жаргалант уул	Жаргалант	-	Жаргалант
25	Тужийн нарс	Тужийн нарс	Дөчин нарс	Тужийн нарс
26	Жавхлант	Жавхлант	-	Жавхлант
27	Зүүн нарс	Зүүн нарс	-	-
28	Сэлэнгэ гол	Сэлэнгэ гол	Сэлэнгэ гол	Сэлэнгэ гол

29	Орхон гол	Орхон гол	Орхон гол	Орхон гол
30	Хараа гол	Хараа гол	Хараа гол	Хараа гол
31	Ерөө гол	Ерөө гол	Ерөө гол	Ерөө гол
32	Хурхын гол	Хурхын гол	-	Хурхын гол
33	Бугат гол	-	-	Бугантын гол
34	Шар гол	Шарын гол	Шарын гол	Шарын гол
35	Мухар гол	Мухар гол	Мухар гол	Мухарын гол
36	Элбэг гол	Элбэг гол	-	-
37	Хөшөөт гол	Хөшөөт гол	Хөшөөт гол	Хөшөөт худаг
38	-	Хүйтэн гол	Хөдөн гол	Хүйтэн гол
39	-	Ивэн гол	-	Ивэнгийн гол
40	-	Богдын булаг	Богд булаг	-
41	-	Тойриг булаг	-	-
42	-	Сахиралт булаг	-	-
43	Зэлтэр гол	Зэлтэр	Зэлтэр гол	Зэлтэр
44	Манхдай гол	Манхдайн гол	-	Шар Манхтайн гол
45	Салуужин гол		Салуужин	-
46	Цагааннуур	Цагааннуур	Цагааннуур	Цагааннуур
47	Хантай уул	Хантай уул	-	-
48	Буга толгой	Буга толгой	-	-
49	Салуужин гол	Салуужин гол	-	-
50	Өлөнтийн гол	-	Өлэй горхи	Өлөнтийн гол
51	-	-	Тоолби гол	Тольбын гол
52	-	-	Уялага горхи	
53	-	-	Хөдөн гол	-
54	-	-	Хааз горхи	-
55	-	-	Нарийн гол	Нарийн гол
56	-	-	Хүүш гол	-
57	-	-	Галттай горхи	-
58	-	-	Бүхлэй гол	Бүхлээ гол
59	-	-	Ялбагын гол	Ялбагын гол
60	-	-	Ус хээрийн булаг	-

*Хүснэгт №3 Гурван зургийн хилийн овоо*

**А. 1907 оны зургийн хилийн овоо**

Нэгдүгээр Банхын нурууны овоо

Хоёрдугаар Хараа ба хоёр голын бэлчрийн овоо

Гуравдугаар Буга толгойн овоо

Дөрөвдүгээр Бүрэн уулын нурууны овоо

Тавдугаар Сэлэнгэ, Салуужин хоёр голын бэлчрийн овоо

Зургаадугаар Хантай уулын нурууны овоо

Долоодугаар Шаргалт, Зэлтэр хоёр голын бэлчрийн овоо

Наймдугаар Номгон давааны үзүүрийн овоо

Есдүгээр Бугын толгойтын адаг Ширээтийн овоо

Аравдугаар Харагчин голын захын овоо

Арван нэгдүгээр Өлөнтийн голын захын овоо

Арван хоёрдугаар Ширээтийн овоо

Арван гуравдугаар Залбихан голын адгийн овоо

Арван дөрөвдүгээр Зах-Өндөрийн овоо

Арван тавдугаар Шар чулуутын овоо  
Арван зургаадугаар Улаалзаганы овоо  
Арван долдугаар Баруун Асгатын овоо  
Арван наймдугаар Зүүн Асгатын овоо  
Арван есдүгээр Баянзүрхийн овоо  
Хорьдугаар Суварга уулын овоо  
Хорин нэгдүгээр Гацаа-Устын овоо  
Хорин хоёрдугаар Орхон, Сэлэнгэ хоёр голын бэлчрийн овоо  
Хорин гуравдугаар Нарст аралын овоо  
Хорин дөрөвдүгээр Огидай адгийн овоо  
Хорин тавдугаар Цагаан харуулын овоо  
Хорин зургаадугаар Самарын амны овоо  
Хорин долоодугаар Халзан хамарын эхийн овоо  
Хорин наймдугаар Талын овоо  
Хорин есдүгээр Энхт ухаа овоо  
ГучдугаарТалын ганц модны овоо  
Гучин нэгдүгээр Мухар төхөмийн овоо  
Гучин хоёрдугаар Эвцэг, Бөхлэй хоёр горхины бэлчрийн овоо  
Гучин гуравдугаар Залаа толгойн овоо  
Гучин дөрөвдүгээр Баянзүрхийн овоо  
Гучин тавдугаар Шавартын овоо  
Гучин зургаадугаар Чулуун овоо  
Гучин долоодугаар Улаан элсний Цагаан толгойн овоо  
Гучин наймдугаар Шоргоолжин-Өндрийн Цагаан үзүүрийн овоо  
Гучин есдүгээр Май уулын ар үзүүрийн Май голын байц хадны овоо  
Дөчдүгээр Мянга гол, Хуриг хоёрын бэлчрийн овоо  
Дөчин нэгдүгээр Майн уулын нурууны овоо  
Дөчин хоёрдугаар Худаг, Зүрх хоёр голын бэлчрийн овоо  
Дөчин гуравдугаар Хурган голын адгийн овоо

**Б. 1922 оны зургийн хилийн овоо**

Нэгдүгээр Май гол Чуулан Хорго хоёрын бэлчрийн овоо  
Хоёрдугаар Май уулын нурууны овоо  
Гуравдугаар Худаг, Зүрх хоёр голын бэлчрийн овоо  
Дөрөвдүгээр Хурган голын адгийн овоо  
Тавдугаар Банхын нурууны овоо  
Зургаадугаар Хараа Баян хоёр голын бэлчрийн овоо  
Долоодугаар Бугатолгойн овоо  
Наймдугаар Бүрэн уулын нурууны овоо  
Есдүгээр Сэлэнгэ Салуужин хоёр голын овоо  
Аравдугаар Хантай уулын нурууны овоо  
Арван нэгдүгээр Шаргалт Зэлтэр хоёр голын бэлчрийн овоо  
Арван хоёрдугаар Номгон давааны үзүүрийн овоо  
Арван гуравдугаар Бугатолгойн адаг Ширээтийн овоо  
Арван дөрөвдүгээр Харагчин голын захын овоо  
Арван тавдугаар Өлөнтийн голын захын овоо  
Арван зургаадугаар Ширээтийн овоо  
Арван долоодугаар Залбихан голын адгийн овоо  
Арван наймдугаар Зах-Өндрийн өвөө  
Арван есдүгээр Шар чулуутын овоо  
Хорьдугаар Улаалзаганы овоо  
Хорин нэгдүгээр Баруун Асгатын овоо

Хорин хоёрдугаар Зүүн Асгатын овоо  
Хорин гуравдугаар Баянзүрхийн овоо  
Хорин дөрөвдүгээр Суварга уулын овоо  
Хорин тавдугаар Гацаа-Устын овоо  
Хорин зургаадугаар Орхон Сэлэнгэ хоёр голын бэлчирийн овоо  
Хорин долоо дугаар Буур Хориг Орхон голын бэлчирийн овоо  
Хорин наймдугаар Буур Хоригын захын овоо  
Хорин есдүгээр Хамарын овоо  
Гучдугаар Бүргэдэй уулын овоо  
Гучин нэгдүгээр Талын овоо  
Гучин хоёрдугаар Энхт-Ухаагийн овоо  
Гучин гуравдугаар Талын ганц модны овоо  
Гучин дөрөвдүгээр Мухар төхөмийн овоо  
Гучин тавдугаар Эвцэг Бөхлэй хоёр горхины бэлчрийн овоо  
Гучин зургаадугаар Залаа толгойн овоо  
Гучин долоодугаар Баянзүрхийн овоо  
Гучин наймдугаар Шавартын овоо  
Гучин есдүгээр Чулууны овоо  
Дөчдүгээр Улаан элсний Цагаан толгойн овоо  
Дөчин нэгдүгээр Шоргоолжин-Өндөр Цагааны үзүүрийн овоо  
Дөчин хоёрдугаар Май уулын ар үзүүрийн Май голын Байц хадны овоо

#### **В. 1930 оны зургийн хилийн овоо**

Нэгдүгээр Ар нарт байц хадны овоо  
Хоёрдугаар Минж гол Цүүхлэг горхи хоёрын бэлчрийн овоо  
Гуравдугаар Май уулын нурууны овоо  
Дөрөвдүгээр Ходон, Ерөө хоёр голын бэлчрийн овоо  
Тавдугаар Хургад голын адагийн овоо  
Зургаадугаар Банхын нурууны овоо  
Долоодугаар Хараа, Баян хоёр голын бэлчрийн овоо  
Наймдугаар Бортолгойн овоо  
Есдүгээр Бүрэн уулын нурууны овоо  
Аравдугаар Сэлэнгэ, Салуужин хоёр голын бэлчирийн овоо  
Арван нэгдүгээр Хантай уулын нурууны овоо  
Арван хоёрдугаар Сангалт, Зэлтэр хоёр голын бэлчирийн овоо  
Арван гуравдугаар Орос лугаа зах нийлэх Нэвшээ уулын нурууны овоо  
Арван дөрөвдүгээр Гүү уулын хил овоо  
Арван тавдугаар Байв голын бэлчрийн хил овоо  
Арван зургаадугаар Хотгойд уулын хил овоо  
Арван долоодугаар Ёнхорын хил овоо  
Арван наймдугаар Монгол толгойн хил овоо  
Арван есдүгээр Хонгорын хил овоо  
Хорьдугаар Хөх чулуутын хил овоо  
Хорин нэгдүгээр Буйлаастын хил овоо  
Хорин хоёрдугаар Ганц нарсны модон хил овоо  
Хорин гуравдугаар Бичигт хошууны ногоон хил овоо  
Хорин дөрөвдүгээр Оргойтын хил овоо  
Хорин тавдугаар Оргойтын бэл овоо  
Хорин зургаадугаар Өндрийн өврийн модон овоо  
Хорин долоодугаар Модон толгойн гуугийн модон овоо  
Хорин наймдугаар Бага цоорхойн модон овоо  
Хорин есдүгээр Хамар толгойн модон овоо

Гучдугаар Хярааны дөрөөний баруун талын модон овоо  
Гучин нэгдүгээр Хярааны ар төхөмийн модон овоо  
Гучин хоёрдугаар Сөдөтийн хил овоо  
Гучин гуравдугаар Худаг-Өндөрийн хил овоо  
Гучин дөрөвдүгээр Дөрөө-Ухаагийн хил овоо  
Гучин тавдугаар Шар буга нугын хил овоо  
Гучин зургаадугаар Цайдам горхийн адаг Цөх голын өмнийн хил овоо  
Гучин долдугаар Хааз горхины адаг Цөх голын өмнө захын хил овоо  
Гучин наймдугаар Хүдэр голын адаг Цөх голын өмнө захын хил овоо  
Гучин есдүгээр Уялга горхины адаг Цөх голын өмнө захын хил овоо  
Дөчдүгээр Ар хадны хил овоо  
Дөчин нэгдүгээр Ар хадамсуугийн гол Өлөй горхи хоёрын бэлчирийн хил овоо  
Дөчин хоёрдугаар Өвөр Хадамсуугийн хил овоо





## ᠨᠴᠢᠨᠦᠨᠦᠨᠦᠨᠦᠨᠦ


гэж гардгийг Х.Н.Оркун *ol<sup>a</sup> y biş y<sup>e</sup>ğrmike k<sup>e</sup>yre b<sup>a</sup>şı üç birküde t<sup>a</sup>r birle k<sup>a</sup>tı tokid'm, sin<sup>a</sup>ri bud<sup>u</sup>n i<sup>ç</sup>kdi...*<sup>125</sup> “тэр сарын арван таванд Хэйрийн эхэнд Гурван Биркү-д Татартай тулалдсан. Зарим иргэн орсон...” гэж уншсан. Л.Болд *WLY : bisygrimka : kyra : BŞi : üçbirküda : TTR : birla : Qti : TWQiDM : şinRi : BWDN : içkdi* : гэж уншжээ<sup>126</sup>. Энэ мэдээ бидэнд тус газар зүйн биетийн байршлын тухай тойм баримжааг өгдөг. Татар болон түрэг аймгуудын нутгийн зааг орчим болох нь ойлгогдоно. Б.Батсүрэнгийн “Туулын сав нутаг ялангуяа одоогийн Улаанбаатар хотоос дээших газар нь VI зууны II хагасаас – VIII зууны II хагас хүртэлх хугацаанд *түрэг, монгол* хэлтэн аймгуудыг заагладаг, завсрын уулзвар бүс (контактный зон) байсныг үгүйсгэх аргагүй.”<sup>127</sup> гэсэн саналыг харгалзан үзвэл бидний сонирхон буй Хэйр ба Гурванбиркү нь Хэрлэнгийн баруун эргээс Туул голын эхэн хавийн нутагт байх ёстой юм. Тиймээс энэ бүс нутагт буй газар нутгаас эдгээр газар зүйн биетүүдийг хайх нь зүйтэй. Энэ бүс нутагт *k<sup>e</sup>yre*-Хэйрэ нэртэй газар зүйн биетэд таацах магадлалтай хоёр газар байгаа нь Хэрлэн ба Хээр (Сайр хээр) юм. Мөнхүү *üç birkü* буюу Гурван биркү нь өнөөгийн Төв аймгийн Мөнгөн морьт сумын нутаг, Хэрлэн голын баруунаас нийлэх Баруун Бүрхийн гол, Дунд Бүрхийн гол, Зүүн Бүрхийн гол хэмээх Гурван Бүрхи мөн гэж үзэж байна. Энэхүү гурван Бүрхийн голын нэр нь Орхоны бичгийн дурсгалд *üç birkü* хэмээн гардаг эртний нэр ажээ. Үүний бас нэгэн баталгаа нь эрт үед зүүн зүгийг өмнө, умардыг зүүн, өмнөдийг баруун гэж нэрлэж байсны улбаа тус гурван голын нэрээс тодорхой ажиглагддаг. Хэрэв XIII зуунаас хойших нэр байсан бол Хэрэнгийн зүүн эрэг дэх Урд хориуд, Хойд хориудын нэгэн адил Урд бүрхийн гол, Дунд бүрхийн гол, Хойд бүрхийн гол гэж нэрлэгдэх байсан билээ. Тиймээс Б.Батсүрэнгийн Шинэ усны бичээст гарч буй *üçbirkü* бол Монголын нууц товчооны *bürgi-ergi* мөн гэсэн санал: Бүрги эргийг Бүрхийн голд зааснаараа дэмжүүштэй боловч Гурван бүрхи нь Бүрги эрги мөн гэж шууд хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай юм. Тодорхой хэлбэл, Түрэгийн үед *üçbirkü* (Гурван бүрхи) нэртэй байгаад дундад зууны үед Бүрги эрги нэртэй болоод хожим дахин Гурван бүрхи нэртэй болсон байж таарахгүй. Өөрөөр хэлбэл *üçbirkü* бол Гурван бүрх мөн боловч Бүрги эрэг нь тус голуудын савд орших өөр нэг жижиг газар зүйн биет гэдэг нь ойлгомжтой юм.

*k<sup>e</sup>yre* хэмээх газар зүйн биетийн хувьд С.Харжаубай ‘Хэйрэ’ (Käyrä)-г одоогийн Хэрлэн гол” гэсэн санал дэмжүүштэй байна. Учир нь тус үгтэй хамтатган хэрэглэсэн *başı* “тэргүүн, эхэн” хэмээх үгийг Орхоны бичгийн дурсгалуудад *Arqar başı, Şip başı, Çuş başı, Tsiz başı* гэх мэтээр ихэнхидээ голын нэртэй хамт “тэргүүн, эхэн, дээд урсгал” гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Тийм учраас тус *k<sup>e</sup>yre b<sup>a</sup>şı* гэдэг газар зүйн биетийн *k<sup>e</sup>yre* нэр гол усны нэр болох нь илэрхий ойлгогдож байна. Түүнчлэн авилаа жижиг газарзүйн биетийн байршлийг тодорхойлохдоо ойролцоох томоохон уул, усаар баримжаа болгодог билээ. Хэрэв *üç birkü* буюу өнөөгийн Гурван Бүрхийн гол мөн л бол түүнийг байршлыг тодорхойлохдоо Хэрлэн голоор баримжаа болгох нь гарцаагүй юм.

<sup>125</sup> H.N.Orkun. *Eski Türk Yazıtları*. Ankara. TDKY. 1994. s.169-170

<sup>126</sup> Болд Л. *Орхон бичгийн дурсгал VI*. УБ., 2019. т.166


<sup>127</sup> Б.Батсүрэн. *VI-X Зууны Монгол Аймгууд* (Түүх – угсаа гарвалын шинжилгээ). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. УБ., 2012. т.78



Зураг №1

Шинэ усны бичээсийн 6-р мөрөнд *k<sup>e</sup>yre b<sup>a</sup>şında üç birküde*, 7-р мөрөнд *k<sup>e</sup>yre b<sup>a</sup>şı üç birküde* хэмээн гарч буйг “Хэрлэнгийн эх, Гурван бүрхэд” гэсэн утгатай гэж үзвэл бидэнд Монголын нууц товчоонд дурдагддаг хэд хэдэн газар зүйн биетийн байршлийн тухай мэдээлэл өгч байна.

Нэгдүгээрт, *kelüren-müren-ü teriün* гэх ойлголт тодорхой болж байна. Энэ мэдээ ёсоор бол Хэрлэн мөрний тэргүүн, эхэн урсгалын тухайд Гурван бүрхийн голын адаг буюу Хэрлэн гол ба Баруун Бүрхийн голын бэлчир хүртэлх хэсгийг хамруулах тодорхой харагдаж байна. Сансарын зургаас үзэхэд Баруун Бүрхийн гол, Хэрлэн голын бэлчир орчмын нутаг, өнөөгийн Намсрай уул, Хөндлөн булаг, Номгоны эрүү толгой орчмоор Хэрлэн голын том хөндий ерөнхийдөө хоёр хуваагдаж байгаа нь сансарын зургаас тодорхой харагдаж байна. Үүгээр Хэрлэнгийн эхэн урсгал төгсгөл болж байх шиг байна. (Зураг. №2) Намсрай уулын зүүнтэйгүүр Баруун бүрхийн гол нийлснээс эхлэн Хэрлэн гол задгайран маш олон салаалж, өргөн хуурай сайрыг үүсгэсэн байдаг.



(Зураг №2).

Ийнхүү “Хэрлэн мөрний тэргүүн” хэмээх газар зүйн ойлголтыг тодорхой болгосноор Чингис хааны зарлигаар *qurban müred-ün teri'ün ken-e ber bu bawūlutqun* хэмээн дархалсан нутгийн өмнөд зах хязгаарыг тоймлох боломжтой болж байна. Онон, Туулын тэргүүнийг Хэрлэн мөрний тэргүүнтэй дүйлгэн ойролцоогоор тогтоож болох болов уу.

Хоёрдугаарт, Хэрлэн мөрний тэргүүнээр баримжаа болгосон Бүрги эрги гэх газрын байршлын талаар ерөнхий мэдээлэл өгч байна. Монголын нууц товчоонд Бүрги эрги гэх нэр нэр нийт 6 удаа гардаг.

*senggür-qoroqan-aca newüjü kelüren-müren-ü teri'ün bürgi-ergi-de nuntuqlan bawuju*<sup>128</sup> “Сэнгүр гохиноос нүүж, Хэрлэн мөрний тэргүүн Бүрги эргид нутаглан бууж”;

*tendece qariju bürgi-ergi-de бүкүй-түр бурқан-қалдун-аца uriangqadai gü'ün jarci'udai ebügen kü'ürge-ben ürcü jelme neretü kö'ün-iyen uduritcu irejü*<sup>129</sup> “тэндээс харьж Бүрги эргид

<sup>128</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.37

<sup>129</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.37

бүхүйд Бурхан Халдунаас урианхадай хүмүүн, жарчиудай өвгөн хөөргөө үүрч, зэлмэ нэрт хөвүүнээ удирдаж ирж”;

*kelüren-müren-nü teri'ün-e bürgi-ergi-de bawuju бүкүй-түр niken manaqar erde gerel siral üdür geyin бүкүй-түр hö'elün-eke-yin ger dотор gödölküi qo'a[q]cin-emegen boscu ügülerün*<sup>130</sup> “Хэрлэн мөоний тэргүүн Бүрги эргид бууж бүхүйд нэгэн маргааш эрт гэрэл шарал өдөр гийн бүхүйд Өгэлүн эхийн гэр дотор хөдлөх Хоагчин эмгэн босч өгүүлрүүн”;

*to'oril- qan morilarun burqan-qaldun-u ebür kelüren-ü bürgi-ergi jorin ayisi ke'en temüjin bürgi-ergi-de бүрүн мөр-түр bui ke'en jayilan tünggelik ö'ede newüjü tana-qorqon-a burqan-qaldun-u ebür bawuju ...*<sup>131</sup> “Тоорил хан морилруун Бурхан Халдуны өвөр Хэрлэнгийн Бүрги эрги зорин айсуу хэмээн Тэмүжин Бүрги эргид бүрэн мөрт буй хэмээн зайлан Түнггэлиг өөд нүүж Тана горхинд Бурхан Халдуны өвөр бааж...”;

*bi ö'esün kelüren-ü bürgi-ergi-dece*<sup>132</sup> *uqдun yorciju güse'ür-na'ur-a jolqalduba-je*<sup>133</sup> “би өөрөө Хэрлэнгийн Бүрги эргээс угтан зорчиж, Гүсээр нуурт золголдод зэ”;

Ийнхүү Хэрлэн мөрний түргүүн, Бурхан Халдуны өвөр, Түнггэлиг горхин, Тана горхин, Сэнгүр горхиноос холгүй орших Бүрги эрги нь өнөөгийн Хэрлэнд цутгах Баруун бүрхийн гол, Юүдэгийн голыг цутгалаас дээш, Намсрай уул, Номгоны эрүү толгойгоос өгсөөд байх ёстой ажээ.

Бүрэг эргийн тухай судлаачдын зөрүүтэй саналууд байдаг боловч дээр өгүүлсэн зүйлсэд үндэслэвэд Б.Батсүрэн (2010), V. Pecchia RIBA (2010), Ж.Гэрэлбадрах (2019) нарын гаргасан саналууд нэлээд баримжаатай болсон гэж үзэж байна. Эдгээр гурван эрдэмтэн Бүрги эргийг Гурван Бүрхийн голын хөндийд зааснаараа нийтлэг боловч яг байршлын тухайд тус тусын ялгаатай саналууд гаргасан юм. Б.Батсүрэн Шинэ усны бичээст гарах Үчбиркү-г Бүрги эрэг гарцаагүй мөн<sup>134</sup> гэж үзсэн бол Бристолын их сургуулийн эрдэмтэн V. Pecchia RIBA “Тэмүжиний хүрээ Бүргийн голын эрэг дэх Бүргийн далангийн зүүн үзүүрт байсан.”<sup>135</sup> гэж таамаглажээ. Харин Ж.Гэрэлбадрах “Зүүн Бүрхийн голын баруун эрэгт буй Бүрхийн дөрвөлжингийн ойр Тэмүжиний зусч байсан Бүрги эрэг байсан”<sup>136</sup> гэжээ. Бид мөн Монголын нууц товчоонд гардаг Бүрги эрэг нь өнөөгийн Гурван бүрхийн голын ойролцоо, Баруун бүрхийн голоос хойшоо Хэрлэнгийн эрэг дагуу байгаа гэдэг ерөнхий чигийг дэмжиж байна.

<sup>130</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.38

<sup>131</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.43

<sup>132</sup> Үүнийг Монголын нууц товчоонд “kelüren-ü teri'ün-ece cinggis-qahan ö'esün esergü otcu” хэмээн бичсэн буй.

<sup>133</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.88

<sup>134</sup> Батсүрэн Б. Уйгур ба Байырку, Есөн татар нар 747-751 онд // *JOURNAL OF EURASIAN STUDIES*. Volume II., Issue 2. April — June 2010. p. 70

<sup>135</sup> V. Pecchia RIBA. *Geography of 'The Secret History Of The Mongols'* (Location of C13th Mongol Place Names and Topographical Features in NE Mongolia). In collaboration with the Dept. of Archaeology and Anthropology of Bristol University, Bristol, UK., 2010. p. 21

<sup>136</sup> Гэрэлбадрах Ж. “Монголын нууц товчоон”-д гардаг Бүрги эрэг чухам хаана байсан вэ? // *Acta Historica*.

Tomus. XX, УБ., 2019. т. 61

**Монгол Ш. МӨНХБААТАР**

**ХАЛХЫН ДӨРВӨН АЙМГИЙН ӨРТӨӨНИЙ БАЙРШЛЫГ НУТГИЙН ЗУРГААР  
ТОДРУУЛАХ НЬ**

Манж Чин улс Ойрад монголчуудын Зүүнгар улстай дайтах, цэргийн хүнс зөөвөрлөх, мэдээлэл түргэн шуурхай дамжуулах зорилгоор Монгол нутагт 1696-1719 онд өртөө зам байгуулжээ.<sup>137</sup> Эдгээр өртөө Бээжин хотоос умард зүг Хаалган, Сайр ус, Улиастай хүрч байв. 1758 онд Их Хүрээ, 1762 онд Ховдод Манжийн сайдын газар байгуулагдсан учир Улиастайгаас Ховд хүртэлх өртөөг цэгцлэн байгуулсан байдаг. Сүүлд Хүрээнээс шууд Улиастай руу явах, Сайр усаас Хүрээ, Хүрээ-Хиагтын өртөө зам тавьжээ. Тус өгүүлэлд Халхын дөрвөн аймгийн нутгаар дайран өнгөрөх өртөөдийн байршлыг тодруулахыг зорив.

Монгол нутаг дахь өртөөний байршлыг тодруулахад аймаг, хошуудын нутгийн зураг, харуул, өртөөг тэмдэглэсэн бүдүүвч зураг, Монгол нутгаар явсан аялагчдын тэмдэглэл, өнөө цагийн газрын зураг, нутгийн малчдын мэдээллийг ашиглав. Халхын нутгийн өмнөд захын Хярын мухараас Сайр ус хүртэлх өртөө, Сайр усаас Их Хүрээ, Их Хүрээнээс Хиагт өртөө, өрнө зүг Сайр усаас Улиастай, Улиастайгаас Ховд хүртэлх өртөө гэсэн байдлаар ялган авч үзлээ.

### **1. Хярын мухараас Сайр ус хүртэлх 14 өртөө**

Харуул, өртөөг тэмдэглэсэн бүдүүвч зурагт урд зүгээс эхлэн “kir-a-yin muqur ōuqum” (Хярын мухар чухам), “bulung dam” (Булан дам), “sūji ōuqum” (Сүүж чухам), “toli bulaγ” (Толь булаг) “tögürig ōuqum” (Төгрөг чухам), “muqur qasiγun ōuqum” (Мухар гашуун чухам), “qoniċ ōuqum” (Хоньч чухам), “naran dam” (Наран дам), “qaċabċi ōuqum” (Хацавч чухам), “jalatu dam” (Залаат дам) “jöübür ōuqum” (Зөөвөр чухам), “boru obuγ-a dam” (Бор-Овоо дам), “kötül dolun” (Хөтөл долоон) гэсэн Сайр ус хүртэлх 14 өртөөний нэрийг бичжээ.<sup>138</sup> Тус бүдүүвч зурагт буй чухам хэмээх үг бодитой, тогтвортой гэсэн утгатай. Дам гэдэг бол дамжилга буюу дамжуулах гэсэн үг юм. Түшээт хан аймгийн Мэргэн засгийн хошууны нутгийн зурагт Хярын мухараас хойших өртөөдийг зуржээ. Мэргэн засгийн хошууны нутгийн зураг ҮНС-д лав 10 бий.<sup>139</sup> Он цагийн хувьд 1868-1930 он хүртэл байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын архивт 1907-1930 оны 4 зураг байгаа юм.<sup>140</sup> Эдгээр зургаас 1907 оны “Түшээт хан аймгийн хэбэй засаг төрийн жүн вангийн хошууны нутгийн зураг”<sup>141</sup>-т өртөөний эзэмшил нутгийг тэмдэглэснээрээ бусад нутгийн зургаас онцлог ажээ. Уг зурагт “kir-a-yin muqur örtege” (Хярын мухар өртөө), “dam bulung örtege” (дам Булан өртөө), “seüji bulaγ örtege” (Сүүж булаг өртөө), “toli bulaγ örtege” (Толь булаг өртөө), “tögüreg örtege” (Төгрөг өртөө), “muqurγasiun örtege” (Мухар гашуун өртөө), “qoniċi örtege” (Хоньч өртөө), “dam bilgekü örtege” (дам Билгэх өртөө), “qaċabċi örtege” (Хацавч өртөө) гэсэн 9 өртөөний нэрийг өмнөөс баруун хойд зүг рүү дараалуулан бичсэн байна. Өртөөний замыг хар бэхээр цэгэн шугам татаж, өртөөний сууринг дугуй хэлбэртэй тэмдэглэж шар өнгөөр буджээ.

<sup>137</sup> Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн судлаач

mogi89181119@gmail.com

Ц.Насанбалжир. Ар Монголоос Манж чин улсад залгуулж байсан алба 1691-1911 он. УБ., 1964. т.53

<sup>138</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 345/96

<sup>139</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 712/96, 715/96, 722/96, 725/96, 726/96, 727/96, 764/96, 900/96, 1056/96, 1058/96

<sup>140</sup> Монгол нутгийн зураг. Түүхэн газрын зургийн цомог. Халхын Түшээт хан аймаг. II боть. Галиглаж хөрвүүлсэн Ж.Гэрэлбадрах, Ш.Мөнхбаатар. УБ., 2020. т. XXVII

<sup>141</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг. д-2, хн-9

1. Хярын мухар. Тус өртөөний зүүн талд *“Хярын мухар өртөөний зүүн этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Цагаан гэр”* гэж бичээд дээд талд нь *“Хярын мухар өртөөний зүүн этгээд журганы занги, засаг нарын хэмжсэн гучин газар, адаг Цагаан гүвээ”* хэмээн бичжээ. Мэргэн засгийн хошууны нутагт буй Хярын мухар өртөөний зүүн тал нь 30 газар (1 газар-576 м) буюу 17 км 280 м байна. Хярын мухар өртөөний баруун тал мөн 30 газар бололтой. Хярын мухар өртөө зүүнээс баруун тийш 34 км орчим эзэмшил нутагтай байжээ. Тус зурагт “нэр зааж тэмцсэн” хэмээн өгүүлж буй нь өртөө, хошуу хооронд газар нутгийн зарга үүсэж, шийдэж байсныг илтгэнэ. Ийм маргааныг хошууны нутгийн зурагт тэмдэглэхээс гадна өртөөний нутгийн зургийг давхар үйлдэж баталгаажуулдаг байв. 1847 оны 5 сарын 15-нд Палладий Кафаров Хярын мухар өртөөнд хоногложээ. Тэрээр *“Хярын мухар өртөөнд хүрч очвол баруун урдаас зүүн хойшоо сунан тогтсон нэгэн их элсэн далангийн хормой дор байрлажээ. Хоёр худаг байсан агаад гайгүй сайн юмсанж”*<sup>142</sup> гэж өгүүлсэн байна. Маргааш нь Хяр мухарын давааг даваад чанх хойшоо явсан байдаг. А.Позднеев 1892 онд явсан тайландаа *“Зэс хонгорын дараачийн өртөөг Шар мухарын өртөө гэх бөгөөд энэ нь Өвөр Монголын Дөрвөн хүүхэд хошууны зах юм”*<sup>143</sup> хэмээн өгүүлжээ. Угтаа Хярын мухар өртөө Мэргэн засгийн хошууны хамгийн урд талын өртөө юм. Нутгийн зураг, цэсэнд үүнийг тодорхой тэмдэглэсэн бий. Хярын мухар өртөөг 1:100.000 масштабтай зургаас үзвэл өнөөгийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Сулин хээр багийн нутаг Баян-Овоогийн худаг орчим байна.

2. Булан өртөө. Булан өртөөний баруун талд *“Булан өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Бор нуруу”, “Булан өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Цагаандов”* зүүн талд *“Булан өртөөний зүүн этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг”, “Булан өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн гучин газрын адаг”* хэмээн бичжээ. Булан өртөөний эзэмшил баруунаас зүүн тийш 60 газар буюу 34 км юм. Тус өртөөний тухай Кафаров *“Булан гэдэг нэртэй нэгэн гүдгэрийн хормойд орших агаад баруун урд, баруун, хойд, зүүн хойд талыг нь ороосон их судагтай, эргэн тойрондоо атираа намхан уулстай болой”*<sup>144</sup> гэжээ. Тус газрын байршлыг Хатанбулаг сумын Сулинхээр багийн малчин Осонбадрахын Отгонбатаас лавшруулан асуухад *“Энд худаг бий. Гэхдээ усны гарц муу. Ар талын толгодын хяр дээр хуучин сүм хийдийн туурь байдаг”* гэж хэлж өгөв. Одоо тэнд бүдэг туурь л үлдсэн бололтой. Булан өртөөний өнөөгийн байршлыг Дорноговь аймгийн 1:550.000 масштабтай газрын зургаас үзвэл Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвөөс зүүн урд зүгт 63 км орчим зайтай. Сулин хээр багийн нутагт Хангийн боомтоос баруун хойд зүгт 25 км орчим зайтай газар Уушиг уулын урд Булангийн Улаан тойромын баруун талд байна.

3. Сүүж өртөө. *“Сүүж өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Олон овоо хэмээх газар”, “Сүүжийн өртөөний зүүн этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Үйзэн цагаан толгой”, “Сүүж өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн гучин газрын адаг Дунд цал хэмээх газар”* гэж тэмдэглэжээ. Сүүжийн өртөөний эзэмшил нутаг баруунаас зүүн тийш мөн 34 км орчим газар байна. П.Кафаровын тэмдэглэлд *“Эргэн тойрноо ахиулан ажваас тиймэрхүү хадан цохио нийтдээ долоо байх агаад баруун, баруун хойд, хойд зүгт хагас тойрог үүсгэн тогтжээ. Хадан цохионууд холоос ногоондуу өнгө зонхилсон төмөр мэт үзэгдэнэ. Өртөөний баруун урдхантай Раашсамбал хэмээх дөрвөлжин оройтой дөрвөлжин хийцийн нэгэн хийд байх агаад дөрвөн талд нь нижгээд эсгий гэр бөртийнэ”*<sup>145</sup> гэжээ. Хойд талд От хайрхан уул, баруун талаар Хөвийн хоолой үргэлжилнэ. Зүүн талд Бүргэд

<sup>142</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.195

<sup>143</sup> А.Позднеев. Дорожня замьтки на пути по Монголии въ 1847 и 1859 г. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ., 1892. стр. 173

<sup>144</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.198

<sup>145</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.200

толгой, Сүүжийн толгод, Уртын хяр байна. Сүүж хэмээх нэрийн тухайд монголчууд уул толгодын ар хэсгийг хүн, амьтны сүүжтэй зүйрлэн нэрлэсэн бололтой. Сүүжийн өртөөний дэргэд байсан Сүүжийн хийдийн туурийг Дорноговь аймгийн газрын зурагт тэмдэглэгдсэн байна. Булангийн Улаан тойромоос баруун хойд зүгт 25 км орчим, Хатанбулаг сумын төвөөс зүүн урд зүгт 45 км орчим зайтай газар Сулинхээр багийн нутагт байх ажээ.

4. Толь өртөө. *“Толь өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээсэн гучин газрын адаг Нарийн замын зүүн этгээд газар”, “Толь өртөөний баруун этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн гучин газрын адаг Хөшөө чулуу”, “Толь өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Хар овоо хэмээх газар”* гэсэн байна. Тус өртөө өмнөх өртөөдийн нэгэн адил зүүнээс баруун тийш 34 км орчим нутагтай. Толь булаг өртөөний байрлалыг П.Кафаров *“...тэрүүхэндээ тэгшхэн тал, харин тэртээ баруун хойд зүгт намхан толгод харагдана. Өртөөний хажуугийн зүлгэн дундуур нэрийг нь үл мэдэх нарийхан горхи баруун хойшоо жирэлзэн урсана. Өртөөний ойр орчимд олон хиргисүүр торойх агаад, дээр нь хоёр шавар хананы нурангитай гүвээ харагдав”*<sup>146</sup> гэжээ. Мөн Толь өртөөний ойр Цы иньсы буюу Энэрлийн сүм байсан тухай дурдсан байна. Түүний замаар явсан А.Позднеев *“Монгол хүмүүсийн надад хуучилснаар Толийн хажууд байдаг сүмийг Канси хаан, нэгдүгээрт, тэнд Галдангийн нэг хэсэг цэргийг бут цохисны, хоёрдугаарт, гэнэт газар доороос булаг гарч, цэргүүдийг нь ангаж үхэх аюулаас аварсны дурсгал болгон баруулах зарлиг буулгажээ. Эзэн хааны зарлигаар боссон бусад бүх л сүмийн адил үүнийг ч бас байгалийн боржин чулуугаар босгосон болохоор Өргөөд байдаг Майдарын модон сүмээс архитектурын болон чимэглэлийн хувьд хавьгүй илүү юм билээ”*<sup>147</sup> гэж тэмдэглэжээ. Манжийн Энх-Амгалан хааны үед Толь булаг хэмээх газар сангийн мөнгөөр сүм байгуулж, Найралт Төвийн 8 (1730) онд дуусган Хөх хотын Түмэдээс нэгэн да ламыг зургаан шавийн хамт урин суулгасан тухай баримт үлдсэн байна.<sup>148</sup> Дорноговь аймгийн газрын зурагт хийдийн туурийг тэмдэглэжээ. Толийн Зуугийн хурлын туурь Сүүжийн худгаас баруун хойд зүгт 22 км орчим зайтай, Хатанбулаг сумаас зүүн урд зүгт 21 км орчим зайтай байна. Тус өртөө өнөөгийн Хатанбулаг сумын Сулин хээр багийн нутагт байжээ.

5. Төгрөг өртөө. *“Төгрөг өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн гучин газрын адаг Сайн заваг, Улаан хонд хоёрын хоорондох газар”, “Төгрөг өртөөний зүүн этгээд тэдний нэр зааж тэмцсэн гучин газрын адаг Цагаан хад”, “Төгрөг өртөөний баруун этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн гучин газрын адаг ...-ийн хойд Тээг”* гэж бичсэн нь 30 газар буюу баруунаас зүүн тийш 34 км орчим газар нутагтайг харуулна. Тус өртөөний тухай П.Кафаров *“Ногоорон үзэгдэх хонхор луу бууж ирвээс Төгрөгийн өртөө гэгч нь юмсанж. Нэгэн их нуур байх агаад түүн рүү хүрч болох нэг тал нь намаг ихтэй, нөгөө гурван талаар нь бударгана ургасан элсэн далангууд үргэлжлэх ажгуу. Энэхүү Төгрөгийн өртөө гэгч нь их говийн хамгийн сүүлчийн өртөө аж. Дараачийн өртөөнүүд нь Халхын нутагт ордог”*<sup>149</sup> гэжээ. Мэргэн засгийн хошуунд буй бүх өртөө Халхын нутагт хамаарахыг П.Кафаров андуурчээ. Хүрээгийн сайрын ард, Гүн тойрмын зэргэлдээ Төгрөг худаг бий. Дорноговь аймгийн газрын зурагт Төгрөгийн худгийг тэмдэглэсэн байдаг. Толийн Зуугийн хурлын тууриас баруун хойд зүгт 27 км орчим зайтай, Хатанбулаг сумын төвөөс хойд зүгт 6 км орчим зайтай, Эргэлийн зоогийн зүүн урд талд бий.

6. Мухар гашуун өртөө. Тус өртөөг *“Мухар гашуун өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн далан газрын адаг Санга”, “Мухар гашуун өртөөний баруун*

<sup>146</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.202

<sup>147</sup> А.Позднеев. Дорожная замятки на пути по Монголии въ 1847 и 1859 гг. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ., 1892. стр. 181

<sup>148</sup> Монголын сүм хийдийн түүхээс. Баримт бичгийн эмхтгэл. Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Гандантэгчэнлин хийд Эрдэм соёлын хүрээлэн. УБ., 2012. т.11

<sup>149</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.205

этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг Ухаа дэлийн бууцны өмнө этгээд газар”, “Мухар гашуун өртөөний зүүн этгээд тэдний нэр зааж тэмцсэн далан газрын адаг Од”, “Мухар гашуун өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг Бударганы хошууны баруун хяр” хэмээн бичжээ. Энэ нь зүүнээс баруун тийш нийтдээ 140 газар (140 х 576 м = 81.792 м) буюу 81 км орчим юм. Тус өртөөнд өмнөх өртөөнөөс даруй 3 дахин их газар нутаг олгосон байна. Нэг хошуунд буй өртөөнд өөр хэмжээтэй газар олгосон нь учиртай. Чухам тус өртөөнд нэгдүгээрт, мал сүргийг оторлуулах газрыг байгуулсан, хоёрдугаарт, цагдан сэргийлэх цэрийг олноор суулгаж байсантай уялдаж илүү газар олгож байсан бололтой. П.Кафаровын тэмдэглэлд “Хайрхны хормойгоос хөндлөн явсаар мөн л тэгш талын дунд орших Мухар гашууны өртөөн дээр хүрч ирвэй”<sup>150</sup> гэж бичжээ. Тэрбээр Өртөө Хонгор толгойгоос шууд Мухар гашуун өртөөнд ирсэн мэт байна. Мухар гашуун бол өнөөгийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвөөс 33 км зайд Эргэл багийн нутагт орших Гашууны худаг юм. Төгрөгийн худгаас баруун хойд зүгт Хяр хоолой, Газар дундын элс, Гашууны сайрыг туулан 28 км орчим яваад Мухар гашууны өртөөнд ирнэ.

7. Хоньч өртөө. Эл өртөөний тухай “Өртөөний баруун этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг Харганын хоолойн хойд гүвээ”, “Хоньч өртөөний баруун этгээд тэдний нэр зааж тэмцсэн далан газрын адаг Цавчарын худаг ус”, “Хоньч өртөөний зүүн этгээд ... тэмцсэн далан газрын адаг ...”, “Хоньч өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг ...” гэж тэмдэглэжээ. Хоньч өртөө зүүнээс баруун тийш 81 км орчим газар нутагтай. Эл өртөөний тухай П.Кафаров “Жинхэнэ Хоньчийн өртөө нь хийдийнхээ дорно этгээдэд байрлах ажээ. Монголоор бол Хоньчийн сүм, хятадаар бол Бозньси буюу Их энэрлийн сүм хэмээх нь уран барилгын гайхалтай үзэсгэлэнт хийц хэлбэртэй, дотроо гэрэл гэгээ ихтэй, цэвэрхэн бөгөөд тансаг тавилгатай, хятад уран зургаар чадамгай чимэглэсэн, энэ ч тэр ч хананд нь Сининь газрын хивс өлгөсөн байлаа”<sup>151</sup> хэмээн тэмдэглэсэн бол А.Позднеев “Энэ хийдэд 200 орчим лам байнга сууна, нийт хүн ам нь 500 орчим, мөргөл, хурлын үеэр бол 2000 хүрнэ”<sup>152</sup> гэжээ. Хийдийн туурь Хайрхан Булаг уулын зүүн талд оршино. А.Кафаровын мэдээгээр өртөө нь хийдийнхээ зүүн талд Хоньчийн сайран дээр Талын шанд худгийн дэргэд байсан бололтой. Урд талд Цагаан Овоот толгой, баруун талд Хоньчийн толгод байрлана. Хоньчийн хийдийн туурь Дорноговь аймгийн Мандах сумын Алхан тээг багийн нутаг Нарангийн булаг хэмээх газар сумын төвөөс зүүн урд зүгт 77 км зайтай оршино. Дорноговь аймгийн газрын зурагт хийдийн туурийг тэмдэглэжээ. Гашууны худгаас баруун хойд зүгт 44 км орчим зайтай юм. Тус өртөө нэлээд сунгуу өртөө байсан бололтой.

8. Билгэх өртөө. “Билгэх өртөөний баруун этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг Сайн сүүж худаг усны баруун гүвээ”, “Билгэх өртөөний баруун этгээд нэр зааж тэмцсэн далан газрын адаг Сайн сүүж”, “Билгэх өртөөний зүүн этгээд журганы занги засаг нарын хэмжээлсэн далан газрын адаг Бөөрөнхий чулуу”, “Билгэх өртөөний зүүн этгээд нэр зааж тэмцсэн далан газрын адаг Үйзэн худаг ус” гэжээ. Билгэх өртөөний эзэмшил нутаг зүүнээс баруун тийш 81 км орчим газар байна. Уг Билгэх өртөөний байршлын тухай П.Кафаров “Тэр өртөө мөн л хязгааргүй их талын дунд орших бөгөөд зүүн талаар нь олон жижиг ухаа гүвээд эмжин тогтжээ. Тэндхийн айлууд түлшиндээ аргал биш, харин ойр хавьд маш их ургадаг хайлаас модны хуурай мөчир түлдэг юм билээ. Газрын байдал нь ерөнхийдөө зүүн хойноос баруун урагш намссан төлөвтэй”<sup>153</sup> гэжээ. А.Позднеев “Нарийн Билгэхийн өртөөг бас Билгэх гэдэг, харин албан ёсны нэрийг нь Хатавчийн өртөө гэдэг. Хатавчийн өртөөнөөс хойш 7

<sup>150</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.204

<sup>151</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.205

<sup>152</sup> А.Позднеев. Дорожня замьтки на пути по Монголии въ 1847 и 1859 г. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ., 1892. стр. 184

<sup>153</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.206



орчим мод газарт байдаг Цэнхэр дов хэмээх газраар Мэргэн засгийн хошууны нутаг дуусна”<sup>154</sup> гэж бичжээ. Билгэхийн өртөө Хатавчийн өртөө хоёр бол тусдаа газар байсныг А.Позднеев андуурчээ. Мөн нутгийн зургаар бол Билгэхийн өртөө Мэргэн засгийн хошууны хамгийн хойд талын өртөө биш юм. БНМАУ-ын Геодези, зураг зүйн газраас 1986 онд эрхлэн гаргасан 1:225.000 масштабтай Дорноговь аймгийн Мандах сумын газрын зурагт сумын баруун урд талд Билгэх нэртэй газар байхгүй. Бид уг нэрийг нутгийн ахмад настан, малчдаас асуухад сайн мэдэхгүй, “Уул гээд” хийдийн туурийг зааж өгсөн бөгөөд үүгээр өртөө зам явдаг байсан гэв. Уул гээд хийдийн туурь сумын төвөөс баруун урд зүгт 40 км зайтай, хойд талаараа уулархаг, зүүн талаараа томоохон голын сайртай дэнж дээр байрлаж байна. Хэд хэдэн барилгын шавар туурь үлджээ. Хойно буй том туурийг нутгийнхан малын хороо болгон ашиглаж байсан гэлтэй хаалга хийж, цонхыг нь даржээ.

9. Хацавч өртөө. Хацавч өртөөний тухай П.Кафаров “Хатавчийн өртөөнөөс хойд зүг рүү хөтлөн гарсан зам элсэн манхан, далангуудын дундуур мургинсаар тачир өвстэй хээр тал руу гарч ирснээ дахиад л элсэн говь руу шурган орно. Удалгүй Хатавчийн давааг өгсөн мацаж эхлэхүй нуранги элсэнд тэрэгний дугуй, морь, тэмээний хөл шигдээд явж өгөхгүй нэн хэцүү байсан”<sup>155</sup> хэмээн өгүүлжээ. Нутгийн зурагт тэмдэглэсэн Хацавч хэмээх нэр хожуу Хатавч болсон мэт байна. Тус үг ижил утгатай юм. Хатавчийн ус Дорноговь аймгийн Мандах сумын нутагт сумын төвөөс баруун урд зүгт 20 гаруй км, Халзан овоот уулын ард талд, Талбарын голын баруун талд дөрвөн талдаа уулсаар хүрээлэгдсэн хадан дунд байрлана. Нутгийн ахмад настан Эрдэнэбилэг “Хатавчийн булгийн баруун талаар халзарсан хэсэг газар бий. Үүнийг манай хууччуул өртөө зам гэж ярьдаг байсан юм. Энэ зам уулын ам руу ороход хоёр талын хадыг тэгшилж зассан байдаг. Энэ зам дагуу морины тах ихээр олддог” гэж хуучилсан юм. Биднийг тэнд очиход элсэрхэг, хоёр талаараа бартаа ихтэй, зарим уулын хормойд буй хадыг зассан гэлтэй чулуу өрсөн байлаа.

Дараагийн дөрвөн өртөө Түшээт хан аймгийн Ачит засгийн хошууны нутагт бий. Тус хошууны нутгийн зураг лавтайяа 10 бий. Үүнээс 7 зураг ҮНС-д<sup>156</sup>, 1 зураг Германы Бонны номын санд<sup>157</sup>, 2 зураг ГЗБГЗЗГ-ын архивт байна.<sup>158</sup> 1892 оны “засаг тэргүүн зэрэг тайж Жамьянхорлоо агсны хошууны нутгийн зураг”<sup>159</sup>-т “damjalatu örtege” (дам Залаат), “jöbüri örtege” (Зөөвөр өртөө), “dam boruobuγ-a örtege” (дам Бор овоо өртөө), “kötöldölun örtege” (Хөтөл долоон өртөө) гэх 4 өртөөг зуржээ. Өртөөг гурвалжин хэлбэртэй тэмдэглэжээ. Нутгийн зургийн өмнө талаас баруун хойд зүгт хошууны хилийн дагуу замыг хүрэн өнгөөр давхарлан будсан байна. Нутгийн зургийн баруун талд өртөөний эзэмшил нутгийн овооны нэрийг бичсэн байна.

10. Залаат өртөө. Тус өртөөг П.Кафаров “...эртний туурийн үлдэгдэл гэмээр хэсэг хар хад чулуу тааралдана. Тийн буугаад бутархаг ургамал, ногоон зүлэг хослон харагдах тэгш талаар гэлдрүүлсээр Залаат өртөөнд хүрч ирэв”<sup>160</sup> хэмээн бичжээ. Дорноговь аймгийн 1:550.000 масштабтай газрын зурагт Залаат хэмээх нэр тааралдахгүй байна. 2015 оны 6 сард Мандах сумын иргэн С.Мөнхбаяр, Л.Дамдинсүх, Э.Эрдэнэбаатар, Ш.Лувсандорж нар Ачит гүний хошууны нутаг Замын булаг, Замын дэл, Замын тойром, Улаан дэлээр өнгөрч Хацавчийн өртөө, Хадан хөндий Залаатын тахилгат овоо, Амаар

<sup>154</sup> А.Позднеев. Дорожня замьтки на пути по Монголии въ 1847 и 1859 г. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ., 1892. стр. 187

<sup>155</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.208

<sup>156</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 819/96, 820/96, 821/96, 822/96, 841/96, 843/96, 8750/96

<sup>157</sup> <http://mongol.tufs.ac.jp/landmaps/>

<sup>158</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-15, 16

<sup>159</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-16

<sup>160</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.208

гарахын худгийг дайрч Залаат өртөөнд хүрсэн тухай бичжээ.<sup>161</sup> Бид Залаатын өртөөг хайж Мандах сумын нутагт төөрч явахад ахмад настан Уртнасан гуай зам зааж өгөв. Тэрбээр *“Биднийг бага байхад Залаатын хонхрын Харчингууд гэж ярьдаг байлаа. Одоо Сүмбэр л гэж дуудна. Залуучууд Залаатын тухай бараг мартсан. Сүмбэр уулын баруун талд Залаатын хийдийн туурь бий”* хэмээн тайлбарлав. Залаатын ус Дорноговь аймгийн Мандах сумын Баянхошуу багийн нутагт сумын төвөөс баруун зүгт 40 км Сүмбэр уулын баруун хойд суганд байрлана. Чулуун өрлөгтэй нэг худаг юм. Баруун, зүүн тийш харсан хоёр төмөр онгоцтой. Усны гарц сайтай аж. Залаат уснаас баруун урд зүгт 1 км зайтай Сүмбэр уулын баруун урд суганд Залаатын хийдийн туурь байх ажээ.

11. Зөөвөр өртөө. Уг өртөөнд очсон П.Кафаров *“Олон олон манхдын дундуур сүлжин явсаар тэр чигээрээ сул элстэй газар байрлах Зөөвөр хэмээх өртөөнд хүрэв. Тэр хавьд хар чулуу зонхилсон боловч хөрснийх нь өнгө улаавтар, өвс ургамал нь урьдынхаас шал өөр болой”*<sup>162</sup> гэж тэмдэглэжээ. Үнэхээр сул элстэй газар юм. Намар биднийг очиход бут, харгана их ургасан байлаа. Зөөврийн худаг нь Өмнөговь аймгийн Манлай сумын Өехий багийн нутагт Загсгалтын зооны ар талд Зөөврийн овоот толгойн зүүн талд Зөөврийн Улаан тойрмын зүүн урд талд олон толгод дунд байна. Энд зэргэлдээ хэд хэдэн худаг гаргажээ. Залаатын уснаас баруун хойд зүгт 25 км орчим зайд байх ажээ.

12. Бор-Овоо өртөө. П.Кафаров *“Тийн явсаар тэв тэгшхэн талын дунд орших Бор овоогийн өртөөнд хүрвээс харин ч булгийн сайхан устай юмсанж”*<sup>163</sup> гэжээ. Өмнөговь аймгийн Манлай сумын Өехий багийн нутагт Даамайн булаг усны зүүн талд Бор овоот толгойн баруун урд байрлана. Бор овоо усны зүүн талаар урт нуруу үргэлжилнэ. Хойд талд 10 км зайтай Загийн говь харагдана. Тэгш талд сайран дотор хоёр худаг бий. Хойд талын худаг зүүн тийш харсан төмөр онгоцтой, чулуун өрлөгтэй аж. Зөөврийн их уснаас баруун хойд зүгт 26 км зайтай. Бор овоо уснаас чанх хойд зүгт 1 км-т уулын энгэрт Бор овоо хийдийн туурь байна.

13. Хөтөл долоон өртөө. Эл өртөөг П.Кафаров *“Орчин тойрноо харц сунгаваас элсэрхэг тэгш тал агаад хөрсний гадарга дээгүүр нарийн хар чулууд торойно. Зүүн хойд толгойнх нь орой дээр овоо, хормой дор нь жижигхэн сүм барайна”*<sup>164</sup> гэж дурджээ. Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг сумын төвөөс зүүн урд зүгт 60 км зайтай Жавхлант уул, Өөш манханы дунд Хөтөл ус байх ажээ. Хөтөл ус нь Бор овоо уснаас баруун хойд зүгт 32 км зайд оршино. Урд харагдах Өөш манхныг баруун талаар нь ороогоод явахад Хөтөлийн хийдийн туурь дээр очно. Хийдийн туурь уулын нөмөрт байрлана. Түүхий тоосго, шар шавраар хийдээ барьсан байна. Хожим айлууд хийдийн туурийг хороо болгон ашиглажээ.

14. Сайр ус өртөө. Тус өртөө Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутаг өнөөгийн Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутагт буй Талын ус юм. Талын усыг Сайр ус, Тал долоон зэргээр нэрлэж байжээ. Талын уснаас урд зүгт 20 км орчим зайтай Хавтгай уул үргэлжилнэ. Баруун, зүүн, хойд зүгт ойр орчим уулгүй тэгш хөндий үзэгдэнэ. Баруун урд зүгт хэдэн толгой харагдах агаад орой дээрээ овоотой. Нутгийн иргэдийн яриагаар энэ овоог эртнээс тахиж иржээ. Тиймээс тэр толгодыг Тахилгат гэж нэрлэдэг аж. Талын усанд гурван худагтай. Нутгийнхан дунд худгаас ундаалах төдийгүй малаа усалдаг бололтой. Урд болон хойно байгаа хоёр худгийг шагайж үзэхэд төдийлөн ашигладаггүй мэт. Талын ус дэрс, бутаар хүрээлэгдсэн сайран дунд хонхор газар байрлана. Эртний гол мөрний сайр бололтой хайрга, чулуу ихтэй хөндий ажээ. Тиймээс Сайрын ус буюу Сайр ус гэж нэрлэж заншсан байх. Нутгийнхан худаг, булаг зэрэг усны ундаргатай газраа ус хэмээн дууддаг. Өлзийт сумын малчин ахмад настан Б.Дэмбэрэл гуай *“Талын усны энэ хөндийд эрт долоон худаг байсан гэдэг. Тэрээр Тал долоон гэж*

<sup>161</sup> Ш.Лувсандорж. Дорноговь аймгийн Мандах сумын хураангуй түүх. УБ., 2017. т.26

<sup>162</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.208

<sup>163</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.209

<sup>164</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.210

нэрлэж байсан юм” хэмээн хуучлав. Сайр ус умард зүг Хүрээ, өрнө зүг Улиастай, өмнө зүг Хаалган руу явах замыг холбосон зангилаа газар юм. Сайр усны өртөөнд Бээжингээс гурван жилийн хугацаатай томилогддог 2 хүн байнга суудгийн нэг нь Ичжуньдао буюу шуудангийн бүх өртөөний захирагч, нөгөө нь бичээч-нарийн бичгийн дарга юм.<sup>165</sup> Сайр усны өртөө нэлээд том суурин байсан ул мөр өдгөө хадгалагдан үлджээ. Эндээс түүхий тоосго, төмөр хонх, ваар, шаазангийн хагархай, байшингийн сууриуд, хятад хөөрөгний хагархай, холоос зөөж ирсэн гэлтэй гоёмсог чулуун эдлэл олддог. Талын худагас хойд зүгт 2 км орчим зайтай Жасын туурь нэртэй чулуу өрж түүхий шавраар шавардсан хоёр байшингийн үлдэгдэл бий.

Хярын мухараас Сайр ус хүртэлх 14 өртөө Халхын Түшээт хан аймгийн Мэргэн засаг, Ачит засаг, Түшээт засгийн хошууны нутгаар дамжин явдаг байжээ. Тус өртөөний үндсэн албыг харчингууд гүйцэтгэнэ. Мэргэн засгийн хошууны Сүүж, Толь, Хоньч, Хацавч зэрэг өртөөний ойролцоо сүм хийд байжээ. Үүнийг аялагчдын тэмдэглэл, албан сурвалж, хийдийн тууриас мэдэж болно. Гэтэл нутгийн зурагт тэмдэглээгүй байна. Мэргэн засгийн хошууныхан өртөөтэй бэлчээр булаалдан маргаан өрнөсөн бололтой. Нүүж ирсэн Харчингуудад олгосон өртөөний эзэмшил газрыг тодорхой тэмдэглэжээ. Мэргэн засгийн хошууны нутгаар 9 өртөө дамжин гардаг байсны 6 нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт, 3 нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт бий. Ачит засгийн хошууны 4 өртөөний 1 нь аймгийн Мандах сумын нутагт, 2 нь Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт, 1 нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байна.

## 2. Сайр усаас Их Хүрээ хүртэлх өртөө

Харуул, өртөөг тэмдэглэсэн бүдүүвч зурагт Сайр усаас Их Хүрээ хүртэл “süji” (Сүүж), “soluyai” (Солгой), “buyangbilgekü” (Баянбилгэх), “bayangqosiu” (Баянхошуу), “borubürin” (Борбүрэн) “tourum” (Тойром), “modun” (Модон), “naran” (Наран), “talbulay” (Талбулаг), öngdür dobu (Өндөр дов), jiryalangtu (Жаргалант), amaγulangtu (Амгалант), bayasqulangtu (Баясгалант), sonusqulangtu (Сонсголонт) гэсэн 14 өртөөний нэрийг бичжээ.<sup>166</sup>

Тус өртөөд Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошуунаас эхэлнэ. Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн зураг лавтайяа 6 бий. 1868, 1901-1904, 1911 оны 3 зураг ҮНС-д, 1907 оны зураг ГЗБГЗЗГ-ын архивт, 2 зураг (1914, 1922) хагас дутуу гэрэл зургийн шилэн хальс хэлбэрээр ҮТА-д хадгалагдаж байдаг.<sup>167</sup> Үүнээс 1907 оны “Халхын Түшээт хан аймгийн чуулганы дэд дарга, засаг улсын түшээ гүн Ча-гийн хошууны нутгийн зураг”<sup>168</sup>-т Чуулалт хаалга-Улиастай чиглэлийн 10 өртөөг тэмдэглэжээ. Чингэхдээ өртөөний эзэмшил нутгийг хошууны нутгаас ялган тусад нь зурсан байна. Өртөө замыг хар бэхээр цэг хатган зурж өртөөний сууринг гурвалжин хэлбэртэй тэмдэглэсэн байна. Нутгийн зургийн хэмжээсээр баримжаалбал суурь өртөө хоорондын зай 50 илүү газар буюу (50 x 576 м = 28800 м) 28 км байна. Нэг өртөөний нутаг хааш хаашаа 50 газрын (50 x 50 x 576 м = 1440000 м) буюу 1440 ам дөрвөлжин км хэмжээтэй байгаа нь мэдэгдэнэ. Зүүн талаас “taldolun örtege” (Тал долоон өртөө), “süji örtege” (Сүүж өртөө) өртөөний нэрийг бичжээ.

1. Сүүж өртөө. Уг өртөө Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутагт өнөөгийн Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутаг Сүүжийн ус хэмээх газарт байна. Сайр усаас чанх хойшоо 20 гаруй км яваад Сүүжийн өртөөнд ирнэ. Монголчууд хоорондоо ойрхон зайтай өртөөг татуу өртөө гэдэг. Сүүжийн өртөө бол татуу өртөө юм. Сүүж нь

<sup>165</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.210

<sup>166</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-52

<sup>167</sup> Ж.Гэрэлбадрах. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн нэгэн зургийн судалгаа.//Монголын газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т.55

<sup>168</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-35

баруун талдаа бэсрэг толгодтой. Толгод баруун урдаас зүүн урд зүгт худгаа ороож тогтсон байна. Тиймээс нутгийн иргэд толгодын төгсгөлд буй учраас мал, амьтны сүүжтэй адилтган нэрлэсэн бололтой. Баруун талын толгой дээрээс ойр орчмын бүх зүйл ил тод харагдана. Толгойн урд талын энгэрт хашаа хорооны бололтой туурь, энд тэндээс зөөж авч ирсэн чулуу, түүхий тоосго хөглөрсөн байна. Сүүжийн худгийг хожуу засаж өндөр худаг болгожээ. Худгийн баруун талаар Мандалговиос Өмнөговь аймгийн Манлай сумыг холбосон сайжруулсан шороон зам дайран өнгөрнө. Зүүн зүгт уудам тал цэлийнэ. Хойд зүгт ажихад алсад урт урт нуруу үргэлжилнэ.

Сүүж өртөөнөөс Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошуу дуусаж Дайчин засгийн хошуу залгана. Дайчин засгийн хошууны нутгийн 5 зураг бий. ҮНС-д 4 зураг байна.<sup>169</sup> ГЗБГЗЗГ-ын архивт буй “Түшээт хан аймгийн улсад туслагч гүнгийн засгийн тэргүүн зэрэг тайж долоон зэрэг нэмсэн таван зэрэг тэмдэглэсэн Батсуурийн хошууны нутгийн зураг”<sup>170</sup>-т өртөөний замыг шар бэхээр будаад өртөөний сууринг хар гурвалжин хэлбэртэй зуржээ. Тус зурагт Их Хүрээнээс Сайр ус чиглэлийн долоон өртөөг тэмдэглэжээ. Дээд талд нь “qalq-a-yin örtege jam” (Халхын өртөө зам) хэмээн хар бэхээр бичсэн байна. Урд талаас нь эхлэн “soluγai örtege” (Солгой өртөө), “bilgekü örtege” (Билгэх өртөө), “bayangqosiu örtege” (Баянхошуу өртөө), “boru day-a örtege” (Бордаага өртөө), “toyirum örtege” (Тойром өртөө), “modun örtege” (Модон өртөө), “naran örtege” (Наран өртөө) гэж бичжээ.

2. Солгой өртөө. Солгой ус Дундговь аймгийн Өлзийт сумын Буянт багийн нутагт сумын төвөөс зүүн хойд зүгт 50 км-т оршино. Сүүжийн худгаас чанх хойд зүгт 24 км зайтай. Сүүжийн худгаас Солгой усанд ирэхэд тэгш тал дундуур явна. Солгой ус Хатуу уулын зүүн үзүүрт цагаан хадтай цохионы дор эргэн тойрон дэрстэй газар байх ажээ. Зүүн тийш уудам тал үргэлжилнэ. Энд мотортой худаг, усны ундарга сайтай булаг бий. Булгийн гарц сайн хэдий боловч хашаалж хамгаалтад аваагүй учраас мал орж тахалжээ. Уснаас шивтэр амтагдаж байв. Худгаас нутгийнхан амны усаа авна. Худгийн дээр блок өрж шавардан дээвэр хийж, дотор нь мотор тавьжээ. Солгой хэмээх нэрийн тухайд Хатуу уулын зүүн үзүүрт буюу солгой талд байх учраас ийнхүү нэрийдсэн бололтой.

3. Билгэх өртөө. Билгэх ус Дундговь аймгийн Гурвансайхан сумын Дэрсэн ус багийн нутагт бий. Сумын төвөөс баруун зүгт 40 км, Солгой уснаас чанх хойд зүгт 21 км зайтай. Билгэх хайрхны баруун урд өвөрт Билгэхийн худаг байна. Билгэхийн худаг эргэн тойрон хайрга ихтэй элсэрхэг газар байрлана. Усны ундарга сайтай, усаа гараар татдаг ажээ. Нутгийн иргэд ундны усаа авч малаа усалдаг бололтой. Жижиг чулуу ихтэй элсэрхэг хөрстэй ажээ. Худгаас баруун хойд зүгт Үнстэй хар уул тод харагдана. Урд талд нь тэгш тал үргэлжилж хойшоо өндөрлөг болж ирнэ. Худаг дээр бидэнтэй таарсан Өлзийт сумын Буянт багийн малчин Н.Батаа гуай “Сүүж, Солгой, Билгэхийн усыг холбосон энэ шулуун замыг манай нутгийнхан Хүрээ зам гэж хэлдэг” гэв. Өртөө зам татан буугдаад зуу орчим жил болсон ч нутгийн иргэд уг нэрийг нь хэвээр хэрэглэж байна. Засмал замгүй үед энэ замаар Улаанбаатар хот руу явдаг байжээ. Одоо энэ замаар машин бараг явдаггүй бололтой, өвс ургамал ургаж ихэд бүдгэрчээ. Билгэхийн худгийг Билгэх хайрхны нэрээр нэрлэсэн байна.

4. Баянхошуу өртөө. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Дэрсэн ус багийн нутагт бий. Билгэхийн худгаас чанх хойш 22 км зайтай. Баян хошууны худаг эргэн тойрон хад асгатай хэд хэдэн толгой хошууран түрж орсон хэсэгт хонхор газар байрлах ажээ. Хэд хэдэн толгодын хошуу нийлэх учраас Баянхошуу хэмээн нэрийдсэн бололтой. Хошууран орж ирсэн эдгээр толгодоос өөр ойр хавьд уул, толгой байхгүй, тэгш тал үргэлжилнэ. Эргэн тойрон хад, хайрга, дэрс ихтэй. Энд уламжлалт чулуун өрлөгтэй хоёр худаг байна. Худгийн ундарга муу. Урд талын худагт мотор тавьжээ.

<sup>169</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 824/96, 825/96, 3483/96, 818/96

<sup>170</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 824/96

5. Бордаага өртөө. Тус өртөөг Борогчин, Бордаага зэргээр сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Дундговь аймгийн Сайнцагаан сумын Далай багийн төвөөс зүүн тийш 8 км зайтай Борогчин уулын зүүн урд бэлд байх ажээ. Баянхошуу өртөөнөөс чанх хойд зүгт 23 км зайтай. Борогчин ус урд талаараа дэрс зонхилсон сайран дунд байрлана. Зүүн талаар нь тал хөндий үргэлжилнэ. Урд талд 8 км зайтай хоёр хар уул харагдана. Хүрээ зам тус хоёр хар уулын дундуур гарч ирнэ. Борогчин усны худаг гарц сайтай ажээ. Нутгийн иргэд ундны усаа эндээс авна. Борогчин усны баруун талаар үргэлжилэх хөндийг Бордаагын хөндий гэдэг билээ.

6. Тойром өртөө. Тус өртөөний туурь Дундговь аймгийн Дэрэн сумын Алаг-Өндөр багийн нутагт байна. Бордаагаас чанх хойд зүгт 20 км зайтай. Тойромын урд талаар урт үргэлжилэх намхан нуруу бий. Хойд талдаа бэсрэг толгодоор хүрээлэгджээ. Алсын бараа харагдахгүй. Баруун, зүүн талд ижил хөндий үргэлжилнэ. Тойром хужир мараатай эргэн тойрон дэрсээр хүрээлэгджээ. Тойром одоогоор ширгэсэн байдалтай байна. Тойромын зүүн урд талд чулуун овоолго хэд хэд тааралдана. Нутгийн иргэд “Өртөө тойром” гэж нэрлэдэг.

7. Модон өртөө. Эл өртөө Дундговь аймгийн Дэрэн сумын Саруул багийн нутагт бий. Модон ус нь Модонгийн зооны ар талд эргэн тойрон жижиг толгодоор хүрээлэгдсэн газар оршино. Хад чулуу ихтэй, дэрсэрхэг газар ажээ. Дөрвөн талаас зам орж ирээд Модон худагт нийлдэг. Модон худаг усны гарц сайтай аж. Худгийг модоор доторложээ. Модонгийн зооны ард талд байрладаг учир Модон өртөө гэж нэрлэсэн бололтой. Тойромын өртөөнөөс чанх хойд зүгт 30 км зайтай. Модонгоос урагш, хойш явсан замыг нутгийн иргэд мөн “Өртөө зам” гэж нэрийдэж байна.

8. Наран өртөө. Тус өртөө Дундговь аймгийн Дэрэн сумын нутагт Наран уулын баруун урд энгэрт байрлана. Наран булаг Модон худгаас чанх хойд зүгт 32 км зайтай. Модон худгаас Наран булаг хүртэлх замд хоёр худаг бий. Урд талын худгийг Арын ус гэнэ. Арын ус ундарга сайтай. Урт талаар намхан урт нурууд, баруун, зүүн талаар тал хөндий үргэлжилнэ. Эргэн тойрон дэрс ихтэй хөндийн дээд талд Наран булаг байна. Наран булгаас ус ундран гарч доод хөндий рүү урсана. Наран булгаас ус жилийн дөрвөн улирлын турш ундрах ажээ. Наран булгийн ар талын Наран уулын оройд 3 ширхэг том чулуун овоо босгожээ. Нутгийнхан Нарангийн гурван овоо гэж нэрлэнэ. Нутгийн малчид Тойром, Модон худаг, Наран булгийг дайран явах шулуун замыг “Өртөө зам” гэж нэрлэсэн хэвээр байна. Өртөөний ул мөрийг өдгөө ч хадгалан үлджээ. Замын дагуу хоёр талд 500 м орчим газар яваад л томоохон боржин чулуу тааралдана. Өндөрлөг газар чулуун овоолго эгнүүлэн тавьжээ. Дэрэн сумын ахмад малчин Н.Цэцэг гуай эдгээр зам дагуух чулууг замаас төөрөхгүй гэж тавьсан өртөөний таних тэмдэг гэж хуучилж байлаа.

Дараагийн өртөөд Дархан засгийн хошууны нутагт байна. Тус хошууны нутгийн зураг 5 бий. Үүнээс 1868, 1892, 1907, 1922 оны зураг ҮНС-д<sup>171</sup>, мөн 1907 оны нэг зураг Герман улсын Бонны ИС-ийн номын санд хадгалагдаж байна. 1907 оны “Түшээт хан аймгийн засгаар залгамжилсан хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын есөн зэрэг нэмсэн, найман зэрэг тэмдэглэсэн засаг хошууны бэйс Пунцагцэрэнгийн хошууны нутгийн зураг”<sup>172</sup>-т Их Хүрээний өмнө замын өртөөг улаан өнгө бүхий дугуй хэлбэртэй дүрсэлж, замаа тод шар өнгөөр буджээ. Зургаан өртөөний нэрийг хойноос дугаарлан бичсэн нь “nigedüger sonusqulangtu örtege” (нэгдүгээр Сонсголот өртөө), “qoyaduγar bayasqulangtu örtege” (хоёрдугаар Баясгалант өртөө), “γurbaduγar amuγulangtu örtege” (гуравдугаар Амгалант өртөө), “dörbedüger jirγalangtu örtege” (дөрөвдүгээр Жаргалант өртөө), “tabuduγar öngdürdobu örtege” (тавдугаар Өндөрдов өртөө), “jirγuduγar talabulaγ örtege” (зургаадугаар Тал булаг өртөө) юм. Нэг дөрвөлжинд 50 газар багтаасан уг хэмжээсийг баримтлан тооцвол, өртөө хоорондын зайг олж болно. Хүрээнээс Талбулаг хүртэлх 6 өртөөний

<sup>171</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 760/96, 759/96, 3490/96, 751/96

<sup>172</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 759/96

хооронд 6.6 дөрвөлжин (6.5 x 50 газар x 576 м = 187.200 м) 187 км байна. Өртөө хоорондын зай 31 км болно. Энэ нэлээд бодитой хэмжээ юм. Мөн хошууны нутгийн дундуур өртөөдийг зуржээ.

9. Тал булаг өртөө. Тус өртөө нь Төв аймгийн Баянцагаан сумын Алтад багийн нутагт бий. Сумын төвөөс баруун зүгт 42 км-т Адуун чулуу хэмээх уулын ард дэрсэн дотор Тал булаг байх ажээ. Ундарга нь уулынхаа араас гарч доошоо хөндий рүү урсдаг байжээ. Өдгөө ямарч усгүй хоосон ширэг болон үлдсэн байна. Тал булгийн баруун талд 3 км орчим зайтай Улаанбаатар Мандалговийг холбосон засмал зам байна. Наран булгаас чанх хойд зүгт 26 км орчим зайтай. Баянцагаан сумын малчин Мэндбаяр гуай “1998 оноос өмнө Тал булаг нь өвөл зунгүй ундаргатай байсан юм. Өвөл бол харзалж урсаад доод талын энгэр газрыг дүүргэдэг байлаа” гэж хэлэв. Тал булгаас 100 м орчим зайд нэгэн худаг буйг нэлээд хожуу малтаж гаргасан бололтой. Тал булаг Их Хүрээнээс 153 км зайтай юм.

10. Өндөр дов өртөө. Өндөр довын өртөө Дундговь аймгийн Баянцагаан сумын Өлзийт багийн нутагт байна. Зурхайчийн хөндий хэмээх дэрсээр хүрээлэгдсэн талын дунд онцгой ганц толгой буйг Өндөр дов хэмээн нэрийджээ. Тус толгойг өдгөө нутгийн зарим иргэд “Хуучин дов”, “Эрдэнэ толгой” зэргээр нэрлэж байна. Өндөр довын чанх ар талд 1 км орчим зайтай Довын худаг байна. Худгийн ус баруун тийш ундрэн гарч сайр үүсгэнэ. Худгийн баруун урд талд ус ихтэй тойром байна. Зүүн урд талд Социализмын үед баригдсан бололтой барилгын тууриуд үлджээ. Тал булгаас чанх хойд зүгт 33 км зайтай байна. Өндөр довын баруун талд 1 км зайтай Мандалговь-Улаанбаатарыг холбосон засмал зам бий. Замын дэргэд Өндөр довын хоолны газрууд байрлана.

11. Жаргалант өртөө. Төв аймгийн Алтанбулаг сум Шархайн Тариа багийн нутагт Жаргалант булаг бий. Жаргалант булгийн баруун талд Зос хайрхан уул онцгой тод харагдана. Жаргалант булгаас урагш тал хөндий ажээ. Баруун, зүүн, хойд зүгт уулс өндөрсөж илүү бартаатай болно. Өндөр довоос чанх хойд зүгт 32 км зайтай. Булгийн ойролцоо дов ихтэй юм. Булаг доош сайр үүсгэн урсана. Хур ихтэй жил сайруудыг дүүргэн урсдаг бололтой. Жаргалант булгаас 2 км зайтай зүүн талд Улаанбаатар-Мандалговийн хатуу хучилттай засмал зам байна.

12. Амгалант өртөө. Тус өртөөг зарим сурвалж бичигт Долоон өртөө гэж тэмдэглэсэн байдаг. Төв аймгийн Сэргэлэн сумын Тахилт багийн нутагт Амгалантын хөндий, Долоон толгой бий. Жаргалант булгаас зүүн хойд зүгт 21 км-т оршино. Урдаасаа хойшоо цуварсан толгод байна. Үүнийг нутгийнхан Долоон гэж нэрлэнэ. Тус толгодын зүүн талаар Долооны горхи, Долооны гол урсана. Баруун талд Улаанбаатар-Мандалговийн хатуу хучилттай засмал зам бий. Замаас баруун тийш Амгалантын хөндий бий болдог. Амгалантын булаг засмал замаас баруун тийш 1 км зайтай уулын энгэрт байрлана. Тус худаг усны гарц сайтай. Урагшаа харсан нэг онгоцтой аж. Усаа мотороор татдаг.

13. Баясгалант өртөө. Төв аймгийн Сэргэлэн сумын Тахилт багийн нутагт Бөхөгийн нуур, Эрдэнэ толгойн ард Баясгалант уул хэмээх газар бий. Баясгалант уулын урд талаар Бөхөгийн гол урсана. Бөхөгийн гол Алтанбулаг сум Шархайн тариа баг, Сэргэлэн сум Тахилт багийн нутгаар дамжина. Мандалговь-Улаанбаатарын чиглэлийн засмал зам Бөхөгийн голыг хөндлөн гарах ажээ. Баясгалант уул Долоон-Амгалантаас хойд зүгт 15 км орчим зайтай. Бөхөг голын хөвөөнд Баясгалант уулын энгэрт Баясгалант өртөө оршиж байсан бололтой.

14. Сонсголонт өртөө. Улаанбаатар хот Хан уул дүүргийн Сонсголонгийн гүүрний урд талд Сонсголонтын өртөө бий. Энэ хэсэгт Туул гол олон салаа урсаж усны түвшин гүехэн болж ирдэг. Тиймээс худалдаачид, аялагчид, өртөөгөөр яваа албаны хүмүүс Туулын олон салаа бэлчирт гол гэтэлгэн гардаг байжээ.

Сайр усаас Их Хүрээ хүртэлх 14 өртөө Түшээт хан аймгийн Түшээт засаг, Дайчин засаг, Дархан засгийн хошууны нутгаар дамжин гардаг байжээ. Түшээт засгийн хошуунд 1 өртөө буй нь өнөөгийн Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байна. Дайчин засгийн

хошуунд 7 өртөө байгаа юм. Тэдгээрийн нэг өнөөгийн Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт, 2 өртөө Гурвансайхан сумын нутагт, 1 өртөө Сайнцагаан сумын нутагт, 3 өртөө Дэрэн сумын нутагт хамаарна. Дархан засгийн хошууны нутагт 6 өртөө байжээ. Үүнээс 2 нь Төв аймгийн Баянцагаан сумын нутагт, 1 нь Алтанбулаг сумын нутагт, 2 нь Сэргэлэн сумын нутагт, 1 нь Улаанбаатар хотын Хан уул дүүрэгт тус тус байна.

### 3. Их Хүрээ-Хиагтын өртөө

Өртөө, харуулыг тэмдэглэсэн бүдүүвч зурагт Их Хүрээнээс Хиагт хүртэл “küi” (Хүй), “burγaltai” (Бургалтай), “buluγtoluγai” (Булаг толгой), “bayangbaruqai” (Баянбаруухай), “qaraγool” (Хараа гол), “šangdudobu” (Шанд дов), “nomtu” (Номт), “deresütü bulung” (Дэрст булан), “irüge γool” (Ерөө гол), “narin moγai” (Нарийн могой) гэсэн 11 өртөөг тэмдэглэжээ.<sup>173</sup>

Эхний 2 өртөө Халхын Түшээт хан аймгийн Илдэн засгийн хошууны нутагт байна. Илдэн засгийн хошууны нутгийн 1891, 1923 оны 2 зураг ҮНС-д хадгалагдаж байна.<sup>174</sup> “Хэбэй таван зэрэг нэмсэн, гурван зэрэг тэмдэглэсэн засаг улсад туслагч гүн Мандарвагийн хошууны нутгийн зураг”<sup>175</sup>-т өртөөний сууринг улаан өнгө бүхий дугуй хэлбэртэй дүрсэлсэн байна. Өртөө замыг хар бэхээр цэгэн шугам хатгаж тэмдэглэжээ. Тус нутгийн зурагт “küi-yin örtege” (Хүйн өртөө), “burγaltai-yin örtege” (Бургалтайн өрөө) гэж нэрийг урд талаас эхлэн бичжээ.

1. Хүй өртөө. Тус өртөөний тухай П.Кафаров “Толгойтын даваанаас буухад нэгэн гол таарсныг Хүйн гол гэх ажээ. Голын эргийн нуга даган явсаар, аажмаар баруун хойшоо эргэн голоос нэлээд алдарсан хойноо нэгэн өртөөн дээр ирвэл Хүйн өртөө юмсанж”<sup>176</sup> гэжээ. Харин А.Позднеев “Рашаантын голын хөндий рүү буухад замын баруун талд Гахай уул тосно. Рашаантын голын хөндий үргэлжилсээр Хүйн хөндийтэй нийлэх бөгөөд Өргөө-Хиагтын шуудан замын эхний өртөө болох Хүйн өртөө уг голын эрэгт оридог юм”<sup>177</sup> гэж тэмдэглэжээ. А.Позднеевын дурдах Гахай уулыг БНМАУ-ын Геодези, зураг зүйн газраас гаргасан 1:125.000 масштабтай 1986 оны Төв аймгийн Батсүмбэр сумын нэрийн зурагт тэмдэглээгүй байна. Хэдий тийм авч Хүй өртөө Батсүмбэр сумын нутагт Улаанбаатар хотоос чанх хойд зүгт 38 км зайтай Тасархай толгойн урд талд, Мөөгтийн амны зүүн талд Хүйн нуурын баруун дэнжид байрлана. Хүй өртөөний буудалдаг газар Их Хүрээ нутаглаж байсны тэмдэг болгон хөшөө босгожээ.

2. Бургалтай өртөө. П.Кафаров “Өлийн даваанаас Бургалтайн хөндий рүү буухад байгаль нь хачин сайхан, хөрс нь улаавтар өнгөтэй. Өртөөний баруун талаар Бургалтайн гол өмнө зүг рүү урсана”<sup>178</sup> гэж өгүүлсэн байдаг. Бургалтай өртөө Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Шанагын Зүүн уулын урд, Бургалтай голын хойд хөндийд байрлаж байжээ. Хүй өртөөнөөс Бургалтай өртөөнд хүрэхэд гол гэтэлж, намаг шавар, өндөрлөг газраар явдал тул бартаа ихтэй гэж ойлгож болно. Энэ нь Хүйн өртөөнөөс баруун хойд зүгт 18 км зайд юм.

Дараачийн өртөө Түшээт хан аймгийн Баатар засгийн хошууны нутагт байв. Баатар засгийн хошууны 7 зураг, нутгийн цэс ҮНС-д,<sup>179</sup> 1 зураг ГЗБГЗЗ-н архивт хадгалагдаж байна. 1868 онд үйлдсэн “Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж нэг зэрэг

<sup>173</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II данс-2, хн-52

<sup>174</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 767/96, 468/96

<sup>175</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 767/96

<sup>176</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 223

<sup>177</sup> А.Позднеев. Дорожные замьтки на пути по Монголии въ 1847 и 1859 гг. Императорскаго Русскаго Географическаго общества. Санктпетербургъ., 1892. стр. 227

<sup>178</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т. 224

<sup>179</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 723/96, 724/96, 8774/96, 8775/96, 713/96, 714/96, 719/96

нэмсэн, гурван зэрэг тэмдэглэсэн Цэрэндоржийн хошууны нутгийн зураг”<sup>180</sup>-т 4 өртөөг тэмдэглэжээ. Өртөөдийг урд талаас эхлэн “bayangool örtege” (Баянгол өртөө), “qaray-a örtege” (Хараа өртөө), “qorint örtege” (Хоринт өртөө), “quncil örtege” (Хунцал өртөө) гэж бичжээ.

3.Хунцал өртөө. Архивын баримтад “boru nuur” (Бор нуур)<sup>181</sup> гэж тэмдэглэжээ. Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн дансанд тус өртөөг “buluyangtoluyai” (Булган толгой)<sup>182</sup>, Хүрээний хойдох 11 өртөөний цэсэнд “buluyangtoluyai” (Булган толгой)<sup>183</sup>, “Энэ нэгэн дэвтэр”-т “buluyangtoluyai” (Булган толгой)<sup>184</sup> гэж тус тус бичжээ. Н.Я.Бичурин 1821 оны 7 сарын 21-ний өдөр тус өртөөгөөр дайран явжээ. Түүний тэмдэглэлд “30 орчим ли яваад уул давж нэргүй жижиг нуурын дэргэдэх Хатцэль (Хунцал) хэмээх эдлэнд (өртөөнд Ш.М.) буудаллав. Энд айлын бууц зөндөө байсан бөгөөд суурьшигчид хангалттай олон гэдэг нь илэрхий. Би салхилахаар хусан ойтой уулаар алхав. Нууранд олон ангир хөвж явна”<sup>185</sup> хэмээн өгүүлдэг. Түүнтэй хамт явсан Игорь Тимковский мөн л “1821 оны 7 сарын 21-ний 4 цагт бид Хунцал өртөөнд хүрч ирэв”<sup>186</sup> хэмээн бичжээ. Түүнээс 26 жилийн дараа 1847 оны 6 сарын 2-нд П.Кафаров Хунцал өртөөнд ирэхдээ “Уг өртөөний ойр хавийн газар Харчин нутгийнхтай төстэй санагдсан юм. Цайвар хужир намхан дэрстэй, эргэн тойрных нь толгод хээр талыг санагдуулна. Нэгэн жижиг нуурын эргэн тойронд сондуул, намаг ихтэй, өвс нь тачирхан ч ялаа шумуул ихтэй байлаа”<sup>187</sup> хэмээн тэмдэглэжээ. Сурвалжийн мэдээ, албан баримт, аялагчдын тэмдэглэлд өртөөний нэр зөрүүтэй буй нь Монгол нутаг дахь өртөөд улирал, байгаль, цаг уурын хүчин зүйлээс шалтгаалан эзэмшил дотроо нүүдэгтэй холбоотой юм. Өртөөний нэрийг нутаглаж буй гол мөрөн, нуур, тойром, худаг, булаг, уул, толгойн нэрээр нэрлэдэг.<sup>188</sup> О.Сүхбаатар авгай “Хүрээ Хиагтын 3 дахь өртөө Хунцалын голын эхний Булан тохойд өвөлжиж Аяга, Шанага хэмээх хоёр жижиг нуурын дэргэд зусдаг”<sup>189</sup> гэж бичжээ. Мөн Ц.Батсайхан нар “Хунцалын өртөө Хунцалын голын эх Булан толгойд өвөлжиж Аяга, Шанага хэмээх хоёр жижиг нуурын дэргэд зусдаг”<sup>190</sup> гэж О.Сүхбаатар авгайг шууд хуулжээ.

Нутгийн зургаас үзвэл, Хунцал нуурын эхэнд Булан толгой бус Тайлан толгой, Эрдэнэ толгой гэдэг нэр гарч байна. Хунцал голын дунд хэсэгт Дээд Булаг, Доод Булаг хэмээх хоёр толгой бий. Түүнийг андуурч бичсэн бололтой. Аялагчдын тэмдэглэл, нутгийн зураг, өртөөний зурагт Хунцалын ойролцоо зусдаг тухай тодорхой дурддаг. Харин хаана өвөлжиж байсныг шууд хэлээгүй ч Булган толгойд гэдэг нь ойлгомжтой байна. Булган толгой хэмээх газрын нэр өнөөгийн Булаг толгой мөн бололтой. Төв аймгийн газрын зурагт Хунцал голыг Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт тэмдэглэжээ. Хунцалын эх Нарст уул, Нарстын давааны зүүн талд оршино. Хунцал нь сумын төвөөс баруун зүгт 23 км-т байна. Харин Аяга, Шанага нуур Хунцал нуураас зүүн урд зүгт 8 км зайтай бий.

4.Хоринт өртөө. 1820 оны 9 сарын 10-нд Егорь Тимковский тус өртөөний сууринд иржээ. Тэрбээр “Бороо голыг бид дахиад 3 цагийн үед гатлаад Ноён уулын хормойд

<sup>180</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-14

<sup>181</sup> Монгол улс.УТА. Түүхийн баримтын архив. М-146, д-1, хн-4, 9, 10, 11,

<sup>182</sup> Дөрвөн аймгийн алба тэгшитгэсэн данс. Ред. Ш.Нацагдорж. УБ., 1962. т.22

<sup>183</sup> Монгол улс.УТА. Түүхийн баримтын архив. М-1. д-1, хн-5748, нугалбар эх-38

<sup>184</sup> Ene nigen debter amui. Галиглаж хөрвүүлсэн Ж.Гэрэлбадрах. УБ., 2006. т.147

<sup>185</sup> Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орч.Б.Даш-Ёндон. УБ., 2019. т.68

<sup>186</sup> Егорь Тимковский. 1820-1821 оны Монгол. Орч.Ж.Нэргүй. УБ., 2019. т.382

<sup>187</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.224

<sup>188</sup> Ш.Мөнхбаатар. Их Хүрээнээс Сайр ус хүртэлх өртөөний нэрийг нягтлах нь. //Цайны зам эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал. УБ., 2016. т.67

<sup>189</sup> О.Сүхбаатар. Монгол дахь цайны замын их замын суурь өртөөнүүдийн байрлал. //Нүүдэлчдийн өв. Томус XIII. УБ., 2012. т.66

<sup>190</sup> Ц.Батсайхан, Н.Төрбат, А. Мөнх-Эрдэнэ. Түмэн газрын цайны их зам ба Монгол орон. 2017. т.153



орших Хуримт өртөөнд хоноглохоор буув. Бидний буусан гэрээс баруун урагш нэгэн сунагар урт нуруу харагдах нь яг л шороон далан мэт, түүний тэгсгөл дээр Хуримт хэмээх сүрлэг цохио сэрийнэ<sup>191</sup> гэж бичжээ. Үүнээс яг нэг жилийн дараа хамт буцсан Н.Я.Бичурин “1821 оны 7 сарын 21-ний өдөр бид 50 орчим ли яваад Бороо голын эрэг дээр мөн ийм нэртэй эдлэнд (өртөөнд-Ш.М) буудаллав. Энэ бүх зам уул бэлийг дайран өнгөрчээ. Буудал (өртөө-Ш.М) хүрэхэд арван ли зайд замын баруун талд өндөр сүрлэг Ноён уул оршино<sup>192</sup> хэмээн өгүүлдэг. Н.Я.Бичурины тэмдэглэлээс Бороо голын өртөөнд ирсэн мэт ойлгогдохоор байна. Гэтэл Е.Тимковский “Хунцал өртөөнөөс мөн л 6 цагт хөдөлж, 10 орчим мод яваад, Ноён уулын баруун хормойг ороон Сүсээгийн хөндий рүү орж, хус, гачуур их ургасан өтгөн ой харж нүдээ баясган явсаар үдийн 12 цаг болж байхад Хуримт өртөөнд хүрэв<sup>193</sup> хэмээн өгүүлдэг. Тэднийг явж байх үед Бороо голын зүүн тал Ноён уулын баруун суганд буюу одоогийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багийн нутаг Хуримтад нутаглаж байжээ. Харин П.Кафаровыг 1847 оны 6 сарын 2-нд ирэхэд Баянбярүүхайд нутаглаж байсан бололтой. “Баянбэрхийн (Баянбярүүхай-Ш.М) өртөөнд хүрэв. Өртөөний зүүнтээ Ноён хэмээх сунагар урт уул харагдах нь мөнөөхөн Ногоон модон давааны үргэлжлэл бололтой. Ноён уулыг холоос ажвал өтгөн ойгоор бүрхэгдсэн, бүслүүр хавьцаа нь улаан шаргал судалтай хэсэг зурвас газар байх нь шатсан ой бололтой. Баянбэрхийн хөндий маш үзэсгэлэнтэй, өтгөн сахлаг өвстэй, эртний байшин барилгын туурь олонтой, тэдгээрийнх нь дөв дөрвөлжин суурь хаа холоос ч нүдэнд мэдэгдэхүйц. Өртөөний зүүн талд, нэгэн толгойн хормойд зөв байршилтай маш олон туурь харагдана<sup>194</sup> гэж өгүүлдэг. Баянбярүүхайн хөндий Хуримтаас урд зүгт өнөөгийн Төв аймгийн Борнуур сумын Арангат Баянгол багийн нутагт бий. Байршил нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх багийн нутаг Ноён уулын баруун хормой ажээ. Энэ нь сумын төвөөс урд зүгт 10 км, Хунцал өртөөнөөс хойд зүгт 30 гаруй км-т юм.

5. Хараа өртөө. Н.Я.Бичурин “Ноён уулын зүүн тал Хараа голын баруун эрэгт буудаллав<sup>195</sup> гэж бичдэг. П.Кафаров “Хөндийн хойд захыг зүүнээс баруун тийш урсах Хараа гол эмжжүхүй. Тэр хавьд голын өргөн 20 алхам л байх тул бид бууж, хөл нүцгэлэн гатлаад том ногоон сондуул дамжин явсаар Хараа өртөөнд хүрч буув<sup>196</sup> гэж өгүүлсэн байдаг. Хараа өртөөний суурин Сэлэнгэ аймгийн Мандал сум Хэрх багийн нутаг Элсний хөндийн баруун, Ширхэнцэг уулын зүүн талд, Хараа голын ард нутаглаж байжээ. Энэ нь Баянбаруухай өртөөнөөс баруун хойд зүгт 22 км зайтай оршино.

6. Шанд дов өртөө. Н.Я.Бичурин “Бид шулуун замаар 35 ли орчим явж Мангадай уулыг давж Баянголын эрэг дээр мөн тийм нэртэй эдлэнд (өртөөнд Ш.М) буув” гэжээ. Тус өртөөг мөн л нутаглан буй газрынх нь нэрээр Шанд дов, Баянгол хэмээн бичсэн ажээ. Шанд довыг 1984 онд Улсын геодези, зураг зүйн газраас гаргасан 1:125.000 масштабтай газрын зурагт Шант овоо гэж бичсэн байна. Шанд дов Баянголоос хойд зүгт 6 орчим км зайтай. Баянголын өртөө Баянгол сумын Төмөрт багийн нутаг Манхдайн давааны ар талд байжээ. Энэ нь Хараагийн өртөөнөөс хойд зүгт 25 км орчим зайтай юм.

Түүний дараагийн өртөө Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутагт байжээ. Эрдэнэ засгийн хошууны нутгийн зураг лавтайяа 8 бий. “Түшээт хан аймгийн гүн Намсрайн хошууны нутгийн нутаг<sup>197</sup>-т Их Хүрээ-Хиагт чиглэлийн 5 өртөөг тэмдэглэжээ. Тэдгээр нь суурин урд талаасаа “nomtu örtege” (Номт өртөө), “deresütü bulung örtege” (Дэрст булан өртөө), “irüge yool örtege” (Ерөө гол өртөө), “narin moyai örtege” (Нарийн могой

<sup>191</sup> Егорь Тимковский. 1820-1821 оны Монгол. Орч.Ж.Нэргүй. УБ., 2019. т.71

<sup>192</sup> Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орч.Б.Даш-Ёндон. УБ., 2019. т.69

<sup>193</sup> Егорь Тимковский. 1820-1821 оны Монгол. Орч.Ж.Нэргүй. УБ., 2019. т.382

<sup>194</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.224

<sup>195</sup> Н.Я.Бичурин. Монголын тухай тэмдэглэл. Орч.Б.Даш-Ёндон. УБ., 2019. т.70

<sup>196</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.227

<sup>197</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 835/96. 4880

өртөө), “giluγan naγur örtege” (Гялаан нуур өртөө) юм. Нутгийн зургийн хэмжээсээр баримжаалбал суурин өртөө хоорондын зай 1,5 дөрвөлжин хавтгай байгаа нь 43 км (1,5 х 50 х 576 м = 43.200) болно.<sup>198</sup>

7. Номт өртөө. Уг өртөөний тухай П.Кафаров “*Хоёр захаараа намаг, бургас ихтэй Сайрын голыг гатлан Номт өртөөнд дээр хүрч очив. Эргэн тойронд нь эзгүй мянган толгод үргэлжилнэ*”<sup>199</sup> хэмээн өгүүлжээ. Архивын зарим баримтад тус өртөөг örmegetei (Өрмөгтэй) хэмээн бичжээ.<sup>200</sup> Номтод зуны цагт нутаглаж, өвлийн улиралд Өрмөгтэйд буудаг байжээ. Нутгийн иргэд Өрмөгтэй төмрийн хүдэртэй аянга их буудаг газар гээд тэнд буудаггүй. Номт өртөө Дархан уул аймгийн Хонгор сум, Шарын голын уурхай хоёрын заагт Шарын голын зүүн эрэг дээр зусч Өрмөгтэй өртөө Дархан уул аймгийн нутаг Дархан уулын хойно орших Өрмөгтэй уулын урд хормойд өвөлждөг байжээ.

8. Дэрст булан өртөө. Эл өртөөг П.Кафаров “*Хүйтний голыг гатлаад Дэрст булан хэмээх өртөөнд хүрэв. Тус өртөө тээр хавьдаа хамгийн өндөр уулын хормойд оршино*”<sup>201</sup> гэж тэмдэглэжээ. Хүйтний голын хойно буй хамгийн өндөр нь Хонгор уул юм. Нутгийн ахмадууд Дэрст булан өртөөг Тайны Гозгор уулын энгэрт зусдаг хэмээн тайлбарлан ярьж байв. Дэрст булан өртөө Сэлэнгэ, Ерөө хоёр сумын зааг дээр Хүйтний голын хөндийд байрлаж байжээ.

9. Ерөө гол өртөө. П.Кафаров “*Ерөө голын хөндийд Ерөөгийн өртөө байрлана. Хойд талаараа уулс үргэлжилж голын сав дагуу бургас багширна*”<sup>202</sup> хэмээн өгүүлжээ. Ерөө голын өртөө Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Тал булагт өвөлжиж, Амбасын дов хэмээх газар зусдаг байв. Энэ нь Ерөө сумаас 20 км орчим зайтай Ерөөгийн дунд гүүрний хойд талд юм.

10. Нарийн могой өртөө. П.Кафаров “*Ерөөгийн хөндийг туулаад уужимхан хавцал руу шургаж өгссөөр Нам даваа руу гарч, тэндээсээ нарийхан хавцал уруудан буугаад битүү ногоон зүлэгтэй талаар явж сүүлдээ намгийн сондуул дундуур Нарийн могойтын өртөөнд хүрлээ*”<sup>203</sup> хэмээн өгүүлдэг. П.Кафаров явсан газрынхаа тухай цөөн хэдэн газрын нэрийг л дурдсан байгаа юм. Нам даваанаас хойш Бумбатын шовх уул, Байц уул, Бичээч толгойн дундуур явж Бумбат голыг гатлан өгсөж Нарийн могойн өртөөнд хүрнэ. Нарийн могой өртөө одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Их могой багийн нутагт сумын төвөөс урд зүгт 30 км-т Даяанч уулын зүүн хойно, Бага Мэлхийн толгойн баруун талд байрлана. Нарийн могой өртөө нь Ерөө голын өртөөнөөс хойд зүгт 25 км зайтай оршино.

11. Гялаан нуур өртөө. П.Кафаров “*ардаа Ерөөгийн салбар уулсыг орхиод хоёр ч нарсан төгөлийг өнгөрвөл Хиагтын сүмийн цагаан орой цавцайн, гонх нь сэрийгээд, хажууд нь цайны агуулахын бараа харагдав. Эндээс бид Гялаан нуурын өртөө рүү бууж ирлээ*”<sup>204</sup> гэж бичжээ. Гялаан нуурын өртөөнөөс Алтанбулаг ойрхон байгааг уг тэмдэглэлээс харж болно. Гялаан нуур Алтанбулаг сумаас урд зүгт 8 км зайтай. Нарийн могой өртөөнөөс гарч Зүүн Тогос уулын зүүн сугаар гарч Их, Бага цоорхойг даган Доргонтын нарс, Тужийн нарсыг дайраад Худгийн гуу хүрч Талын нурууны зүүн амаар гарч Гялаан нуурын өртөөнд хүрнэ. Гялаан нуур Сэлэнгэ аймаг Алтанбулаг сумын Талын нуруу багийн нутаг Бунхан балгасын урд оршино. Нарийн могой өртөөнөөс хойд зүгт 23 км зайтай юм.

Их Хүрээ-Хиагт хооронд 11 өртөөтэйгээс Түшээт хан аймгийн Илдэн засгийн хошуунд 2, Баатар засгийн хошуунд 4, Эрдэнэ засгийн хошуунд 5 өртөө байв. Тэдгээр нь

<sup>198</sup> Ш.Мөнхбаатар. Халхын Түшээт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны нутгийн гурван зураг.//Евразийн нүүдэлчдийн түүхэн замнал: Төр, нийгэм, соёл. УБ., 2018. т.34

<sup>199</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.227

<sup>200</sup> Монгол улс. УТА. Түүхийн баримтын архив. М-146. д-1. хн-62

<sup>201</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.228

<sup>202</sup> Ж.Нэргүй. Нууц товчооны Палладий Кафаров. УБ., 2015. т.228

<sup>203</sup> Мөн тэнд

<sup>204</sup> Мөн тэнд

Одоогийн Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт 3, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт 1, Дархан уул аймгийн Хонгор суманд 1 өртөө, Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 1, Алтанбулаг сумын нутагт 2 өртөө тус тус байжээ.

#### 4. Сайр ус- Улиастайн өртөө

Өртөө, харуулыг тэмдэглэсэн бүдүүвч зурагт Сайр усаас Улиастай хүртэл “modun” (Модон), “sibutai” (Шувуутай), “lausa” (Луус), “jirem” (Жирэм), “čabčir” (Цавчир), “jegerin” (Зээрэн), “onggin” (Онги), “üneged” (Үнэгэд), “qadatu” (Хадат), “qaranidün” (Хар нүдэн), “garudi” (Гарьд), “taču” (Таац), “qudduyurtu” (Худаг урт), “šaraγaljud” (Шаргалзуут), “tüi” (Түй), “urtu” (Урт), “oluγai” (Олгой), “uuta” (Уут), “bayidaray” (Байдраг), “jaγ” (Заг), “qobulčegen” (Ховол цэгээн), “ulaγangbumba” (Улаан бумба), “öberjirγalangtu” (Өвөр жаргалант), “arujirγalangtu” (Ар жаргалант), “qujirt” (Хужирт), “daγangdel” (Дааган дэл), “temürtü” (Төмөрт), “šoruy” (Шорог), “quwašorutu” (Ухаа шороот), “uliyasutai” (Улиастай) гэж 30 өртөөний нэрийг тэмдэглэжээ.<sup>205</sup> Сайр усаас Улиастай хүртэлх эхний Модон өртөө Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутагт байв.

Түшээт засгийн хошууны нутгийн зураг лавтай 6 байна. 1868, 1901-1904, 1911 оны 3 зураг ҮНС-д, 1 зураг ГЗБГЗЗГ-ын архивт, 2 зураг (1914, 1922) хагас дутуу гэрэл зургийн шилэн хальс байдлаар ҮТА-д хадгалагдаж байна.<sup>206</sup> Үүнээс 1907 оны “Халхын Түшээт хан аймгийн чуулганы дэд дарга, засаг улсын түшээ гүн Ча-гийн хошууны нутгийн зураг”<sup>207</sup>-т Чуулалт хаалган-Улиастай чиглэлийн 10 өртөөг тэмдэглэжээ. Чингэхдээ өртөөний эзэмшил нутгийг хошууны нутгаас ялган тусад нь зуржээ. Өртөө замыг хар бэхээр цэг хатган зурж өртөөний сууринг гурвалжин хэлбэртэй тэмдэглэсэн байна. Нутгийн зургийн хэмжээсээр баримжаалбал суурь өртөө хоорондын зай 50 дөнгөж илүү газар буюу (50 x 576 м = 28800 м) 28 км байна. Зүүн талаасаа “taldolun örtege” (Тал долоон өртөө), “süji örtege” (Сүүж өртөө), “modun örtege” (Модон өртөө), “damqabirγ-a örtege” (дам Хавирга өртөө), “sibutai örtege” (Шувуутай өртөө), “lausa örtege” (Луус өртөө), “jirim örtege” (Жирэм өртөө), “damšaγsiurγ-a örtege” (дам Шагшуурга өртөө), “čabčir örtege” (Цавчир өртөө), “damqasiyatu örtege” (дам Хашаат өртөө) гэж өртөөний нэрийг бичжээ.

1. Модон өртөө. Дундговь аймгийн Өлзийт сумын Дэрэн багийн нутагт Модонгийн зооны ард Тахилгат толгойн зүүн суганд Модон ус хэмээх газар байна. Сумын төвөөс зүүн тийш 23 км-т эргэн тойрон хад асгатай урт үргэлжилсэн намхан нурууны сайран дотор хоёр худаг байрлана. Тус худгийг нутгийнхан Модон ус хэмээнэ. Худаг хоорондын зай 200 м орчим юм. Худгаас усаа гар аргаар татаж авна. Худгийн урд талд Хар толгой хэмээх өндөр хадан цохио байрлана. Уг худгийн талаар Дэрт багийн малчин С.Баянмөнх “Манай нутгийн ахмадууд Харчин өртөөний худаг гэж ярилцдаг байсан. Одоо Модон ус л гэж нэрлэж байгаа” гэв. Сайр уснаас Улиастай чиглэлд явах хамгийн эхний өртөө Модон юм.

2. Хавирга өртөө. А.Позднеев “Хавирга өртөөг нутгийнхан Булаг өртөө гэдэг. Яагаад ингэж нэрлэсэн тухайд энэ нутагт булаг тун ховор атал нэг булаг байдаг болохоор тэгж нэрлэжээ”<sup>208</sup> гэж тэмдэглэжээ. Дундговь аймгийн Өлзийт сумын Дэрт багийн нутагт Үхэр Чулууны хөндийн зүүн урд тэгш талд Баян ус гэх худаг байна. Үхэр чулууны хөндий дэрс, ширэг ихтэй газар юм. Тус худаг Модон уснаас баруун хойд зүгт 21 км зайтай газар байх ажээ. Үүнийг бид Хавирга ус мөн байх гэж үзэж байна. Нутгийн хэд хэдэн хүнээс хуучны нэрийг тодруулах гэж асуусан боловч Баян ус

<sup>205</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-14

<sup>206</sup> Ж.Гэрэлбадрах. Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны нутгийн нэгэн зургийн судалгаа.//Монгол газрын зураг, газрын нэр судлал. УБ., 2015. т.55

<sup>207</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг-II, данс-2, хн-35

<sup>208</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томь I, С-Петербург., 1896, стр. 181

гэдэг нэрнээс цааш сайн мэдэхгүй гэв. Урд талд Цахиур баян уул 5 орчим км зайтай харагдана. Баруун хойд зүгт тэгш тал үргэлжилнэ. Баян худгаас баруун хойд зүгт машин замаар бус тэгш тал дээрх хэсэг дэрсийг даган Нүхэн цагаан уул, Тахилгат цагаан уулын дундуур гарч 12 км орчим явсаар Баруун булгийн худагт ирэв. Өлзийт сумын Дэрт багийн малчин Батболд гуай Баян худаг Баруун булгийн хоорондох 10 гаруй км дэрстэй газрыг “Дэрсэн тэмдэгт өртөө зам” гэж тайлбарлаж байв. Энд цувраа гурван худаг сайран дотор байна. Эл гурван цувраа худгийн баруун талд Мандалговь-Өлзийт сум чиглэлийн зам 100 м зайтай байна.

3. Шувуутай өртөө. Дундговь аймгийн Хулд сумын Шувуутай багийн нутагт Шувуутай хайрханы баруун өмнө талд 8 км зайтай Шувуутай хийдийн туурь, Шувуутай ус байна. Дундговь аймгийн 1:500.000 масштабтай газрын зурагт Шувуутай хайрханыг Тахилгат Овоот уул гэж бичжээ. Шувуутай хийдийн хэдэн барилгын туурь, түүхий тоосго, шар шавар, чулуун суурь бүхий юм үлджээ. Хийдийн баруун талд 100 м орчим зайтай Шувуутайн ус байна. Чулуун өрлөгтэй гар худаг байсныг лайдах гэж оролдоод улам нураасан бололтой. Хавирга уснаас баруун хойд зүгт тэгш тал дундуур явсаар нэгэн өндөр толгойг дөнгөж тойроод Шувуутай усанд ирнэ. МУБИС-ийн философийн багш Хулуд Ж.Отгонбаяр Шувуутай хайрханы өвөрт бага насаа өнгөрөөжээ. Түүний, хэлснээр аав, ах нар Шувуутай бус Шавагтай хэмээн нэрлэдэг байжээ. Тэр уулын энгэрт шар шаваг их байдаг гэнэ. Үүнээс баруун урд талд 5 км орчим зайтай Үйзэнгийн цохионы урд Үйзэн худаг гэх сайн устай худаг байна. Чухам өртөөнийхөн эл худгаас амны усаа зөөн авч хэрэглэдэг байсан бололтой.

4. Луус өртөө. Дундговь аймгийн Хулд сумын Шувуутай багийн нутаг Ар Цагаан толгойн урд талд буй Луусын хийдийн тууриас 250 м-т Луусын худаг байна. Хийд нэлээд том байсан бололтой. Мөн л энд тэндгүй чулуун суурь, шар шавар, тоосго, дээврийн хэлтэрхий тааралдана. Хойд талд нь 2 суварга босгожээ. Луус хайрханаас зүүн тийш 10 км зайтай ажээ. Баруун, хойд талаараа хадтай уулсаар хүрээлүүлсэн дэрс ихтэй тал газар байна. Хоёр худагтай. Шувуутай худгаас баруун хойд зүгт 22 км-т байна. Энд хэд хэдэн худаг байна. Луусын худгийн хойно 3 орчим км-т Баруун Сүүж худаг, урд талд нь Шовхын тойром, Баян хошууны худаг бий.

5. Жирэм өртөө. Тус газрыг өдгөө нутгийнхан Өртөө жирэмийн худаг гэж хэлдэг Дундговь аймгийн Хулд сумын Бүлээн багийн нутаг, Хар хад уулын зүүн талд Жирэмийн хөндийн хяр дээр Өртөө Жирэмийн худаг байна. Урд талдаа мөргөцөг хадтай, хойд талд нь Завсарын Улаан толгой хэмээх уул харагдана. Эргэн тойрон дэрсээр хүрээлэгдсэн элсэн дунд нэг худаг байрлана. Луус худгаас баруун хойд зүгт 49 км зайтай. Тус өртөө сунгуу өртөө бололтой. Тал дундуур явсаар олон толгод, уулсыг нуруулдан Аргалын Улаан толгойг өгсөж Жирэмийн хөндийн хяр дээр гарч ирнэ. Чулуун дараастай, чулуун өрлөгтэй нэг худагтай. Урагшаа харсан нэг төмөр, хойшоо харсан нэг бетон онгоцтой ажээ. Усны гарц сайн. Усаа мотороор татаж авдаг. Өртөө Жирэм худгийн баруун талд 2 км хүрэхгүй зайтай Баруун Жирэмийн худаг байна.

6. Дам Шагшуурга өртөө. Энэ өртөөний өөр нэг нэр нь Мэнгэт юм. Дундговь аймгийн Хулд сумын Бүлээн багийн нутаг Мэнгэт уулын зүүн хойд талд Мэнгэтийн тойрмын ард Мэнгэтийн худаг байна. Түүний ойр оршиж байсан Мэнгэтийн хийдийн туурь том бөгөөд чулуун суурь, тоосго, шавар, барилгын үлдэгдэл энд тэндгүй тааралдана. Мэнгэтийн худаг уулын урд өвөрт хонхор газар байрлана. Эргэн тойрон чулуу, хад, дэрс ихтэй ажээ. Урд талд нь урт говь харагдана. Мэнгэтийн хийдийн тууриас 100 м орчим зайтай Жирэмийн худгаас баруун хойшоо Бударгана Усны хоолойг дамжин 13 км уруудан явсаар Мэнгэтийн усанд ирнэ. Модон өрлөгтэй хоёр худагтай. Мэнгэт уснаас Жирэм өртөө хүртэлх зайд өвс ургаагүй хэсэг халцгай газар буйг нутгийн иргэд эртний өртөө замын ул мөр гэж хэлж байв.

7. Цавчир өртөө. Мэнгэт уснаас баруун хойд зүгт 30 гаруй км бартаатай замаар Хулгарын Хөх уул, Цахиуртын говь, Хонгор уул, Замын Хар толгой зэрэг газрын дэргэдүүр

өнгөрч Цавчир өртөөнд ирнэ. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Цавчир багийн нутагт Цавчир хадны өвөрт уулын бэлд хонхор газар Цавчирын худаг байна. Худгаас 200 м зайтай зүүн хойд талын дэнж дээр Цавчирын хийдийн туурь бий. Тус хийдийн туурь том ажээ. Шавар хана, тоосго, чулуун суурь, төмөр тогоо, дээврийн хэсэг зэрэг сүм хийдийн тууриуд холоос тод харагдана. Цавчир худгийг нутгийн иргэд Билгэх усны худаг гэж нэрлэнэ. Эргэн тойрон бэсрэг толгодоор хүрээлүүлсэн хонхор газар дэрсэн дотор байна. Төмөр онгоцтой ганц шавар худагтай. Усаа мотороор татна. Усны гарц сайн ажээ.

8. Хашаат өртөө. Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Төгрөг багийн нутаг Цайдамын хонхорын баруун талд Хашаатын ухаагийн арын хонхорт Их хашаатын худаг бий. Цавчир худгаас баруун тийшээ 41 км зайтай Төгрөг нуур, Төгрөгийн худгийн хойд талаар Баруун Цохт толгой, Зүүн Цохт толгой, Хашаатын толгой зэрэг өндөрлөг газруудыг нуруулдаж явсаар эргэн тойрон дэрстэй элсэрхэг газар байрлах Хашаатын худагт ирнэ. Хоёр худагтай. Хожим зассан модон амбаартай өндөр худгаас нутгийн иргэд амны усаа авдаг ажээ. Усны гарц сайтай юм.

Түшээт засгийн хошууны нутгаар дамжин өнгөрөх 10 өртөөний 4 нь өнөөгийн Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт, 4 өртөө Хулд сумын нутагт, 1 өртөө Эрдэнэдалай сумын нутагт, 1 өртөө Сайхан-Овоо сумын нутагт байна. Сайр ус, Шувуутай, Луус, Мэнгэт, Цавчир, Төгрөг өртөөний ойролцоо хийдийн тууриуд байна. Харин эдгээрийг нутгийн зурагт тэмдэглээгүй.

Дараагийн 1 өртөө Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошууны нутагт байжээ. Сайн ноён аймгийн Илдэн засаг Дондовжанцаны хошууны нутгийн 5 зураг, цэс Монгол улсын ҮНС-д,<sup>209</sup> 1 зураг ГЗБГЗЗГ-т хадгалагдаж байна. “*Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын умар замын дундах өмнөд засаг бэйл Дондовжанцаны хошууны нутгийн зураг*”<sup>210</sup>-т “*qaγacin jegerin örtege*” (Харчин Зээрэн өртөө)-г зуржээ. Чингэхдээ өртөөг гурвалжин хэлбэртэй дүрсэлжээ.

9. Зээрэн өртөө. Тус өртөөг Илдэн засгийн хошууны нутгийн урдуур, Бор довын овооны ар талын зайд зурсан байна. Ойр хавьд өөр газрын нэр бичээгүй ажээ. А.Позднеев 1892 оны 8 сарын 2-ны өдөр Зээрэн өртөөнд буужээ. Тэрээр “*Зээрэн өртөө нь зүүнээс баруун тийш сунасан, баруун тийш хэлбийсэн уудам тал дээр байрлана. Энд хоёр худагтай. Ус нь тунгалаг хэдий боловч шорвог амттай ажээ. Зээрэн өртөөнд 52 цацарт Харчингууд байна. Угтаа 18 цацар нь орон тоонд орно. Тэнд нэг байшин байгаа нь өртөөний эдлэл хэрэглэлийг хураажээ. Дотор нь хэдэн хайрцагтай юм, олбог, хивс, хөшиг, ном хөглөрч харагдана*”<sup>211</sup> гэж тэмдэглэжээ. Чухам энд хэдэн худаг бий. Билгэх дэрсний худаг, Өлзийт худаг, Цагаан усны худаг, Өлзийт худаг, Холбоо худаг зэрэг юм. Зээрэн өртөө өнөөгийн Өвөрхангай аймгийн Сант сум Улаан овоо багийн нутаг Ширээт уул, Өлзийт хошууны голд Домбонгийн говийн хойно дэрсээр хүрээлэгдсэн талд байна. Зээрэн усыг нутгийнхан Өртөө ус гэж нэрлэнэ. Хашаат худгаас баруун хойд зүгт 32 км зайтай оршино. Хашаат худгаас Ихэрийн ухаа, Нарийн ухаа, Их Баянгийн нурууг дамнан явсаар Зээрэн худагт ирнэ. Зээрэн худгаас зүүн хойд зүгт 1 км орчим зайтай Зээрэнгийн хийдийн туурь байна. Зээрэнгийн хийдийн туурь нэлээд том ажээ. Шавар суурь, чулуун хана, түүхий тоосго, шар шавар, сүмийн дээврийн үлдэгдэл зэрэг ул мөр энд тэндгүй таржээ.

Зээрэнгийн дараагийн өртөө Ахай засгийн хошууны нутагт байжээ. Сайн ноён аймгийн Ахай засаг бэйл Цэрэндоржийн хошууны нутгийн 2 зураг ҮНС-д<sup>212</sup>, 1 зураг Японы Тэнри ИС-ийн номын санд хадгалагдаж байна. Тэнрид буй зурагт Сайн ноён аймгийн бүх

<sup>209</sup> Монгол улс. ҮНС-ийн Монгол судлал-Гар бичмэлийн сан хөмрөг. 615/96, 721/96, 961/96, 626/96, 923/96

<sup>210</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар, сансрын зургийн архив. Монгол нутгийн зураг III, д-1, хн-3

<sup>211</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр.190

<sup>212</sup> Монгол улс. ҮНС-ийн Монгол судлал-Гар бичмэлийн сан хөмрөг. 80607/96, 8584/96

хошууг багтаан зуржээ. Уг зурагт Илдэн засгийн хошуунд буй 1 өртөөг улаан өнгө бүхий гурвалжин дүрсээр тэмдэглээд *qaračin* “būyürceg-yin örtege” (Харчин Бүүрцэгийн өртөө)<sup>213</sup> хэмээн бичжээ. А.Позднеевын тэмдэглэлд тус өртөөг Онгийн өртөө гэж тэмдэглэжээ. “Онгийн голын хөвөөнд Онгийн овоог түшиглэн буужээ. Өртөөний хүмүүс 65 цацартай. Сайр усны мэдлийн хамгийн захын өртөө”<sup>214</sup> гэжээ. Өвөрхангай аймгийн 1:500.000 масштабтай газрын зурагт Бөөрцэг, Онгийн овоо зэргийг тэмдэглээгүй. Тус өртөө Өвөрхангай аймгийн Баянгол сумын Цагаан булаг багийн нутаг Зүүн Цагаан булан, Онгийн овооны ард Онгийн голын дэнж дээр байжээ. Онгийн өртөө сумын төвөөс баруун хойд зүгт 20 км, Зээрэн өртөөнөөс баруун хойд зүгт 47 км орчим зайтай байна.

10. Үнэгэд өртөө. Дараагийн өртөө болох Үнэгэд өртөө Үйзэн засгийн хошууны нутагт байжээ. Тус хошууны нутгийн зураг, цэс ҮНС-д 6 байна.<sup>215</sup> Японы Тэнри ИС-ийн номын санд хадгалагдаж буй зурагт Үйзэн засгийн хошуунд 1 өртөөг улаан гурвалжин хэлбэртэй тэмдэглэж “*qaračin üneged ö*” (Харчин Үнэгэдийн ө)<sup>216</sup> гэж нэрийг бичжээ. А.Позднеев “Сулийн талд хүрмэгц зам тэгшихэн болов. Сулийн талын баруун хойно Үйзэн дэх задгай голд Долоон Үнэгтийн өртөө байлаа”<sup>217</sup> хэмээн өгүүлжээ. Жаргалантын хоолойн тэгш талаар явж Зүүн, Баруун Жаргалант уулын хаяагаар тойрон Их Үнэгт уулын хормойд орших Үнэгтийн өртөөнд хүрнэ. Үнэгт өртөө Өвөрхангай аймгийн Тарагт сумын Туяа багийн нутаг Задгай голын ард Өлзийт толгойн зүүн талд Сүүл толгойн урд талд байжээ. Сумын төвөөс зүүн урд зүгт 50 км, Онгийн өртөөнөөс баруун зүгт 35 км зайтай оршино. Дараагийн өртөө Сайн ноён аймгийн Сайн ноён ханы хошууны нутагт байжээ.

Сайн ноён ханы хошууны нутгийн 5 зураг, цэс ҮНС-д,<sup>218</sup> 1 зураг ГЗБГЗЗГ-ын архивт зураг бий. “Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын Сайн ноён чуулганы дарга засаг чин ван Намнансүрэнгийн хошууны нутгийн зураг”<sup>219</sup>-т өртөөг гурвалжин хэлбэртэй дүрслээд өртөөний замыг цэг хатган тэмдэглэжээ. Өртөөний нэрийг зүүн талаас нь “*qaračin qadatu-yin örtege*” (Харчин Хадатын өртөө), “*qaranidün-yin örtege*” (Хар нүдэнгийн өртөө), “*garudi-yin örtege*” (Гарьдын өртөө), “*taču-yin örtege*” (Таацийн өртөө) гэж бичжээ. Эдгээр 4 өртөө хошууны нутгийн төв дундуур Таргатын цохио, Гүн нуур, Аргуйн гол, Өшхиг уулын араар явдаг байв.

11. Хадатын өртөө. Хадатын өртөө бол Харчин 36 суурь өртөөний хамгийн баруун талынх юм. А.Позднеев “Шандын хөндийд Хадатын өртөө, Хадатын сүм байрлана. Энэ сүм гурван дуган хорин байшинтай. Дуганд бурхантай, лам нар модон байшинд сууна. Хадатын өртөө бол Сайр усны захиргаа дахь Харчин хүмүүсийн алба хаадаг эцсийн өртөө болно. Хадат өртөө зундаа Хорхойт булгийн гүн нарийн хавьцаа буудаг. Майханаас хойш хөндий, уулын сүрлэг бие тодхон харагдана. Өртөөний одоогийн байр бол зүүн тийш Эрдэнэ үйзэн гүний хошуу хийгээд баруун тийш Сайн ноёны хошууны уулзварт ойрхон болоод байна”<sup>220</sup> гэж бичжээ. Хорхойтын булаг Хадат Хүрэн уул, Хадатын булгаас баруун зүгт 3 км орчим зайтай байна. Тус өртөө зуны улиралд Хорхойд булагт ирж өвөл Хадат Хүрэн уулын өвөрт өвөлждөг бололтой. Хадатын өртөө

<sup>213</sup> В.Оyunbilig, В.Нasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>214</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 193

<sup>215</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 845/96, 855/96, 856/96, 867/96, 656/96, 18491/96

<sup>216</sup> В.Оyunbilig, В.Нasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>217</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896. стр.194

<sup>218</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 694/96, 926/96, 931/96, 18473/96, 663/96

<sup>219</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар, сансрын зургийн архив. МНЗ-З. д-1. хн-1

<sup>220</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 195

Өвөрхангай аймгийн Тарагт сумын Туяа багийн нутагт сумын төвөөс чанх урд зүгт 50 км орчим, Үнэгтийн өртөөнөөс баруун зүгт 30 км-т оршиж байна.

12. Хар нүдэн өртөө. Халхын 20 өртөө эндээс эхэлдэг. А.Позднеевын тэмдэглэлд “Хар нүдэн өртөө Гүн нуурын өмнө байрлана. Тус өртөө Улиастайн жанжин буюу туслагч амбан нарын онцгой харьяанд багтана. Тийнхүү тайж, нарын шууд хяналтанд байх тул таван өртөө бүрийг нэг тайж захирна. Халхуудын өртөө хооронд тогтсон ус бэлчээрийн зааг байхгүй. Өртөөн дэх тусгай харуул ч байхгүй. Зөвхөн орон тооны 14 өрх, улаач хийгээд 7 цацартай сул албаны хүмүүс бий. Улаач нь Сэцэн хан аймаг, Түшээт хан аймгийн хошуунаас иржээ. Сул албаныхан цөм Сайн ноён аймгийнхан хийгээд Үйзэн гүний хошууныхан ажээ. Энд буй сул албаныхан гэр өрхтэйгээ яваа нь Харчингуудтай ижил өртөөний ажилтан нь Харчин өртөөнөөс хол цөөн байна. Хар нүдэн өртөө зун болоход Гүн нуурын өмнө оторлож өвөлдөө Хар нүдэнд өвөлждөг юм. Гүн нуурын ус шорвог”<sup>221</sup> гэж тэмдэглэжээ. Дээрх мэдээнээс үзэхэд Халхын өртөөдийн эзэмшил нутаг тодорхойгүй байсан мэт. Хар нүдэн өртөө Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Гүн Нарийн багийн нутаг Гүн нуурын урд талд, Гүн овоот толгойн ар талд байжээ. Сумын төвөөс урд зүгт 17 км-т, Хадатаас баруун зүгт 35 км зайтай оршино.

13. Гарьдын өртөө. Уг өртөөний тухай А.Позднеев “Хар нүдэн өртөөнөөс гараад тэгш тал дундуур урагшаа явлаа. Гүн нуурын хойд талаас эхлээд чулуу олон бөгөөд дэрс их ургажээ. Гарьдын голын хөндийд Гарьдын өртөө байрлана. Хар нүдэн өртөөнөөс холгүй оршино”<sup>222</sup> хэмээн бичжээ. Гарьдын өртөө Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын Гүн Нарийн багийн нутаг Гарьдын Хадан цохио, Хараат толгойн баруун талд, Гарьдын голын урд талын дэнж дээр байжээ. Сумын төвөөс баруун урд зүгт 25 км зайтай. Хар нүдэнгээс баруун зүгт 18 км зайтай оршино. Өртөө хоорондох зай ойрхон хэдий боловч бартаа саад ихтэй ажээ.

14. Таац өртөө. А.Позднеев “Гангын амаар гараад Шаргын голын хөндийд орж Таацын өртөөнд хүрч хоноглов. Таацын өртөөний ойролцоо чийгтэй байна. Шаргын гол энд олон салбарладаг тул намаг ихтэй. Улаач нар үүнээс айж өндөр хөтөл дээр майхнуудаа босгожээ”<sup>223</sup> гэж бичжээ. Тус өртөөг Шаргын гол, Таацын голд цутгадаг газар байх үеэр ирсэн бололтой. Таац өртөө Өвөрхангай аймгийн Нарийн тээл сумын Баян тээг багийн нутагт Таацын голын зүүн талд Шаргын голын баруун талд Эмээлт Улаан хяр, Байшинт сайрын хөндийд байрлана. Сумын төвөөс урд зүгт 20 км, Гарьдаас баруун зүгт 35 км зайтай байна.

Сайн ноён ханы хошууны нутгаар 4 өртөө дамжин гардаг байжээ. Тэдгээр өртөөний 1 нь Харчин, 3 нь Халхын өртөө юм. Эдгээр нь Өвөрхангай аймгийн Тарагт суманд 1, Хайрхандулаан суманд 2, Нарийнтээл суманд 1 байна.

Дараагийн өртөө Сайн ноён аймгийн Эрдэнэ бандида хутагтын шавийн нутагт байжээ. Эрдэнэ бандида хутагтын шавийн нутгийн 2 зураг ҮНС-д,<sup>224</sup> 1 зураг ГЗБГЗЗГ-ын архивт хадгалагдаж байна. “Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын Эрдэнэ бандида хутагтын шавь нарын нутгийн зураг”<sup>225</sup>-т улаан гурвалжин дүрсээр 2 өртөөг тэмдэглэжээ. Өртөөний нэрийг зүүн талаас “qudduγ urtu-yin örtege” (Худаг уртын өртөө), “šaraγaljuda-yin örtege” (Шаргалзуутын өртөө) хэмээн бичжээ.

<sup>221</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 197

<sup>222</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 198

<sup>223</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 199

<sup>224</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 971/96, 972/96, 18504/97

<sup>225</sup> Газрын харилцаа Геодези зураг зүйн газар. Агаар, сансрын зургийн архив. МНЗ-3. д-3. хн-26

15. Худаг уртын өртөө. А.Позднеев “Худаг Уртын өртөө өргөн хөндийд буужээ. Худаг уртын гол дэргэдүүр урсана. Бид энэ өртөөнөөс Мэргэн ноён хутагтын нутагт сүндэрлэх Богд уулын цаст оргилуудыг нэг удаа харж авлаа. Худаг Уртын өртөөний хүмүүсийн 11 майхан өрх бүгд Сэцэн хан аймгаас, 3 майхан нь Сайн ноён аймгаас иржээ. Сул албаны 7 майхан хүмүүс Сайн ноёны хошуудаас ирсэн байна”<sup>226</sup> гэж бичжээ. Худаг Уртын гол Их Тахилга уулаас эх авч Таацын голд цутгана. Худаг Уртын голын эхэнд тус өртөө байжээ. Одоогийн Баянхонгор аймгийн Өлзийт сумын Худаг Урт багийн нутаг Бүдүүний хөндийн хойно, Цагаан овоот толгойн баруун талд Худаг Уртын голын баруун талд байрлана. Сумын төвөөс зүүн урд зүгт 25 км, Таацын өртөөнөөс баруун хойд зүгт 20 км зайтай байна.

16. Шаргалзуутын өртөө. Тус өртөөний тухай А.Позднеев “Шаргалзуутын өртөө нь Шаргалзуутын голын хөндийд байрлана. Энд буй сул албаны гурван майхан нь Эрдэнэ үйзэн гүний хошууных, дөрөв нь Балдан засгийн хошууных байв. Өртөөг бүрдүүлсэн арван дөрвөн майхан бүгдээр Сэцэн ханых бололтой”<sup>227</sup> гэж тэмдэглэжээ. Шаргалзуутын рашааны ойролцоо өртөө буудалж байсан бололтой. Нутгийнхны аман ярианд Манж Чин улсын ноёд, түшмэд өртөөний ойролцоо рашаанд амарч биеэ сувилдаг тухай гардаг. Тус өртөө өнөөгийн Баянхонгор аймгийн Өлзийт сумын Бийрийн багийн нутаг Шаргалзуутын голын өмнө талд, Хаан Овоот уулын баруун талд Хөх толгойт уулын зүүн талд байрлаж байжээ. Сумын төвөөс зүүн урд зүгт 9 км, Худаг Уртын өртөөнөөс баруун зүгт 29 км зайтай газар юм.

Эрдэнэ бандида хутагтын шавийн нутгаар хоёр өртөө дамжин гардаг байсан нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт байна.

Шаргалзуутын дараагийн өртөө Дайчин засгийн хошууны нутагт байв. Дайчин засгийн хошууны нутгийн 6 зураг, цэс ҮНС-д,<sup>228</sup> Японы Тэнри ИС-ийн номын санд буй Сайн ноён аймгийн Дайчин засгийн хошууны төв хэсгээр хоёр өртөө дайран өнгөрч буйг цэг хатган тэмдэглээд өртөөний нэрийг “tūi-yin örtege” (Түйн өртөө), “urtu qaradoluγai-yin örtege” (Уртын хар толгойн өртөө) гэж бичжээ.

17. Түй өртөө. А.Позднеев “Бумбатын амнаас гараад чулуугаар дүүрэн Хар чулууны давааг туулав. Давааны цаана Түй голын хөндий үүснэ. Түй голын хөндийд Түйн өртөө байх ажээ”<sup>229</sup> гэж тэмдэглэжээ. Түй гол Хангай нурууны өврөөс эх аван урсаж Орог нуурт цутгадаг. Дунд урсгал Баян-Овоо орчим Түй өртөө оршиж байсан бололтой. Түй өртөө Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Сэнжит багийн нутаг Нөмөр уулын урд Түй голын зүүн талд байрлаж байжээ. Сумын төвөөс баруун урд зүгт 14 км, Шаргалзуутын өртөөнөөс баруун хойд зүгт 21 км зайтай байна.

18. Урт Харын өртөө. Эл өртөөний тухай А.Позднеев “Урт харын өртөө нь Уртын голын шивээ дээр байрлажээ. Улаач нар нь Сэцэн хан аймаг, Түшээт хан аймаг, Сайн ноён аймагт харьяалагдана. Сул албын хүмүүс бүгд Сайн ноён аймгийн Ма засгийн хошуу, Далай гүний хошуу Да чин вангийн хошуу энэ хавийн улс байв”<sup>230</sup> гэж өгүүлжээ. Уртын гол Хүрэн толгойн уулаас эх аван урсаж Бэлчир толгой хүрнэ. Урт Харын өртөө Уртын голын төгсгөл хэсэгт байрлана. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Уртын Голын багийн нутаг Тарвагатайн нуруу, Индэрт уулын зүүн талд Дугуй өвөр уулын баруун

<sup>226</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 202

<sup>227</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 203

<sup>228</sup> Монгол улсын ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 1001/96, 1003/96, 1005/96, 1006/96, 1007/96, 670/96

<sup>229</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 205

<sup>230</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 207



талд оршиж байжээ. Сумын төвөөс хойд зүгт 12 орчим км, Түйн өртөөнөөс баруун хойд зүгт 26 км зайтай байна.

Дайчин засгийн хошууны нутгаар 2 өртөө дамжин гарсны нэг нь Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт, нөгөө нь Баян-Овоо сумын нутагт байна.

Урт Харын удаах өртөө Цогтой засгийн хошууны нутагт байжээ. Цогтой засгийн хошууны нутгийн зураг, цэс ҮНС-д 4 бий.<sup>231</sup> Японы Тэнри ИС-ийн номын буй Сайн ноён аймгийн нутгийн зурагт Цогтой засгийн хошууг зуржээ.<sup>232</sup> Цогтоо засгийн хошууны нутгийн төв хэсэгт “olūai-yin örtege” (Олгойн өртөө)-г гурвалжин хэлбэртэй тэмдэглэжээ.

19. А.Позднеев “Олгой өртөө өвс ургамал өндөр ургасан уулсаар хүрээлүүлсэн үзэмж сайтай, удам тэнүүн газар буужээ. Ар талд нь Харгана уул, зүүнтэй Жаргалант уул, өмнө нь Бугач уул, баруунтай нь Элст толгой харагдана”<sup>233</sup> гэж тодорхой өгүүлдэг. Энэ бол Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэр багийн нутаг Олгой нуурын ар талд, Чандмань уулын зүүн талд Халтар дөрөлжийн баруун талд оршино. Сумын төвөөс урд зүгт 12 км, Урт Харын өртөөнөөс баруун хойд зүгт 30 км-т бий.

Түүний дараах өртөөг Чин сүжигт Номун хан хутагтын шавийн нутгийн зурагт тэмдэглэжээ. Японы Тэнри ИС-ийн номын санд буй Сайн ноён аймгийн нутгийн зурагт<sup>234</sup> Чин сүжигт номун хан хутагтын шавийн нутгийн төв хэсэгт хоёр өртөөг зурж, “uutu-yin örtege” (Уутын өртөө), “bayidaᠭay-yin örtege” (Байдрагийн өртөө) гэж нэрийг нь бичжээ.

20. Уутын өртөө. Уг өртөөний тухай А.Позднеев “Тус өртөөг Уутын голоор нэрлэжээ. Уутын голын хөндийд бас хоёр гол бий”<sup>235</sup> гэж өгүүлжээ. Тэрбээр Өлзийт гол, Олгойн голыг хэлсэн бололтой. Цагаан түрүүгийн гол, Өвөр тээлийн гол нийлж Уутын голыг үүсгэнэ. Уг өртөө Баянхонгор аймгийн Галуут сумын Үнэгт багийн нутаг Уут голын хөндийд Цагаан Түрүүгийн голын урд талд байрлаж байв. Сумын төвөөс баруун хойд зүгт 12 км, Олгой өртөөнөөс баруун хойд зүгт 24 км зайтай газар юм.

21. Байдрагийн өртөө. Тус өртөөний тухай А.Позднеев “Улаачид бүгдээрээ Сэцэн хан аймаг, Түшээт хан аймгийн монголчууд байв. Сул албаныхан бүгдээрээ дэд да вангийн хошуу хийгээд Жонон гүний хошууныхан байлаа. Би Байдраг өртөөний хэдтэй ярьж байгаад голын доод урсгалд тариа тарьдаг болохыг мэдлээ. Байдраг голын хөндийд таван хошууны тарианы газар байдаг аж”<sup>236</sup> гэж бичжээ. Байдраг гол Хангай нурууны өмнөд хажуугаас эх авч Адгийн цагаан нуур хүртэл 310 км урсана. Байдраг өртөө Баянхонгор аймгийн Заг сумын Тосуй багийн нутаг, Байдраг голын баруун эрэг Баян Улаан уулын ар талд Их Дулаан Хайрхан уулын урд талд байжээ. Сумын төвөөс урд зүгт 22 км, Уутын өртөөнөөс баруун зүгт 54 км зайтай оршино.

Чин сүжигт номун хан хутагтын шавийн нутгаар хоёр өртөө дамжин гардаг байсан нь Баянхонгор аймгийн Галуут, Байдраг суманд байна.

Дараагийн өртөөг Эрдэнэ засгийн хошууны нутгийн зурагт тэмдэглэсэн байна. Эрдэнэ засгийн хошууны нутгийн 4 зураг, цэс ҮНС-д,<sup>237</sup> 2 зураг цэс ГЗБГЗЗГ-ын архивт хадгалагдаж байна.<sup>238</sup> Японы Тэнри ИС-ийн номын санд буй Эрдэнэ засгийн хошууны

<sup>231</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 928/96, 953/96, 960/96, 651/96

<sup>232</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>233</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербург., 1896, стр. 209

<sup>234</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>235</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербург., 1896, стр. 212

<sup>236</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербург., 1896, стр. 214

<sup>237</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 487/96, 655/96, 1072/96, 8600/96

<sup>238</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын зургийн архив. МНЗ-3. д-3. хн-31

нутгийн зурагт “jaγ örtege” (Заг өртөө), “qobul-yin örtege” (Ховолын өртөө)-г улаан гурвалжин хэлбэртэй тэмдэглэжээ.

22. Заг өртөө. А.Позднеев *“Загийн өртөө тэгш талын голын эрэгт байлаа. Талын өмнүүр Шивээт уул хөндөлсөж баруун талаар голын баруун бас нэгэн даваатай, түүнд ерөнхий нэр байхгүй боловч тус тусдаа нэртэй. Тэнгэрийн мухар улаан толгой гэх буюу өртөөний тахилгат Цагаан овоо болно”*<sup>239</sup> гэжээ. Тэнгэрийн мухар даваа Баянхонгор аймгийн Заг сумын Лүнгийн багийн нутаг Загийн голын баруун эрэг Цагаан овооны нурууны ард байсан бололтой. Сумын төвөөс баруун хойд зүгт 1 км орчим, Байдрагийн өртөөнөөс баруун хойд зүгт 30 км зайтай оршино.

23. Ховол өртөө. Тус өртөөний талаар А.Позднеев *“Бид Жаргалантын даваанаас Шар усны уулыг өнгөрч Шар усны голд ирэхэд Ховолын өртөө яг энд байв”*<sup>240</sup> гэж өгүүлжээ. Түүнийг явж байх хугацаанд өртөө нэлээд хойш нүүсэн бололтой байна. Өртөө Ховол нуурын эх Ховол сайрын хөндийд байсныг ШУТИС-ийн түүхийн багш Ю.Болдбаатар *“Манай удамд өртөөний бичээч нар байсан гэдэг. Ахмад хүмүүс Ховол сайрт өртөө нутагладаг тухай ярьж байлаа”* гэж хэлсэн юм. Ховол сайр Хүрээмарал сумын зүүн хойд талд гэсэн үг. Тус өртөө Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Хөх бүрд багийн нутагт Ховолын нуурын орчим байсан бололтой. Сумын төвөөс зүүн хойд зүгт 66 км, Заг өртөөнөөс баруун урд зүгт 30 км зайтай газар юм.

Эрдэнэ засгийн хошууны нутагт 2 өртөө байсан нь Баянхонгор аймгийн Заг сум, Хүрээ марал суманд байна.

Үүний дараагийн өртөөд Жонон засгийн хошууны нутагт тэмдэглэгджээ. Жонон засгийн хошууны нутгийн 5 зураг, цэс ҮНС-д,<sup>241</sup> Японы Тэнри ИС-ийн номын санд буй Сайн ноён аймгийн нутгийн зурагт Жонон засгийн хошууны нутагт 2 өртөөний нэрийг бичсэн нь “ulaγangbumba-u örtege” (Улаанбумбын өртөө), “öberjiγalangtu-yin örtege” (Өвөр Жаргалантын өртөө)<sup>242</sup> юм.

24. Улаан бумбын өртөө. А.Позднеев *“Бумбын өртөө уулаар хүрээлэгдсэн цав дотор байв. Өмнө нь богино уул, ард нь урт уул үргэлжилнэ”*<sup>243</sup> гэжээ. Түүний тэмдэглэлд гарах урт уул бол Ноён Хайрхан уул, богино уул нь Улаан Бумба уул мөн бололтой. Өртөөний нэрээр байх Улаан Бумба уул Баянхонгор аймгийн Баянбулаг, Гурванбулаг сумын заагт оршино. Баянбулаг сумаас зүүн хойд зүгт 27 км, Гурванбулаг сумаас баруун урд зүгт 30 км, Ховол өртөөнөөс баруун хойд зүгт 30 км зайтай байна.

25. Өвөр Жаргалантын өртөө. Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутаг Дөшийн давааны зүүнтээ Өвөр Жаргалантын голын хойд бэлчирт оршино. Сумын төвөөс хойд зүгт 18 км, Бумбатын өртөөнөөс баруун зүгт 24 км-т бий. Жонон засгийн хошууны нутагт хоёр өртөө байсан нь Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутагт байна.

Дараагийн өртөөг Хошууч мэргэн засгийн хошууны нутгийн зурагт тэмдэглэжээ. Хошууч мэргэн засгийн хошууны нутгийн 4 зураг, цэс ҮНС-д,<sup>244</sup> 1 зураг ГЗБГЗЗГ-ын архивт байна. *“Бадаргуулт төрийн гучин гуравдугаар онд үйлдсэн Халхын умар замын дундад умард засаг хэбэй бэйсийн зэрэг гүн Дугаржавын хошууны нутгийн зураг”*<sup>245</sup>-т 10 өртөөг

<sup>239</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 215

<sup>240</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 216

<sup>241</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 511/96, 658/96, 884/96, 917/96, 933/96

<sup>242</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>243</sup> А.Позднеев. Монголия и Монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 218

<sup>244</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 668/96, 954/96, 976/96, 8601/96

<sup>245</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар, сансрын зургийн архив. МНЗ-3. д-3. хн-36

тэмдэглэжээ. Нутгийн зургийн зүүн талаас баруун хойд чиглэлд өртөөний нэрийг дараалуулан бичсэн нь “arujirgalangtu-yin örtege” (Ар Жаргалантын өртөө), “qujirtu-yin örtege” (Хужиртын өртөө), “dayandel-yin örtege” (Даагандэлийн өртөө), “temürtü-yin örtege” (Төмөртийн өртөө), “šoruy-yin örtege” (Шорогийн өртөө), “quwašorutu-yin örtege” (Хув шороотын өртөө), “uliyasutai-yin čereg-ün küriy-e” (Улиастайн цэргийн хүрээ), “aldar örtege” (Алдар өртөө), “borqu-yin örtege” (Борхын өртөө), “ulaγan qudduγ örtege” (Улаан худаг өртөө), “narin örtege” (Нарийн өртөө) юм.

26. Ар Жаргалантын өртөө. Уг өртөө Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутаг Дөш хайрхан уулын ард Ар Жаргалантын голын дэнж дээр байрлана. Энэ нь сумын төвөөсөө баруун хойд зүгт 39 км, Өвөр Жаргалантын өртөөнөөс баруун хойд зүгт 22 км орчим зайтай газар юм.

27. Хужиртын өртөө. А.Позднеев *“Хавцал огтолж хөндлөн даваа туулав. Түүнээс буувал Хужирт голын сав болно. Хужирт гол Буянт голд нийлнэ. Энэ уулзварт Хужиртын өртөө байх ажээ”*<sup>246</sup> гэж тэмдэглэжээ. Хужирт Буянт хоёр голын бэлчирт ойрхон Отгон сумын төв байрладаг. Хойд талд нь Өвгөн Овоо толгой, Бага Майхан уул тод харагдана. Тус өртөө Завхан аймгийн Отгон сумын Буянт багийн нутагт сумын төвөөсөө хойд зүгт 2 км орчим зайтай, Буянт голын баруун талд, Хужиртын голын хойд дэнж Хужиртын аманд буудаг байжээ. Ар Жаргалантын өртөөнөөс баруун хойд зүгт 30 км зайтай.

28. Дааган дэл өртөө. А.Позднеев *“Бид Нарийн булгийг огтлоод элдэв олон салаа урсгалын дунд Хуурай нарийн гэдэг ширгээсэн голын дэргэдүүр өнгөрөв. Ширгээсэн голын хөндийгөөс гараад бид дүүрэн талд оров. Дааган дэлийн өртөө энэ талын нэгэн хоргын хажууд буужээ”*<sup>247</sup> гэж бичсэн байдаг. Тус өртөө Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт Хуурай нарийн голын урд Дааган дэлийн хярд буудаг байжээ. Сумын төвөөс хойд зүгт 42 км, Хужиртын өртөөнөөс баруун зүгт 33 км зайтай Элсэн толгой, Сэрвэй толгойн дунд байжээ.

29. Төмөртийн өртөө. Уг өртөөг А.Позднеев *“Өртөө нь жижиг талд буужээ. Талын баруун талд Захар, Их булаг хоёр уул, ар талд нь Үнэрт уул, өмнө нь Агуйтын гэр зүүнтэй урт хөндий байна”*<sup>248</sup> хэмээн өгүүлжээ. Дээрх газар усны нэр хэвээр хадгалагдаж байгааг 1:500.000 масштабтай Завхан аймгийн газрын зургаас харна. Тус өртөө Завхан аймгийн Цагаанчулуут сумын Жавцаг багийн нутаг Төмөртийн голын дунд урсгал Захар толгой, Булагийн хэжүү толгойн ар талд Дээд Төмөртийн амны баруун урд талд байжээ. Сумын төвөөс зүүн хойд зүгт 30 км, Дааган дэлийн өртөөнөөс баруун хойд зүгт 20 км зайтай газар юм.

30. Шорогийн өртөө. А.Позднеев *“Бид голдиролыг огтолж гараад мөн л Төмөртийн голыг дагаж уруудсаар хавцлаас гарч өргөн талд орлоо. Тэндээс Шүрээгийн өртөөг харах. Өртөөний майханууд Төмөрт, Ширээгийн хоёр голын уулзварт тархан суужээ”*<sup>249</sup> гэж бичсэн байна. Ширээгийн гол, Төмөрт голын уулзвар Майхан толгой, Ар агуйт амны хойд талд байжээ. Тус газрын нэр БНМАУ-ын Геодези, зураг зүйн газраас 1986 онд хэвлүүлсэн Завхан аймгийн 1:620.000 масштабтай газрын зурагт байгаа юм. Өнөөгийн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Агьт багийн нутагт аж. Сумын төвөөсөө баруун урд зүгт 6 км, Дааган дэлийн өртөөнөөс баруун хойд зүгт 24 км-т бий.

<sup>246</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поездки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 216

<sup>247</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поездки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 232

<sup>248</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поездки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 234

<sup>249</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поездки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 235

31. Ухаа шороотын өртөө. А.Позднеев *“Зам дагуудаа хүрээг өнгөрмөгц зүүн хойш муруйгаад Намширын завд орж дахин хойш эргэж Цагаан булагийн хавцалд оров. Хув шороотын өртөө энд байрлаж байв”*<sup>250</sup> гэж бичжээ. Агьтын давааны зүүн, Бичигийн давааны урд талд Цагаан булагийн аманд байрлаж байсан бололтой. Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Агьт багийн нутаг байрлана. Сумын төвөөсөө зүүн хойд зүгт 9 км, Шорогийн өртөөнөөс зүүн хойд зүгт 21 км зайтай. Тус өртөө Улиастай орох хамгийн сүүлчийн өртөө юм. Улиастайгаас зүүн урд зүгт 20 км орчим байна.

32. Улиастайн цэргийн хүрээ. Улиастай хотыг Манжийн эрх баригчид 1733 оны орчим байгуулжээ. Тэнд анхандаа цэргийн зориулалттай хүнс, зэр зэвсэг, хэрэглэл зэргийг агуулж байв. 1748 оноос өргөтгөж Тэс, Орхон, Байдрагийн голын дагуух жижиг хот, цэргүүдийг татаж цэргийн бэхлэлт суурингуудыг барьжээ. Зүүн гар улсыг устгасны дараа цэргүүдийн ихэнхийг тарааснаар цэргийн хотоос засаг захиргааны төв болон хувирч Ар Монгол дахь Манжийн тэргүүн амбан суудаг болжээ. 1818 оны Улиастайн цэргийн хотыг Халхын дөрвөн аймаг цагдах сүвд хуваарилсан нутгийн зурагт<sup>251</sup> Улиастай хотын ойр хавийн газрыг зурж нэрийг бичээд дундуур нь дөрвөн хэсэгт хувааж шугам татаад баруун дээд хэсэгт *“энэ хоёр этгээд улаан зураг хооронд Түшээт хан аймгийн цагдах газар”*, баруун доод хэсэгт *“энэ хоёр этгээд улаан зураг хооронд Сэцэн хан аймгийн цагдах газар”*, зүүн дээд хэсэгт *“энэ хоёр этгээд улаан зураг хооронд Засагт хан аймгийн цагдах газар”*, зүүн доод буланд *“энэ хоёр этгээд улаан зураг хооронд Сайн ноён аймгийн цагдах газар”* хэмээн бичжээ. Ийнхүү тус зурагт дөрвөн аймгийн цагдах газрыг тодотгон хэрэм цайз, тариан талбай, хотод орох, гарах зам сүвийг зурж тэмдэглэсэн нь Улиастай хотыг чухалд тооцож байсны нэг жишээ юм. Улиастай цайз нь өнөөгийн Улиастай хотоос баруун зүгт 18 км зайтай оршино.

Сайр усаас Улиастай хүртэлх өртөөд Халхын Түшээт хан аймгийн Түшээт засаг, Сайн ноён аймгийн Илдэн засаг, Ахай засаг, Үйзэн засаг, Сайн ноён ханы хошуу, Эрдэнэ бандида хутагтын шавь, Дайчин засаг, Цогтой засаг, Чин сүжигт Номун ханы шавь, Эрдэнэ засаг, Жонон засаг, Хошууч мэргэн засаг гэсэн 12 хошуу, шавь нутгаар дамжин явдаг байв. Энэ нь Дундговь аймгийн Өлзийт, Хулд, Луус, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Өвөрхангай аймгийн Сант, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баян-Овоо, Галуут, Байдраг, Заг, Хүрээ марал, Баянбулаг, Гурванбулаг, Завхан аймгийн Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут Цагаанхайрхан сумын нутаг юм.

## 5. Улиастай-Ховдын өртөө

Өртөө, харуулыг тэмдэглэсэн нутгийн зурагт Улиастайгаас Ховд хүртэл *“aldar”* (Алдар) *“borqu”* (Борх), *“qudduγulaγan”* (Худаг улаан), *“yekejes”* (Их зэс), *“baγajes”* (Бага зэс), *“jürküjügүй”* (Зүр хүзүү), *“buγu-a”* (Буга), *“arγalangtu”* (Аргалант), *“baγ-a nuur”* (Бага нуур), *“dörgün nuur”* (Дөргөн нуур), *“qarγan-a”* (Харгана), *“jirγalangtu”* (Жаргалант), *“jaqabulaγ”* (Зах булаг), *“qarausu”* (Хар ус) гэсэн 14 өртөөг тэмдэглэжээ.<sup>252</sup>

1. Алдар өртөө. Завхан аймгийн Алдархаан сумын Алдар багийн нутагт Яруугийн голын баруун талын дэнж дээр Алдар уулын өвөрт Хэц уулын ар талд оршино. Сумын төвөөс баруун зүгт 2 км орчим, Улиастайгаас зүүн урд зүгт 18 км орчим зайтай газар юм.

2. Борх өртөө. А.Позднеев *“Энэхүү Борхын өртөө бол Богд голын хөвөөнд байршиж байна. Голын зүүн хөвөөнд Борхын уул сүндэрлэж байх учраас түүний орчин дахь газруудыг Борх хэмээн нэрлэдэг аж”*<sup>253</sup> гэж өгүүлжээ. А.Позднеев Борхын голыг

<sup>250</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 236

<sup>251</sup> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар. Агаар сансрын архив. Монгол нутгийн зураг III. данс-3, хн-38

<sup>252</sup> Монгол улс. ҮНС-ийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөг. 345/96

<sup>253</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 284

Богдын гол гэж андуурсан бололтой. Уг газраас нэлээн зайтай Алдархаан сумын доод хөндийгөөс Богдын голд Шивээгийн гол нийлж Борхын голыг үүсгэдэг. Өртөө байсан газар Борхын голын хөндий гэнэ. Завхан аймгийн Алдархаан сумын Өгөөмөр багийн нутаг Борхын Их уулын баруун талд Борхын голын баруун эрэгт Өгөөмөр овоот уулын зүүн бэлд оршиж байжээ. Сумын төвөөс зүүн урд зүгт 27 км, Алдар өртөөнөөс мөн зүүн урд зүгт 30 км орчим зайтай байрлаж байв.

3. Худаг улаан өртөө. Эл өртөөний тухай А.Позднеев “*Үргэлжилсэн Цагаан нуруу уул байх бөгөөд төгсгөл хэсэгт нь улаан өнгөтэй Улаан хайрхан уул байна. Улаан худаг өртөө Улаан хайрхан уулаас холгүй оршино*”<sup>254</sup> гэж бичсэн байдаг. Тус өртөө Сэнгийн Хар толгойн баруун хойно орших Худаг Улаан уулын ойролцоо оршиж байсан бололтой. Худаг Улаан уулаас баруун урд зүгт 3 км орчим зайтай Худаг Улааны худаг байдаг. Мөн зүүнтээ Худаг булаг гэх худаг бий. Тус өртөө Завхан аймгийн Алдархаан сумын Аргалант багийн нутаг Завхан голын хойд дэнж Баян Улаан уулын урд хөндийд байв. Сумын төвөөс баруун урд зүгт 54 км, Борхын өртөөнөөс баруун зүгт 30 км зайтай газар юм.

Худаг улааны дараагийн өртөө Засагт хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутагт байжээ. Засагт хан аймгийн Сэцэн засгийн хошууны нутагт 5 өртөөг улаан өнгө бүхий гурвалжин хэлбэртэй тэмдэглэжээ. Зүүн талаас нь “*уеке жес өртеге*” (Их Зэс өртөө), “*баγ-a жес өртеге*” (Бага Зэс өртөө), “*jür өртеге*” (Зүр өртөө), “*буγи-a өртеге*” (Буга өртөө)<sup>255</sup>-г Завхан голын хойд эрэг дагуу зурж бичсэн байна.

4. Их Зэс өртөө. Уг өртөөний тухай А.Позднеев “*Бид Баруун Цахир гэдэг улаан довцог уул хүрэхээс өмнө Завхан голын хөвөөг чиглэн явав. Их Зэс өртөө даруй энэхүү голын хөвөөнд байж*”<sup>256</sup> хэмээн бичжээ. Түүний тэмдэглэлээр бол Баруун Цахир уулын зүүнтээ Их Зэсийн өртөө байсан бололтой. Энэ нь Зүүн Цахир уул, Хар чулууны амын ойролцоо юм. Энэ өртөө Алдархаан сумын Аргалант багийн нутаг Баруун Цахир уулын зүүн хойрмойд Завхан голын хөвөөнд байжээ. Сумын төвөөс баруун урд зүгт 70 км орчим, Худаг улаан өртөөнөөс баруун зүгт 18 км зайтай юм.

5. Бага Зэс өртөө. Эл өртөөг А.Позднеев “*Бид дэрс ихтэй зам дагаж явсаар Хар Овоот уулын бэлд шууд хүрч ирэхэд Бага Зэс өртөө энд байлаа*”<sup>257</sup> гэжээ. Энд гарч буй Хар овоог одоогийн Бор овоо мөн гэж үзэж байна. Бор овооны урд Зэсийн булан Шонтгор толгой бий. Уг өртөө Завхан аймгийн Дөрвөлжин сумын Буурлын багийн нутаг Зэсийн буланд Завхан голын хойд талын дэнж дээр байржээ. Энэ нь сумын төвөөс зүүн зүгт 30 км, Их Зэс өртөөнөөс баруун зүгт 21 км зайтай газар юм.

6. Зүр өртөө. Энэ өртөөний тухай А.Позднеев “*Зүр уулын ард талд нэгэн өртөө байгаа нь Зүр өртөө юм*”<sup>258</sup> гэж бичжээ. Тэр хавьдаа Зүр уул, Далт овоо хоёр хамгийн өндөрлөг газар юм. Зүр өртөө Завхан аймгийн Алдархаан сумын Буурлын багийн нутаг Зүр уулын хойд талд Сэнжит уулын баруун талд байрлаж байжээ. Сумын төвөөсөө баруун зүгт 6 км орчим, Бага Зэс өртөөнөөс баруун зүгт 24 км-т бий.

7. Буга өртөө. А.Позднеев “*Бид хэдэн хэсэг дэрс ургаман хужирлаг газар Буга хайрханы ар бэлээр өнгөрч Буга өртөөнд хүрэв*”<sup>259</sup> гэжээ. Буга Хайрхан уулыг дөнгөж

<sup>254</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 284

<sup>255</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>256</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 286

<sup>257</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 291

<sup>258</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 291

<sup>259</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 291

өнгөрөөд Хайрхан Цахир толгой бий. Завхан аймгийн Дөрвөлжин сумын Буурлын багийн нутаг Буга Хайрхан уулын ар бэлд Хайрхан Цахир толгойн зүүн талд байрлаж байжээ. Сумын төвөөс баруун зүгт 15 км, Зүр өртөөнөөс баруун хойд зүгт 27 км зайтай оршино. Сэцэн засгийн хошууны нутагт 4 өртөө байсны 1 нь Завхан аймгийн Алдархаан сумын нутагт, 3 нь Дөрвөлжин сумын нутгаар дайран гардаг аж.

Дараагийн өртөөд Баатар засгийн хошууны нутагт байжээ. Баатар засгийн хошууны нутагт 2 өртөөг улаан гурвалжин хэлбэртэй дүрслээд, өртөө хоорондын замыг хар цэгэн шугам татан тэмдэглэжээ. Зүүн талаас “arɣalangtu örtege” (Аргалант өртөө), “baγanuur örtege” (Бага нуур өртөө) гэж бичээд хажуу талд нь улаан бэхээр хятад ханзаар орчуулж бичжээ.<sup>260</sup> Аргалант өртөөг Завхан голын урд дэнж дээр, Бага нуурын өртөөг Бага нуурын зүүн урд зурсан байна.

8. Аргалант өртөө. Энэ өртөөний тухай А.Позднеев “*Аргалант өртөө бол Завхан голын зүүн хөвөөний өндөр нэгэн элсэн довын хяр дээр байрлаж байв*”<sup>261</sup> гэж өгүүлсэн байдаг. А.Позднеевыг явж байх үед өртөө голын хойд талд зүүн хөвөөнд байсан бололтой. Угтаа өртөө Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Завхан гол багийн нутагт Аргалант уулын баруун энгэрт байжээ. Сумын төвөөс баруун хойд зүгт 36 км, Буга өртөөнөөс баруун зүгт 40 орчим км зайтай газар юм.

9. Бага нуур өртөө. А.Позднеев “*Уулын амнаас буувал шууд нуурын хөвөө хүртэл үргэлжилсэн элсэрхэг хөндий байсан бөгөөд энэхүү нуурын хөвөөн дээр Бага нуурын өртөө бий*”<sup>262</sup> гэж бичжээ. Өртөөний зам Завхан гол хүрээд улмаар Монгол элсэн дундуур явж Бага нуурт хүрнэ. Өртөө Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц багийн нутаг Хомын элсний ар талд Бага нуурын зүүн урд талд оршино. Сумын төвөөс баруун зүгт 90 орчим км, Аргалант өртөөнөөс баруун урд зүгт 36 км зайтай газар юм.

Баатар засгийн хошууны нутагт байсан 2 өртөөний 1 нь Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт, нөгөө нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт байжээ.

Бага нуурын дараагийн өртөө Эрдэнэ засгийн хошууны нутагт байжээ. Эрдэнэ засгийн хошууны нутгийн зурагт 6 өртөөг улаан гурвалжин дүрсээр тэмдэглэжээ. Өртөө хоорондын замыг хар цэгэн шугам хатган зурсан байна. Зүүн талаас нь “ᠰᠣᠴᠣᠬᠣᠷ нуур өртөө”, “dörgeᠭen örtege” (Дөргөн өртөө), “qarɣan-a örtege” (Харгана өртөө), “jirɣalangtu örtege” (Жаргалант өртөө), “jaɣ bulaɣ örtege” (Зах булаг өртөө), “qara usu örtege” (Хар-Ус өртөө) гэжээ.<sup>263</sup> Түүний хажуу талд улаан бэхээр хятад ханзаар орчуулан бичжээ. Цоохор нуур өртөөг Дөргөн нуурын зүүнтээ, Дөргөн өртөөг Дөргөнө нуурын зүүн урд, Харгана, Жаргалант, Зах булаг өртөөг Дөргөн нуурын өмнө зурсан байна.

10. Цоохор нуур өртөө. Тус өртөө Цоохор нуурын дэргэд Монгол элсэн дотор байжээ. Өнөөгийн Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Цоохор нуур багийн нутаг юм. Сумын төвөөс баруун хойд зүгт 60 км, Бага нуурын өртөөнөөс чанх урагшаа 18 км орчим зайтай ажээ.

11. Дөргөн өртөө. Энэ талаар А.Позднеев “*Бид Дөргөн нуурын өмнө хөвөөг туулаад баруун хөвөө тийш муруйгаад хэсэг яваад сая өндөр хулс ургасан хэсэг газраас Дөргөн нуурын өртөөг эрж олов*”<sup>264</sup> гэж бичжээ. Дөргөн нуур зэгс ихтэй тул өртөөг олоход бэрх байсан биз. Тус өртөө Ховд аймгийн Чандмань сумын Тал булаг багийн

<sup>260</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>261</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 293

<sup>262</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 294

<sup>263</sup> В.Оyunbilig, В.Nasundalai. Studies in Mongolian Manuscript Maps Preserved in the Tenri Central Library, Tenri University, Japan. Beijing., 2014. pp.67

<sup>264</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 295

нутагт Дөргөн нуурын баруун хөвөөнд байрлаж байжээ. Сумын төвөөс зүүн зүгт 48 км, Цоохор өртөөнөөс баруун зүгт 37 км орчим зайтай бий.

12. Харгана өртөө. А.Позднеев *“Харгана өртөө нэгэн муруй тахиралдсан голын хөндийд байрлаж байв. Тэр голыг Харганын гол гэнэ”*<sup>265</sup> гэж бичжээ. А.Позднеев Жаргалантын голыг Харгана гол гэж андуурсан байна. Тус өртөө Ховд аймгийн Чандмань сумын нутагт байжээ. Сумын төвийн зүүн талд, Дөргөн өртөөнөөс баруун талд 36 орчим км зайтай оршино.

13. Жаргалант өртөө. Уг өртөө Ховд аймгийн Чандмань сумын Баян хайрхан багийн нутаг Жаргалант уулын зүүн бэлд оршиж байв. Сумын төвөөс баруун зүгт 18 км, Харгана өртөөнөөс баруун хойд зүгт 32 км зайтай газар ажээ.

14. Зах булаг өртөө. А.Позднеев *“Зах булаг өртөөний одоогийн байршил нь Улаан худгийн хажууд байна”* гэж бичжээ. Улаан худаг бол одоогийн Ховд аймгийн Манхан сумын Баянгол багийн нутаг Цагаан худгийн зэргэлдээ орших Улаан Бух худаг мөн бололтой. Сумын төвөөс хойд зүгт 30 км, Жаргалантын өртөөнөөс баруун зүгт 42 км орчим зайтай газар юм.

15. Хар ус өртөө. Тус өртөөний тухай А.Позднеев *“Нуурын ус шорвог тул мал ч уухгүй байлаа. Өртөөнийхөн цөм ойрхон буй Цагаан худгаас усаа авдаг”*<sup>266</sup> гэж өгүүлжээ. Цагаан худаг нь Ховд аймгийн Мянгад сумын Наран Хайрхан багийн нутагт Сартагтайн шуудууны баруун талд орших Цагуугийн худаг мөн бололтой байна. Сумын төвөөс урд зүгт 48 км, Зах булаг өртөөнөөс баруун хойд зүгт 36 км орчим зайтай газар юм. Эрдэнэ засгийн хошууны нутагт 6 өртөө байснаас 1 өртөө Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт, 3 өртөө Ховд аймгийн Чандмань сумын нутагт, 1 өртөө Манхан сумын нутагт, 1 өртөө Мянгад сумын нутагт байна.

Улиастайгаас Ховд хүртэлх 15 өртөөд Сайн ноён аймгийн Хошууч мэргэн засаг, Засагт хан аймгийн Сэцэн засаг, Баатар засаг, Эрдэнэ засгийн хошууны нутагт байжээ. Одоогийн Завхан аймгийн Алдархаан сумын нутагт 5, Дөрвөлжин сумын нутагт 2, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт 2, Ховд аймгийн Чандмань сумын нутагт 3, Манхан сумын нутагт 1, Мянгад сумын нутагт 1 өртөө байжээ.

Дээрх нутгийн зургийн мэдээг нэгтгэн үзвэл, Хярын мухараас Сайр ус хүртэл 14 өртөө, Сайр ус- Их Хүрээний 14 өртөө, Их Хүрээнээс Хиагт хүртэл 11 өртөө, Сайр ус-Улиастайн 32 өртөө, Улиастай-Ховдын 15, нийт 86 өртөөг тэмдэглэжээ. Эдгээрээс Халхын Түшээт хан аймгийн найман хошууны нутагт 45 өртөөг байгуулсны 23 нь Харчин өртөө юм. Халхын Сайн ноён аймгийн арван нэгэн хошууны нутагт 28 суурь өртөө байгаагаас 5 өртөөний албыг харчингууд залгуулна. Халхын Засагт хан аймгийн гурван хошууны нутагт 13 суурь өртөө байсан ажээ. Өртөө хоорондын зай харилцан адилгүй, 25-35 км байгаа нь тухайн нутгийн онцлог, гол мөрөн, газрын бартаа, худаг усны хол ойроос шалтгаалсан ажээ.

<sup>265</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 295

<sup>266</sup> А.Позднеевымъ. Монголія и Монголы. Результаты поѣздки въ Монголію, исполненной въ 1892-1893 гг. Томъ I, С-Петербургъ., 1896, стр. 296